



БОЛОВСРОЛЫН  
ЯАМ



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

# БАГШИЙН ГАРЫН АВЛАГА

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ  
АХЛАХ БҮЛЭГ



УЛААНБААТАР ХОТ  
2025 ОН

## АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: БАГШИЙН ГАРЫН АВЛАГЫН ТУХАЙ	2
1.1 Багшийн гарын авлагын зорилго, бүтэц	2
1.2. Сургалтын хөтөлбөр, гарын авлагатай танилцъя	2
1.3. Сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх	5
ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХӨТӨЛБӨРИЙН ОНОЛ, АРГА ЗҮЙ	7
2.1. Бага насны хүүхэд цэцэрлэгийн орчинд дасан зохицох тухай	7
2.2. Сургалтын хөтөлбөрийн арга зүйтэй уялдах онол	8
2.3. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй	10
ГУРАВДУГААР БҮЛЭГ: СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ	17
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - IX САР	17
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - X САР	28
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - XI САР	38
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - XII САР	49
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - I САР	59
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - II САР	68
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - III САР	78
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ – IV САР	88
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - V САР	100

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: БАГШИЙН ГАРЫН АВЛАГЫН ТУХАЙ

### 1.1 Багшийн гарын авлагын зорилго, бүтэц

Энэхүү гарын авлага нь сургуулийн өмнөх боловсролын түвшний сургалтын хөтөлбөр болон долоон чиглэлийн сургалтын хөтөлбөрийг ойлгох, ухагдахуунуудыг тайлж уншихад дэмжлэг үзүүлэх, сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд багш нарт онолын мэдлэг, арга зүйн чиглэл, практик жишээ, зөвлөмжөөр дэмжлэг үзүүлэх, хүүхдийн хөгжилд чиглэсэн чанартай сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, үнэлэх чадварын хөгжлийг дэмжих зорилготой.

Та бүхэн гарын авлагатай танилцахын зэрэгцээ сургуулийн өмнөх боловсролын түвшний сургалтын хөтөлбөрөөс философи, онол, арга зүйн үндэс, суурь зарчим, бүтцийг сайтар судлаарай. Мөн долоон чиглэлийн сургалтын хөтөлбөрөөс бүтэц, чадвар, суралцахуйн үр дүн, арга зүй, орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээний хэсгүүдийг уялдуулан харах хэрэгтэй.

Багшийн гарын авлагын Нэгдүгээр бүлгээс суралцахуйн үр дүн болон бусад гол ухагдахуунуудын талаар цэгцтэй, дэлгэрэнгүй ойлголт авахын зэрэгцээ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хэрхэн жил, сар, долоо хоногоор төлөвлөхийг харах боломжтой.

Хоёрдугаар бүлгээс сургалтын хөтөлбөрийн суралцахуйн онолын үндэс, хэрэгжүүлэх арга зүй нь сургалт, үйл ажиллагааны төлөвлөлттэй хэрхэн уялдаж байгаатай танилцана уу.

Гуравдугаар бүлгээс жил, сар, долоо хоногийн төлөвлөлтөд хэд хэдэн чиглэлийн суралцахуйн үр дүнг хэрхэн нэгдмэл байдлаар авч хэрэгжүүлж болох жишээтэй танилцаарай. Жишиг сарын төлөвлөлтөөс хичээлийн жилийн турш суралцахуйн үр дүнгүүдийг (НСХ 3.1а, МАТ3.2а гэх мэт) нэгтгэж харах, төлөвлөх, хянах боломжтой. Энэ бүлэг дэх нэгдмэл үйл ажиллагаанууд нь та бүлгийнхээ хүүхдүүдийг тодорхой суралцахуйн үр дүнд хүргэхийн тулд санаа авч хэрэгжүүлж болохуйц арга, ажиллагааны жишиг гэдгийг сайтар санаарай. Эдгээр жишиг үйл ажиллагааг сайжруулах, өөрчлөх, санаа авч өөрсдийнхөөр шинээр төлөвлөх боломжтой юм.

Мөн энэхүү гарын авлагаар хүүхдийн суралцахуйг анги танхимаас гадна эцэг эхтэй хамтран гэр бүлд нь хэрхэн үргэлжлүүлж болох талаар жишиг санааг тусгаж өгсөн.

Багш нар гарын авлагаа ашиглан хамтран төлөвлөх, харилцан хичээлд суух, эргэцүүлэх, туршлагаа хуваалцах замаар мэргэжлийн тасралтгүй хөгжлөө дэмжих боломжтой бөгөөд энэхүү гарын авлага нь шинэ, залуу багш нарыг сургах, чиглүүлэхэд тохиромжтойгоор боловсруулагдсан.

### 1.2. Сургалтын хөтөлбөр, гарын авлагатай танилцъя

Чадамжид суурилсан хөтөлбөр

Чадамж гэдэг нь 1. Мэдлэг (юуг мэдэх), 2. Чадвар (яаж хийх), 3. Хандлага (ямар үнэт зүйл, зан төлөвтэй байх) гурвын нэгдлийг хэлнэ. Хөтөлбөр чадамжид суурилна гэдэг нь хүүхэд ямар нэгэн мэдээллийг цээжлээд өнгөрөх төдий бус харин амьдралд хэрэглэх мэдлэг, чадвар, хандлага, зан үйл, сэтгэлгээний арга барил эзэмшихэд чиглэнэ гэсэн үг юм.

Сургалтын хөтөлбөр нь хүүхдийг оюун санааны дархлаатай, аз жаргалтай насан туршдаа суралцах чадамжтай болгохыг гол зорилгоо болгосон. Хөтөлбөрийн агуулга, арга зүй нь хүүхэд бүрийн оролцоонд суурилсан үйл ажиллагаагаар дамжуулан ирээдүйд суралцах суурь чадвар бүхий бие хүн болгож төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

Хөтөлбөр, гарын авлагын уялдаа

Багш нь сургалтын хөтөлбөр, багшийн гарын авлагыг хамтад нь хослуулан хэрэглэнэ. Ингэхдээ сургалтын хөтөлбөрөөс хүүхдүүдийн ямар чадамжийг хөгжүүлж ямар суралцахуйн үр дүнд хүргэхээр зорьж байгаагаа харна. Харин багшийн гарын авлага дээрх санал болгосон жишгүүдээс арга зүйн санаа авна.

Сургалтын хөтөлбөрөөс харах зүйлс	Багшийн гарын авлага дээр хэрхэн буусан бэ?
Хөтөлбөрийн үзэл баримтлалд тулгуурлан эзэмшүүлэх чадамж, суралцахуйн зорилт, хөгжлийн ай, дэд ай, суралцахуйн үр дүнг тодорхойлсон.	Хөтөлбөр дахь суралцахуйн зорилтод чиглэсэн нас, хөгжлийн онцлогт тохирсон жишиг арга зүй, өдөр тутмын үйл ажиллагаа санал болгосон.
Суралцахуйн үр дүн бүрээр 2-5 настай хүүхдэд хөгжлийн 4 түвшнийг тодорхойлсон.	Түвшин бүрд жишиг үйл ажиллагаа санал болгохын зэрэгцээ СҮД-үүдийн залгамж холбоог хангах арга зүйн дэмжлэг үзүүлнэ.
Сургалтын долоон чиглэлийн хүрээнд нэгдмэл арга зүй баримтлахаар боловсруулсан.	Сургалтын чиглэл дэх айнуудыг сэдэвт үйл ажиллагаагаар нэгтгэж болох жишээ санал болгосон.

Сургалтын хөтөлбөр, гарын авлагын бүтэц

Нэн түрүүнд сургалтын долоон чиглэл, эдгээрт тодорхойлсон хөгжлийн дөрвөн түвшин, суралцахуйн үр дүн, үнэлгээний шалгууруудыг нарийн танилцаж ойлгох нь чухал юм.

**Сургалтын чиглэл.** Сургалтын хөтөлбөрийг хүүхдийн хөгжлийн чиглэлд үндэслэн дараах 7 чиглэлээр боловсруулсан. Үүнд: 1) Нийгэм-сэтгэл хөдлөл; 2) Хөдөлгөөн, эрүүл мэнд; 3) Хэл яриа; 4) Байгаль, нийгмийн орчин; 5) Математик; 6) Зураг, урлал; 7) Хөгжим; зэрэг юм.

Хөтөлбөрийн сургалтын чиглэл бүр нь чадвар, тухайн чадварын ай, дэд айгаас бүтнэ. Дэд ай бүр 1-4 түвшинд тодорхойлогдсон суралцахуйн үр дүнтэй. Жишээ нь: Нийгэм-сэтгэл хөдлөлийн сургалтын чиглэл *"Хүүхэд сэтгэл хөдлөл, мэдрэмж, харилцаа, хүмүүнлэг байдлын талаар ойлголт мэдлэгтэй бусадтай эергээр харилцах, хамтрах, зан үйлээ хариуцлагатайгаар удирдан зохицуулах чадвартай, өөрт болон бусдад төдийгүй нийгэмдээ энэрэнгүй, эрх тэгш, хүндэтгэлтэй хандлагатай болж төлөвших"* чадварыг эзэмшүүлэхийг зорих бөгөөд үүний тулд 1. Өөрийгөө таних; 2. Бусадтай харилцах; 3. Харилцан хамаарал гэсэн гурван айтай, ай тус бүр гурван дэд айн хүрээнд нийт 36 суралцахуйн үр дүнг тодорхойлсон байна.

**Суралцахуйн үр дүн (СҮД).** Сургалтын хөтөлбөрийн зорилго, агуулгыг хэрэгжүүлснээр хүүхдийн хөгжлийн хувьд хүрэх үр дүнг "Суралцахуйн үр дүн" гэж нэрлэсэн. Тиймээс "Суралцахуйн үр дүн" нь мөн сургалтын хөтөлбөрийг амжилттай эзэмшсэн суралцагчийн мэдэх, ойлгох, хэрэглэх шаардлагатай хүрэх түвшний илэрхийлэл болно.

**Суралцахуйн үр дүнгийн хүрэх түвшин.** Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хүүхдэд эзэмшүүлэх чадварыг дөрвөн түвшинтэй боловсруулсан. Энэхүү хөтөлбөрөөр эзэмшүүлэх чадварын түвшин нь сургуулийн өмнөх боловсролын зохион байгуулалтын түвшингээс тусдаа ойлголт болно. Өөрөөр хэлбэл, хүүхэд бүрийн хөгжлийн хурд, явц ялгаатай учраас эзэмших чадварын 4 түвшин нь бага, дунд, ахлах, бэлтгэл бүлэгт дүйцэх албагүй юм.

**Суралцахуйн үр дүн ба чадамж.** Суралцахуйн үр дүнгүүд нь хүүхдийн ерөнхий болон суурь чадамж (мэдлэг, чадвар, хандлага)-д чиглэнэ. Ингэхдээ хүүхдийн өмнөх мэдлэг, төсөөлөл, амьдралын туршлагад тулгуурлан аливаа зүйлийг сонирхон судалж, эргэцүүлэн таамаглаж тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэглэх чадамж хандлагыг хөгжүүлэх юм.

**Нэгдмэл арга зүй.** Суралцахуйн үр дүнд хүрэхийн тулд багш нэгдмэл арга зүйг хэрэглэнэ. Нэгдмэл арга зүй нь сургалтын хэд хэдэн чиглэлийг хамарсан, олон талт, нарийн нийлмэл, оролцоонд тулгуурласан хэлбэртэй байна. Нэгдмэл арга зүйд ямар сургалтын загвар, хэлбэрийг авч ашиглах нь багшийн өөрийн шийдэл боловч энэхүү гарын авлагын хүрээнд дараах дөрвөн арга зүйг жишээ болгон авч үзсэн. Үүнд: Тоглоомд суурилсан; Зохиолд суурилсан; Сонирхон судлахад суурилсан; Төсөлд суурилсан зэрэг болно. Эдгээр арга зүйгээр өдөр тутмын сургалт, үйл ажиллагааг төлөвлөж, өдрийн хуваарьт (хүлээн авалт, тойргийн цаг, чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа, төвийн үйл ажиллагаа, зугаалгын цаг, хөгжөөн баясах үйл ажиллагаа, номын цаг ... гэх мэт) цагуудад зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээг цогцоор нь багтаасан.

Багш та төлөвлөлтөө хийхдээ өдрийн хуваарьт үйл ажиллагааг бүтцийн дагуу зохион байгуулахад анхаараарай. Өдрийн хуваарьт үйл ажиллагааны онцлогийг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 1. Өдрийн хуваарьт үйл ажиллагааны онцлог

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны онцлог
Тойргийн цаг	<p>Өдрийг амжилттай эхлэхийн нэг үндэс нь өглөөний тойргийн цагт хийгдэж буй ажлын төлөвлөлт байдаг. Тухайн өдрийн судлах зүйлийн талаар суурь ойлголт авах боломж олгодог.</p> <p>Тойргийн цаг нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Мэндчилгээ</li> <li>- Ярилцлагаас бүрдэнэ.</li> </ul>
Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	<p>Багшийн заавар, тодорхой зорилго, аргачлалтайгаар танин мэдэхүй, хэл яриа, бие бялдар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлдэг.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тоолох, ангилах, ялгах</li> <li>- Туршилт хийх</li> <li>- Сонсох, ярих, санаа бодлоо үйл явдлын дагуу үргэлжлүүлэн зохиох,</li> <li>- Зураг, наамал, барих, зохион бүтээх</li> </ul>
Төвийн үйл ажиллагаа	<p>Бие даасан байдал, асуудал шийдвэрлэх, бүтээлч оролцоог дэмждэг. Багш чиглүүлэхээс илүү ажиглагч, дэмжигчийн үүрэгтэй. Хэдэн төвтэй, ямар тоглоомтой байхыг багш төлөвлөж тоглоомын аргачлал, тоглох заавар зэргийг зургаар илэрхийлж хайрцаг, саванд байрлуулж, хүүхэд аль төвд ажиллах сонголт хийнэ.</p> <p>Төв нь: Хүүхдийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн, сонголт хийх боломжтой байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Туршилт танин мэдэхүйн төв</li> <li>- Математикийн төв</li> <li>- Хэл яриа-номын төв</li> <li>- Тоглоомын төв</li> </ul>
Зугаалга	<p>Хүүхдийг байгальтай танилцуулах, орчноо ажиглах, туршин судлах, хөдөлгөөнийг дэмждэг өдөр тутмын үйл ажиллагааны хэлбэр юм.</p> <p>Зугаалга нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ажиглалт</li> <li>- Хөдөлмөр</li> <li>- Тоглоом</li> </ul>
Номын цаг	<p>Хүүхдийн хэл яриа, уран дүрслэл, сонсох чадвар, анхаарал төвлөрөл, төсөөллийг хөгжүүлэх үлгэр, номын зохиол уншиж, ярилцана. Чиглүүлэх асуултаар баяжуулна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Үлгэр унших</li> <li>- Зурагт ном тайлбарлах</li> <li>- Дүрд тоглох</li> <li>- Үлгэрийг үргэлжлүүлэх</li> </ul>
Өөртөө үйлчлэх цаг	<p>Хүүхдийг өдөр тутмын хувийн хэрэгцээг хангахад чиглэсэн. <i>Эх сурвалж: Бямбадорж.П, Гандолгор.Ш., (1994). “Бага насны хүүхдийн хөдөлмөр, зурагт сургах арга зүй”</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- Гар, нүүр угаах</li> <li>- Хувцас өмсөх/эвхэх</li> <li>- Ор хураах, засах гэх мэт</li> </ul>
Хөгжөөн баясах цаг	<p>Хүүхдийг хөгжөөн баясахад, чиглэсэн өдөр тутмын үйл ажиллагаа, үлгэр зохиолын дүрд хувирах, хөгжилтэй хөдөлгөөн, хөнгөн дасгал, хөгжимт тоглоомоор сэргээнэ.</p> <p>Хөгжөөн баясах цаг:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Үлгэр зохиол танилцуулах, дүрд хувирах</li> <li>- Хөгжмийн хэмнэлээр бүжиглэх</li> <li>- Хөгжөөнт тоглоом</li> <li>- Хөгжилтэй дасгал</li> </ul>

### 1.3. Сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх

#### 1. Үйл ажиллагааны сэдэв сонгох

Гарын авлагад "Сэдэв" гэх ойлголтыг нэг сарын хугацаанд хэд хэдэн суралцахуйн үр дүнг нэгтгэх, арга зүйг нэгдмэл байдлаар хооронд нь уялдуулах зорилгоор оруулж ирсэн. Багш нар хүүхдүүдээ хөгжүүлэхээр зорьж буй суралцахуйн үр дүн, орон нутгийн онцлог, хүүхэд, эцэг эхийн хүсэл сонирхол, өөрийн боломж, давуу тал зэрэг хүчин зүйлсийг харгалзаж төлөвлөлтийн сэдвийг тодорхойлно. Сэдэв нь дотроо хэд хэдэн дэд үйл ажиллагааг агуулах бөгөөд нэгдмэл арга зүйгээр хэрэгжинэ. Өөрөөр хэлбэл, багш үйл ажиллагааг суралцахуйн чиглэл тус бүрээр салангид явуулах бус харин хүүхдүүдийн хувьд утга учиртай, нэгдмэл байдлаар төлөвлөх, зохион байгуулахад "сэдэв" чиглэгдэх юм.

#### 2. Сэдэв, үйл ажиллагааны хүрээнд эзэмших СҮД-гүүдийг нарийвчлан уялдаа холбоог сайжруулах

Сэдвийн хүрээнд төлөвлөхдөө сургалт, үйл ажиллагааны СҮД-гүүдийн уялдаа холбоог шалгахын зэрэгцээ нийт жилийн сургалт, үйл ажиллагаанд нэг СҮД хэт олон давтагдах эсвэл орхигдож байгаа эсэхийг лавлаарай. Мөн нөгөө талаас бүх үйл ажиллагаанууд тухайн СҮД-д чиглэж байгаа эсэх, зорилтот СҮД-гүүд хангагдаж байгаа эсэхийг байнга нягталж байх хэрэгтэй. Тухайлбал, дараах үйл ажиллагаанд Нийгэм-сэтгэл хөдлөлийн есөн СҮД-гээс нэгийг нь эзэмшүүлэхээр төлөвлөсөн байна.

#### Бага бүлэг

Үйл ажиллагаа	Нэгдмэл байдлаар төлөвлөсөн суралцахуйн үр дүн (СҮД)	Суралцахуйн үйл ажиллагаа
Ангитайгаа танилцъя	НСХ1.1а. Биеийн зарим мэдрэмжээ нүүр, гар, биеийн хөдөлгөөн, дуу авиа, үгээр илэрхийлдэг болно. БНО1.1в. Ойр орчны эд зүйлс, тоглоомыг мэдэрч нэрлэнэ. МАТ1.1а. Гэр, цэцэрлэгийн орчин тойронд байх юмсаас 1 эсвэл 3 ширхэг тоглоом, юмсыг заах, нэг гэж хэлнэ.	Өөрт таатай, таагүй байгааг биеийн хэлэмж, үгээр хэлэх, заах Орчныхоо тоглоом, эд зүйлсийг сонирхон ажиглах, тоглох, нэрлэх Ангийн тоглоомоос нэг тоглоом сонгон тоглох

#### Дунд бүлэг

Үйл ажиллагаа	Нэгдмэл байдлаар төлөвлөсөн суралцахуйн үр дүн (СҮД)	Суралцахуйн үйл ажиллагаа
Олоорой	НСХ2.1а. Биеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг үгээр илэрхийлдэг болно. МАТ2.1б. Дараалан байрлуулсан тоглоом, юмсын зүй тогтлыг ажиглаж, дуурайна.	Таних тэмдэгтэй өрж байгуулах тоглоомоор тоглох Өөрийн таних тэмдгийг таних, бусдынхтай харьцуулах Ойр орчмын дуу чимээ танил үг, өгүүлбэрийг анхааралтай сонсох, дуурайх.

#### Ахлах бүлэг

Үйл ажиллагаа	Нэгдмэл байдлаар төлөвлөсөн суралцахуйн үр дүн (СҮД)	Суралцахуйн үйл ажиллагаа
Миний зуны амралт	ХЯ2.2а. Энгийн өгүүлбэрээр харилцан ярилцана. ЗУ2.2а. Зураас, дүрсээр өөрийн бодол төсөөллөө илэрхийлнэ. НСХ2.3в. Аливаа үйл ажиллагаанд бие даан дуртай оролцоно.	Өдөр тутмын үйл ажиллагааны явцад сэдвийн хүрээнд өөрийгөө илэрхийлэн, бусадтай харилцахдаа асуулт харилцан яриаг эхлүүлэх Дугуй дүрс, цэг зураасаар дүрсэлж зурах Өдрийн дэглэмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох

Дээрх жишээнд ахлах бүлгийн эхний сарын зарим үйл ажиллагаануудыг хоёрдугаар түвшний СҮД-гийн хүрээнд төлөвлөсөн байна. Энэ нь хүүхэд бүлэг шилжих үед СҮД-гийн түвшнийг уусгах, шилжилтийг хүүхдэд хялбарчлах зорилготой. Мөн эндээс та бүхэн СҮД-гийн түвшин сургалтын зохион байгуулалтын түвшин буюу бүлэгтэй заавал тохирох албагүй байгааг харж болно.

#### Бэлтгэл бүлэг

Үйл ажиллагаа	Нэгдмэл байдлаар төлөвлөсөн суралцахуйн үр дүн (СҮД)	Суралцахуйн үйл ажиллагаа
Би-миний найзууд	БНО4.2а. Өөрийнхөө тухай танилцуулж, бусдын сонирхол, ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандана. НСХ4.3в Өдөр тутмын үйл ажиллагаанд тодорхой дүрэм баримтлан хамтран оролцдог болно.	Өөрийгөө болон гэр бүлийнхээ тухай танилцуулах Ангийн дүрмээ хэлэлцэхэд өөрийн саналаа хэлэх, хамтдаа зохиох

#### 3. Сар, долоо хоногийн төлөвлөгөө зохиох

Гарын авлагад хичээлийн жилийн эхнээс буюу 9-өөс 5 дугаар сарын нийт есөн сарын жишиг төлөвлөлтийн загвар оруулсан. Ингэхдээ сар бүрийн эхний хоёр долоо хоногийн үйл ажиллагааны төлөвлөлтийг жишиг болгосон. Эндээс багш нар санаа авч тухайн сарын 2 долоо хоногийг үргэлжлүүлэн төлөвлөх зориулалттай юм. Сар бүр нэгдсэн сэдэвтэй бөгөөд цааш долоо хоногийн дэд сэдэв, үйл ажиллагаагаар төлөвлөгдсөн.

Жишээ нь: Бага бүлгийн 9 дүгээр сар *"Шинэ орчин"* сэдэвтэй бөгөөд удиртгал хэсэгт сургалтын хөтөлбөрийн чадамжууд, СҮД-гүүдтэй хэрхэн уялдах байдал болон суралцахуйн үйл ажиллагааг тодорхойлсон. Энэ нь цаашаа долоо хоног, үйл ажиллагаануудаар төлөвлөгдсөн бөгөөд, тухайлбал нэг, хоёрдугаар долоо хоногууд *"Ангитайгаа танилцъя"*, *"Миний хөөрхөн гар, нүүр"*, *"Дуулцгаая"* гэсэн үйл ажиллагаануудаас бүрдэж байна.

Жишээ нь: Дунд бүлгийн 9 дүгээр сар *"Хамтдаа тоглоё"* сэдэвтэй бөгөөд удиртгал хэсэгт сургалтын хөтөлбөрийн чадамжууд, СҮД-гүүдтэй хэрхэн уялдах байдал болон суралцахуйн үйл ажиллагааг тодорхойлсон. Энэ нь цаашаа долоо хоног, үйл ажиллагаануудаар төлөвлөгдсөн бөгөөд, тухайлбал, нэгдүгээр долоо хоног *"Зогсоорой"*, *"Олоорой"*, *"Алгаа ташаарай"*, *"Олсоор наадъя"*, *"Гараа угаацгаая"* гэсэн үйл ажиллагаануудаас бүрдэж байна.

Жишээ нь: Ахлах бүлгийн 9 дүгээр сар *"Миний танил орчин"* сэдэвтэй бөгөөд удиртгал хэсэгт сургалтын хөтөлбөрийн чадамжууд, СҮД-гүүдтэй хэрхэн уялдах байдал болон суралцахуйн үйл ажиллагааг тодорхойлсон. Энэ нь цаашаа долоо хоног, үйл ажиллагаануудаар төлөвлөгдсөн бөгөөд, тухайлбал, нэгдүгээр долоо хоног *"Миний зуны амралт"*, *"Миний нэг өдөр"*, *"Авхаалжтай хүүхэд"* гэсэн үйл ажиллагаануудаас бүрдэж байна.

Жишээ нь: Бэлтгэл бүлгийн 9 дүгээр сар *"Хөгжилтэй найзууд"* сэдэвтэй бөгөөд удиртгал хэсэгт сургалтын хөтөлбөрийн чадамжууд, СҮД-гүүдтэй хэрхэн уялдах байдал болон суралцахуйн үйл ажиллагааг тодорхойлсон. Энэ нь цаашаа долоо хоног, үйл ажиллагаануудад задрах бөгөөд тухайлбал нэгдүгээр долоо хоног *"Би-миний найзууд"*, *"Бид хамтдаа"*, *"Хамтдаа хийгээрэй"* гэсэн үйл ажиллагаануудаас бүрдэж байна.

Дээрх жишиг төлөвлөлтүүдээс дараах асуултад хариулт авах боломжтой.

Үүнд:

- Үйл ажиллагаа, арга зүйг хэрхэн сонгож сарын төлөвлөлт хийх вэ?
- Тухайн сард ямар СҮД-гүүдийг сонгон авч хэрхэн хооронд нь уялдуулах вэ?
- Долоо хоног, өдрийн төлөвлөлтийг хэрхэн хийх вэ?
- Сургалтын чиглэл хоорондын уялдааг хэрхэн хангах вэ?
- Шаардлагатай дасгал, үйл ажиллагааны давтамжийг хэрхэн тодорхойлох вэ?
- Сургалтын долоон чиглэлийн тэнцвэртэй байдлыг хэрхэн хангах вэ?

Сэдвийн хүрээнд тоглох, үлгэр, зохиол унших, турших, төсөл хэрэгжүүлэх, дуу, хөгжим, хөдөлгөөн, зурах, бүтээх гэх мэт бүх төрлийн үйл ажиллагааг хослуулахыг хичээгээрэй. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүх арга зүйн үндэс нь **тоглох үйл ажиллагаа** байгаа учраас бүлгээр, хамтран, зэрэгцэн, чөлөөт сонголттой хэлбэрүүдийг тэнцвэртэй оруулбал зүйтэй. Эдгээр үйл ажиллагаа, тоглох үйл явцуудыг хүүхдийн сонирхол, хэрэгцээ, хөгжлийн түвшинд тохируулан сонгож төлөвлөнө.

#### 4. Хэрэгжүүлэх, ажиглах, үнэлэх, эргэцүүлэх

Сургалтын хөтөлбөрийн үнэлгээний үндсэн хэлбэр нь тасралтгүй ажиглалтад суурилсан албан бус үнэлгээ юм. Зорилтот СҮД-д баримжаалан хүүхдийн ахиц, хөгжлийн хэрэгцээг тодорхойлох зорилгоор үнэлгээг хийнэ. Багш өөрийн хэрэгцээ, нөөц боломжид тулгуурлан улирал, жилээр үнэлгээг нэгтгэж хүүхдийн ахицыг тодорхойлж дараагийн төлөвлөлтөд тусгана. Ингэхдээ багш нар үнэлгээний шалгуурын хүрээнд ажиглалтын хуудас, эргэцүүлэл, шалгах хуудас зэрэг хэрэгсэл ашиглана.

Гарын авлага нь багшид мэргэжлийн хөгжлийн хөтөч болох давхар ач холбогдолтой. Үүний тулд багш нар сэдэв бүрийн төгсгөлд амжилттай хэрэгжсэн үйл ажиллагаа, шалтгаан, сайжруулах шаардлагатай үйл ажиллагааны талаар эргэцүүлээ бичиж хэвших хэрэгтэй. Мөн эргэцүүллийн хүрээнд бусад багш нартай хэлэлцүүлэг өрнүүлж санал бодлоо солилцвол илүү үр дүнтэй. Эдгээрт тулгуурлан багш үйл ажиллагаануудыг төлөвлөж цаашид хүүхдийнхээ хэрэгцээ, сонирхол болон орон нутгийн онцлогтой уялдуулан сайжруулахын зэрэгцээ өөрөө мэргэжлийн ур чадварын хувьд өсөж хөгжих юм.

### ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХӨТӨЛБӨРИЙН ОНОЛ, АРГА ЗҮЙ

#### 2.1. Бага насны хүүхэд цэцэрлэгийн орчинд дасан зохицох тухай

Хүрээлэн буй орчны өөрчлөлт, түүний зүгээс тавигдаж байгаа шаардлагад нийцэх нь дасан зохицох чадвар юм. Дасан зохицох чадвар нь сэтгэц-физиологи, гүйцэтгэх үйл ажиллагаа, хүрээлэн буй орчны нөхцөл байдал, хүмүүсийн харилцаа хандлагад дасах үйл явцыг агуулна. Тиймээс хүүхэд цэцэрлэгт дасан зохицох чадвар нь нийгмийн орчинд дасан зохицож буй нэг хэлбэр бөгөөд цэцэрлэгийн орчинд хүүхэд бие бялдар, сэтгэлзүйн хувьд аюулгүй тайван байх мэдрэмж юм.

Хүүхэд цэцэрлэгийн орчинд дасан зохицох чадварт тэдний сэтгэл хөдлөл, танин мэдэхүй, нийгэмшихүйн хөгжлийн онцлогоос гадна дараах хүчин зүйлс нөлөөлдөг.

- Хүүхдийн өөрийн туршлага
- Эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс хүүхдийн цэцэрлэгт итгэх итгэл
- Эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс хүүхдэдээ итгэх итгэл
- Цэцэрлэгийн багшийн хүүхдэд анхаарал хандуулах, итгэлцлийн харилцаа

Судлаачид дасан зохицохуйн гурван түвшинд авч үзсэн байдгийг дараах хүснэгтэд авч үзье.

*Хүснэгт 2. Хүүхдийн дасан зохицох түвшин*

Дасан зохицох чадвар сайн	Дасан зохицох чадвар дунд	Дасан зохицох чадвар сул
<ul style="list-style-type: none"> <li>– 10-15 хоногийн дотор хүүхэд хэвийн байдалд орж хамт олны дотор биеэ чөлөөтэй авч явж, өвдөх, хямрах байдал бага байна.</li> <li>– Хичээлийн агуулга хөтөлбөрийг хялбархан бүрэн эзэмшинэ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>– Ахиц дэвшил нь сарын дотор хэвийн байдалд орж, жин нь түр зуур хасагдаж, “өвдөх” болон сэтгэл санааны бага зэргийн хямралаар илэрнэ.</li> <li>– Цэцэрлэгт явахдаа дургүйцдэггүй.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>– 2-6 сар үргэлжилдэг. Энэ үед хүүхэд байн байн өвдөх, дадал болсон зүйлээ мартаж, биеийн болон сэтгэл санааны хямралд ордог.</li> <li>– Цэцэрлэгтээ явах дургүй.</li> <li>– Сэтгэл зүйн хувьд дарамттай.</li> </ul>

<ul style="list-style-type: none"> <li>- Төвөгтэй асуудлыг шийдвэрлэнэ.</li> <li>- Хичээнгүй, багшийн заавар тайлбарыг анхаарч сонсоно. Хяналт шаардлагагүйгээр үүрэг даалгаврыг биелүүлнэ.</li> <li>- Цэцэрлэгт явах дуртай, багшийн шаардлагыг зохистой хүлээж авна.</li> <li>- Бие даан ажиллах чадвар сайн.</li> <li>- Нийгмийн идэвх өндөр, хариуцлагатай уриалгахан байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Багш хичээлийг дэлгэрэнгүй, дүрслэлтэй заахад ойлгож авна.</li> <li>- Томчуудын хяналт дор даалгаврыг анхааралтай хийж гүйцэтгэнэ.</li> <li>- Зөвхөн сонирхолтой зүйлд төвлөрнө.</li> <li>- Ангийн олон хүүхэдтэй нөхөрлөнө.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Ангийн дүрэм журмыг дагаж мөрдөхгүй.</li> <li>- Багшийн тайлбарласан зүйлийг хэсэгчлэн ойлгоно.</li> <li>- Бие дааж ажиллах чадвар сул, аливаа даалгаврыг хяналт дор гүйцэтгэнэ.</li> <li>- Багш эцэг эхийн зүгээс тогтмол хяналт тавих, байнга сануулах, тусламж шаардлагатай.</li> <li>- Дотно найз нөхөдгүй, цөөн тооны хүүхдийн нэрийг мэднэ</li> </ul>
---	--	--

Түүнчлэн хүүхдийн бие махбод, өөрийгөө илэрхийлэх, орчноо мэдрэх чадвар, гэр бүлдээ эзлэх байр суурь, гэр бүлийн уур амьсгал зэрэг нь дасан зохицолд нь нөлөөлдөг. Оюун ухааны хөгжил сайтай, сэтгэл хөдлөлийн хувьд тогтвортой хүүхдэд дасан зохицоход бэрхшээл тулгардаггүй бол сэтгэл хөдлөлийн тогтворгүй хүүхдүүдэд хүндрэлтэй байдаг.

Хүүхдийн хувийн онцлог, гэр бүлийн соёл, дадал зэргээс шалтгаалан шинэ нөхцөлд дасан зохицох чадвар нь харилцан адилгүй өөр өөр байдаг ч дасан зохицох тодорхой үе шатыг туулдаг. Тухайлбал, З.Фрейдийн онолоор хүүхэд хуучин байдлаа хадгалан үлдэхийг хичээдэг учраас шинэ нөхцөлд дасан зохицохдоо түгшүүрийн үе, дайчлах үе, дасан зохицох эсвэл үл дасан зохицох гэсэн 3 үе шатыг дамждаг бөгөөд дасан зохицохын тулд хичээж, тайван юм уу тэнцвэртэй байдлыг олж авахыг хичээдэг гэж үздэг байна. Үүнд:

*Түгшүүрийн үе:* Энэ үе шат нь айх, түгших, сандрах, зөрүүдлэх, зэрэг сэтгэл санааны тогтворгүй байдлаар илэрдэг. Энэ үед хүүхдэд дарамттай мэдрэмж зонхилж, жин нь хасагдах, хоолонд дургүй болох, ойр ойрхон өвдөх, дадал болсон зүйлээ мартах, дүрэм журам зөрчих зэрэг шинж тэмдэг болно. Энэ үе шат хүүхдийн дасан зохицох чадвараас шалтгаалан харилцан адилгүй хугацаанд үргэлжилнэ.

*Дайчлах үе:* Энэ үе шат нь сэтгэл санаагаа тайвшруулах, айдсаа даван туулах, бусдыг дуурайх, өөрийгөө танин мэдэх, өөртөө итгэлтэй болох, бусдад итгэх зэрэгт хүчин чармайлт гаргах үе. Хүүхдийн өсөлт хөгжил удаашралтай тэнцвэрийн энэ үе шат 3-5 сар үргэлжилнэ. Энэ үед хүүхдүүд өөрийн бие махбодыг дээд зэргээр дайчилна.

*Дасах эсвэл үл дасах үе:* Энэ шатанд хүүхэд маш хурдтай хөгжиж, өмнөх удаашралыг нөхөж гүйцдэг. Хэрэв хүч нөөцөө хэчнээн дайчлаад нөлөөллийг даван туулж чадахгүй бол үл дасах байдалд орно. Ийм тохиолдолд хүүхдийн сурч, хөгжих боломжид саатал гарах магадлалтай. Харин дасан зохицлын хувьд хэвийн хүүхдүүд шинэ чадвар, дадал эзэмших авьяас билгээ хөгжүүлэх явцдаа асар их сэтгэл ханамж авч цэцэрлэгтээ дасан зохицож, суралцах чадвар нь илүү байдаг ажээ.

Цэцэрлэгийн бүлгийн багшаас хүүхдийн дасан зохицож буй чадварыг өглөөний хүлээн авалтын үед 14 хоногоос дээш хугацаанд хүүхдэд илрэх шинжийг ажиглан тэднийг орчинд нь дасгахад тусламж дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

## 2.2. Сургалтын хөтөлбөрийн арга зүйтэй уялдах онол

Сургалтын хөтөлбөрийг суралцахуйн загварын онол, бодит суралцахуйн онол болон конструктивист онолд суурилж боловсруулахыг Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд тусгасан.

Зан үйлийн болон танин мэдэхүйн онолууд нь хүүхдийн хувийн болон ялгаатай суралцахуйд нөлөөлдөг гэдгийг хүлээн зөвшөөрдөг хэдий ч хоорондоо ялгаатай хоёр хүчин

зүйлийг илүү чухалчилж үздэг. Тухайлбал, зан үйлийн онолууд нь хүрээлэн буй орчны нөлөө, ялангуяа өдөөлт ба сэдэлжүүлэлтийн онцлог, түүний зохион байгуулалт, хэлбэр, мөн хүүхдийн үзүүлэх зан үйлд багшийн хариу үйлдэл, орчныг онцгой чухалчилдаг (Dale, 2012). Зан үйлийн онолын гол төлөөлөгчид нь Джон Ватсон (John Watson), Б.Ф.Скиннер (B.F.Skinner) нар бөгөөд тэд зан үйлийн зөв дадал төлөвшихөд дотоод сэтгэлгээ бус, орчны нөлөө чухал үүрэгтэй гэж үзээд нөхцөлт үйл, эерэг хариу үйлдлээр хүүхэд эерэг зан үйлд суралцана гэж үзжээ. Энэ онолын үүднээс суралцах үйл, дадал нь орчноос ирэх хариу үйлдлийн үр дүн хэмээн үздэг ба эерэг, сөрөг хариу үйлдэл, давталт нь хүүхдийн суралцах зан үйлийг бэхжүүлэх ба энэ нь хүүхдийн сурах хандлага, оролцоонд шууд нөлөөлдөг (Schindler et al., 2019). Өөрөөр хэлбэл, хүүхэд орчноос ирэх нөлөөлөл буюу орцоор суралцах үйлд сэдэлждэг бөгөөд эдгээрийг хүүхэд хэрхэн боловсруулдаг үйл явцыг танин мэдэхүйн онол тайлбарладаг.

Танин мэдэхүйн онолууд нь хүрээлэн буй орчноос ирэх хариу үйлдэл нь хүүхдийн суралцахуйд нөлөөлдөг гэдгийг хүлээн зөвшөөрдөг (Dale, 2012). Багшийн мэдээлэл, өдөөлт, сэдэлжүүлэлт, үйл ажиллагаа, зааварчилгаа, хүүхдийн асуулт, хүсэлтэд өгөх багшийн хариу үйлдэл зэрэг нь хүүхдэд орчноос ирж буй суралцахуйн орц юм. Эдгээр орцууд нь хүүхдэд суралцах чадварыг бүрэн өгдөггүй (David et al., 2015). Танин мэдэхүйн онолын гол төлөөлөгч нь Ж. Пиаже, Ж. Брунер нар бөгөөд хүүхэд орчноо хүртэж, танин мэдэхдээ оюуны идэвхтэй үйл хийдэг. Харин тэдгээрийг хүүхэд ажиглах, дуурайх, давтах, залруулах зэрэг идэвхтэй үйлээр боловсруулж байдаг нь суралцахуйд хөтөлж, чиглүүлж байдаг. Хүүхэд орчноос ирж буй орцыг (багшийн мэдээлэл, өдөөлт, сэдэлжүүлэлт, үйл ажиллагаа, зааварчилгаа, хүүхдийн асуулт, хүсэлтэд өгөх багшийн хариу үйлдэл зэрэг) анхаарах, ажиглах, дүрслэх, хувиргах, кодлох, хадгалах, өөрт шинэ мэдлэгийг бүтээх нь чухал юм. Өөрөөр хэлбэл, танин мэдэхүйн онолууд нь хүүхдийн өөрийнх нь сонирхол, бодол санаа, итгэл үнэмшил, хандлага, үнэт зүйлсийн үүргийг чухалчилдаг.

Дээрх хоёр чиглэлийн онолоос гадна хүүхдийн сурах арга барил, хандлага төлөвшихөд чиглэсэн конструктивист (Constructivist) онолууд нь хүүхэд мэдээлэл хүлээн авагч бус, мэдлэгийг өөрийн үйл ажиллагаа, туршлагаар бүтээгч хэмээн үздэг, хүүхдийг идэвхтэй суралцагч хэмээн үздэг. Конструктивист онолчид шинжлэх ухааны цор ганц, туйлын үнэн байдаг гэсэн ойлголтоос татгалзаж, үнэн олон талтай, эргэлзээтэй үнэнийг олон янзаар нээж, баталж болно хэмээн үздэг (Dale, 2012). Энэ олон талт үнэнийг илрүүлэх арга зам нь асуулт тавих, ажиглах, асуудлыг олж харах, бодох, уялдаа холбоог олох, шийдвэр гаргах зэрэг идэвхтэй үйл ажиллагаа юм. Энэ идэвхтэй үйл ажиллагаа нь хүүхдийн тоглох үйл юм. Хүүхэд тоглонгоо ертөнцийг танин мэдэх, төсөөлөн бодох, нийгэмших, хэл ярианы чадвараа хөгжүүлдэг. Тоглонгоо юмс үзэгдлийн мөн чанар, логик уялдааг ойлгож, асуудлыг олж харах, шийдэх чадвартай болдог.

Аливаа үйл ажиллагааг хүүхэд өөрийн хүсэл сонирхлоор, зорилготой, сонголтоор хийх (үүнийг хүүхэд төвт үйл ажиллагаа гэж хэлдэг) ба багш орчныг сонирхолтой байдлаар төлөвлөж, зохион байгуулах, хүүхдийн үйл ажиллагааг ажиглах, чиглүүлэх, шаардлагатай дэмжлэгийг үзүүлнэ. Энэ нь хүүхэд өөрийн хурдаар тааваараа, сонирхолдоо хөтлөгдөн, учир утга зорилготой үйл ажиллагаанд оролцох, улмаар бие даасан байдал, шүүмжлэлт сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх чадварт суралцах боломжийг бүрдүүлдэг (Farquhar & White, 2014). Конструктивист онолын гол төлөөлөгчид нь Ж. Пиаже, Ж. Брунер, Л. С.Выготский нар юм. Тэд хүүхдийн идэвхтэй оролцоотой, бодит орчны утга учиртай үйл ажиллагаа, хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон үйл ажиллагаа, хүүхдийн суралцахуйд нийгэм соёлын үзүүлэх нөлөө зэрэг дээр санаа нийлдэг.

Бага насны хүүхдийн суралцахуйг дэмжих, хөтлөн чиглүүлэхэд багшийн анхаарах зүйлсийг суралцахуйн онолтой холбон үзье.

## Хүснэгт 2. Суралцахуйн онол

Суралцахуйн онол	Зорилго	Багшийн үйл ажиллагаа
Зан үйлийн онол	Хүүхдийн суралцах үйл ажиллагааг сэдэлжүүлэх, нөлөөлөх (суралцахуйн орц)	Хүүхдэд эерэг зан үйл төлөвшихөд чиглэсэн давтамжтай, эерэг хариу үйлдэлт, чиглүүлэгтэй орчин бүрдүүлэх. Хүүхдийн зан үйлд тохирсон эерэг хариу үйлдэл (урамшуулал, чиглүүлэг, дэмжлэг гэх мэт) үзүүлэх, сөрөг зан үйлийг залруулах. Эерэг зан үйлийг давтах, бататгах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, үр дүнг ажиглах, үнэлэх.
Танин мэдэхүйн онол	Хүүхдийн суралцахуйг идэвхжүүлэх, суралцахуйн дадал хөтлөх (мэдээлэл боловсруулах, суралцах үйл явц)	Хүүхдийн сэтгэхүйн хөгжлийг дэмжих нээлттэй асуулт асуух, сорилттой дасгал даалгавар өгөх. Хүүхдийн анхаарах, ажиглах, дүрслэх, төсөөлөх, илэрхийлэх, дүгнэх үйлийг дэмжсэн үйл төлөвлөх. Суралцах үйл ажиллагаанд багш мэдээлэл дамжуулагч бус, чиглүүлэгч, хамтрагч байх.
Конструктивист онол	Хүүхдийн сурах арга барил эзэмшихэд чиглүүлэх, суралцах хандлага төлөвшүүлэх (суралцахуйг хөтлөх үйл, үр дүн)	Хүүхдийн идэвхтэй үйл ажиллагаа, оролцоог дээдэлсэн, бие даан мэдлэг бүтээх орчныг бүрдүүлэх (зохиолд суурилсан, тоглоход суурилсан, төсөлд суурилсан, судлан шинжлэх). Хүүхдийн хүсэл сонирхолд тулгуурласан, утга учиртай, зорилготой үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах. Хамт олонтойгоо харилцах боломжийг нэмэгдүүлэх, хамтын суралцахуйг дэмжих.

Бага насны хүүхдийн хөгжил, суралцахуйг дэмжихдээ багш зан үйлийн, танин мэдэхүйн, конструктивист онолуудад тулгуурлах нь багшлах үйл ажиллагаа үр дүнтэй болох шинжлэх ухааны үндэслэл болно. Хүүхдийн зан үйлд тохирох эерэг хариу үйлдэл үзүүлэх, оюуны болоод нийгэмшихүй, сэтгэл хөдлөл, бие даасан бүтээлч сэтгэлгээг дэмжих нь суралцах үйл ажиллагааг хүүхдийн хөгжлийн онцлогт нийцүүлэн үр дүнтэйгээр удирдахад чухал ач холбогдолтой. Иймээс суралцахуйн онолуудын уялдаа холбоог ойлгож, багшлах үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх нь багшийн мэргэжлийн чадамжийн нэг чухал бүрэлдэхүүн болдог.

### 2.3. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүйн талаарх дараах чиглэлийг тусгасан. Үүнд:

- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд суралцагчийн хөгжлийн онцлогт нийцүүлэн суралцахуйн загварын, бодит суралцахуйн, конструктивист болон хувилбарт сургалтын онолын үндсэн дээр боловсруулсан сургалтын идэвхтэй аргыг хэрэглэнэ.
- Сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан сургалт, үйл ажиллагаанд тоглоом, зохиол, шинжлэн судлах, төсөлд суурилсан арга зүйг хүүхдийн насны онцлог, эзэмших чадамж суралцахуйн үр дүн, сургалтын чиглэлийн онцлогтой холбон бүтээлчээр хэрэглэнэ.
- Монгол суралцагчийн цогц чадамжийг төлөвшүүлэхэд суралцахуйн чиглэлийн онцлог бүрийн оруулах хувь нэмрийг тусгасан бөгөөд үүнийг нэгдмэл уялдаатай, хүүхэд төвтэй байхуйц суралцахуйн арга зүйгээр зохион байгуулна.

Сургуулийн өмнөх 4-5 настай хүүхэд буюу цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлэгт хэрэгжүүлэх арга зүйн онцлогийг авч үзье.

**Тоглоомд суурилсан арга зүй:** Бага насны хүүхэд, тэдний суралцахуйн талаарх үзэл онолын, судалгааны чиг хандлагын ихэнх бүтээлүүдэд, хүүхэд тоглонгоо суралцаж, бусадтай

харилцах, ойлголтоо хөгжүүлэх зэрэг суралцахуйн ашиг тус үлэмж их талаар авч үзсэн байдаг. Тухайлбал, Жан Линда Гиллепси–ийн “хэзээ ч зүгээр тоглодоггүй” номд тайлбарласнаар тоглох нь хүүхдэд суралцах, юмсыг таних, мэдрэх, хөгжлийн онцлогт тохирсон хамгийн үр дүнтэй арга гэсэн байна.

Тоглоомд суурилсан арга зүйн онцлог нь хөгжилтэй, сонирхолтой, бүтээлч, идэвхтэй оролцоотой, хамтын ажиллагаатай байх явдал.

Тоглоомын явцад дөрөв, таван настай хүүхдүүд идэвхтэй хөдөлгөөн хийж, оролцсоноор тэдний хүч чадал, хурд, тэнцвэр, авхаалж самбаа, уян хатан чанар хөгждөг. Тиймээс багш нь хүүхдүүдтэй хамт тоглохдоо тэдний оролцоо, бүтээлч байдлыг урамшуулж, тоглох явцдаа суралцах үйлийг дэмжинэ. Тоглоомд суурилсан арга зүйн суралцахуйн үйлийн явцад насанд хүрэгчид хүүхдийн өмнөөс асуудлыг шийдвэрлэхийн оронд тэднийг аливаа зүйлийн учрыг олоход нь тусалж үгээр урамшуулан дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Тоглоом, үйл ажиллагааны явцад багшийн тохиромжтой зөв урамшууллын дараа хүүхэд өөрийгөө үнэлэх сайн үйл хийснээрээ бахархах, өөртөө итгэх итгэл нь нэмэгдсэнээр “зөөлөн ур чадвар”-ын эх үндэс тавигдана.

Тоглоомд суурилсан арга зүй нь дөрөв, таван настай хүүхдэд насанд хүрэгчдийн зан үйлийг дуурайн тоглох, бусдыг халамжлах, аврах, зэмлэх боломжийг олгож, эдгээр зан үйлд тулгуурласан тодорхой дүр бүтээхийг дэмжинэ. Дөрөв, таван настай хүүхдүүд тоглоомын дүрийг сонгох, тухайн дүрд хувиран тоглохдоо түүний хэлдэг, үг, хийдэг үйлдлийг дуурайх замаар үгийн баялаг нэмэгдэж, хүмүүсийн хийдэг үйлийг сурч, нийгмийн амьдралыг тоглоомоор дамжуулан ойлгож эхэлдэг.

Анхаарлын төвлөрөлт, зориудын анхаарал сайжирч, дуу шүлэг, үлгэр богино өгүүллэгийн утгыг ойлгож, сэргээн ярьж чадах тул тоглоомд суурилсан суралцахуйгаар дамжуулан дэмжих боломжтой. Заримдаа өөрсдийн мөрөөдөж буй хүсэл, авах гэсэн зүйлээ илэрхийлэхдээ “худлаа, зохиож” ярих нь олонтоо. Гэхдээ сэтгэл судлаачид хүүхдийн энэ зан үйлийг “буруу” гэж үздэггүй. Учир нь энэ нь хүүхдийн сониуч зан, бусдыг дуурайх гэсэн хүсэл, гэнэн цайлган зантай холбоотой.

Түүнчлэн хүүхдийн дүрслэн бодохуй нэлээд хөгжсөн байх тул бэлэн тоглоом наадгайгаас гадна байгалийн материал, ахуйн хэрэглээний зүйлийг ашиглан тоглож чадна. “Айл гэр”, “Дэлгүүр” зэрэг сэдэвт тоглоомын явцад ахуйн хэрэглээний эд зүйлсийг ашиглан тоглох, өрж байгуулах, эвлүүлж угсрах зэргээр тоглоомынх нь нэр төрөл, хүрээ өргөжнө. Тиймээс багш Та бүлгийн сургалт, үйл ажиллагаанд тоглоомд суурилсан арга зүйг зохион байгуулахдаа дээрх онцлогийг харгалзан үзэхээс гадна хүүхэдтэйгээ хамтран тоглохдоо тэд ямар төрлийн тоглоом сонирхож байгаа болон сонирхохгүй байгааг ажиглах, цаашид хэрхэн хөгжлийг нь дэмжих гарцаа ч олж харах боломжтой. Мөн бүлгийн сургалт, үйл ажиллагааг тоглоомыг бусад арга зүйтэй хослуулан, тухайлбал, зохиолд, шинжлэн судлахад, төсөлд суурилсан арга зүйтэй хослуулсан хэлбэрээр зохион байгуулж болно.

**Зохиолд суурилсан арга зүй.** Үлгэр ярих нь бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих үр дүнтэй үйл ажиллагааны нэг юм. Олон улсад бага насны хүүхдийг хөгжүүлэхэд зохиолд суурилсан (Story-based learning), үлгэр өгүүллэг ярих (Storytelling) гэсэн хоёр арга зүйг өргөн хэрэглэдэг. Эдгээр нь үлгэр, зохиол ашиглахаас гадна хүүхдийн өөрийн өгүүлэмж яриаг суралцах үйлийн эх сурвалж болгон ашигладаг онцлогтой. Зохиолд суурилсан арга зүй нь зөвхөн үлгэр, зохиол, хүүхдийн яриа, өгүүлэмжийг сонсож, ярихын дээр тэдгээрийн дүр, үйл явдал, юмс үзэгдлээр хүүхдийг сэдэлжүүлэх, суралцах үйлийг бодит амьдралтай уялдуулах гүүр болгож ашигладгаараа онцлог арга юм. Хүүхэд үлгэр, өгүүллийг сонсох үедээ анхаарлаа төвлөрүүлж, дүрүүдийг өөрөөрөө төсөөлж уран сэтгэхүйгээ хөгжүүлж, баярлах, гуниглах, санаа зовних зэрэг сэтгэл хөдлөлийн хариу үйлдэл гаргах, бусдын мэдрэмжийг ойлгох эхлэл болдог. Багш, хүүхэд үлгэр зохиол, өөрт тохиолдсон явдлаа ярихын зэрэгцээ асуулт асууж харилцан ярилцах, үлгэрийн дүрд тоглох, дүр үйл явдлыг урлан

бүтээх, үлгэрийн төгсгөлийг өөрийнхөөрөө бодож бүтээх зэрэг идэвхтэй үйл ажиллагаанд оролцдог. Ингэснээр хүүхэд мэдээлэл хүлээн авах бус, мэдлэг “бүтээж” суралцах боломжтой болдог.

Зохиолд суурилсан арга зүйг хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан хэрэглэх нь багшлахуй, суралцахуйг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зохион байгуулах гол нөхцөл болдог. 4–5 настай хүүхэд нь үлгэр, зохиолын дүрийн зан үйл, сэтгэл хөдлөл, үйл явдлын учир шалтгааны холбоог ойлгох, баатрын үйлдлийг дуурайж туршиж үзэх, дүрийн гаргасан зан үйлийг судлах, тайлбарлах чадвартай болдог. Мөн үйл явдлын дэс дарааллыг ойлгож, таамаглах чадваруудыг эзэмшдэг. Зохиолын дүр ба үйл явдлаар дамжуулан хүүхэд танин мэдэхүй, хэл яриа, сэтгэл хөдлөл, нийгэмшихүй, харилцааны чадваруудаа сайжруулж байдаг. Мөн үлгэрийн үйл явдлыг өргөн хүрээтэй, учир шалтгааны уялдаатай ойлгож, дүрүүдийн зан үйлд дүгнэлт хийх, хамтдаа мэдлэг бүтээх чадвар эзэмшдэг.

### **Зохиол сонгоход анхаарах зүйлс**

1. Зохиолын үйл явдал бага зэрэг ээдрээтэй байж, 2–3 үйл явдал болон үр дагаврын холбоог агуулсан байх.
2. Үйл явдал, үг хэллэгийн давтагдсан хэсэгтэй, шүлэглэл, ритмтэй хэсэгтэй байх нь хүүхдийн анхаарлыг татах, хэлний уран яруу хэллэгт суралцахад тустай.
3. Дүрийн сэтгэл хөдлөл тод илэрхийлэгдсэн, баатрын зан үйл, шийдвэр ойлгомжтой.
4. Дуу авиа, бие болон гарын хөдөлгөөн ашиглах боломжтой байх.
5. Ном сонгох бол дүрийн зураг илүү ойлгомжтой, үйл явдлын логик холбоо дүрслэгдсэн байх.

### **Хэрэгжүүлэх үе шат**

4-5 насны ахлах бүлэгт зохиолд суурилсан арга зүйг дараах ерөнхий бүтцийн дагуу хэрэгжүүлж болно. Үүнд:

1. *Зохиолтой танилцах үе шат*: Зохиол сонсох, дүрүүд, үйл явдал, баатрын зан үйл, шалтгаан-үр дагаврыг ойлгож танилцах.
2. *Давтах үе шат*: Өөр хэлбэр, зохион байгуулалттайгаар (асуулт, хөдөлгөөн, дүрслэл) зохиолтой дахин танилцах.
3. *Дүрд тоглох, бүтээлчээр оролцох үе шат*: Хүүхэд зохиолын баатрын дүрд орж, үйл явдлын өөр хувилбар санал болгох, дүрийн зан чанар, шийдвэрийг туршиж үзэх.
4. *Суралцахуйн чиглэлийн интеграцчилал*: Зохиолтой танилцсан, дүр ба үйл явдлыг мэддэг болсон үед бусад сургалтын чиглэлтэй холбох. Дасгал даалгавар, зураг, тоо, хэл ярианы дасгалд зохиолын дүр, үйл явдал, юмс үзэгдлийг ашиглах.

### **Арга зүйн зөвлөмж**

- **Зохиол ярих**: Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан, удаан, энгийн үгсээр, хүүхэд бүрийн **ойлгох түвшин, анхаарал төвлөрөх чадварт нийцүүлэн** ярина. Давтан ярихдаа жүжиглэх, орчин, хэрэглэгдэхүүнээр баяжуулах нь анхаарлыг нэмэгдүүлнэ.
- **Хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх**: Зохиолыг давтан ярих үйл ажиллагаанд хүүхэдтэй хамтарсан, хэсэгчилсэн байдлаар зохиолыг ярина. Зохиолын дүр, үйл явдал, юмс үзэгдлийн онцлог шинж байдлын талаар тойргийн цаг болон чөлөөт цагаар танин мэдэхүйг дэмжих ярилцлага хийх, асуудал дэвшүүлсэн эргэцүүлэл хийх зэргээр хүүхдийн логик сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх, эрэл хайгуул хийх чадварыг дэмжих боломжтой.
- **Хөдөлгөөнт тоглоом, үйл хөдлөлтэй хослуулах**: Амьтны дуу авиаг дуурайх, баатрын хөдөлгөөнийг дуурайсан дасгал тоглоомыг тоглуулах, ийм тоглоомыг хүүхдээр зохиолгох зэрэг нь хүүхдэд зохиолын агуулгыг ойлгоход дэмжлэг үзүүлэхээс гадна бүтээлч сэтгэлгээг хөгжүүлнэ.
- **Сургалтын чиглэлтэй интеграцчилал**: Зохиолын дүр, үйл явдал, юмс үзэгдлийг ашиглан бусад сургалтын чиглэлийн чадварыг уялдуулан дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах нь хүүхдийн танин мэдэхүйн хүрээг тэлж, дүр, үйл явдлыг эргэн санах, тэдгээрийн уялдаа холбоог ойлгоход тусална.

**Шинжлэн судлахад суурилсан арга зүй:** Бага насны хүүхэд орчиндоо буй эд зүйлс, ургамал, мал, амьтан, хүмүүс болон үйл явдлыг ажиглаж, мэдэрч, судалснаар байгаль, нийгмийн орчны холбоо хамаарал, учир шалтгааныг танин мэдэж, аливааг сонирхон шинжлэн судлах арга барилд суралцах суурь болдог.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд шинжлэн судлахад суурилсан арга зүйг "Суралцагч судлах зүйлийнхээ талаар асуулт асуух, таамаглал дэвшүүлэх, туршилтыг төлөвлөх, сорил туршилтыг гүйцэтгэх, юмс үзэгдлийн зүй тогтол, харилцан хамаарлын учир шалтгаан, сорил туршилтын үр дүнг илэрхийлэх, тайлбарлах, үнэлэх, үр дүнгээс дүгнэлт гаргах мэдлэг, чадварыг дэмжих системтэй арга зүй"<sup>1</sup> гэж тодорхойлсон.

Шинжлэн судлахад суурилсан (ШСС) арга зүй нь асуулт асуух, ажиглах, мэдээлэл цуглуулах, баримт нотолгоонд тулгуурлан хамтран дүгнэлт гаргах замаар эргэцүүлэн бодох сэтгэлгээг хөгжүүлж, хүүхдэд төрөлхийн сониуч зангаараа асуудлынхаа шийдлийг хайж, өргөн хүрээнд сэтгэн бодоход тусалж, суралцах үйл явцыг илүү сонирхолтой болгодог.

Сургуулийн өмнөх насны хүүхдэд тоглоомд суурилсан арга зүйтэй шинжлэн судлах арга зүйг хослуулан хэрэгжүүлэхэд тохиромжтой байдаг. Учир нь шинжлэн судлах арга зүй нь тоглоомд суурилсан арга зүйг баяжуулж, илүү сонирхолтой, идэвхтэй суралцах орчин бүрдүүлэхэд нөлөөлдөг. Шинжлэн судлахад суурилсан арга зүй нь цэцэрлэгийн бүх бүлэгт хэрэгжих боломжтой бөгөөд 2–3 насанд мэдрэхүйн орчин, тоглоомоор дамжуулан суурийг нь тавьж, 4–5 настайд өргөжүүлэн чиглүүлэгтэй болон бие дааж шинжлэн судлах үйл ажиллагаагаар хөгжүүлэх нь оновчтой.

*Шинжлэн судлахад суурилсан арга зүйн онцлог*

№	Онцлог	Жишээ
1	Хүүхдийн сониуч байдал, асуух, судлах, нээх, олох, төрөлх зан чанарт тулгуурладаг.	3 настай хүүхэд цэцэрлэгийн гадаа шувуу хараад "Яагаад шувуу нисдэг юм бол?" гэж асууж, багштайгаа хамт хариултыг хайдаг. Энэ нь хүүхдийн төрөлхийн сониуч занг дэмжиж байна.
2	Хүүхдийн шүүмжлэлт сэтгэлгээ, бүтээлчээр сэтгэх чадамж хөгждөг.	Хүүхэд навчсыг ажиглаж "Энэ навч яагаад хурдан унасан бэ? хоёр төрлийн навчны ялгааг ажиглаж, таамаг дэвшүүлэн өөр өөр нөхцөлд туршилт хийж үздэг.
3	Хүүхэд өөрөө асуулт тавьж, хариултыг олох үйл явцад идэвхтэй оролцсоноор бодит ойлголт, гүнзгий мэдлэг бий болдог.	Хүүхэд ус хэрхэн уур болж хувирдаг талаар өөрсдөө ус буцалгах туршилт хийж оролцсоноор илүү гүнзгий мэдлэгтэй болдог.
4	Хүүхдүүд өдөр тутмын амьдралд тулгардаг асуултуудад хариу олох замаар орчноо илүү сайн ойлгож сурдаг.	Хүүхэд "Яагаад унтраалгыг асаахад гэрэл гардаг вэ?" гэсэн асуултыг эцэг эх, багштайгаа ярилцан ойлголтоо нэмдэг.
5	Хүүхдэд бэлэн мэдлэг өгөхөөс илүүтэй өөрөө мэдлэг бүтээх суралцагч байхыг зорьдог.	"Шувуу нисдэг учир нь ..." гэж тайлбарлахын оронд, шувуудыг ажиглуулах замаар хүүхэд өөрөө мэдлэг бүтээх үйлийг дэмждэг.
6	Хүүхдийн ажиглах, харьцуулах, таамаг дэвшүүлэх, турших, дүгнэх чадвар хөгждөг.	Модны навчсыг янз бүрийн өнцгөөс ажиглаж, навчнуудын өнгө, хэлбэр, хэмжээг харьцуулан Энэ навч илүү нимгэн учраас хурдан хатна.
7	Хүүхдийг бие даасан, хариуцлагатай суралцагч болгон төлөвшүүлдэг.	Хүүхэд өөрийн ургуулж байгаа ургамлаа услах, арчлах ажлыг хариуцлагатай хийж, үр дүнг өөрөө анзаарч, тайлбарладаг.

### Шинжлэн судлах арга зүйн төрлүүд

Шинжлэн судлахад суурилсан арга зүй нь дараах гурван төрлийн хэлбэртэй бөгөөд эдгээр нь хүүхдэд хэр зэрэг чиглүүлэг, бүтэцтэй орчин санал болгож байгаагаар ялгагдана.

1. **Бүтэцтэй шинжлэн судлах:** Тогтсон үе шаттай. Багш тодорхой асуудал, чиглэлийг өгч, хүүхдүүдийг алхам бүрд чиглүүлдэг. Ихэвчлэн байгаль, нийгмийн орчин сургалтын чиглэлд ихэвчлэн ашигладаг

<sup>1</sup> Монгол Улсын Засгийн газар. (2024). Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал (2024-2036). Цахим холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140353213781>

2. **Чиглүүлэгтэй шинжлэн судлах:** Багш хүүхдүүдтэй хамт судлах асуултыг гаргаж, бодит асуудлын шийдлийг олоход хүүхдэд тусалдаг.
3. **Нээлттэй шинжлэн судлах:** Хүүхдүүдэд өөрсдийн сонирхсон сэдвийнхээ талаар асуудал дэвшүүлж, судалгаа хийж, шийдэл олох боломжийг олгодог, илүү чөлөөтэй хэлбэр юм. Ихэвчлэн нийгэм-сэтгэл хөдлөл сургалтын чиглэлд ашигладаг.

Хүснэгт 3. Шинжлэн судлахад суурилсан арга зүйн үе шат

Үе шат	Хүүхдийн хийх үйл	Багшийн дэмжлэг
<b>Оролцох үе шат</b> Энэ нь хүүхдэд урам зориг өгөх үе бөгөөд тэдний өмнөх мэдлэгийг сэргээн сануулах зорилготой юм.	<ul style="list-style-type: none"> <li>- Ажиглах</li> <li>- Асуулт асуух</li> <li>- Таамаглал дэвшүүлэх</li> </ul>	<i>Асуултаар эхлэх</i>
		Асуултаар сургалт, үйл ажиллагааг эхлүүлэх нь үр дүнтэй. Ингэснээр хүүхдүүд сэдвийн талаар эргэцүүлэн бодоход түлхэц өгч, хүүхэд өөрсдөө асуулт асуух, асуултад хариулахад дэмжлэг болно.
<b>Шинжлэн судлах үе шат</b> Хүүхдэд тодорхой суралцах туршлагыг өгч, идэвхтэй эрэл хайгуул хийх боломжийг олгодог.	<ul style="list-style-type: none"> <li>- Төлөвлөх</li> <li>- Мэдээлэл цуглуулах</li> <li>- Туршилт хийх</li> </ul>	<i>Эрэл хайгуул хийхийг зөвшөөрөх</i>
		Сонирхол татсан асуулт, хариултын дараа хүүхдэд бие даан судлах, боломжийг олгох хэрэгтэй. Энэ нь тухайн зүйлээ сайтар ойлгоход тусална.
<b>Тайлбарлах үе шат</b> Хүүхэд ойлголтоо цэгцэлж, эргэцүүлсэн ойлголтоо илэрхийлэх боломжийг олгодог.	<ul style="list-style-type: none"> <li>- Таамаглалаа нотлох</li> <li>- Мэдээллийг шинжлэх</li> <li>- Харилцан ярилцах</li> </ul>	<i>Туршилтын үр дүнг хэлэлцэх</i>
		Хүүхдүүд өөр хоорондоо санал бодлоо хэлэлцэхэд нь урамшуулж дэмжинэ. Ингэснээр хүүхэд тухайн зүйлээ гүнзгийрүүлж ойлгоход тусална.
<b>Нарийвчлан судлах үе шат</b> Сургалтын зорилгоо бусад агуулгатай нэгтгэн илүү сайн нарийвчлан боловсруулна.	<ul style="list-style-type: none"> <li>- Үр дүнг таамаглалтай харьцуулах</li> <li>- Шийдвэр гаргах</li> <li>- Батлах, нотлох</li> </ul>	<i>Хэрэглэгдэхүүн, нэмэлт эх сурвалжаар хангах</i>
		Хүүхэд бие даан судлахад ашиглаж болох эх сурвалж, нэмэлт хэрэглэгдэхүүнээр хангах хэрэгтэй. Онлайн сургалтын платформууд хэрэглэх боломжтой ба хүүхдийн ойлголтыг бататгахад тусалдаг.
<b>Үнэлэх үе шат</b> Багш хүүхдийг үнэлэхээс гадна хүүхдүүд өөрсдийн ойлголтыг үнэлэх боломжийг олгодог.	<ul style="list-style-type: none"> <li>- Ололтоо бусадтай хуваалцах</li> <li>- Үнэлэх</li> <li>- Сайжруулах санал гарах</li> </ul>	<i>Сурсан мэдсэнээ нэгтгэн дүгнэх</i>
		Сургалтын үйл ажиллагааны төгсгөлд сурсан зүйлээ дүгнэх хэрэгтэй. Энэ нь хүүхдүүдэд шинэ мэдээллийг эргэн санахад тусалдаг.

Хүүхэд 4-5 насандаа өөрсдийн сонирхсон зүйлийн талаар ярилцах, таамаглал дэвшүүлж, туршиж үзэх, бүтээлчээр сэтгэх, логик холбоог ойлгох, харьцуулах дүгнэлт гаргах чадварт суралцаж эхэлдэг. Түүнчлэн багаараа судалгаа хийх, дүрд тоглох зэргээр харилцах, хамтрах чадвар төлөвшиж, амжилт, саад бэрхшээлд сэтгэл хөдлөлөө зохицуулах чадвар нь хөгжиж эхэлдэг.

Тиймээс энэ наснаас эхлэн шинжлэн судлах үйл явцыг цогцоор нь буюу асуулт тавих-таамаглах-турших-дүгнэх шатлалаар төлөвлөж болно.

Хүүхдийн тавьсан асуултыг хүндэтгэн сонсож, тэдэнд чөлөөтэй туршиж, шинэ зүйлийг нээх орчныг бүрдүүлэх нь чухал. Туршилтын үр дүн зөв эсвэл буруу гарсан эсэхээс үл хамааран хүүхдийн оролдлого, сэтгэн бодох үйл явцыг урамшуулж дэмжих хэрэгтэй. Ийнхүү урам өгч дэмжлэг үзүүлснээр хүүхэд алдаанаасаа суралцах, дахин оролдож, шалтгааныг эрэлхийлэх сонирхолтой болно. Мөн хүүхдийг ажиглалтаа дүрсээр тэмдэглэж, бусдад

өөрийн санаагаа ярьж тайлбарлах боломжтой байлгах нь тэдний сэтгэн бодох, харилцах чадварыг хөгжүүлнэ.

4-5 насанд шинжлэх ухаанч сэтгэлгээний суурь ойлголтуудыг бага багаар төлөвлөж, хүүхдийн сонирхсон асуудлаар жижиг төсөл, багийн судалгаа зохион байгуулж, дүгнэлтийг зураг, загвар, тайлбар хэлбэрээр илэрхийлэх боломжтой.

Шинжлэн судлах арга зүйг хэрэгжүүлэх хэлбэр:

- Жижиг төслүүд (жишээ: “ус цэвэршүүлэх арга”, “хамгийн бат бөх материал”)
- Өөрийн туршилт, дүгнэлтээ хуваалцах
- Шинжлэх ухаанч арга хэрэглээний суурь тавих (ажиглалт-таамаглал-туршилт хийх-дүгнэлт гаргах)

Хүүхдийн санаачилгыг дэмжиж, туршилт, ажиглалт хийх үйл явцыг олон өнцгөөс харах боломжтой орчин бүрдүүлэх нь чухал. Туршилтын үр дүнгийн зөв буруу байдлаас илүүтэй хүүхдийн сэтгэн бодох чадвар, судалгааны үйл явц, оролдлогыг үнэлж, урамшуулах хэрэгтэй.

### **Арга зүйн зөвлөмж**

Шинжлэн судлахад суурилсан арга зүй нь сургалтын үндсэн үйл ажиллагааны цагт, гадаа тоглох ба байгальтай харилцах үед, чөлөөт тоглоомын цагуудад хамгийн үр дүнтэй хэрэгжих боломжтой байдаг.

Цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааны дараах цагуудад хэрхэн хэрэгжих боломжтойг жишээгээр харуулбал:

#### **1. Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа (Хамгийн тохиромжтой үе-10:00–11:30 орчим)**

- Энэ цагт хүүхдийн анхаарал төвлөрөл, бие махбодын идэвх хамгийн өндөр байдаг.
- Багшийн төлөвлөсөн сургалт, үйл ажиллагаа, шинжлэн судлах ажиглалт, туршилт, туршлага хуримтлуулах үйлдэл хийхэд хамгийн тохиромжтой.

Жишээ үйл ажиллагаа:

- ✓ Ус, элс, гэрлийн материал ашиглан туршилт хийх
- ✓ Хүүхдийн санаачилгыг дэмжиж, байгаль орчныг ажиглах, туршилт хийх, тэмдэглэл хөтлөх, олж мэдсэн зүйлээ ярилцах, бусдад танилцуулах орчныг бүрдүүлэх
- ✓ Асуултын дагуу таамаглал дэвшүүлэх, үр дүн ажиглах
- ✓ “Хэрвээ ... бол яах вэ?” гэх асуудал шийдэх тоглоом тоглох

#### **2. Гадаа тоглох, зугаалгын цаг (Шинжлэн судлах үйлд нээлттэй орчин-11:10–11:45 орчим/ 16:30–17:00 орчим)**

- Хүүхэд байгалийн объект (ургамал, шавж, чулуу, салхи, сүүдэр, цас гэх мэт)-той шууд харьцаж, туршиж үзэх боломжтой.
- Бие даан ажиглаж, нээх, харьцуулах, сонирхсон зүйлийнхээ талаар асуух боломжтой.

Жишээ үйл ажиллагаа:

- ✓ “Шавж яагаад мөөгөн дээр суудаг юм бол?” гэх мэт байгаль дээр суурилсан ажиглалт
- ✓ Цэцэг, модны навчны хэлбэрийг харьцуулах
- ✓ Шавар, элсээр барилга, байгууламж хийх туршилт
- ✓ Цаг агаарын өөрчлөлтийг мэдэрч, дүгнэх, тэмдэглэх

#### **3. Бие даан тоглох, бүтээх цаг (Хүүхдийн санаачилга, сониуч байдлыг дэмжих орон зай-чөлөөт тоглоомын үе – өглөө/өдөр/орой)**

- Хүүхэд өөрөө санаачлан нээлт хийх, турших, оролдож үзэх боломжтой
- Багш хүүхдийг ажиглаж, хэрэгтэй үед бодит дэмжлэг үзүүлэх боломжтой.

Жишээ үйл ажиллагаа:

- ✓ Тоглоомын сүүдрүүд яагаад өөр өөр урттай байна вэ?” туршилт хийх
- ✓ Усыг янз бүрийн саванд хийгээд ялгаа ажиглах
- ✓ Гэр барих тоглоомын явцад байгууламжийн бүтцийг турших

**Төсөлд суурилсан арга зүй:** Иоганн Генрих Песталоццийн сургаснаар “Толгой, зүрх, гар”-аа нийлүүлэн оюуны болон биеийн хөдөлмөрийг хослуулан суралцахыг энэхүү арга зүйгээр эзэмшдэг. Төсөлд суурилсан арга зүй нь эцсийн бүтээгдэхүүнээс илүүтэй үе тэнгийнхэн эсвэл бусадтай харилцах, суралцах үйл явцад төвлөрдөг.

Төсөлд суурилсан аргазүй нь:

- Төслөөр дамжуулан мэдлэг, чадвар, компетенци бүтээх, эзэмших зорилготой.
- Хамтдаа суралцах, багаар ажиллах, харилцаа холбоог чухалчилдаг.
- Багш бүх үйл ажиллагаанд чиглүүлэн оролцдог.
- Бодит амьдрал дээрх сорилт, асуултууд дээр суурилдаг.
- Нээлттэй, үр дүн нь урьдчилан тодорхойлогдоогүй шинэ зүйл байдаг.

Төсөл нь хүүхдийн танин мэдэхүй, хөгжлийн түвшин, сонирхлыг харгалзан гарах бөгөөд дараах зарчмуудад тулгуурлан төсөлт ажлуудыг зохион байгуулах боломжтой.

1. Бодитой байх: Хүүхэд бодит амьдралд тулгарсан асуудлуудыг шийдвэрлэх төсөл дээр ажиллана. Энэ нь хүүхдийн мэдлэгээ бодит байдалд ашиглах, шинжилгээ хийх чадварыг нэмэгдүүлдэг.
2. Нотолгоонд суурилсан байх: Хүүхдээс асуулт асуух, судлах, судлахад дэмжлэг үзүүлэхэд суурилдаг. Энэ нь сониуч зан, шүүмжлэлтэй сэтгэх чадварыг хөгжүүлдэг.
3. Хугацааг төлөвлөх: Төслийг богино, дунд, урт хугацаанд хэрэгжүүлэх боломжтой. Ихэвчлэн урт хугацаанд хэрэгжүүлэх нь асуудлыг нарийвчлан судалж эрэл хайлт хийх, оновчтой шийдвэрлэхээс гадна багийн ажлын зохион байгуулалт, цагийн хуваарилалт зэрэг ур чадваруудыг хөгжүүлэх боломжийг олгодог.
4. Хүүхэд төвтэй байх: Хүүхдүүд хамтран төслөө сонгох, сэдвийг хэрхэн судлахаа шийдэх бие даасан эрхийг олгодог. Энэ нь тэдний сониуч занг өдөөж, аливаа юмыг мэдэх, хийх хүсэл эрмэлзлийг төрүүлж, оролцоо, урам зоригийг нэмэгдүүлдэг.
5. Нэгдмэл байх: Сургалт, үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн сургалтын чиглэлүүдийг нэг цогц болгон нэгтгэдэг.
6. Өөрийн суралцах үйл явцыг зохион байгуулах: Төслийн явцад өөрсдийн суралцах үйл явцыг удирдана. Энэ нь тэдний өөрийгөө хянах, хариуцлага хүлээх чадварыг нэмэгдүүлдэг.
7. Хамтын ажиллагаатай байх: Ихэвчлэн багаар хамтран ажилладаг бөгөөд хүүхдүүд үе тэнгийнхэнтэйгээ санаа бодлоо хуваалцаж, бие биетэйгээ хамтрах, туслах дэмжих замаар асуудлыг шийдэж, төслийг хэрэгжүүлдэг. Энэ нь тэдний багаар ажиллах болон харилцааны ур чадварыг сайжруулдаг.<sup>2</sup>

Эдгээрээс гадна, хүүхдүүдийн өөрсдийнх нь харилцан яриа, тоглоомын явцад гарч ирсэн санаануудыг баримжаалан төсөл гаргаж болно.

Төсөлд суурилсан суралцахуйн ач холбогдол

ХҮҮХДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	БАГШИЙН ДЭМЖЛЭГ
4 нас	4 настай хүүхдэд үзүүлэх дэмжлэг
Ажиглах: <ul style="list-style-type: none"> <li>- Байгальд гарсан өөрчлөлт (ургамал, цаг агаар гэх мэт)-ийг ажиглах</li> <li>- Туршилт хийх</li> <li>- Амьтан, хүн, юмсын үйлдлийг ажиглах</li> <li>- Хүүхдүүд зураг, видео үзэж, юу харснаа ярилцаж, сонирхсон зүйлээ асууж, ойлгосон мэдээллээ хуваалцана.</li> <li>- Тоглох ба дүр бүтээх:</li> <li>- Дүрд тоглох</li> </ul>	Сонирхлыг өдөөж, сэдэлжүүлэх <ul style="list-style-type: none"> <li>- Хүүхдийн сонирхлыг судалж, түүнд тулгуурлан төсөл төлөвлөх</li> <li>- Асуудал дэвшүүлж, “Яагаад?”, “Яаж?” гэх мэт асуултаар өдөөх</li> <li>- Сэдэвт тохирсон ном, зураг, бодит материал ашиглан сонирхлыг нэмэгдүүлэх</li> </ul> Төслийн үе шат бүрд чиглүүлэх <ul style="list-style-type: none"> <li>- Төсөл эхлэхээс өмнө зорилго, хийх ажлыг ойлгомжтой тайлбарлах</li> <li>- Ажлын үе шат бүрд тохирсон үүрэг өгөх</li> </ul>

<sup>2</sup> <https://www.projectapproach.org/>

<ul style="list-style-type: none"> <li>- Дүрсэлж үзүүлж тоглох (амьтны хөдөлгөөн дуу авиаг дуурайх)</li> <li>- Барьж бүтээх тоглоом тоглох</li> <li>- Судалж буй агуулгад тохирсон хөдөлгөөнт, хөгжимт тоглоом тоглох</li> </ul> <p>Бүтээх, урлах:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Зурах, наах, зохион бүтээх</li> <li>- Байгалийн болон дахин боловсруулах материалаар бүтээл хийх</li> <li>- Шавар, элсээр бүтээх</li> </ul> <p>Ярилцах:</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Яагаад?”, “Яаж?”, “Ямар?” гэх мэт асуулт асуух</li> <li>- Хамт тоглож буй найзуудтайгаа санаа солилцох</li> <li>- Өөрийн мэдсэн зүйлээ бусдад ярьж тайлбарлах</li> </ul> <p>Дуулах, шүлэг унших:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төсөлтэй холбоотой дуу, шүлэгт суралцах</li> </ul> <p>Төслийн үр дүнгээ танилцуулах:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хийсэн бүтээлээ бусдад танилцуулах</li> <li>- Хамтдаа үзэсгэлэн гаргах</li> <li>- Аав ээждээ үзүүлж тайлбарлах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Цаг хугацаа болон орчныг зөв зохион байгуулах</li> </ul> <p>Хүүхдийн оролцоог дэмжих</p> <ul style="list-style-type: none"> <li>- Санал санаачилгыг сонсох, үнэлэх</li> <li>- Багаар ажиллах, ээлжээр оролцох, хамтдаа шийдвэр гаргахыг дэмжих</li> <li>- Хийсэн зүйлийг магтах, бүтээлч байдлыг нь дэмжих</li> </ul> <p>Хэл яриа, харилцааг хөгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> <li>- Үг хэллэг, ойлголтыг нь баяжуулах шинэ үг тайлбарлаж өгөх</li> <li>- Асуулт асууж, ярилцах боломж олгох</li> <li>- Сургалтын хэрэглэгдэхүүн, ном, зураг ашиглан яриаг идэвхжүүлэх</li> </ul> <p>Танин мэдэхүй ба хөдөлгөөний хөгжлийг дэмжих</p> <ul style="list-style-type: none"> <li>- Туршилт, ажиглалт хийх орчин бүрдүүлэх (ус, элс, байгалийн материал)</li> <li>- Хөдөлгөөн оролцсон үйл ажиллагаа төлөвлөх</li> <li>- Зурах, барих, өрөх, хөдөлгөөн хийхэд дэмжих</li> </ul> <p>Үнэлгээ, урамшуулал</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүүхдийг ажиглаж тэмдэглэх</li> <li>- Ажлын төгсгөлд хүүхдийн бүтээлүүдийг танилцуулах, үзэсгэлэн гаргах, эцэг эхтэй хуваалцах</li> </ul>
---	--

## ГУРАВДУГААР БҮЛЭГ: СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ

### СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - IX САР

#### МИНИЙ ТАНИЛ ОРЧИН

##### Хүүхдийн эзэмших чадамж

**Нийгэм, сэтгэл хөдлөл:** Хүүхэд өөрийнхөө өсөлт, амжилтад бахархах мэдрэмж төрөх, сайн үйл хийхийн утга учрыг ойлгох, дүрэм баримталж хамтдаа тоглох, хөдөлгөөнт тоглоомд багийн уур амьсгалыг дэмжих, "хамтдаа" гэсэн үзэл хандлагатай болоход суралцах, баяр баяслаа илэрхийлэх болон бусдад туслах хүсэл эрмэлзэлтэй болох зэрэг чадварт суралцана.

**Харилцах:** Хүүхэд харилцан ярианд идэвхтэй оролцох ба сонирхсон зүйлийнхээ тухай асууж тодруулах замаар мэдээлэл цуглуулах, багш болон найзуудынхаа яриаг таслахгүй сонсож, ээлжлэн ярих чадвар эзэмшинэ.

**Шүүн тунгаах:** Асуулт асуух, хийсэн үйл явдлаа тайлбарлах, ярих, зөв буруу үйлдлийг ялгаж дүрмийг ойлгох, мөн өөрийнхөө үйлдэл болон бусдын үйлийг үнэлж дүгнэх боломж олгох зэргээр эргэцүүлэн бодох, шүүн тунгаах чадварыг эзэмшинэ.

##### Аюулгүй байдлын зөвлөмж:

Ангийн төвүүдийн тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнийг тухайн насны хүүхдийн онцлогт тохируулан олон хувилбараар ашиглах сонголттой байхаар бэлтгэх, төвүүдийн тавиур булангийн хамгаалалт хийх, ангийн дүрмийг хүүхдийн харагдахуйц газар байрлуулах, зурах, наах хэрэгсэл нь хоргүй, хүүхдийн насанд тохирсон, иртэй үзүүргүй байхад анхаарах, зугаалах газрыг урьдчилан шалгаж, орчин аюулгүй эсэхийг тодорхойлох зэргээр сургалтын орчныг бүрдүүлж үйл ажиллагааг зохион байгуулаарай.

##### Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

*Тойргийн цаг:*

- Ярилцлагын үед нээлттэй асуулт ашиглан ярих үйлийг өдөөх, өдөр тутмын хийсэн үйлээ дарааллаар ярих үед үгийн баялгийг нь нэмэгдүүлж, өөрийн санаа илэрхийлэх боломж олгоно.
- Асуултаар дамжуулан зөв, буруу үйлдлийг ялгаж ойлгоход нь чиглүүлнэ.

Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:

- Зурах, бүтээл хийх хэрэглэгдэхүүнээ өөрөө сонгож бүтээлчээр сэтгэх боломж олгоно.
- Өөрийнхөө өндрийг хэмжиж харьцуулах үед өсөлтөд нь ахиц гарсан бол бахархах мэдрэмжийг төрүүлэх үг хэллэг хэрэглэнэ.
- Хөдөлгөөнт тоглоомд багийн уур амьсгалыг дэмжих, “хамтдаа” гэсэн үзэл хандлагатай болоход нь тусална.

Төвийн үйл ажиллагаа:

- Хүүхэд бүр санаагаа илэрхийлэх боломжтой, чөлөөтэй уур амьсгал бүрдүүлж ярилцлагыг асуултаар чиглүүлэхдээ хүүхдийг бодуулж сэтгүүлсэн асуулт тавина.
- Ангийн дүрмийг богино, ойлгомжтой өгүүлбэр зураглалаар ойлгуулж, өдөр бүр сануулах, хэрэгжүүлж буй сайн жишээг магтах байдлаар дадал болгох, хүүхдийн оролцоог үнэлж хамтын дүгнэлт хийж бататгана.

Зугаалга:

- Зугаалгын бэлтгэл ажлыг хангах үүрэг даалгаврыг хүүхдийн сонирхолд тохируулан хуваарилан өгөх, “Зугаалгаар явахад хамгийн хөгжилтэй зүйл юу байв?”, “Хэн сайн үүрэг даалгавраа биелүүлсэн бэ?”, “Дараа дахин явах бол ямар зүйлийг сайжруулах вэ?” гэх мэт асуултаар хүүхдэд өөрийгөө үнэлэх, эргэцүүлэх боломж олгоно.

Хөгжөөн баясах цаг:

- Бээлий хүүхэлдэйгээр үзүүлсэн жүжигчилсэн тоглолтоор сайн үйл хийхийн утга учрыг ойлгуулж, бусдад туслах хүсэл эрмэлзэл төрүүлэх, тусч үйлийг стикер нааж тэмдэглэх зэргээр өөрийн болон бусдын үйлийг үнэлэх, урамшуулах, бахархах мэдрэмжийг төрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

**Боломжууд:**

Хүүхэд өөрийн өдөр тутмын үйлдлээ ярихдаа дарааллыг алдах, андуурах, “Би юу ярих вэ?” гэж эргэлзэх тохиолдол гарвал асуултаар чиглүүлж дэмжлэг үзүүлнэ. Хүүхэд бүр өөрсдийн өндрийг хэмжихдээ бусадтай харьцуулах тохиолдол гарч болзошгүй. Энэ үед хүүхэд бүрийн биеийн хөгжил өөр байдаг тухай нэмэлт тайлбар өгөөрэй. Яагаад дүрэм хэрэгтэй вэ? заавал мөрдөх шаардлагатай юу? гэсэн асуултууд ирж магадгүй тул шалтгаан үр дагаврыг ойлгуулж сайн үйл хийхэд нь дэмжлэг үзүүлээрэй.

**Үйл ажиллагааны төлөвлөлт**

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
ХЯ2.2а. Энгийн өгүүлбэрээр харилцан ярилцана. ЗУ2.2а. Зураас, дүрсээр өөрийн бодол төсөөллөө илэрхийлнэ. НСХ2.3в. Аливаа үйл ажиллагаанд бие даан дуртай оролцоно.	<ul style="list-style-type: none"> <li>- Өдөр тутмын үйл ажиллагааны явцад сэдвийн хүрээнд өөрийгөө илэрхийлэн, бусадтай харилцахдаа асуулт харилцан яриаг эхлүүлэх</li> <li>- Дугуй дүрс, цэг зураасаар дүрсэлж зурах</li> <li>- Өдрийн дэглэмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох</li> </ul>	Миний зуны амралт
МАТ2.2б. Өөрийн хийдэг үйлийг, өглөө, оройтой холбож нэрлэнэ. ХЯ2.2д. Үйл явдлыг тоочиж ярина.	<ul style="list-style-type: none"> <li>- Өглөө, оройг нэрлэх тоглоом (зурган картыг хараад хүүхэд цэцэрлэгтээ явж байгаа болохоор өглөө байна гэх мэт) тоглох;</li> </ul>	Миний нэг өдөр

	<ul style="list-style-type: none"> <li>- Өдөр тутмын үйл ажиллагааны явцад болсон үйл явдал, өөрт тохиолдсон зүйлийн тухай дарааллаар нь ярих</li> </ul>	
<p>ХЭМ2.1г. Алхаж, гүйхдээ гар хөлийн хөдөлгөөнөө хослуулан хурдан гүйцэтгэнэ.</p> <p>ХЭМ3.1д. Алхалт, гүйлт бүхий хөдөлгөөнт тоглоомыг хамтран тоглоно.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Алхалт, гүйлтийн үед аюулгүй байдалд анхаарч, хоорондын зайг тохируулах</li> <li>- Хөгжимт гимнастик, бие хөгжүүлэх цогц дасгалыг хөгжмийн хэмнэлд тохируулан, бусдыг даган дуурайж гүйцэтгэх (6-8 тоот);</li> </ul>	Авхаалжтай хүүхэд
<p>БНО3.2б. Өөрийн гэр бүлийг танилцуулж, ойр орчны хүмүүсийн ажил мэргэжлийг ялган ойлгож, гэрийн ажилд оролцоно.</p> <p>ХЯ3.2б. Харилцан ярианд сонирхсон зүйлийн тухай асууж, тодруулна.</p> <p>ЗУ3.2а. Өөрийн бодол төсөөллөөр зохиомжлон зурна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Гэр бүлийн гишүүдийнхээ ажил мэргэжлийн талаар (ажлын онцлог, хэрэгцээтэй багаж хэрэгсэл, үүрэг) танилцуулах</li> <li>- Багш болон найзуудынхаа яриаг таслахгүй сонсох, ээлжлэн ярих, асуултаар чиглүүлсэн харилцан яриаг ойлгож хариулах</li> <li>- Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн ялгааг зургаар илэрхийлэх</li> </ul>	Миний хүрээлэл
<p>ХЭМ3.2е. Хүрээлэн байгаа орчин дахь анхааруулах, болгоомжлох тэмдэг, тэмдэглэгээг таньж, дагаж мөрдөнө.</p> <p>БНО3.2в. Ойр орчны үйлчилгээний газар (дэлгүүр, эмийн сан, эмнэлэг, номын сан) хүмүүс юу хийдэг, ямар зориулалттайг ялгаж, тухайн газрын дүрмийг баримтална.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хайч, харандаа, шугам зэрэг үзүүртэй зүйлсийг зөв барьж дамжуулах, болгоомжтой зөөх санамж зохион бүтээж, ангид байрлуулах</li> <li>- Ангийн дүрмийг зохиоход оролцох</li> </ul>	Бидний дүрэм
<p>ХӨГ2.1б. Дууны аялгууг дагаж, хамтдаа дуулна.</p> <p>ХӨГ2.1в. Дуу, аялгууны хэмнэлийг мэдэрч хамтран тоглоно.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Үг, аялгууны давталттай богино дууны нэгээс хоёр үетэй үгийг хэлж, дагаж аялах</li> <li>- Эргэн тойрны хүмүүсийн дуу хоолой, дүр хөдөлгөөнийг дуурайж тоглох.</li> </ul>	Хамтдаа мэдэрье, дуулья

### 9 дүгээр сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Зуны амралтын сонин сайхан	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Зуны амралтаа хэрхэн өнгөрүүлсэн тухай ярилцана. Хүүхдүүд зураас, дүрс ашиглан зурах ба бүтээлээ найзууддаа танилцуулж тайлбарлана.	Балын, тосон, өнгийн харандаа, бийр, гуаш, эсгий бал.	Зуны амралтаа хаана, хэнтэй хамт өнгөрүүлсэн бэ?; Юу хийж сурсан бэ?; Шинэ танилуудынхаа тухай танилцуулна уу?.	Харилцах: Санаа бодлоо илэрхийлэх, бусдын яриаг сонсох Шүүн тунгаах: Зураас, дүрсээр бодол төсөөллөө илэрхийлэх	Хүүхэд өөрийн санаагаа хэлэх, бусдыг сонсох, хариулах зэргээр ярианд оролцдог. Зураасны төрлүүдийг ашиглан зурж, дүрсэлдэг. Өдөр тутмын тоглоом, үйл ажиллагаанд бие даан дуртай оролцдог.
Зугаалах төлөвлөгөө	Тойргийн цаг	Дараагийн өдрийн зугаалгын талаар танилцуулж, хүүхдүүдтэй хамт төлөвлөгөө гаргана (хаашаа явах, очоод юу хийх, хүнс, тоглоом зэргийг хэн хариуцахыг ярилцана).	Дэлгэц цаас, маркер, зугаалгад хэрэгтэй зүйлсийн зураг.	Хаашаа явах вэ? Хоолыг хэн хариуцах вэ?, Ямар тоглоом авч явах вэ?	Харилцах: Өдөр тутмын үйлд идэвхтэй оролцох	Төлөвлөгөө гаргахад хамтран оролцдог.
Хамтдаа зугаалсан нь	Зугаалга	Хүүхдүүд өмнөх өдрийн хариуцсан зүйлээ бэлтгэж ирэх ба төлөвлөгөөний дагуу зугаалга зохион байгуулна. Буцаж ирээд зугаалгынхаа тухай ярилцана.	Нэг удаагийн аяга, таваг, халбага, сэрээ, эвхдэг сандал ширээ, бөмбөг.	Зугаалгаар явахад хамгийн хөгжилтэй зүйл юу байв?; Хэн сайн үүрэг даалгавраа биелүүлсэн бэ?; Дараа дахин явах бол ямар зүйлийг сайжруулах вэ?.	Шүүн тунгаах: Өөрийгөө үнэлэх, юу хийхээ эргэцүүлэх Нийгэм, сэтгэл хөдлөл: Дүрэм баримтлах	Ажиглалт. Үйл ажиллагаанд төлөвлөгөөний дагуу оролцдог.
Миний хийсэн зүйлс	Тойргийн цаг	Хүүхдүүд "Миний нэг өдөр" сэдэвтэй фото зургийн танилцуулга бэлтгэнэ. Өглөө, өдөр, орой, шөнө хийсэн үйл явдлуудаа тайлбарлан ярих ба багш бүтэн өгүүлбэрээр, үйл явдлыг тоочин ярьж байгаа эсэхэд чиглүүлэг өгнө.	Фото, А4 цаас, цавуу, эсгий бал.	Чи өглөө, өдөр, орой, шөнө юу хийсэн бэ?; Эдгээрээс хамгийн таалагдсан зүйл нь юу байсан бэ?.	Харилцах: Үйл явдлыг дарааллаар тоочиж ярих, бүтэн өгүүлбэрээр ярих, харилцах	"Өглөө босоход юу хийдэг вэ?" гэх мэт асуултад хариулдаг. Бүтэн өгүүлбэрээр үйл явдлыг тоочин ярьдаг.

Би өндөр боллоо	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхэд бүрийн өндрийг хэмжиж, өмнөх жилийн хэмжээтэй харьцуулж, хэн нь өндөр болсныг тоолж хэлнэ. Өндөр болоход нөлөөлдөг хүчин зүйлсийн талаар (эрт унтах, эрүүл хоол, дасгал) тайлбар өгнө.	Наалддаг тууз, эсгий бал, өндөр хэмжигч, метр.	Өндөр болохын тулд чи юу хийх хэрэгтэй вэ?	Нийгэм, сэтгэл хөдлөл: Өөрөөрөө бахархах Шүүн тунгаах: Хэмжиж, жишиж харьцуулах	10 хүртэл юмсыг дараалуулан тоолж, хоёр бүлэг юмсыг харьцуулдаг.
Байраа сольё	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хөгжилтэй аянд өнгийн тууз солилцох, алхалт гүйлтийн төрлүүдийг гүйцэтгэнэ.	Тууз, бөмбөг, Хөгжмийн ая,	Алхалт гүйлтийн төрлүүдийг гүйцэтгэнэ.	Нийгэм, сэтгэл хөдлөл: Дүрэм баримталж хамтдаа тоглох	Алхах, гүйх техникээ зөв ашиглаж, дүрмээ баримталдаг.
Цагаригтай дасгал	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Цагаригтай хөгжимт гимнастикийн дасгалуудыг зохиомжлон хийнэ.	Жижиг өнгийн цагариг.	Дасгалыг зохиомжлон хийнэ.	Нийгэм, сэтгэл хөдлөл: Хөдөлгөөнөө хослуулан хурдан гүйцэтгэх	Баруун, зүүн гараар эсрэг хөдөлгөөн даган дуурайж гүйцэтгэдэг.
Шаламгай хүүхэд	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Саваа модыг унагалгүй барьж авах тоглоом тоглоно.	Саваа мод	Саваа модоор тоглоно.	Шүүн тунгаах: Хөдөлгөөнөө хослуулан хурдан гүйцэтгэнэ.	Саваа модыг барьж хөдөлгөөнийг гүйцэтгэдэг.
Миний цэцэрлэг	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Цэцэрлэгийн хаяг, байршил, бүлгийг тогтооно. Цэцэрлэгийн танилцуулга бичлэг үзүүлэх, цэцэрлэгт хийдэг зүйлсийн талаар ярилцана. Гэрээс цэцэрлэг хүртэлх замыг зураглах даалгавар өгнө.	Цэцэрлэгийн танилцуулга бичлэг, цэцэрлэг, байшин, гэрийн зураг, самбар, маркер.	Чи цэцэрлэгтээ ирээд юу хийдэг вэ?; Өглөөний дасгалын дараа юу хийдэг вэ?; Аль нь чамд хамгийн их таалагддаг вэ?.	Харилцах: Асуултад хариулах, цэцэрлэгээ танилцуулах	Бусдын яриаг сонсож хариулдаг.
Миний найз	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд найзуудаа хөтөлж ирэх, найзуудыг танилцуулна. Найзгүй хүүхдүүдийг найз болохыг уриална. Найзуудын тусархаг сайн үйлийг стикерээр урамшуулан тэмдэглэнэ.	Дэлгэц цаас, таних тэмдэг, скоч, стикер.	Чиний найзыг хэн гэдэг вэ? Чи найздаа хэрхэн тусалсан бэ?	Нийгэм, сэтгэл хөдлөл: Нөхөрсөг харилцаа, сайн үйл хийх, урамшуулах, өөрийгөө үнэлэх	Найзтай эсэхээ хэлэг, танилцуулдаг. Асуултыг ойлгож санаагаа хэлдэг.
		Гэр бүлийн зураг авч ирэх даалгавар өгнө. Гэр бүлийн гишүүдийн тоо, ажил	Гэр бүлийн зураг, ажил мэргэжилтэй	Гэртээ хэн хэнтэйгээ хамт амьдардаг вэ?;	Харилцах:	Гэр бүлийг гишүүд юу хийдэг болохыг танилцуулдаг.

Миний гэр бүл	Төвийн үйл ажиллагаа	мэргэжлийн талаар ярилцана. Төвөөр ажиллана. 1) Танилцуулга самбар хийх, 2) Гэр бүлээ зурах, 3) Бяцхан ном хийх зэрэг бүтээлч үйл хийж, тайлбарлана.	холбоотой зураг, зургийн дэвтэр, өнгийн харандаа, гуаш, цаасны хэрэглэгдэхүүн.	Танай гэр бүл хэдэн гишүүнтэй вэ?; Ямар ажил, мэргэжилтэй вэ?.	Гэр бүлээ танилцуулах, асуулт асуух	Өөрийн төсөөллөөр зурсан зургаа тайлбарладаг.
Хуваалцах гэж юу вэ?	Тойргийн цаг	Хичээлийн хэрэгслээ бусадтай хуваалцах тухай ярилцах. Хуваалцахдаа эв найрамдалтай, эелдэг байх, талархал илэрхийлэх зэргийг тайлбарлана.	Зурагт үзүүлэн Сургалтын хэрэглэгдэхүүн	Хичээлийн хэрэгслээ бусадтай хуваалцаж болох уу? Яагаад?; Найзаасаа гуйхдаа юу гэж хэлэх вэ? Зөвшөөрөхгүй тохиолдолд яах вэ?.	Нийгэм, сэтгэл хөдлөл: Эв найрамдалтай, хүндэтгэлтэй харилцах Шүүн тунгаах: Шалтгаан үр дагаврыг ойлгох	Өөрийнхөө юмыг бусадтай хуваалцдаг.
Дүрмээ хамтдаа бүтээцгээ	Төвийн үйл ажиллагаа	Хүүхдүүдтэй хамт ангийн хамгийн чухал 5-7 дүрмийг ярилцаж сонгоно. Дүрмийг сонгосон шалтгаанаа тайлбарлана. Дүрэмтэй холбогдох эерэг зургийг сонгож, ил тод газар байршуулна.	Видео бичлэг Цахим холбоос	Яагаад дүрэм хэрэгтэй вэ?; Заавал мөрдөх шаардлагатай юу?.	Нийгэм, сэтгэл хөдлөл: Дүрэм баримтлах Шүүн тунгаах: Дүрмийн шалтгаан, үр дагаврыг ойлгох	Олон нийтийн газар баримтлах дүрмийг биелүүлдэг  Анхааруулах тэмдэглэгээг таньж ялгадаг.
Миний амлалт	Хөгжөөн баясах цаг	Бээлий хүүхэлдэйгээр найздаа тусалсан хүүхдийн тухай өгүүллэгээр жүжигчилсэн тоглолт хийж, сайн үйл хийхийн утга учрыг ойлгуулна. Найзуудын самбарт тусч үйлийг стикерээр урамшуулна.	Бээлий хүүхэлдэй, самбар.	Чи найздаа яаж тусалсан бэ?	Нийгэм, сэтгэл хөдлөл: Сайн үйл хийх хүсэл эрмэлзэлтэй болох	Бусдад туслах үйлдэл хийдэг.
Хөгжмийн хэмнэлийг мэдрэх	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хөгжмийн хэмнэлийг мэдрэх тоглоом тоглоно. Хурдан удаан аянд хоёр гартаа бөмбөгийг дамжуулж тоглоно.	Даралтат хөгжим, өсгөгч, ая, бөмбөг.	Сонссон аялгуунд удаан хөдөлсөн үү, хурдан хөдөлсөн үү?; Удаан/хурдан	Харилцах: Бусдын яриаг анхааран сонсох	Хөгжмийн хэмнэлийг сонсоод аянд тохируулан хөдөлгөөн хийдэг.

				хөдөлгөөн хийсэн бол ямар аялгуу байсан байна?.		
Хамтдаа дуулъя	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	“Амин хүү дээ би” дууг сонсгон, утгын талаар ярилцах. Мөр мөрөөр дагуулан, хөгжмийн хамсраатай болон хамсраагүй дуулна.	Хөгжмийн ая, шум	Дуунд хэний тухай гарч байна вэ?	Нийгэм, сэтгэл хөдлөл: Баяр баяслаа илэрхийлэх Харилцах: Санаа бодлоо илэрхийлэх	Дууг сонсоод дууны утгыг тайлбарладаг. Дууны хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийдэг.

Албан хэрэгцээ

## 9 дүгээр сарын I долоо хоног

### МИНИЙ ЗУНЫ АМРАЛТ

**Шинэ үг:** Зуны амралт, нэг өдөр

**Үйл ажиллагаа 1.** Зуны амралтын сонин сайхан (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Балын харандаа, тосон харандаа, өнгийн харандаа, бийр, гуаш, эсгий бал

**Аргачлал:** Миний зуны амралт гэсэн сэдвийн хүрээнд ярилцана.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Зуны амралтаа хаана, хэнтэй хамт өнгөрүүлсэн бэ?
- Зуны амралтаараа юу хийж сурсан бэ?
- Амралтаараа танилцсан шинэ танилуудынхаа тухай танилцуулна уу?

Хүүхдүүд өөрсдийн зуны амралтын тухай зураас, дүрс ашиглан зурна. Зураг зурсныхаа дараа бусад найзууддаа өөрийн бүтээлээ тайлбарлан танилцуулна.

**Үйл ажиллагаа 2.** Зугаалах төлөвлөгөө (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Дэлгэц цаас, маркер, зугаалгад хэрэгтэй зүйлсийн зураг

**Аргачлал:** Багш дараагийн өдрийн зугаалгын цагаар хамтдаа ойр газар зугаалах тухай танилцуулах ба хүүхдүүдтэй хамт төлөвлөгөөг гаргана. Хэн ямар ажлыг хариуцах тухай ярилцаж дэлгэц цаасан дээр багш бичнэ. (хаашаа явах, очоод юу хийх, хоолыг хэн хариуцах, майхан авч явах эсэх, эвхэгддэг сандал эсвэл суух зүйл хэн авч ирэх, тоглоом тоглох бол ямар тоглоом авч явах гэх мэтээр ярилцаж төлөвлөх)

**Үйл ажиллагаа 3.** Хамтдаа зугаалсан нь (Зугаалга)

**Хэрэглэгдэхүүн:** Нэг удаагийн аяга, таваг, халбага, сэрээ, эвхдэг сандал ширээ, бөмбөг

**Аргачлал:** Хүүхдүүд өмнөх өдрийн хариуцаж авсан зүйлээ бэлтгэж ирсэн байна. Хамтдаа төлөвлөсөн газар луу зугаалгаар явна. Зугаалах газартаа очоод төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг зохион байгуулна. Зугаалгаар явж ангидаа ирээд зугаалгынхаа тухай ярилцана.

### МИНИЙ НЭГ ӨДӨР

**Шинэ үг:** Танилцуулга

**Үйл ажиллагаа 1.** Миний хийсэн зүйлс (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Фото, А4 цаас, цавуу, эсгий бал

**Аргачлал:** Багш маргаашийн тойргийн цагаар хүүхдүүдэд өөрсдийн нэг өдрийн хамгийн сонирхолтой нэг хийж буй зүйлийн тухай зургаа дарж ирэх ба баримтжуулсан зургаа файлаар эсвэл хэвлэж авч ирэх даалгавар өгсөн байна. Хүүхдүүд өөрсдийн “Миний хийсэн зүйл” хэсэгт нэг хийсэн зүйлийнхээ тухай танилцуулга бэлтгэнэ. Өөрсдийн бэлтгэсэн танилцуулгаа тайлбарлан ярина. (өглөө, өдөр, орой, шөнө юу хийсэн тухай гэх мэт) Багш хүүхдүүдийг тайлбарлахдаа бүтэн өгүүлбэрээр ярьж байгаа эсэхэд хяналт тавьж дэмжлэг үзүүлж чиглүүлнэ.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Чи өглөө, өдөр, орой, шөнө юу хийсэн бэ?
- Эдгээрээс хамгийн таалагдсан зүйл нь юу байсан бэ?
- Хэрэв чамд дахин тэр үйлдлийг хийхээр бол чи яаж хийх байсан бэ?

**Үйл ажиллагаа 2.** Би өндөр боллоо (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Наалддаг тууз, эсгий бал, өндөр хэмжигч, метр

**Аргачлал:** Хүүхэд бүрийн өмнөх жилийн өндрийн хэмжээг багш нарийн туузан дээр эсгий балаар тэмдэглэж бэлтгэсэн байна. Багш хүүхдүүдийн өндрийг дахин хэмжиж өөр өнгийн эсгий балаар тэмдэглэнэ. Хүүхдүүд өөрийн туузан цаасаа ажиглаж өмнөх жилээс хэр өндөр

болсноо харьцуулна. Өндөр болоход юу нөлөөлдөг талаар багш тайлбар өгнө. (эрт унтах, чанартай эрүүл хоол хэрэглэх, дасгал хөдөлгөөн хийж, спортоор хичээллэх гэх мэт)

## АВХААЛЖТАЙ ХҮҮХЭД

**Шинэ үг:** Авхаалж, самбаа, шаламгай

**Үйл ажиллагаа 1.** Байраа сольё (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Хөгжилтэй ая, хүүхэд бүрд өнгийн жижиг тууз /урт нь 50см/ мөн бөмбөг, саваа мод

**Аргачлал:** Хүүхдүүд цуваагаар алхаж ангид орж ирээд өнгийн туузаас нэг нэгийг сонгож аваад 2 эгнээнд хуваагдан зогсоно. 1-р эгнээний хүүхдүүд алхаад 2 эгнээний хүүхэдтэй туузаа солилцоод байрандаа ирнэ. 2-р эгнээний хүүхдүүд алхаад 1-р эгнээний хүүхэдтэй туузаа солилцоод байрандаа ирнэ. 2 эгнээний хүүхдүүд зэрэг өөд өөдөөсөө алхаад туузаа солилцоод буцаж эргээд байрандаа зогсоно. Алхалт, гүйлтийн төрлүүдээс ашиглаж өөр өөр даалгавар гүйцэтгэж болно. /алхалт дунд зогсолт хийх, суух, алга таших, өлмий, өсгий дээр алхах, хавсралттай алхах гэх мэт/

**Үйл ажиллагаа 2.** Цагаригтай дасгал (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Хөгжмийн ая, хүүхэд бүрд жижиг өнгийн цагариг

**Аргачлал:** Хүүхэд бүрийг дасгал хийх байрлалд зогсооно. Багш бие хөгжүүлэх хөгжимт гимнастикийн дараах дасгалуудаас сонгон зохиомжилно. Цагаригаа 2 гараар барьж урагш, дээш өргөж буулгах, баруун/ зүүн тал руу эргүүлэх, хазайх, урагш бөхийх, хоёр гартаа ээлжлэн дамжуулах, газар тавьж үсрэх гэх мэт хөдөлгөөнийг зохиомжлон хийнэ.

**Үйл ажиллагаа 3:** Шаламгай хүүхэд (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Саваа мод

**Аргачлал:** Хүүхдүүд тойрог болж зогсоно. Багш тойргийн голд зогсож саваа модоо эгцээр нь тогтоож хүүхдүүдийн нэрийг сонгож дуудахад тухайн хүүхэд газар унагахгүйгээр алхаж эсвэл гүйж барьж авна. Саваа модыг газарт унагахгүй байх дүрмийг баримтлан тоглоно. Унагасан тохиолдолд давтан хийнэ.

Тайвшруулах дасгал: Дасгал хийх боломжтой зай авч зогсоно.

- Хөлийн өлмийг газраас салгахгүйгээр шагайн үеэр тойргоор эргүүлэх
- Гар хөлийг сэгсэрч суллах
- Амьсгалын дасгал

## 9 дүгээр сарын II долоо хоног

### МИНИЙ ХҮРЭЭЛЭЛ

**Шинэ үг:** Хаяг, сайн найз, гишүүд

**Үйл ажиллагаа 1.** Миний цэцэрлэг (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Цэцэрлэгийн танилцуулга бичлэг, цэцэрлэг, байшин, орон сууц, гэрийн зураг, самбар маркер

**Аргачлал:** Багш хүүхдүүдэд өөрийн цэцэрлэгийн хаяг, байршил, бүлгийг хэлж хүүхдүүдээр давтан хэлүүлж тогтоолгоно. Цэцэрлэгийн үүдний хэсэг, анги бүлэг, коридор, хөгжим, биеийн тамирын танхим, гадна тоглоомын талбай зэргийг харуулсан бичлэгийг багш бэлтгэн үзүүлж цэцэрлэгээ танилцуулна. Хүүхдүүдэд цэцэрлэгт хийдэг зүйлсийн зургийг тараан өгч асуултын дагуу ярилцана.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Чи цэцэрлэгтээ ирээд юу хийдэг вэ?

- Өглөөний дасгалын дараа юу хийдэг вэ?
- Өдрийн хоолны өмнө чи юу хийсэн бэ? гэх мэтээр зохиомжлон асууна.
- Цэцэрлэгт хийдэг зүйлсээс аль нь чамд хамгийн их таалагддаг вэ?
- Цэцэрлэгт байхдаа чи юу хийж сурсан бэ?

Самбарт цэцэрлэгийн зураг болон хашаа байшин, орон сууц, гэр гэсэн зургуудыг байрлуулна. Хүүхдүүд хаана амьдардаг тухайгаа сонгоно. Багш гэрийн даалгаварт гэрээс цэцэрлэг хүрэх замд тааралдсан зүйлсийн зургийг авч цаасан дээр нааж зураглал хийж ирэх даалгавар өгнө.

**Үйл ажиллагаа 2.** Миний найз (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Дэлгэц цаас, таних тэмдэг, скоч, стикер

**Аргачлал:** Багш хүүхдүүдэд өөрсдийнхөө найзуудыг хөтөлж ирэх даалгавар өгнө. Хөтөлж ирсэн хүүхдүүдээс найз мөн эсэхийг асууж тодруулна. Хоёр хүүхэд хүлээн зөвшөөрвөл багш хоёр хүүхдийн таних тэмдгийн зургийг “Ангийн найзууд” гэсэн дэлгэц цаасан дээр наана. Багш ангийн хүүхэд бүртэй ярилцаж найзуудыг бусдад танилцуулна. Найзгүй хүүхдүүдийг хамтдаа ярилцан тоглож, найзууд болохыг уриална. Найзуудын самбарт тухайн найзуудын тусархаг сайн үйлийг урамшуулан стикер нааж болно.

**Үйл ажиллагаа 3.** Миний гэр бүл (Төвийн үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Гэр бүлийн зураг, ажил мэргэжилтэй холбоотой зураг, дэлгэц цаас, эсгий бал, зургийн дэвтэр, өнгийн харандаа, гуаш, өнгийн цаас, цаасны цавуу, гэр бүлийн гишүүдийн төлөөлүүлсэн зураг

**Аргачлал:** Өмнөх өдөр гэр бүлийн зураг авч ирэх даалгавар өгсөн байна. Багш гэр бүлийн тухай сэдвээр ярилцана.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Гэртээ хэн хэнтэйгээ хамт амьдардаг вэ?
- Танай гэр бүл хэдэн гишүүнтэй вэ?
- Танай гэр бүлийнхэн ямар ажил, мэргэжилтэй вэ?

Хүүхдүүд өөрсдийн сонирхлоор төвд хуваагдана.

1-р төвийг сонгосон хүүхдүүд гэр бүлийн зургуудаа ашиглан танилцуулга самбар хийнэ. /ээж эмч, аав жолооч гэх мэтээр тойруулан зургуудыг байрлуулж бэлтгэх/

2-р төвд сонгосон хүүхдүүд өөрийн гэр бүлийг зургийн хэрэгслээс сонгон зурна.

3-р төвд сонгосон хүүхдүүд өгөгдсөн гэр бүлийн зургуудыг ашиглан “Миний гэр бүл” сэдэвт бяцхан ном хийнэ. Хүүхдүүд баг багаараа хийсэн зүйлээ танилцуулж тайлбарлана.

## БИДНИЙ ДҮРЭМ

**Шинэ үг:** Дүрэм, эв найрамдал

**Үйл ажиллагаа 1.** Хуваалцах гэж юу вэ? (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Аргачлал:** Багш бусадтай хичээлийн хэрэгслээ хуваалцаж байсан тухай ярилцлага өрнүүлнэ.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Хичээлийн хэрэгслээ бусадтай хуваалцаж хэрэглэж болох уу?
- Яагаад болох вэ? яагаад болохгүй вэ?
- Хэрэв хуваалцвал юу хийх ёстой вэ?
- Найз нь чамд хуваалцсан тохиолдолд буцааж өгөх үү? Юу гэж хэлэх вэ?
- Найзаасаа гуйж авахдаа юу гэж хэлэх вэ?
- Зөвшөөрөхгүй тохиолдолд яах вэ?

Хуваалцахдаа эв найрамдалтай, эелдэг байх, хэрэглэснийхээ дараа талархал илэрхийлэх зэрэг тайлбар өгнө. Эв найрамдал гэдэг шинэ үгийг тайлбарлана.

**Үйл ажиллагаа 2.** Дүрмээ хамтдаа бүтээцгээе (Төвийн үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Видео бичлэг

**Аргачлал:** Багш хүүхдүүдтэй хамт ангийн дүрмүүдийг ярилцаж, хамгийн чухал 5-7 дүрмийг сонгоно./цахим холбоос 1./ Хүүхдүүд эдгээр дүрмүүдийг яагаад сонгосон шалтгаанаа тайлбарлаж, ярилцана.

Хүүхдүүд дүрэм тус бүртэй холбогдох зургийг сонгож багшид өгнө. Багш тухайн дүрмийн эерэг зургийг олж хамтад нь нийлүүлж ангийн дүрмийг баталж ил тод газар хананд байршуулах бөгөөд өдөр бүр сануулж мөрдөх чиглэл өгнө. Дүрэм гэдэг үгийг тайлбарлана.

**Үйл ажиллагаа 3.** Миний амлалт (Хөгжөөн баясах цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Бээлий хүүхэлдэй, самбар

**Аргачлал:** Багш гартаа бээлий хүүхэлдэй хийж найздаа тусалсан хүүхдийн тухай богино өгүүллэг зохиож ярихдаа сайн үйлийг урамшуулах тухай жүжигчилсэн тоглолт хийж үзүүлнэ. Найзуудын самбарт бусад найздаа тусалсан хүүхэд өөрийн таних тэмдгийн доор стикэр наах байдлаар тусч үйлийг урамшуулна гэсэн тайлбарыг өгнө. Багш самбар наасан сайн үйлүүдийг дүгнэж ярилцана.

## ХАМТДАА МЭДЭРЬЕ, ДУУЛЪЯ

**Шинэ үг:**

**Үйл ажиллагаа 1.** Хөгжмийн хэмнэлийг мэдрэх (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Даралтат хөгжим, өсгөгч, ая

**Аргачлал:** Хүүхдүүдийг тойрог болгон газар суулган хөгжмийн хэмнэлийг мэдрэх тоглоом тоглоно.

Тоглоомын дүрэм: /цахим холбоос 2./

- Хүүхэд бүр 1 бөмбөг сагсан дотроос сонгон авна.
- Удаан ая явах үед баруун зүүн гараа ээлжлэн дээшээ өргөн буулган хөдөлгөнө.
- Хурдан ая явах үед хоёр гартаа бөмбөгөө ээлжлэн унагалгүй дамжуулна.
- Ая дахин хурдлахад хэмнэлийг даган бөмбөгөө хурдан дамжуулна. Дахин хурдлах үед хэмнэлийг мэдэрч илүү хурдан дамжуулаад ая удаан болох үед гараа дахин ээлжлэн хөдөлгөнө.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Сонссон аялгуунд удаан хөдөлсөн үү, хурдан хөдөлсөн үү?
- Удаан хөдөлгөөн хийсэн бол удаан аялгуу байсан байна. Зөв үү? Буруу юу?
- Энэ аялгуунд хурдан хөдөлсөн үү, удаан хөдөлгөөн хийсэн үү?
- Хурдан хөдөлгөөн хийсэн бол хурдан аялгуу байсан байна. Зөв үү? Буруу юу?

**Үйл ажиллагаа 2.** Хамтдаа дуулъя (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Аргачлал:** Үг Г.Ганболд Ая Л.Галмандах “Амин хүү дээ би” дууг сонсон дууны утгын талаар ярилцана. /цахим холбоос 3./

- Дууг мөр мөрөөр нь дагуулан сэргээн дагуулан дуулна.
- Дуугаа хөгжмийн хамсраатай болон хамсраагүй дуулуулна.

**Сонсьё, дэмжье/ Туслалцаа:**

- Богино өгүүлбэртэй, давтамжтай үг хэллэгтэй дүрс, зураг ашиглан, сонсгол болон харааны ижилсэл бүхий тоглоомоор дамжуулан хэл ярианы чадварыг нь нэмэгдүүлээрэй.
- Сонсгол, хараа, хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд ажиглах, сонсох, барьж тэмтрэх, хөдөлгөөнөөр илэрхийлэх, үйл ажиллагаанд өөрийн санаачилгаар оролцох зэрэг үйлийг дэмжиж, тэдний идэвхтэй оролцоог хангах орчин бүрдүүлэн ажиллаарай.

**Эцэг эхтэйгээ хамтаръя.**

- Цэцэрлэг болон гэртээ болсон үйл явдлыг асууж ярилцахдаа хүүхдийн сурсан шинэ үгийг асууж утгыг дахин тайлбарлах, засаж хэлүүлэх, шинэ үгийг зөв ашиглаж байгаа эсэхэд хяналт тавьж, ойлголтыг нь бататгаж зөвлөх

- Хүүхдийнхээ нэг өдөр хийсэн үйлийг нь баримтжуулан өөрийн танилцуулгыг хамтран бэлтгэж өгөөрэй
- Бусадтай болон эд зүйлстэй хүндэтгэлтэй харилцах чадварыг зөвөөр үлгэрлэн дэмжээрэй.

Цахим холбоос:

1. <https://youtu.be/pNGQqpETGt0?si=45axURZyWwpasFFG>
2. <https://online.fliphtml5.com/qgtdg/irmz/#p=1>
3. <https://youtu.be/INao1GqVmHQ>

### Багшийн эргэцүүлэмж

<p><b>Эргэцүүлэл</b> /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ./</p> <p>Амжилттай хэрэгжүүлсэн: .....</p> <p>Сул хэрэгжүүлсэн:.....</p> <p>Цаашид сайжруулах:.....</p> <p>Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа: .....</p>
--

## СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - X САР

### ӨГӨӨМӨР ХҮҮХЭД

#### Хүүхдийн эзэмших чадамж

**Харилцах:** Найзтайгаа эелдэг харилцаж, бусдын санал хүсэлтийг нь анхаарч сонсох, биелүүлэх, өөрийн санаа бодлыг эелдгээр илэрхийлэх, зохиолын гол санааг ойлгож тайлбарлан ярьдаг болно.

**Хамтран ажиллах:** Найздаа туслах, хэрэгтэй зүйлээ харамгүйгээр үнэн сэтгэлээсээ хуваалцах, хуваалцахгүй байхын үр дагаврыг ойлгох, бусадтай эв найрамдалтай байхад суралцах зэргээр хамтран ажиллахад суралцана.

**Нийгэм сэтгэл хөдлөл:** Бусдын сэтгэл хөдлөлийг таньж мэдэрнэ. Хүүхэд бусдын сэтгэл хөдлөлийн таатай, таагүй байдлыг таньж мэдэн, түүний шалтгааныг тайлбарладаг болохоос гадна, өөрийнх нь үйлдэл бусад хүмүүст хэрхэн нөлөөлдгийг ойлгож мэддэг болно.

#### Аюулгүй байдлын зөвлөмж:

Хичээлийн хэрэгслийг хүүхэд өөрөө авч хэрэглэх боломжтой, сонголттой байхаар хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, хайч болон үзүүрлэсэн харандааг болгоомжтой хэрэглэх заавартай танилцуулах, гадаад талбайд навч түүх нөхцөлийг урьдчилан шалгаж, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах хэрэгтэй.

#### Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

*Тойргийн цаг:*

- Асуултаар чиглүүлж ярилцлага өрнүүлэхдээ хүүхдийн хариултыг анхааралтай сонсож заавал хариу өгөх, хэлсэн үг, өгүүлбэрийг засаж найруулж өгөх, асуултын тайлбарыг хэлэхэд нь урамшуулан дэмжээрэй.

*Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:*

- Бусад хүүхдүүдтэй хамтран тоглох, ярилцах, даалгавар биелүүлэхдээ хүлээцтэй хандаж эелдэг, найрсаг харилцахад чиглүүлээрэй. Бусдад өгөөмөр зан гаргаж туслах үйлдэл хийвэл сайшаан магтаарай.
- Хүүхэд өөрийн сэтгэл хөдлөлийн шалтгааныг тайлбарлан бусдад хуваалцахад туслаарай.

*Төвийн үйл ажиллагаа:*

- Тухайн төвийг сонгоход нь чиглүүлэг өгч, хэрэглэгдэхүүнээ сонгож өгсөн зааврыг биелүүлэхэд нь туслаарай.

*Зугаалга:*

- Гадаад талбайд хөдөлгөөнт тоглоом тоглох, навч түүх, ярилцлага, туршилт хийхдээ хүүхэд бүрийн тэгш оролцоог хангаж бүтээлчээр суралцахад нь дэмжлэг үзүүлээрэй.

**Өөртөө үйлчлэх хөдөлмөр:**

- Өөрийн хичээлийн хэрэгслээ бие даан сонгож гамтай хэрэглэх, байранд нь хураах, эмх цэгцтэй байх зэрэг үйлүүдийг нь урамшуулан дэмжээрэй.

**Хөгжөөн баясах цаг:**

- Үлгэрийн дүрийн үгийг мөр мөрөөр нь тогтооход нь дагуулан хэлүүлж, жүжиглэн тоглоход дэмжлэг үзүүлээрэй. Мөн жүжиглэн тоглох үедээ тухайн дүрийн нүүрний хувирлыг дуурайн үзүүлж үгийг зөв хэлбэл урамшуулаарай.

**Боломжууд:**

Хүүхдүүд үлгэрийн үйл явдалд хариу үйлдэл үзүүлж, сонсоход бэлэн байгаа эсэхийг анхаарна. Анхааралтай чимээгүй сонсохын тулд хөдөлгөөнгүй суух, анхаарлаа төвлөрүүлэх зэргээр зөвлөгөө өгөөрэй. Ингэснээр хүүхэд үлгэрийн үйл явдлыг илүү сайн ойлгож чадна. Бусдаас харамлах үйлдэл гаргадаггүй гэж хэлсэн ч зарим үед харамлах үйлдэл гаргаж магадгүй. Энэ үед бусадтай хуваалцах нь сайн үйл гэдгийг ойлгуулж, дадал болтол тайвнаар, эелдгээр дэмжлэг үзүүлээрэй.

**Үйл ажиллагааны төлөвлөлт:**

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
<ul style="list-style-type: none"><li>- ХЯЗ.2д. Үйл явдлын эхлэл, өрнөл, төгсгөл хэсгийг тоочиж ярина.</li><li>- НСХЗ.2а. Бусдын, сэтгэл хөдлөлийн таатай, таагүй, байгааг тайлбарладаг болно.</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>- Уншиж өгсөн, үлгэр зохиолын тухай энгийн асуултад хариулах, эхэнд төгсгөлд юу болсныг өөрийн үгээр ярих</li><li>- Нүүрний хувирал, биеийн мэдрэмжийг илэрхийлсэн зурагт картуудыг ашиглан таатай, таагүй мэдрэмжийг ялгах</li></ul>	Цэнхэр навчис байдаг болов уу?
<ul style="list-style-type: none"><li>- ХӨГЗ.1б. Богино үгтэй дууг аянд тохируулж бусадтай хамтран дуулна.</li><li>- ХӨГЗ.1г. Аялгууны өөрчлөлтийг мэдэрч хөдөлгөөнөөр илэрхийлнэ.</li><li>- ХЯЗ.2а. Харилцан ярианд өөрийн санаачилгаар оролцож санал бодлоо илэрхийлнэ.</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>- Дууг анхааралтай сонсох, дууны утга санаа, аялгууны шинж төрх зэргийг ярилцах, дууны үгийг тод хэлж, амьсгааг зөв хуваарилан дуулах</li><li>- Аялгууг сонсоод дууны хэмнэлд тохируулан хөгжимт хөдөлгөөн хийх</li><li>- Төрөл бүрийн сэдэв, үйл явдлын тухай харилцан ярьж тайлбарлах</li></ul>	Өгөөмөр сэтгэл гэж юу вэ?
<ul style="list-style-type: none"><li>- ЗУЗ.3в. Тоглоом болон байгалийн материал, дахин ашиглах материалаас сонгож, хүрээлэн буй орчноо бүтээнэ.</li><li>- БНОЗ.1г. Цаг агаарын байдлыг зураг, тэмдэг ашиглан илэрхийлж, тохирсон хувцас болон хийх үйл ажиллагааг сонгож тайлбарлана.</li><li>- МЭТЗ.3а. Тоглоом юмсаас нэг шинжээр 4 хүртэлх хэсэгт ангилж байрлуулна.</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>- Дахин ашиглах материалаар (цаасан хайрцаг, нэг удаагийн аяга таваг) болон байгалийн материалаар зохин бүтээх</li><li>- Өдөр тутмын цаг агаарыг ажиглах, цаг агаарын тухай зурган карт, самбар дээр тэмдэглэгээ хийх (цэлмэг, бороотой, цастай, салхитай, нартай гэх мэт)</li><li>- Тоглоом, юмсыг өнгөөр нь ангилж тоглох</li></ul>	Навчсаар урлахуй
<ul style="list-style-type: none"><li>- ХЯЗ.2б. Харилцан ярианд сонирхсон зүйлийн тухай асууж, тодруулна.</li><li>- ХЯЗ.1а. Асуултыг ойлгож хариулт өгнө.</li><li>- НСХЗ.2в. Зан үйлүүдийг яагаад тустай, тусгүй болохыг тайлбарладаг болно</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>- Сонссон үлгэр, өгүүллийг өөрийн үгээр эргүүлэн ярьж, асуудлыг хэрхэн шийдсэн тухай өөрийн дүгнэлт, харьцуулалтыг хэлэх</li><li>- “Энэ зохиолд ямар үйл явдал болсон бэ?” “Чи энэ зохиолоос юу ойлгосон бэ?” гэх мэт асуултын дагуу үйл явдлыг ярих</li><li>- Үлгэр, түүхийн баатруудын үйлүүдийг яагаад тустай болон тусгүй болоход бусдад тайлбарлах</li></ul>	Ногоон цэнхэр харандаа

<ul style="list-style-type: none"> <li>- ХЭМ3.1д. Алхалт, гүйлт бүхий хөдөлгөөнт тоглоомыг хамтран тоглоно.</li> <li>- МАТ3.1а. 10 хүртэлх тоог цээжээр тоолох, 5 хүртэлх тооны юмсыг оноож тоолох, өгсөн тооноос эхэлж эхэлж 1-ээр нэмэгдүүлэн тоолж, тоог жишнэ. (бодит юмсын олон, цөөнийг ялгаж жиших)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хэрэглэл ашиглан алхалт, гүйлтийн төрлүүдийн дагнасан буухиа тоглоом тоглох</li> <li>- 10 хүртэл цээжээр тоолж (шалан дээр байрлуулсан 1-10 тоог үсэрч алхаж, мөлхөх зам дагаж явахдаа нэрлэх гэх мэт) тоглох</li> </ul>	<p style="text-align: center;">Аялангаа тоглоё</p>
<ul style="list-style-type: none"> <li>- ХЯ3.2д. Үйл явдлын эхлэл, өрнөл, төгсгөлийг өөрийн үгээр ярина.</li> <li>- ЗУ3.2а. Өөрийн бодол төсөөллөөр зохиомжлон зурна.</li> <li>- ЗУ3.2б. Өөрийн бүтээлдээ тохирох өнгийг сонгож будна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Уншиж өгсөн үлгэр зохиолын үйл явдлын тухай энгийн асуултад хариулах, эхэнд, төгсгөлд юу болсныг өөрийн үгээр ярих</li> <li>- Зураас, дүрсээр зохиомжлон, гэр байшин гудамж зэрэг хүрээлэн буй орчноо өөрийн төсөөллөөр дүрслэн зурах</li> <li>- Будаг хольж үүсмэл өнгө үүсгэх</li> <li>- Бүтээлдээ тохирох өнгийг сонгож будах</li> </ul>	<p style="text-align: center;">Намрын навч</p>

Албан хэрэгцээ

### 10 дугаар сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Навчны тухай ярилцъя	Тойргийн цаг	Навчны өнгө, хэлбэрийн тухай мэдлэгийг бататгаж ярилцана. Нэмэлт тайлбар өгнө.	Бодит үзүүлэн (өнгө өнгийн навч).	Навч ямар өнгө, хэлбэртэй байдаг вэ? Навчны судлууд юунд хэрэгтэй вэ?.	Харилцах. Өөрийн санаагаа илэрхийлэн ярих	Энгийн асуултыг ойлгож хариулдаг.
Цэнхэр навчис	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	В.Осеевагийн “Цэнхэр навчис” зохиолыг цахимаар танилцуулж, тусч өгөөмөр занг ойлгуулна.	Цахим хэрэглэгдэхүүн цахим холбоос	Цэнхэр навчис байдаг уу?	Нийгэм, сэтгэл хөдлөл: Бусдад энэрэнгүй хандах тухай ойлгох	Үлгэр зохиолын тухай энгийн асуултад хариулдаг.
Нүүрний хувирал	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүний нүүрний хувирлаар сэтгэл хөдлөл илэрдгийг тайлбарлаж, зохиолын баатруудын таатай, таагүй мэдрэмжийг нүүрний хувирлаар ялгах.	Нүүрний хувиралтай зурагт картууд, дэлгэц цаас.	Катя ногоон харандаагаа харамлахад ямар нүүрний хувирал үзүүлсэн бэ? Лена багшид цэнхэр навчсаа үзүүлэхдээ ямар царай гаргасан бол?	Нийгэм, сэтгэл хөдлөл: Сэтгэл хөдлөлийг таньж мэдрэх	Нүүрний хувирлаар таатай таагүй сэтгэл хөдлөлийг ялгадаг.
Тусалцаа	Төвийн үйл ажиллагаа	Хүүхдүүдийг 5 багт хувааж, багийн нэг гишүүнд илүү нэгэнд нь дутуу хэрэглэгдэхүүн өгч даалгавар гүйцэтгүүлж, тусламж хэрэгтэй найздаа хэн яаж тусалсныг ярилцана.	Дэлгэц цаас, дүрийн зураг (Төвийн хэрэглэгдэхүүн)	Тусламж хэрэгтэй найзаа хамгийн түрүүнд хэн олж харсан бэ?; Хэн найздаа яаж тусалсан бэ?.	Хамтран ажиллах: Туслах, харамгүй хуваалцах	Өөрийн үйлдэл бусдад хэрхэн нөлөөлдгийг тайлбарладаг.
Жүжиглэцгээе	Хөгжөөн баясах цаг	“Цэнхэр навчис” зохиолын дүрүүдийг бүтээж жүжиглэн тоглох. Зохиолыг эергээр өөрчилж тоглох.	Ногоон харандаа.	Зохиолыг яаж өөрчилж болох вэ?; Хэнд ямар санаа байна вэ?.	Хамтран ажиллах: Дүр бүтээж хамтран ажиллах	Үлгэр зохиолыг дүрд хувирч тоглодог.
Сонсьё / Дуу сурцгаая	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	“Өгөөмөр сэтгэл” дууг сонсож, сурна. Дууны үгийг мөр мөрөөр цээжилнэ. Дууны утга санааг ярилцана.	Хөгжим, дууны ая; Даралтат хөгжим, дууны үг.	Хэрвээ Катя ногоон харандаагаа сайхан сэтгэлээр өгсөн бол юу болох байсан бэ?.	Хамтран ажиллах: Дууг хамтран дуулах	Дууны үгийг тогтоож аялгуулан дуулахыг оролддог.

Өгөөмөр тойрог тоглоом	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Дууны аянд зурагт үзүүлэн (Найздаа өгөх, инээмсэглэх, зүрх) ашиглан хөдөлгөөнөөр илэрхийлж тоглоно.	Зурагт үзүүлэн.	Өгөөмөр байвал ямар сайхан зүйл тохиолдох вэ?.	Хамтран ажиллах: Дууны аянд тохируулан хамтарч хөдөлгөөн хийх	Аялгууны хэмнэлийн өөрчлөлтийг мэдэрч хөдөлгөөнөөр илэрхийлдэг.
Навчаа цуглуулъя	Зугаалга	Гадаад талбайд гарч шарласан навч түүж ажиглана. Цаг агаарын байдлыг (цэлмэг, бүрхэг) ажиглаж, шинэ үгсийг тайлбарлана.	Навч хийх уут, сав, хатсан навч.	Гадаа цаг агаар ямар байна вэ?	Нийгэм, сэтгэл хөдлөл: Аюулгүй байдлыг ойлгох	Хөдөлмөр хийхэд оролцдог. Цаг агаарын байдлыг ажиглаж хэлдэг.
Навчаа ангилцгаая	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Түүсэн навчийг өнгө, хэлбэр, хэмжээгээр нь ангилж, саванд хийх. Ангилахдаа оноож тоолно	Сагснууд, хатсан навч.	Сагсанд хэдэн навч байна вэ?	Шүүн тунгаах: Ангилж нэрлэх	10 хүртэл юмсыг ангилан ялгаж, оноож тоолдог.
Навчаар урласан миний бүтээл	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Ангилсан навчаа ашиглан өөрийн хүссэн бүтээлээ хийх, хэрэглэгдэхүүнээ өөрсдөө сонгоно. Бүтээлээ тайлбарлана.	Өнгийн цаас, цавуу, балын харандаа, хайч, навч, эсгий бал, маркер, скоч.	Бүтээлдээ ямар нэр өгсөн бэ? Ямар ямар материал орсон бэ?	Харилцах: Бүтээлээ тайлбарлах	Байгалийн материал ашиглан бүтээл урлан бүтээдэг.
Зөв ба буруу	Тойргийн цаг	Сайн, муу үйлийг ялгаж харьцуулж ярилцах. Зөв/буруу үйлдлийг зурагт үзүүлэн дээр тэмдэглэнэ.	Зурагт үзүүлэн.	Найзаасаа харамлах нь зөв үү? Буруу юу?; Яагаад зөв/буруу гэж бодож байна вэ?.	Нийгэм, сэтгэл хөдлөл: Зөв, буруу зан үйлийг ялгаж ойлгох	Бусдын сэтгэл хөдлөлүүдийг ажиглаж, яагаад таатай, таагүй байгааг тайлбарладаг.
Яагаад зөв, буруу вэ?	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Тараах материал дээрх зургуудад зөвийг ногооноор, бурууг улаанаар тэмдэглэж зурах ба яагаад ингэж тэмдэглэсэнээ тайлбарлана.	Тараах материал, ногоон, улаан өнгийн харандаа.		Нийгэм сэтгэл хөдлөл: Шалтгааныг тайлбарлах Харилцах: Санаа илэрхийлэх	Асуултыг ойлгож хариулт өгдөг.
Тодруулцгаая	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	"Цэнхэр навчис" зохиолд тулгуурлан, хүүхдүүдийг гуйх, зөвшөөрөл авах, анхааруулах зэрэг асуулт зохиоход чиглүүлнэ.	Дэлгэц цаас, дүрүүдийн зураг (Лена, Катя, Ээж, Ах, Багш).	Хүнээс юм гуйхдаа юу гэж асуух вэ? Гуйх асуулт зохиогоорой. Багш нь Катяд хандаж юу гэж хэлсэн бэ?	Харилцах: Ойлгохгүй зүйлээ тодруулах, асуулт асуух	Асуулт зохиож асуудаг.

				(Анхааруулах асуулт зохиох).		
Шидэт зам	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Зоригт аялагчид болж, тодорхой хэмнэлтэй дохионы дагуу (1, 2 - урагш алхах, 3 - зогсох, 4 - ухрах) алхалт, гүйлт, хөдөлгөөн гүйцэтгэнэ. "Шидэт зогсоол" дээр даалгавар хийнэ.	"Шидэт зогсоол" тэмдэглэгээ, цэнхэр навчны зурагтай тараах материал.	Буухиа тоглоом тоглоно.	Хамтран ажиллах: Дүрэм баримтлах	Хөдөлгөөнт тоглоомын дүрмээ баримталдаг.
Тэнцвэртэй хүүхдүүд	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Вандан сандал дээгүүр тэнцвэрээ хадгалан гарын хөдөлгөөнтэй хослуулан алхах. 10 см өндөр саад давж, мөн хойш ухарч алхах даалгаврыг гүйцэтгэнэ.	Зураас, вандан сандал, 10 см өндөр саад.	Буухиа тоглоом тоглоно.	Хамтран ажиллах: Зааврыг дагах Нийгэм, сэтгэл хөдлөл: Анхаарлаа төвлөрүүлэх	Вандан сандал дээр тэнцвэрээ хадгалан алхдаг.
Чирта	Зугаалга	Жижиг цагаригийг чирта хэлбэрээр байрлуулж, 1-10 хүртэлх цифрийг тавина. Цагаригаас цагаригт нэг ба хоёр хөлөөрөө үсрэхдээ тоогоо хэлнэ.	Цагариг, цифр.	Хөдөлгөөнт тоглоом тоглоно.	Хамтран ажиллах: Дүрэм баримтлах Шүүн тунгаах: Тоолж жиших	Цагаригаас цагаригт дамжин нэг ба хоёр хөл дээр үсрэн явдаг. 1-10 хүртэл юмсыг дараалуулан тоолдог.
Ярилцъя / Навчны өнгө	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Ногоон өнгө байхгүй үед асуудлыг хэрхэн шийдэх тухай ярилцана. Үндсэн 3 өнгийн гуашийг хольж ногоон өнгө (үүсмэл өнгө) үүсгэх туршилт хийнэ.	Зургийн цаас, гуаш (үндсэн 3 өнгө), бийр.	Ногоон өнгийг өөр ямар өнгөөр үүсгэж болох вэ?; Ямар өнгөнүүдийг холиход навчны өнгө үүсэх вэ?.	Шүүн тунгаах: Асуудлыг олж шийдвэрлэх	Туршилтад оролцдог. Хийсэн туршилтын үр дүнг тайлбарлан ярьдаг.
Сонирхолтой навч	Төвийн үйл ажиллагаа	1. Дүрслэх урлагийн төв: Будсан цаасан дээр навчны хэлбэр, судлуудыг зураасны төрлүүдийг ашиглан зурна. 2. Туршилтын төв: 2 өөр навчны хээ, судлуудыг ажиглаж, өөрчлөлтийг харьцуулж тайлбарлана.	Зурагт үзүүлэн (зураасны төрөл), будсан цаас, балын харандаа, хайч, навч, томруулдаг шил.	Навчин дээр юу байдаг вэ? Энэ хоёр навч юугаараа өөр байна вэ?	Шүүн тунгаах: Төсөөлөн зурах, бүтээх	Төрөл бүрийн зураас ашиглан зурдаг. Хоёр зүйлийг харьцуулан ажиглаж ялгааг тайлбарладаг.

## 10 дугаар сарын I долоо хоног

### ЦЭНХЭР НАВЧИС БАЙДАГ БОЛОВ УУ?

**Шинэ үг:** Харамлах, нүүрний хувирал

**Үйл ажиллагаа 1.** Навчны тухай ярилцъя (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Бодит үзүүлэн (өнгө өнгийн навч)

**Аргачлал:** Навчны талаар ярилцана.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Навч ямар өнгө, хэлбэртэй байдаг вэ?
- Навчин дээр юу байдаг вэ?
- Навчны судлууд юунд хэрэгтэй вэ?

Багш навчны тухай мэдлэгийг бататгаж тайлбар өгнө.

**Үйл ажиллагаа 2.** Цэнхэр навчис (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Цахим хэрэглэгдэхүүн

**Аргачлал:** Оросын хүүхдийн зохиолч В.Осеевагийн “Цэнхэр навчис” зохиолыг хүүхдүүдэд цахимаар дамжуулан танилцуулна. /цахим холбоос 1./

**Үйл ажиллагаа 3.** Нүүрний хувирал (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Дэлгэц цаас, дүрийн зураг, цавуу, нүүрний хувиралтай зурагт картууд

**Аргачлал:** Багш самбарыг хоёр хувааж Лена, Катя хоёрын зургийг хоёр талд байрлуулах ба нүүрний хувирлын зургийг бэлтгээд асуултаар чиглүүлж ярилцана.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Лена найзаасаа харандааг гуйхад аль нүүрний хувирлыг гаргасан бэ?
- Катя “-Ээжээсээ асууя” гэж хэлэхэд царай нь Ленагийн царайнд ямар хувиралтай болсон бэ?
- Катя “-Юун их юм зурдаг юм бэ?” гэж хэлээд хөмсгөө зангидахдаа ямар нүүрний хувирлыг үзүүлсэн бэ?
- Лена “Хэрэггүй ээ” гэж хэлээд явахад ямар нүүрний хувирал гаргасан бэ?
- Лена багшид цэнхэр өнгөөр будсан навчсын зургаа үзүүлэхдээ ямар царай гаргасан бол?
- Катя чавга шиг улаан болохдоо ямар царайны хувирал үзүүлсэн бэ?

Дараа нь түлхүүр үгсийг хүүхдүүд давтаж хэлнэ. /харандааг гуйсан, ээж, ахаасаа асуусан, харандаагаа харамласан, өгөхгүй гэж татгалзсан, буруу будсандаа санаа зовсон, харамласандаа ичсэн/ Багш түлхүүр үгтэй нүүрний хувирлыг холбож тайлбарлана. /харамлахдаа ямар нүүрний хувирал гаргасан бол? гэх мэт/

**Үйл ажиллагаа 4.** Тусалцгаая (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Дэлгэц цаас, дүрийн зураг, цавуу, нүүрний хувиралтай зурагт картууд

**Аргачлал:** Хүүхдүүд 5 баг болж хуваагдана. Багш баг бүрд чиглүүлэг өгнө. (зураг зурах, цэцэг услах, эвлүүлдэг тоглоомоор байшин барих, ном үзэх, гараа угаах гэх мэт). Чиглүүлэг өгөхдөө багийн нэг гишүүнд тоглоом, хэрэглэгдэхүүнээс дутуу өгөх бол нэг гишүүнд илүү өгнө. Хүүхдүүд тухайн үйл ажиллагааг 10 минутын хугацаанд хийж гүйцэтгээд багаараа самбарын урд цугларч ярилцлага хийнэ.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Танай багийн хэнд ямар асуудал тулгарсан бэ?
- Тэр найз нь бусдаас туслаач гэж гуйсан уу?
- Тусламж хэрэгтэй найзаа хамгийн түрүүнд хэн олж харсан бэ?
- Хэн найздаа яаж тусалсан бэ? Багш тайлбар өгч үйл ажиллагааг дүгнэнэ.

**Үйл ажиллагаа 5.** Жүжиглэцгээе (Хөгжөөн баясах цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Ногоон харандаа

**Аргачлал:** Багш хүүхдүүдээс “Цэнхэр навчис” зохиолын дүр бүтээх сайн дурын 5 хүүхдийг сонгоно. Хүүхдүүд өөрийн сонгосон дүрийн үгийг багштай хамтран давтан хэлж, тогтооно.

Хүүхдүүд самбарын өмнө гарч зохиолыг жүжигчлэн тоглох бөгөөд үгээ мартсан тохиолдолд багш үгийг сануулж дэмжлэг үзүүлнэ.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Зохиолыг яаж өөрчилж болох вэ?
- Хэнд ямар санаа байна вэ?

Бусад хүүхдүүдээр дахин дүрийг сонгуулж тоглоно. Жүжиг дууссаны дараа багш найзаасаа харамлаж болохгүй талаар дүгнэн ярилцана.

## ӨГӨӨМӨР СЭТГЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

**Шинэ үг:** Өгөөмөр, сэтгэл

**Үйл ажиллагаа 1.** Сонсьё (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Хөгжим, дууны ая

**Аргачлал:** Хүүхдүүд танхимд ороод хичээлд бэлтгэнэ.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Та нар найзуудтайгаа тоглоом, харандаагаа хуваалцаж байсан уу?
- Хэрвээ Катя ногоон харандаагаа сайхан сэтгэлээр өгсөн бол юу болох байсан бэ?

“Өгөөмөр сэтгэл” дууг сонсгоно.

**Үйл ажиллагаа 2.** Дуу сурцгаая (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Даралтат хөгжим, дууны үг

**Аргачлал:** Хүүхдүүд инээмсэглэнгээ “хи-хи-хи” - “ха-ха-ха” - “хо-хо-хо” гэж 3 өнгө дээр дуулна. Гараараа цэцэг дэлбээлэх хөдөлгөөн хийнэ. Дууны шүлгийг мөр мөрөөр хэлж цээжлүүлнэ, мөрөөр нь аялгууг заана. Хүүхдүүд хэсэг хэсгээр нь даган дуулна.

**Үйл ажиллагаа 3.** Өгөөмөр тойрог тоглоом (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Зурагт үзүүлэн

**Аргачлал:** Багш хүүхдүүдтэй ярилцаж, дууны аянд зурагт үзүүлэнг харуулж, тухайн хөдөлгөөнийг зааж өгнө.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Чи ингэж найздаа өгч байсан уу?
- Дуунаас чи юу ойлгосон бэ?
- Өгөөмөр байвал ямар сайхан зүйл тохиолдох вэ?

Жишээ хөдөлгөөн: “Найздаа өгч байна” зураг өгөхөд -гараа сунгах хөдөлгөөн, “Инээмсэглэх” зураг өгөхөд - гараа дэлгэж инээх, “Зүрх” зураг өгөхөд -зүрхэн дээр гараа тавьж хоёр тийш хөдөлнө гэх мэт

## НАВЧСААР УРЛАХУЙ

**Шинэ үгс:** Цэлмэг, бүрхэг

**Үйл ажиллагаа 1.** Навчаа цуглуулъя (Зугаалга)

**Хэрэглэгдэхүүн:** Навч хийх уут, сав, хатсан навч

**Аргачлал:** Хүүхдүүд цэцэрлэгийн гадна талбайд гарч навч түүнэ. Цаг агаарын байдлыг ажиглаж тэнгэр цэлмэг, бүрхэг ямар байгааг асууж ярилцахдаа шинэ үгсээ тайлбарлана. Модны навчис ямар өнгөтэй болсон байгааг ажиглуулж тайлбар өгнө. Ямар навч түүх тухай заавар өгнө. Навчаа түүсний дараа ангидаа орж ирэн навчийг хэрхэн түүсэн тухай ярилцана.

**Үйл ажиллагаа 2.** Навчаа ангилцгаая (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Сагснууд, хатсан навч

**Аргачлал:** Багш бүх хүүхдийн түүсэн навчийг ширээн дээр гарган дэлгэж хэмжээ болон өнгөөр нь ижил навчийг цуглуулж саванд хийх даалгавар өгнө. Хүүхэд бүр саванд ангилж ялгахдаа оноож тоолно. Оноож тоолоход нь дэмжлэг үзүүлнэ. Цуглуулж ангилсан навчийг дүгнэж тайлбарлана.

**Үйл ажиллагаа 3.** Навчаар урласан миний бүтээл (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Өнгийн цаас, цавуу, балын харандаа, эсгий бол, маркер, скоч

**Аргачлал:** Өмнөх үйл ажиллагаагаар ангилсан навчаа багш хүүхдүүдийн голд ширээн дээр тавина. Мөн хайч, цавуу, өнгийн цаас, балын харандаа, эсгий бол, маркер зэргийг өргөн сонголттойгоор байрлуулна. Навчаа ашиглан бүтээл хийнэ. Хэдэн ч навч ашиглан, ямар ч бүтээл хийж болох тухай хүүхдэд заавар өгнө. Хүүхдүүдийг өөрсдөө юу хийхээ бодож төлөвлөөд навч болон хэрэглэгдэхүүнээ сонгоорой гэсэн чиглүүлэг өгнө. Хүүхдүүд бүтээлээ хийж дууссаны дараа ямар сэдэвтэй бүтээлийг юу ашиглан хэрхэн хийснээ тайлбарлана.

## 10 дугаар сарын II долоо хоног

### НОГООН, ЦЭНХЭР ХАРАНДАА

**Шинэ үг:** Сайн үйл, муу үйл

**Үйл ажиллагаа 1:** Зөв ба буруу (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Зурагт үзүүлэн

**Аргачлал:** Хүүхдүүд сайн, муу үйлдэл харуулсан зурагт үзүүлэнг ажиглаж багшийн асуултад хариулж ярилцана.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Эхний зургийг ажиглаарай. Зураг дээр хүүхдүүд юу хийж байна вэ?
- Найзаасаа харамлах нь зөв үү? Буруу юу?
- Яагаад зөв эсвэл яагаад буруу гэж бодож байна вэ?
- Дараагийн зургийг ажиглаарай, хүүхдүүд юу хийж байна вэ?
- Найзтайгаа хуваалцах нь зөв үү? Буруу юу?
- Зөв гэж ямар тэмдэглэгээгээр тэмдэглэх вэ? сонгоод өргөөрэй.
- Буруу үйлдлийг ямар тэмдэглэгээгээр тэмдэглэх вэ? сонгоод харуулаарай.

**Үйл ажиллагаа 2.** Яагаад зөв, буруу вэ? (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Тараах материал, ногоон, улаан өнгийн харандаа

**Аргачлал:** Багш хүүхдүүдэд тараах материалыг бэлтгэж өгнө. Хүүхдүүд зургуудыг ажиглаад хоосон нүдэнд зөв, буруу тэмдэглэгээг ялгаж зурна. Зурахдаа зөвийг ногоон өнгөөр, бурууг улаан өнгөөр зурж тэмдэглэнэ. Яагаад буруу, зөвөөр тэмдэглэсэнээ тайлбарлана.

**Үйл ажиллагаа 3.** Тодруулцгаая (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Дэлгэц цаас, дүрүүдийн зураг, цавуу, эсгий бал

**Аргачлал:** “Цэнхэр навчис” зохиолын тухай дэлгэц цаасан дээр нааж, зураглал хийж ярилцана. Багш тулгуур зургуудыг ашиглан хүснэгт бүтээж дээр нь наах байдлаар хүүхдүүдийг асуулт зохиоход чиглүүлнэ. Дэлгэц цаасан дээр Лена, Катя хоёрын зургийг наагаад дунд нь ногоон харандааны зураг байрлуулна. Доод хэсэгт 1 дэх өдөр ээж, 2 дахь өдөр ах, 3 дахь өдөр багшийн зургийг тус тус байрлуулна.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Хүнээс юм гуйхдаа юу гэж асуух вэ? Гуйх асуулт зохиогоорой.
- Эхний өдөр охин хэнээс асууя гэж хэлсэн бэ? Асуух асуулт зохиогоорой.
- Ээжээсээ ямар үг хэлж зөвшөөрөл авсан бэ? Зөвшөөрөл авах асуулт зохионо.
- Багш нь Катяд хандаж юу гэж хэлсэн бэ? Анхааруулах асуулт зохионо.

Хүүхдүүдийн зохиосон асуултыг засаж зөв болгоно. Багш дэлгэц цаасан дээр хийсэн ажлаа дүгнэж тайлбар өгнө.

## АЯЛАНГАА ТОГЛОЁ

**Шинэ үг:** Дохио, зогсоол, хойш ухрах

**Үйл ажиллагаа 1.** Шидэт зам (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** “Шидэт зогсоол” тэмдэглэгээ, цэнхэр өнгийн навчны зурагтай тараах материал

**Аргачлал:** Зоригт бяцхан аялагчид болж, гайхалтай аялал хийхдээ даалгавар гүйцэтгэнэ. Хүүхдүүд зураасны ард зэрэгцэн зогсоно. Багш дохио өгмөгц алхалт болон гүйлтийг гүйцэтгэнэ. “Шидэт зам” болгохын тулд хүүхдүүд тодорхой хэмнэлтэй алхана, гүйнэ. Жишээ

нь: 1,2- гэхэд урагш алхана, гүйнэ, 3 - гэхэд дороо зогсоно, 4-гэхэд ухарч алхана, гүйнэ. Багш зам дээр зарим хэсэгт “Шидэт зогсоол” тэмдэглэгээг тавина. Зогсоолд хүрэх үед хүүхдүүд суниах, эргэх гэх мэт даалгавар гүйцэтгэнэ.

**Үйл ажиллагаа 2.** Мэлхий дасгал (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Бичлэг

**Аргачлал:** Хүүхдүүд бичлэгийг үзээд дасгалыг дагаж хийнэ. /цахим холбоос 5/

**Үйл ажиллагаа 3.** Тэнцвэртэй хүүхдүүд (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэл:** Зураас, вандан сандал, 10 см өндөр саад

**Аргачлал:** Хүүхдүүдийн тэнцвэрийн чадварыг дэмжих тоглоом тоглоно. Талбайн голд вандан сандал байрлуулна. Хүүхдүүд нэгийн цуваанд зогсоно. Багшийн дохиогоор вандан сандал дээгүүр тэнцвэрээ хадгалан гарын хөдөлгөөнтэй хослуулан алхана. Дараа нь вандан сандал дээр 10 см-ийн өндөртэй саадыг байрлуулна. Хүүхдүүд тэнцвэрээ хадгалан саадыг давж алхана. Вандан сандал дээгүүр хойш ухарч алхана. Эдгээр даалгаврыг багш хөнгөнөөс нь хүндрүүлж гүйцэтгүүлнэ. Хүүхдүүдэд биечлэн хийж үзүүлнэ.

Анхаарах зүйл:

- Вандан сандлын голд хоёр хөлөө байрлуулж алхаарай.
- Алхахдаа яарахгүй, тайван алхана.
- Саадыг давахдаа биеийн тэнцвэрийг хадгалж, гарын хөдөлгөөнтэй хослуулан алхана.
- Ухарч алхахдаа баруун, зүүн аль нэг мөрөн дээгүүр толгойгоо эргүүлэн харж алхана.

**Үйл ажиллагаа 4.** Чирта (Зугаалга)

**Хэрэглэгдэхүүн:** Цагариг, цифр

**Аргачлал:** Жижиг цагаригийг чирта хэлбэрээр байрлуулан 1-10 хүртэл тооны цифрийг дарааллын дагуу байрлуулж цагаригаас цагаригт үсэрч тоглоно. Нэг цагаригт нэг хөлөөрөө үсрэх, хоёр цагариг тавьсан бол хоёр хөлийг бүтэн улаар нь тавиад цагаригаас цагаригт үсэрч явахыг тайлбарлаж өгнө. Үсэрч явахдаа хүүхдүүд хөл тавьсан цагаригийнхаа тоог хэлж үсэрнэ. /хувилбар 1: чиртанаас өөр хэлбэрээр цагаригуудаа цувуулан байрлуулж болно./

## НАВЧИС

**Шинэ үг:** Үүсмэл өнгө, зураас, судал

**Үйл ажиллагаа 1.** Ярилцъя (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Аргачлал:** Багш “Цэнхэр навчис” зохиолыг сэргэн сануулж ярилцана.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Лена охинд яагаад ногоон өнгийн харандаа байхгүй байсан бэ?
- Та нар юу гэж бодож байна вэ?
- Хэрвээ чи байсан бол яах байсан бэ?

Хичээлийн хэрэгслээ эмх цэгцтэй, ариг гамтай хэрэглэх талаар тайлбарлана. “Цэнхэр навчис” зохиолын тухай ойлгосноо ярих даалгавар өгнө. Хүүхдүүд зохиолыг өөрийн үгээр бусад хүүхдийн гарч ирж ярьж өгнө. Багш ярьж байгаа хүүхдийн өгүүлбэрийн утга найруулгатай илэрхийлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

**Үйл ажиллагаа 2.** Навчны өнгө (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Зургийн цаас, гуаш, бийр

**Аргачлал:** Лена ямар учраас цэнхрээр навч будсан тухай эргэн сануулж ярилцана.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Хэрэв чамд ногоон өнгө байхгүй байвал чи яаж асуудлаа шийдэх вэ?
- Ногоон өнгийг өөр ямар өнгө үүсгэж болох вэ?
- Ямар өнгөнүүдийг холиход навчны өнгө үүсэх вэ?

Багш хүүхдүүдэд үндсэн 3 өнгийн гуашийг бэлтгэж өгөх ба хүүхдүүд өөрсдөө ногоон өнгөө үүсгэнэ. Навч ногооноос өөр ямар өнгөтэй байгааг харуулж эдгээр навчны өнгийг үүсгэх даалгавар өгнө. Хүүхдүүд цаасыг өөрсдийн үүсгэсэн өнгөөр будна.

### Үйл ажиллагаа 3. Сонирхолтой навч (Төвийн үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Зурагт үзүүлэн (зураасны төрөл), будсан цаас, балын харандаа, хайч, навч, томруулдаг шил

**Аргачлал:** Багш туршилт болон дүрслэх урлагийн төвд хүүхдүүдтэй ажиллана. Дүрслэх урлагийн төв сонгосон хүүхдүүдэд зураасны төрлүүдийг зурагт үзүүлэн дээр тайлбарлаж өгнө. Мөн навчийг бодитоор нь үзүүлж ажиглуулна. Хүүхдүүд өмнөх үйл ажиллагааны дээр өнгө үүсгэн будсан цаасан дээрээ өөрийн хүссэн хэлбэр, дүрстэй навч, зурсан навчин дээрээ судлуудыг зурах даалгавар гүйцэтгэнэ. Зарим хүүхдэд навч болон судал зурахад нь багш дэмжлэг үзүүлнэ. Зурсан навчаа хайчилна.

Туршилтын төвд ажиллах хүүхдүүд 2 өөр навчны хээ, судлуудыг ажиглаж өөрчлөлтийг харьцуулж тайлбарлана.

### Сонсъё, дэмжье/ Туслалцаа:

- Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдээр дасгал гүйцэтгүүлэхдээ сандал дээр суулгасан байдалд гар, хөлөө зөрүүлэн өргөж алхах, гүйх мэт хөдөлгөөн хийж болно.
- Хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан хэрэглэгдэхүүнийг тохируулахад анхаарч, тэдний хэрэгцээнд нийцсэн дэмжлэгийг үзүүлнэ.

### Эцэг эхтэйгээ хамтаръя.

- Биеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг үгээр илэрхийлэхэд нь дэмжлэг үзүүлэх;
- Бусадтай харилцах эерэг орчин бүрдүүлэх;
- Бусдаас зөвшөөрөл хүсэх, найзтайгаа хуваалцаж хэрэглэх, бусдад туслах, урам зориг өгөх зэрэг ач тустай үйлийг нь дэмжиж урамшуулах;

Цахим холбоос:

1. <https://www.youtube.com/watch?v=7Yz9e-Axw2s>
2. <https://www.youtube.com/watch?v=F1eVOo0e-hQ>

### Багшийн эргэцүүлэмж

**Эргэцүүлэл** /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ./

Амжилттай хэрэгжүүлсэн: .....

Сул хэрэгжүүлсэн:.....

Цаашид сайжруулах:.....

Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа: .....

## СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - XI САР

### ХӨГЖИЛТЭЙ ТОГЛООМУУД

#### Хүүхдийн эзэмших чадамж

**Харилцах:** Хүүхэд харилцан яриа, туршилт, дүрд тоглох зэрэгт өөрийн санаачилгаар оролцож, асуултыг ойлгож хариулах, санал бодлоо хуваалцах чадварыг эзэмшихээс гадна өөрт төрсөн мэдрэмж, сэтгэл хөдлөлөө тайлбарлах, уур бухимдлаа удирдаж тайвшрах зэргээр эерэг харилцаанд суралцана.

**Бүтээлчээр сэтгэх:** Хүүхэд хүрээлэн буй орчин болон амьтдын амьдрах орчныг ажиглаж, ялгах, асуултын дагуу шалтгаан үр дагаврыг дүгнэх, өөр хувилбар дэвшүүлж, туршиж үзэх зэргээр бүтээлч сэтгэлгээнд суралцана.

**Шүүн тунгаах:** Хүүхэд юмсын шинж чанарыг ялгах, тоо хэмжээг харьцуулах, шалтгаан үр дагаврыг дүгнэх зэрэг үйлдлүүдээр дамжин хөгжинө.

#### Аюулгүй байдлын зөвлөмж:

Хөдөлгөөнт тоглоом тоглох үед хүүхэд чөлөөтэй гүйх, үсрэх боломжтой талбайг бүрдүүлнэ. Хөгжмийн энгийн зэмсгийг хүүхэд бүрд хүртээмжтэй байдлаар бэлтгэнэ. Хайчтай ажиллах зааврыг хүүхдүүдэд танилцуулж, болгоомжтой хэрэглэх талаар сануулна.

#### Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

*Тойргийн цаг:*

- Хүүхдүүдийн анхаарлыг төвлөрүүлж, нүдээ аниулан төрөл бүрийн хэрэглэгдэхүүн дуугарган гарч буй дуу авиаг таалгаж тоглуулаарай. Ингэснээр тэд сонсголын мэдрэмжээ хөгжүүлээд зогсохгүй, ямар ойлголт мэдлэгтэй байгааг таньж мэдэх боломж бүрдэнэ.
- Хүүхдүүдтэй танин мэдэхүйн ярилцлага өрнүүлж, мэдлэгээ бататгахад нь дэмжлэг үзүүлээрэй.

**Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:**

- Амьтдын үр төлийг зурагт картын тусламжтайгаар танилцуулахдаа тухайн орон нутгийн онцлогт тохирсон амьтдыг сонгож ярилцах нь илүү оновчтой бөгөөд хэрэглэгдэхүүнийг хүүхэд бүрд хүртээмжтэйгээр бэлтгэснээр таны төлөвлөсөн үйл ажиллагаа илүү үр дүнтэй, сонирхолтой өрнөх боломжтой.
- Оноож тоолох, нэгээр нэмэгдүүлэх, хорогдуулах үйлийг бодит зүйлийг цифртэй холбох тоглоомын хэлбэрээр хийлгэх нь илүү үр дүнтэй.
- Уурлаж бухимдсан үедээ 1-10 хүртэл удаан тоолох зэрэг тайвшрах аргуудыг зааж чиглүүлэх нь зүйтэй.

**Төвийн үйл ажиллагаа:**

- Өмнөх сургалт, үйл ажиллагаагаар хийсэн бүтээлүүдийг дахин ашиглан тоглох, баяжуулан хөгжүүлэх зэргээр төлөвлөж болно.
- Хүүхэд сонгосон төв дээр очиход нь тэдний мэдлэг, сонирхолд нийцсэн хэрэглэгдэхүүн хүртээмжтэй байхаар зохион байгуулж ажиллаарай.

**Зугаалга:**

- Хүүхэд бүрийг тоглоомд идэвхтэй оролцуулахын тулд багш болон багшийн туслах хүүхдүүдийг тэнцүү тоогоор хуваан авч, тоглоомыг зохион байгуулан чиглүүлээрэй.

**Хөгжөөн баясах цаг:**

- Орой тарах цагийн өмнө бүлгийн хүүхдүүдийг баясгаж, хөгжилтэй уур амьсгал бүрдүүлэхийн тулд хамтдаа тоглоом тоглох, үлгэр сонсох, ярилцах, жүжигчилсэн тоглоом зэрэг үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлээрэй.

**Боломжууд:**

Зугаалгын үеэр тоглоом зохион байгуулж байхдаа цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалсан бэрхшээл гарвал төлөвлөлтийг өөрчилж тоглоорой. Жишээ нь: салхитай үед цаасан зурагт үзүүлэн хийсэх эрсдэлтэй тул хүүхдүүдийг ээлжлэн барьж зогсох байдлаар зохицуулж болох юм. Хэрэв хөгжмийн энгийн зэмсэг байхгүй бол цэцэрлэгт байгаа бусад боломжит хэрэглэгдэхүүнээр орлуулан ашиглаарай.

“Тоог таниарай” сургалт, үйл ажиллагаанд ашиглах бөглөө хүүхдийн тоогоор бүрдээгүй бол ижил өнгийн цаас, баримлын шавар зэрэг өөр хэрэглэгдэхүүнээр орлуулан ашиглаж болно.

**Үйл ажиллагааны төлөвлөлт:**

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
ХЯЗ.2а.Харилцан ярианд өөрийн санаачилгаар оролцож, санал бодлоо илэрхийлнэ. БНОЗ.1а Амьтдын амьдрах орчныг ялган таньж, тэднийг хамгаалах аргыг нэрлэнэ.	- Төрөл бүрийн сэдэв, үйл явдлын тухай харилцан ярилцах - Амьтдыг амьдрах орчноор нь ялган, хоол тэжээл нь тохирсон нөхцөлд амьдардаг талаар тайлбарлах	Хамтдаа тоглоцгооё
ХӨГЗ.1а. Хөгжмийн энгийн зэмсгийн дуу чимээг ялган таньж, дуугаралтын чанга сул хүчийг тодорхойлно. БНОЗ.1в. Мэдрэхүйн тусламжтайгаар юмсын шинж чанарыг ялгаж харьцуулна. ХЯЗ.1а. Асуултыг ойлгож тодорхой хариулт өгнө.	- “Аль нь чанга вэ?” тоглоом тоглох - Юмсын шинжийг ялган таних асуулт асуух, таамаглах, туршилт хийх - Сонссон зүйлийн тухай дахин давтан өгүүлэх тоглоом тоглох	Сонсоод таая
ЗУЗ.3б. Нугалах, эвхэх, хайчлах аргаар хавтгай болон биет наамлын бүтээл урлана.	- Наамлын багаж хэрэгсэл материалыг бие даан сонгож хэрэглэх	Эртэч тахиа

ХЯЗ.2а. Харилцан ярианд өөрийн санаачилгаар оролцож, санал бодлоо илэрхийлнэ.	- Төрөл бүрийн сэдэв, үйл явдлын тухай харилцан ярилцах	
ХЭМЗ.1к Өргөсөн гараас дээш 10-15см өндөр зүйлд үсэрч хүрнэ. НСХЗ.1б Өөрийн дуртай дургүй чадахгүй зүйлсээ илэрхийлж тайлбарладаг болно.	- Өргөсөн гараас дээш 10-15 см өндөр зүйлд үсэрч хүрэх - Тодорхой үйл явдал, түүнээс чадах, чадахгүй зүйлсийг ярих	Хөгжилтэй үсрэлт
МАТЗ.1а. 10 хүртэлх тоог цээжээр тоолох, 5 хүртэлх тооны юмсыг оноож тоолох, өгсөн тооноос эхэлж нэгээр нэмэгдүүлэн тоолох, тоог жишнэ. ХЯЗ.1а. Асуултыг ойлгож тодорхой хариулт өгнө.	- 5 хүртэл юмсыг оноож тоолох - Сонссон зүйлийн тухай дахин давтан өгүүлэх тоглоом тоглох	Тоог таниарай
НСХЗ.1в. Уурлаж, тавгүйтсэн үедээ бусадтай харилцах, "тайвшрах булан"-д очих зэргээр тайвширдаг болно. ХӨГЗ.1д. Үлгэр, зохиол, дуу, аялгууны дүрийн онцлогийг илэрхийлж тоглоно.	- Дүрд орж жүжиглэн тоглохдоо дүрийн сэтгэл хөдлөл, мэдрэмжийг хэл яриа, биеийн хөдөлгөөнөөр илэрхийлэх	Аа, аа алтан загас

### 11 дүгээр сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Амьтдын үр төл	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Амьтдын үр төлийг зурагт картаар танилцуулна (чоно – бэлтрэг, үнэг – гавар, тэмээ – ботго г.м.). Багуудад хувааж, үр төлийг нь нэрлэн дараагийн хүүхдэд дамжуулан тоглоно.	Зурагт карт (амьтдын үр төл: чоно, үнэг, тэмээ, хонь, баавгай).	Энэ зурагт ямар амьтад байна вэ?; Баавгай хаана амьдардаг вэ?; Баавгай юу иддэг вэ?.	Харилцах: Санаа бодлоо бүтэн өгүүлбэрээр хэлэх	Амьтны бие гадаад төрх, амьдрах орчныг харьцуулж хэлдэг.
Шоо бүтээе	Төвийн үйл ажиллагаа	Хүүхдүүдийг багт хуваан, цаасан хайрцаг болон өрж байгуулах тоглоомоор шоо бүтээлгэнэ. Шооны талд 1-6 хүртэлх тоог бичих, эсвэл өнгөөр будах.	Жижиг, том цаасан хайрцаг, 1–6 хүртэлх цифр, эсгий бал, өрж байгуулах тоглоом.	Хүүхдүүд бие даан тоглоно.	Бүтээлчээр сэтгэх: Багаж хэрэгслийг сонгож, наамлын бүтээл урлах	Өнгийн цаас, дахин ашиглах материалаар хавтгай болон биет наамлын бүтээл урладаг.
Ямар амьтан бэ?	Зугаалга	Өөрсдийн хийсэн шоогоо ашиглан тоглоно. Шоог орхиж гарсан тоогоор газар дээрх амьтдыг тоолж, үр төл, хоол тэжээлийг нэрлэн тайлбарлана.	Шоо, амьтдын зурагт карт, цагариг.	Энд хэдэн амьтан байна вэ? Энэ амьтны үр төл нь аль нь вэ? Үүнийг ямар амьтан хооллодог вэ? Өгүүлбэр хэлээрэй	Шүүн тунгаах: Тоо хэмжээг жиших Харилцах: Өгүүлбэр зохиож тайлбарлах	10 хүртэл юмсыг тоолж, 2 бүлэг юмсыг жишиж харьцуулж тайлбарладаг.
Чимээ ялгая/Аль нь өөр вэ?	Тойргийн цаг	Багш бээлийтэй болон бээлийгүйгээр алгаа ташиж, аль нь чанга, сул дуугарсныг ялгуулна. Мөн хөгжмийн энгийн зэмсгүүдийн дууг сонсоно (Дуут мод, Тамбаран, Хонхт шигшүүр).	Дуут мод, хонхт шигшүүр, тамбаран (хэц), бээлий.	Аль нь чанга, аль нь сул дуугарсан бэ?	Шүүн тунгаах: Мэдрэхүйгээр юмсын шинжийг ялгаж харьцуулах	Хөгжмийн зэмсгийн чанга, сул дуу чимээг ялгадаг.
Хөгжилтэй тойрог	Хөгжөөн баясах цаг	Хөгжмийн зэмсгийн дуу чимээнд тохируулан хөдөлгөөн хийх тоглоом: Сул дуугарвал мөлхөх/алхах, чанга дуугарвал үсрэх/гүйх. Багт хуваагдан тоглоно.	Дуут мод, хонхт шигшүүр, тамбаран (хэц).	(Хөдөлгөөнөө хөгжимтэйгөө зохицуулан гүйцэтгэхийг сануулах)	Харилцах: Дүрэм, зааврыг ойлгож, гүйцэтгэх	Хөгжмийн зэмсгийн чанга сул чимээнд тохируулан хөдөлгөөн хийдэг.

Тахиа яагаад донгоддог вэ?	Тойргийн цаг	Тахиа яагаад өглөө үүрээр донгоддог шалтгааныг ярилцана. Орчноо танин мэдэх, нутаг дэвсгэрээ хамгаалах зэрэг ойлголтын тухай тайлбарлана.	Тахианы зурагт үзүүлэн.	Тахиа яагаад донгоддог вэ?	Харилцах: Харилцан ярианд идэвхтэй оролцох Шүүн тунгаах: Үйл явдлын шалтгааныг тайлбарлах	Ярилцлагад идэвхтэй оролцож, санаа бодлоо хуваалцдаг.
Тахиа урлая	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Өнгийн цаас, хайч, цавуу ашиглан тахианы их бие, залаа, ам, хөл, нүд зэрэг хэсгүүдийг бие даан хийлгэн, нааж тахиа урлана.	A4 цаас, өнгийн цаас, харандаа, хайч, цавуу, хар эсгий бал.	(Урлах дарааллыг багш тайлбарлана)	Бүтээлчээр сэтгэх: Багаж хэрэгслийг сонгож, наамлын бүтээл урлах	Өнгийн цаас, дахин ашиглах материалаар хавтгай болон биет наамлын бүтээл урладаг.
Тахиа (Хуруун хүүхэлдэй)	Хөгжөөн баясах цаг	Хүүхдүүд хуруун хүүхэлдэйгээ ашиглан тахиа болж дүрд хувирна. Тахианы хөдөлгөөн, донгодохыг дуурайлган тоглоно.	Хуруун хүүхэлдэй.	Тахиа яаж донгоддог вэ? Тахиа яаж хөдөлдөг вэ?	Бүтээлчээр сэтгэх: Тахианы дуу чимээ, хөдөлгөөнийг дуурайж хийх	Хуруун хүүхэлдэй ашиглан дүрд хувиран тоглодог.
Бөмбөгт хүрье	Тойргийн цаг	Багш ишинд тогтоосон бөмбөлгийг хүүхдийн дээр өргөж барихад, хүүхдүүд дээш үсэрч хүрэх дасгал хийнэ. Багш хүрч амжаагүй найздаа туслах чиглүүлэг өгнө.	Компьютер, ая, чанга яригч, бөмбөлөг, иш.	Бөмбөлөгт хүрээгүй найз нартаа туслаарай гэсэн чиглүүлэг.	Харилцах: Бусдад туслах, хамтрах	Хөлөө түлхэж, гараа савж, өндөрт үсэрч хүрэх оролдлого хийдэг.
Дээшээ үсэрье	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Нарийн олсонд өлгөсөн 3 бөмбөлөгт (толгойноос дээш 10-15 см өндөрт) хоёр хөл дээр байрандаа дээш үсэрч толгойгоор хүрэх дасгал хийнэ. Өлмийнөөс түлхэлт авахыг зааварчилна.	Компьютер, ая, бөмбөлөг, уяа, нарийн зураас.	Өлмийнөөс түлхэлт авч үсрэх зааварчилгаа	Харилцах: Бусдад туслах, хамтрах	Дээшээ толгойгоороо үсэрч хүрэх оролдлого хийдэг.
Дэггүй бүжин	Зугаалга	3-5 см өргөнтэй урт зураасыг дагаж баруун, зүүн тийш үсрэх тоглоом. Буруу үсэрсэн хүүхэд тоглоомоос хасагдах дүрэмтэй. Ялагч болон хасагдсан хүүхдүүд сэтгэл хөдлөлөө тайлбарлана	3-5 см өргөнтэй 15-20 м урт нарийн зураас.	Ямар сэтгэл хөдлөлтэй байгаагаа тайлбарлана уу? (Ууртай, баяртай, ядарсан).	Шүүн тунгаах: Зааврыг сонсож, зөв үйлдэл хийх	Зааврыг сонсож зөв үйлдэл хийдэг.

Тоолоорой	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Өнгө өнгийн бөглөөг өнгөөр нь ялгаж, тоолох. Тоглоомын явцад нэгээр нэмэгдүүлж, хорогдуулан тоолох үйлдлийг гүйцэтгэнэ.	Сагс, өнгө, өнгийн бөглөө, зурагт үзүүлэн.	Улаан бөглөөнөөс нэгийг аваарай. Одоо хэд болсон бэ? Тоолоорой.	Шүүн тунгаах: Тоог нэмэгдүүлэх/ хорогдуулах, жиших	10 хүртэл юмсыг тоолж, өгсөн тооноос эхлэн нэмэгдүүлэн, 2 бүлэг юмсыг жишиж харьцуулж тайлбарладаг.
Тооны ижлийг олоорой	Тойргийн цаг	1–10 хүртэлх цифр, уг тоотой тэнцэх дүрс бүхий зурагт үзүүлэнг ашиглана. Хүүхдүүд цифрийг таньж, түүнтэй тэнцэх тоотой дүрс, тоглоом, эд зүйлсийг олж холбоно.	0-10 хүртэл цифр, 10 хүртэл дүрстэй зурагт үзүүлэн, тоглоомууд.	(Багшийн заавар чиглүүлэг)	Шүүн тунгаах: Тоо, тоон хэмжээ, дүрсийг холбон ойлгох	10 хүртэл юмсыг тоолж, 2 бүлэг юмсыг жишиж харьцуулж тайлбарладаг.
Тоглоомоо тоольё	Хөгжөөн баясах цаг	Өрж угсрах тоглоомуудыг багууд солилцох, нэмэгдүүлэх, хорогдуулах үйлийг хийж, тоолно. Жишээ нь: 5 тоглоом солилцох, 2 тоглоом буцааж хийх.	Өрж байгуулах тоглоом, өнгийн цаас.	Одоо тэр тоотой адилхан болгохын тулд хэдэн тоглоом нэмэгдүүлэх ёстой вэ?.	Шүүн тунгаах: Тоог нэмэгдүүлэх/ хорогдуулах, жиших	10 хүртэл тооны юмсыг нэмэгдүүлж хорогдуулж боддог.
Тайвширцг аая!	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	"Аа аа алтан загас" дууг дуулахдаа ууртай, гунигтай дүрд хувирч тоглоно. Уураа тайвшруулах аргыг (удаан, тайван өнгөөр 1-10 хүртэл тоолох) сурна.	Байхгүй	Уурлахаараа ямар болж байна вэ?; Хүмүүс уурлах нь таалагддаг уу?.	Харилцах: Сэтгэл хөдлөлөө тайлбарлан ярих Шүүн тунгаах: Тайвшрах аргыг сонгон хэрэгжүүлэх	Уурлаж бухимдвал яах билээ гэж асуухад бусадтай ярилцах, гүнзгий амьсгал авах, тайвшрах булан зэргийг дурдаж хэлдэг.
Шивнээ	Зугаалга	Хүүхдүүд тойрог болон зогсож үг дамжуулах тоглоом тоглоно. Багш зургийг нууцаар харуулж, түүнийг шивнэн дамжуулах ба хамгийн сүүлийн хүүхэд чанга дуугаар хэлнэ. Үг яагаад өөрчлөгдсөнийг ярилцаж дүгнэнэ.	Эд зүйлсийн зураг (нууцаар үзүүлэх)	(Тоглоомын явцад) Яагаад үг өөрчлөгдсөн болохыг дүгнэж ярилцах	Харилцах: Сонссон зүйлийн утга санааг тайлбарлах Шүүн тунгаах: Үр дагаврыг дүгнэн ярих	Сонссон зүйлийн утга санааг тайлбарлан ярьдаг.

## 11 дүгээр сарын I долоо хоног

### ХАМТДАА ТОГЛОЦГООЁ

**Шинэ үг:** Бэлтрэг, гавар, ботго

**Үйл ажиллагаа 1.** Амьтдын үр төл (Чиглүүлэгтэй, тоглоом үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Зурагт карт /чоно – бэлтрэг, үнэг – гавар, туулай – бөжин, баавгай – бамбарууш, тэмээ - ботго, хонь - хурга/

**Аргачлал:** Амьтдын үр төлийг зурагт карт ашиглан танилцуулна. Хүүхдүүдийг 6 багт хувааж, баг бүрд нэг амьтны үр төлийн зургийг өгнө. Багууд тойрог болон сууна. Багш эхний зургийг үзүүлээд, эхний хүүхдийг тухайн амьтны үр төлийг нэрлэж, дараагийн хүүхдэдээ дамжуулан хэлэхийг чиглүүлэн тоглоно. Багш багуудын хооронд зурагт картыг сольж, үйлдлийг давтан хийлгэнэ.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Энэ зурагт ямар амьтад байна вэ? (*Жишээ: Баавгай бамбарууштайгаа байна.*)
- Баавгай хаана амьдардаг вэ?
- Баавгай юу иддэг вэ?
- Яагаад зөгийн баланд дуртай гэж бодож байна вэ? гэх мэт.

**Үйл ажиллагаа 2.** Шоо бүтээе (Төвийн үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Жижиг, том хэмжээтэй цаасан хайрцаг, 1-6 хүртэлх цифр, эсгий бал, өрж байгуулах тоглоом

**Аргачлал:** Хүүхдүүдийг багт хуваан дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

- 1-р багийн хүүхдүүд хайрцгийн 6 талд 1–6 хүртэлх тоог бичих эсвэл тасархай зураасны дагуу холбож тоо бүтээх байдлаар тоглоно.
- 2-р багийн хүүхдүүд том цаасан хайрцгийн 6 талын талбайг өөр өөр өнгөөр дүүртэл будна.
- 3-р багийн хүүхдүүд өрж байгуулах тоглоомоор шоо бүтээнэ.
- 4-р багийн хүүхдүүд шооны дэлгэмэл зурагт үзүүлэнг харж ярилцана. Энэ байдлаар тоглоомыг үргэлжлүүлэн тоглоно.

**Үйл ажиллагаа 3.** Ямар амьтан бэ? (Төвийн үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Шоо, амьтдын зурагт карт, цагариг

**Аргачлал:** Баг бүр өмнөх үйл ажиллагаагаар хийсэн шоогоо ашиглан дараах тоглоомыг тоглоно. Хүүхдүүдийг хоёр баг болгон хуваана.

**Нэгдүгээр баг:** Хүүхдүүд багшид ойр зогсоно. Газарт амьтдын зурагт картуудыг дарааллаар эгнүүлэн байрлуулсан байна. Нэг хүүхэд шоог орхиж, гарсан тооны дагуу газар дээрх амьтдын зургуудыг тоолж таарсан амьтныг нэрлэнэ. Дараа нь тухайн амьтны үр төлийн зургийг доор нь байршуулж, нэрлэнэ. Жишээ нь: Шоо дээр 4 гарвал хүүхэд 1, 2, 3, 4 гэж тоолоод “Энэ бол чоно” гэж хэлээд бэлтрэгийн зургийг тавьж, “Чонын үр төлийг бэлтрэг гэдэг” хэмээн тайлбарлана. Багийн бүх хүүхэд ээлжлэн хийнэ.

**Хоёрдугаар баг:** Хүүхдүүд 6 цагаригийн ойролцоо зогсоно. Цагариг бүрийн хажууд цифр бүхий карт байрлуулна. Хүүхдүүд ээлжлэн шоог орхиж, гарсан тоонд таарсан цагариг руу алхаж орно. Тухайн цагаригийн хажууд байрлуулсан цифрийн картыг эргүүлж, ард нь байгаа амьтдын хоол тэжээлийн зургийг ажиглана. Зурагт үзүүлснийг харж өгүүлбэр зохиож хэлнэ. Жишээ нь: “Энэ бол зөгийн бал. Зөгийн балыг баавгай иддэг. Яагаад гэвэл баавгай зөгийн баланд дуртай.” Бүх хүүхэд энэ мэт ээлжлэн оролцоно.

### СОНСООД ТААЯ

**Шинэ үг:** Чанга, сул

**Үйл ажиллагаа 1.** Чимээ ялгая (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Дуут мод, хонхот шигшүүр, тамбурин (хэц), бээлий

**Аргачлал:** Хүүхдүүд тойргоор зогсоно. Багш эхлээд алгаа шууд ташиж үзүүлнэ. Дараа нь бээлий өмсөөд дахин ташна.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Аль нь чанга, аль нь сул дуугарсан бэ?

Хүүхдүүдийг хоёр хэсэгт хуваана. Нэг дүгээр хэсгийн хүүхдүүд алгаа шууд ташна. Нөгөө хэсгийн хүүхдүүд бээлий өмсөж ташна. Дараа нь багш асуулт тавина.

- Аль нь чанга дуугарсан бэ? Аль нь сул дуугарсан бэ?

**Багшийн тайлбар:** Дуут мод - Дуут мод бол жижигхэн модон саваа шиг хөгжим. Хоёр модон хэсэгтэй, хооронд нь нийлүүлээд тогшвол “*ток-ток*” гэж дуугардаг.

**Тамбурын (хэц) - Тамбурын (хэц) бол дугуй хэлбэртэй хөгжим.** Ирмэг дээр нь жижигхэн төмөр хавтангууд дээр гар дээрээ сэгсрэхэд, эсвэл алгаараа цохиход “**шинг-шинг**” гэж дуугардаг. Хонхот шигшүүр - хонхот шигшүүр хөгжим, гартаа зүүгээд хөдөлгөхөд **жин-жин** гэж хонхны дуу гарна.

**Үйл ажиллагаа 2.** Аль нь өөр вэ? (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Дуут мод, хонхот шигшүүр, тамбурын (хэц)

**Аргачлал:** Хүүхдүүдийг тойруулан суулгана. Багш дараах хөгжмийн зэмсгүүдийг танилцуулж, ээлжлэн дуугаргаж үзүүлнэ.

- Дуут мод (сулхан дуугарна), тамбурын (чанга дуугарна).
- Хонхот шигшүүр (чанга дуугарна)

Хөгжим бүрийн дуу чимээг сонсгосны дараа багш асуулт тавина.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Ямар хөгжим сулхан дуугарсан бэ?
- Ямар хоёр хөгжим чанга байсан бэ?
- Аль хөгжим бусдаасаа өөр байсан бэ?

**Үйл ажиллагаа 3.** Хөгжилтэй тойрог (Хөгжөөн баясах цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Дуут мод, хонхот шигшүүр, тамбурын (хэц)

**Аргачлал:** Хүүхдүүд хагас тойрог болон зогсоно. Багш хөгжмийн зэмсгүүдийн дуу чимээг танилцуулж, тоглоомын дүрмийг танилцуулан чиглүүлнэ.

*Дуут мод сул дуугарвал* мөлхөх, алхах зэрэг хөдөлгөөн хийнэ. *Хонхот шигшүүр чанга дуугарвал* алга таших, үсрэх, эргэх зэрэг хөдөлгөөн хийнэ. *Тамбурын чанга дуугарвал* гүйх, дэгдэх хөдөлгөөн хийнэ. Үүнийг хамтаараа 2–3 удаа тоглоно.

**Тоглоомын дүрэм:** 3 энгийн хөгжмийн зэмсгээс нэг удаад 3 хүүхэд сонгоно. Хүүхэд өөрийн сонгосон хөгжмийг тоглоход зөвхөн тухайн хөгжимд тохиорох хөдөлгөөнийг бусад хүүхдүүд хийнэ. Жишээ нь: Тамбурын чанга дуугарвал хүүхдүүд гүйж, дэгдэх хөдөлгөөн хийнэ харин хонхот шигшүүр дуугарвал алга таших, үсрэх хөдөлгөөн хийх гэх мэт.

**Анхаарах зүйл:**

- Хүүхдүүд хөдөлгөөнөө хөгжимтэйгөө зохицуулан гүйцэтгэнэ.
- Аялгуу өөрчлөгдөхөд өөр өөр хөдөлгөөн хийж байхыг багш сануулна.

## ЭРТЭЧ ТАХИА

**Шинэ үг:** урлах

**Үйл ажиллагаа 1.** Тахиа яагаад донгоддог вэ? (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Тахианы зурагт үзүүлэн

**Аргачлал:** “Тахиа яагаад өглөө үүрээр донгоддог вэ?” гэсэн асуултыг тавьж, хүүхдүүдтэй харилцан ярилцана.

**Багшийн тайлбар:** Тахиа ихэвчлэн нар мандахаас өмнө буюу өглөө үүр цайх үед донгоддог. Донгодох нь:

- Орчноо танин мэдэх
- Нутаг дэвсгэрээ хамгаалах
- Бусад тахиаг ойртуулахгүй байх зорилготой.

Энэ үйл явцаар дамжуулан цаг хугацаа, өглөө үүр, нар мандахтай холбоотой ойлголт болон амьтны онцлогийн тухай нэмэлт тайлбар өгнө.

**Үйл ажиллагаа 2.** Тахиа урлая (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** А4-ийн цагаан цаас, өнгийн цаас, харандаа, хайч, цавуу, хар өнгийн эсгий бал

**Аргачлал:** А4 хэмжээтэй өнгийн цаас бусад хэрэглэгдэхүүнийг хүүхдийн тоогоор бэлтгэнэ. Багш тахианы зурагт үзүүлэн үзүүлж, урлах дарааллыг тайлбарлана. Хүүхэд өөрийн хүссэн өнгийн цаасыг сонгон бэлдэнэ. Сонгосон цаасыг гурав нугалж, тахианы их биеийг бэлдэнэ. Улаан, улбар шар цаасан дээр залаа, ам, хөлийг зурж, бие даан хайчилна. Цагаан цаасан дээр нүдийг зурж, хайчилж бэлдэнэ.

Бэлдсэн хэсгүүдийг тахианы их биеийн тохирох хэсэгт холбож наана. Багш бүрдэл хэсгүүдийг холбох, бэхлэх аргуудыг багш тайлбарлаж, хамтран гүйцэтгэнэ.

**Үйл ажиллагаа 3.** Тахиа (Хөгжөөн баясах цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Хуруун хүүхэлдэй

**Аргачлал:** Хүүхдүүд хуруун хүүхэлдэйгээ ашиглан тахиа болж дүрд хувирна. Тэд тахианы хөдөлгөөн, донгодохыг дуурайлган тоглоно. Багш хөгжөөн баясах байдлаар хүүхдүүдийг удирдан, хамтдаа дүрд хувирч тоглох үйл ажиллагааг зохион байгуулна.

## 11 дүгээр сарын II долоо хоног

### ХӨГЖИЛТЭЙ ҮСРЭЛТ

**Шинэ үг:** Өлмий, тавхай

**Үйл ажиллагаа 1.** Бөмбөгт хүрье (Өглөөний дасгалын цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Компьютер, ая, чанга яригч, бөмбөлөг, иш болохоор урт зүйл

**Аргачлал:** Багш 2-3 метр урттай ишинд бөмбөлгийг тогтоож бэлтгэсэн байна. Багш иштэй бөмбөлгийг хүүхдүүдийн дээр өргөж барихад хүүхдүүд бөмбөлөгт хүрэх гэж дээш үсэрнэ. Багшийн зүгээс “Бөмбөлөгт хүрээгүй найз нартаа туслаарай” гэсэн чиглүүлэг өгөхөд хүүхдүүд бие биеэ ажиглаж хүрч амжаагүй, хүрээгүй нэгнээ дэмжиж, тусална. Багш тухайн хүүхдийн дээр бөмбөлгийг аваачиж хүрэх өндөрт барих ба үсрэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

**Үйл ажиллагаа 2.** Дээшээ үсэрье (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Компьютер, ая, чанга яригч, бөмбөлөг, уяа, нарийн зураас

**Аргачлал:** *Хоёр хөл дээр байрандаа дээш үсрэх:* Нарийн олсонд өлгөсөн 3 бөмбөлгийг тоглоомын талбайн зүүн талд хүүхдийн толгойноос дээш 10-15 см өндөрт байрлуулна. Хүүхдүүд нэгийн цуваанд зогсоно. Алхалт дунд хоёр хөл дээр байрандаа өлмийнөөс түлхэлт аван үсэрч толгойгоор бөмбөлөгт хүрнэ. Хүүхдүүд үйлдлийн гүйцэтгэлийг тойргоор гүйцэтгэнэ.

**Үйл ажиллагаа 3.** Дэггүй бүжин (Зугаалга)

**Хэрэглэгдэхүүн:** Компьютер, ая, чанга яригч, 3-5 см өргөнтэй, 15-20 м урттай нарийн зураас

**Аргачлал:** Тоглоомын талбайд 3-5 см өргөнтэй 15-20 м урт нарийн зураасыг бэлтгэсэн байна. Хүүхдүүд нэгийн цуваанд зогсож зураасны баруун талаас эхэлнэ. Багшийн зааварчилгааны дагуу “баруун” гэхэд баруун тийш үсэрч, “зүүн” гэхэд зүүн тийш үсэрнэ. “Баруун” гэхэд зүүн үсэрсэн хүүхдүүд тоглоомоос хасагдана. “Зүүн” гэхэд баруун үсэрсэн хүүхдүүд тоглоомоос хасагдана. Багшийн зааварчилгааг анхааралтай сонсож үсрэлтийг зөв гүйцэтгэсэн хүүхэд тоглоомын ялагч болно. Багш тоглоомыг дахин тоглож хасагдсан хүүхдэд боломж олгож болно.

**Анхаарах зүйл:**

- Хоёр хөлийн өлмий дээр зэрэг хажуу тийш үсэрнэ.
- Хоорондоо 40 см зайтай зогссон байна.
- Хажуу тийш үсрэхдээ хөлийн өлмийнөөс бүтэн улан дээр бууна.

### ТООГ ТАНИАРАЙ

**Шинэ үг:** Нэмэгдүүлэх, хорогдуулах, нөхөх

**Үйл ажиллагаа 1.** Тоолоорой (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** сагс, өнгө, өнгийн бөглөө, бөглөөг байрлуулах зурагт үзүүлэн

**Аргачлал:** Хүүхдүүдийг өөрсдийн сонголтоор баг болгон хуваана. Багийн хүүхдүүд сагсанд байгаа бөглөөг өнгөөр нь ялгаж, тоолох үйл ажиллагааг хамтран гүйцэтгэнэ. Үйл ажиллагааг гүйцэтгэх явцад багш баг тус бүрийг ажиглаж чиглүүлнэ.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Танай багт ямар, ямар өнгийн бөглөө байна вэ?
- Улаан /шар, цэнхэр... гэх мэт/ өнгийн бөглөө хэд байна вэ?
- Шар өнгийн бөглөөнөөс нэгийг хасаад сагсанд хийгээрэй. Хэдэн бөглөө үлдэж байна вэ?
- Улаан өнгийн бөглөөнөөс нэгийг аваарай. Одоо хэд болсон бэ? Тоолоорой.

Дээрх байдлаар хүүхдүүдэд нэгээр нэмэгдүүлж, хорогдуулан тоолох үйлдлийг тоглоомын хэлбэрээр зохион байгуулж болно.

Хоосон зайг өнгийн бөглөөгөөр бөглөх зурагт картыг хүүхдүүд тавиураас сонгон авна. Өөрийн карт дээр ямар өнгийн хэдэн бөглөө тавьж дүрсийг дүүргэснээ найздаа тайлбарлана. Жишээ нь: *Нохойны зураг дээр 3 ширхэг цэнхэр бөглөө, 4 ширхэг улаан бөглөө, 10 ширхэг ногоон бөглөө тавьсан гэх мэт.*

**Үйл ажиллагаа 2.** Тооны ижлийг олоорой (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** 0-10 хүртэл цифр, 10 хүртэл дүрстэй, хүүхдийн өдөр тутам тоглодог тоглоомууд

**Аргачлал:** 1–10 хүртэлх цифр, уг тоотой тэнцэх 1–10 хүртэлх дүрс бүхий зурагт үзүүлэн байна. 1–10 хүртэлх цифрээ эгнүүлэн тавина. Дүрстэй зурагт үзүүлэнгээ мөн байрлуулна. Жишээ нь: 1 ширхэг алимтай зураг хараад “1” гэж хэлэхэд хүүхэд нэгийн тоог олж зогсоно. 2 ширхэг алимтай зургийг хараад “2” гэж хэлэхэд хүүхэд хоёрын тоог олж зогсох гэх мэт. Хүүхэд 1–10 хүртэлх тоогоо таньдаг бол багш цифрийг өргөж үзүүлнэ. Хүүхдүүд цифртэй ижил тоотой дүрсийг олж зогсоно.

**Хувилбар 2:** Багш цифрийг өргөж үзүүлэх үед хүүхдүүд тухайн цифртэй тэнцэх дүрс, тоглоом, эд зүйлсийг авчирна. Хүүхдүүд авчирсан эд зүйлсээ багшийн хэлсэн газар байрлуулж тоглоно. Энэ мэтчилэн хүүхдүүд тоо, тоон хэмжээ, дүрсийг холбон ойлгох тоглоом, үйл ажиллагааг зохион байгуулж болно.

**Үйл ажиллагаа 3.** Тоглоомоо тоолъё (Хөгжөөн баясах цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Өрж байгуулах тоглоом, өнгийн цаас

**Аргачлал:** Өрж угсрах леги тоглоомуудыг тасалгааны голд байрлуулна. Ижил өнгийн цаас сонгосон хүүхдүүд нэг баг болно. Багаараа тасалгааны голд байрлуулсан тоглоомуудаас өөрийн багийн өнгөтэй ижил тоглоомуудаас 10 ширхэг авч, багшийн дохиогоор ширээндээ өрнө. Өрсөн тоглоомоо багшийн чиглүүлгийн дагуу тоолно. Жишээ нь:

- Цэнхэр баг шар багтай, улаан баг ногоон багтай 5 тоглоомоо солилцоорой. Одоо хэд болсон бэ? Тоолоорой.
- Баг бүр 2 ширхэг тоглоомоо сагсанд буцаагаад аваачиж хийгээрэй. Одоо хэдэн тоглоом үлдсэн бэ?
- Анх хэдэн тоглоом тоолж авсан бэ? Одоо тэр тоотой адилхан болгохын тулд хэдэн тоглоом нэмэгдүүлэх ёстой вэ? Нэмээрэй, тоолоорой.

## АА, АА АЛТАН ЗАГАС

**Шинэ үг:** Тайвшрах, үг дамжуулах

**Үйл ажиллагаа 1.** Тайвширцаагай! (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Аргачлал:** Хүүхдүүд хосоороо өөд өдөөсөө харж зогсоно. Багш яриаг сонсоод, дагаж гүйцэтгэнэ.

“А а алтан загас

Амин голын мөнгөн загас

Тийм тийм хөөрхөн загас

Түүний дараа “ууртай” болж хувирна уу” гэж хэлж дуусахад хүүхдүүд дор бүрнээ ууртай хөшөөний дурд хувирна. Бие, биеэ ажиглаарай. Уурлахаараа ямар болж байна вэ? Ууртай царай ямар байдаг тухай ярилцана.

Таалагдаж байна уу? Таалагдахгүй байна уу? зэргээр ярилцана. Хүүхдүүдийг уурлах таалагдахгүй, муухай гэдэг дүгнэлт хэлэхэд багш дэмжлэг үзүүлнэ. “Тиймээс уурлахаа больж

тайвширцгаая” гэж дараагийн тайвшрах үе шат руу хөтөлнө. Багш “Одоо уураа тайвшруулцгаая. Үүний тулд тоолох арга хэрэглэцгээе” гээд удаан, тайван өнгө аясаар “1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10” гэж дагуулан тоолно. Хүүхдүүд багштай хамт нэг хэмнэлээр тоолно. Хүүхдүүд тайвширсан эсэхээ ярилцаад, тайвшрахаар ямар байгаа талаараа хэлнэ. Багш “Дахиад нэг тоглоцгооё” гэж хүүхдүүдийг уриалж дараагийн үе шат руу хөтөлнө. Багшийн дуулахыг сонсоод дагаж дуулна.

“А а алтан загас

Амин голын мөнгөн загас

Тийм тийм хөөрхөн загас

Түүний дараа “гунигтай” болж хувирна уу” гэж хэлэхэд хүүхдүүд дор бүрнээ гунигтай хөшөөний дурд хувирна. Бие биеэ ажиглаарай. Гуниглахаараа ямар болж байна вэ? Гунигтай царай ямар байдаг тухай ярилцана. Таалагдаж байна уу? Таалагдахгүй байна уу? Хүүхдүүд гуниглах таалагдахгүй, таагүй гэдэг ойлголт руу багшийн чиглүүлэгт шилжинэ. Яахаараа гунигладаг талаар багштай ярилцана. Одоо гуниглахаа больж тайвширцгаая гэж багш хэлэхэд хүүхдүүд “Гуниглахаа больж өөрсдийгөө тайвшруулъя. Үүний тулд тоолох аргаа дахиад хэрэглэцгээе” гээд удаан, тайван өнгө аясаар “1,2,3, 4, 5, 6, 7, 8, 9, 10” гэж тоолно.

**Үйл ажиллагаа 2.** Шивнээ (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Аргачлал:** Багш хүүхдүүдийг тойрог болж зогсохыг сул дуугаар уриална. “Илүү сайн сонсохын тулд чимээгүй болоорой”, “Чимээгүй, зөөлөн яваарай” гэж хэлж хүүхдүүдийг тойрогт байрлуулна. Үг дамжуулах тоглоом тоглоно. Тойргийн эхний хүүхдэд эд зүйлсийн зургийг нууцаар харуулна. Зургийг харсан хүүхэд тухайн үгийг дараагийн хүүхдийнхээ чихэнд шивнэн дамжуулна. Үгийг тойргоор дамжуулсаар хамгийн сүүлийн хүүхэд сонссон үгээ бусдад чанга дуугаар хэлнэ. Эхний хүүхэд дамжуулсан үгээ хэлж, зургаа үзүүлнэ. Хэрэв дамжуулсан үг өөрчлөгдсөн бол бүх хүүхэд ээлжлэн өөрийн чихэнд сонсогдсон үгээ хэлнэ. Хүүхдүүд аль хүүхдийн үед, яагаад үг өөрчлөгдсөн болохыг дүгнэж ярилцана.

**Сонсьё, дэмжье/ Туслалцаа:**

- Хүүхэд зурах, наах, барих, зохион бүтээх үйл ажиллагаанд оролцох үед түүний бүтээлийн гол санааг хэрхэн ойлгож, гүйцэтгэж Хүүхдийн дуртай болон дургүй зүйлсийн талаар байгааг ажиглан, шаардлагатай дэмжлэг үзүүлээрэй. Мөн хүүхдийн хувийн хавтсыг бүтээлээр нь баяжуулж, хөгжлийн явцыг баримтжуулна уу.
- Хүүхдийн дуртай болон дургүй зүйлсийн талаар ярилцаж, ажиглалт, ярилцлагын тэмдэглэл хэлбэрээр хөтлөн хадгалаарай.

**Эцэг эхтэйгээ хамтаръя.**

- Хүүхэдтэйгээ хамт тэдний сайн мэддэг амьтдын үр төл, гадаад төрх, амьдрах орчны талаар ярилцаж, сонирхлыг нь дэмжих;
- Хүүхэд багшийн танилцуулсан зүйлийн талаар юу гэж ойлгож, ямар сэтгэгдэлтэй байгааг анзаарч, тэрхүү бодол, яриаг нь багштайгаа хуваалцаж байвал хүүхдийн хөгжилд илүү сайн дэмжлэг болно.

- **Багшийн эргэцүүлэмж**

**Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ./**

Амжилттай хэрэгжүүлсэн: .....

Сул хэрэгжүүлсэн:.....

Цаашид сайжруулах:.....

Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа: .....

## ЦААСНЫ ТУХАЙ СОНИН ХАЧИН

### Хүүхдийн эзэмших чадамж

**Суралцахууд суралцах:** Хүүхэд хөдөлгөөний чадвараа сайжруулж, эрүүл ахуйн энгийн дадалд суралцахын тулд дасгал, тоглоомыг давтан хийж, оролдлого чармайлт гарган, тууштай байх хандлагатай болж, идэвхтэй оролцох, хүсэл сонирхлоо илэрхийлэн, бусдын зөвлөгөөг хүлээн авч дагадаг болно.

**Бүтээлчээр сэтгэх:** Хүүхэд хүрээлэн буй орчны эд зүйлсийг ажиглаж, асуудалд шийдэл хайх, өөр хувилбар дэвшүүлж, цаасыг дахин ашиглах, шинээр бүтээх туршилт хийх, мөн өөрийн хүссэн зүйлээ урлан бүтээж, санаагаа илэрхийлэх чадварт суралцана.

**Шүүн тунгаах:** Хүүхэд мэдрэхүйн тусламжтайгаар цаас болон бусад эд зүйлсийн 2-3 шинж чанарыг ялгаж, оновчтой үгээр тайлбарлах, туршилтын үр дүнг өөрийн хэмжээнд тайлбарлан, харьцуулж дүгнэх чадварт суралцана.

### Аюулгүй байдлын зөвлөмж:

Төрөл бүрийн цаасыг сонгохдоо цэвэр байхад анхаарах мөн хурц ирмэггүй ашиглахад аюулгүй эсэхийг шалгаж ашиглаарай. Хэрэглэсэн ундааны савыг угааж ариутгах, хог түүх тоглоом тоглохдоо хогийн сав, уутанд тохирох хаягдлыг хаях, түүж байгаа зүйлээ булаалдаж бие биедээ гэмтэл учруулахгүй байхыг зөвлөж, тогтмол сануулга өгч үйл ажиллагааг зохион байгуулна.

### Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

#### Тойргийн цаг:

- Судалж байгаа зүйлийн тухай чиглүүлэх асуултад тохирсон хариулт өгч, өөрийн санаа *Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:*
- Төрөл бүрийн цаасыг ашиглан туршилт хийж, тэдгээрийн ялгааг олоход чиглүүлэг өгөх, бусад хүүхдүүдтэй санал бодлоо хуваалцаж шинэ мэдлэгээ хэрэглэхэд нь дэмжлэг үзүүлнэ.
- Туршилтын үр дүнг хүснэгтэд тэмдэглэж, хүүхдүүдийн мэдлэгийг бататган дүгнэж ярилцаарай.

#### Төвийн үйл ажиллагаа:

- Төвүүдэд байгаа хэрэглэгдэхүүний онцлогт нийцүүлэн сургалт, үйл ажиллагааг харилцан адилгүйгээр төлөвлөн зохион байгуулаарай. Жишээ нь: нүдээ аниад тэмтрэх, ариун цэврийн цаасны бат бөхийг турших үед зоос тавьж, усыг дусаах гэх мэт.

#### Хөгжөөн баясах цаг:

- “Бяцхан цаасны түүх” зохиолын дүрд хувирч, хүүхэд өөрийгөө зохилын гол дүр цаас болсон мэт мэдэрч сэтгэл хөдлөлөө нүүрний хувирлаар илэрхийлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

#### Таралтын цаг:

- Тарахын өмнө хүүхдүүдийн сонирхлыг татахуйц үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлснээр тэд эцэг эх, асран хамгаалагчтайгаа ярилцаж, олж авсан мэдлэгээ гэрийн орчинд бататгах боломжтой болно.

### Боломжууд:

Энэ сар төрөл бүрийн цаасаар туршилт хийх, дахин боловсруулах, юмсын шинж чанарыг мэдрэх мөн дүрд хувирч сэтгэл хөдлөлөө илэрхийлэх зэрэг үйл ажиллагаануудаар баялаг учир, багш энэ үед хүүхдүүдийн асуух, илэрхийлэх, турших гэсэн идэвхтэй оролцоог ашиглан хичээлийг гүнзгийрүүлэх бүрэн боломжтой, Мөн багш сонсгол, хараа, хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдүүдийг өөрийн санаачилгаар оролцохыг дэмжиж, тэдний идэвхтэй оролцоог хангах боломж олгож ажиллаарай.

**Үйл ажиллагааны төлөвлөлт:**

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
ХЯЗ.3а. Номын зургаас үйл явдлыг ойлгож ярина. НСХЗ.3в. Үйл ажиллагаанд тодорхой үүрэг хүлээж оролцдог болно.	<ul style="list-style-type: none"> <li>- Амьтад, байгаль, үлгэрийн сэдэвт сонирхол татахуйц агуулгатай номын зураг, үйл явдлыг ойлгож ярих</li> <li>- Жижүүр хийх гэх мэт хамтын үйл ажиллагаанд нөхөрсгөөр оролцох</li> </ul>	Юу болсныг тайлбарлаарай
БНОЗ.1в. Мэдрэхүйн тусламжтайгаар юмсын шинж чанарыг ялгаж харьцуулна. ХЯЗ.2в. Юмсын шинж чанар, онцлог илэрхийлсэн үгийг яриандаа ашиглана.	<ul style="list-style-type: none"> <li>- Ажиглаж олж мэдсэн зүйлийнхээ талаар ярих</li> <li>- Өдөр тутмын үйл ажиллагааны явцад янз бүрийн эд зүйлийг тэмтрэх, барих, амтлах, ажиглах зэргээр юмсын шинж чанарыг тодорхойлсон үгсийг хэрэглэх</li> </ul>	Цаас ус шингээдэг үү?
ХЭМЗ.1г. Алхалт гүйлтийг чиглэл, хурдаа өөрчлөн гүйцэтгэнэ. ХЭМЗ.1и. Хоёр хөл дээр 10 зураас давж үсэрч бууна. (зураас хоорондын зай 60см) НСХЗ.3в. Үйл ажиллагаанд тодорхой үүрэг хүлээж оролцдог болно.	<ul style="list-style-type: none"> <li>- Шулуун шугамаар алхах, гүйхдээ дохио, тэмдэглэгээ даган хурдаа өөрчилнө.</li> <li>- Урагш, хойш, баруун, зүүн тийш ээлжлэн чиглэлээ өөрчлөн гарын хөдөлгөөнтэй хослуулан зааврын дагуу үсрэх</li> <li>- Өдрийн дэглэмийн аливаа үйл ажиллагааны үед “Бид чадна аа”, “Хамтдаа хийцгээе” гэх мэт бие биеэ дэмжсэн уриа үгийг багаараа зохиож хэлэн эвтэй оролцох</li> </ul>	Анхаар эхэл
БНОЗ.1в. Мэдрэхүйн тусламжтайгаар юмсын шинж чанарыг ялгаж харьцуулна. ХЯЗ.2в. Юмсын шинж чанар, онцлог илэрхийлсэн үгсийг яриандаа ашиглана.	<ul style="list-style-type: none"> <li>- Өөрийн хэрэглэдэг эд зүйл (хувцас, хичээлийн хэрэгсэл, ариун цэврийн хэрэгсэл, тоглоом)-ийн ялгаатай болон төстэй шинж чанарыг тайлбарлах</li> <li>- Хүрч мэдэрдэг болон туршилт хийх ном, бичлэг зэргийг үзээд юмсын шинж чанар, онцлог заасан үгийг тогтоож хэрэглэх, туршилтыг дагаж хийх, хийсэн туршилтаа тайлбарлахдаа үгийг оновчтой сонгож ярих</li> </ul>	Цаасны хэрэглээ
ХЭМЗ.2а. Хувийн ариун цэвэр сахих үйлийг насанд хүрэгчийн сануулгатайгаар бие даан хийнэ. МАТЗ.1а. 10 хүртэлх тоог цээжээр тоолох, 5 хүртэлх тооны юмсыг оноож тоолох, өгсөн тооноос эхэлж 1-ээр нэмэгдүүлэн тоолох, тоог жишнэ (бодит юмсын олон, цөөнийг ялгаж жиших).	<ul style="list-style-type: none"> <li>- Ариун цэврийн цаасыг хэрэглэж, хогийн саванд хаях</li> <li>- 10 хүртэл цээжээр тоолж (шалан дээр байрлуулсан 1-10 тоог үсэрч, алхаж, мөлхөж зам дагаж явахдаа нэрлэх гэх мэт) тоглох</li> </ul>	Ариун цэврийн цаасаа гамная
НСХЗ.1а. Сэтгэл хөдлөлөө таатай, таагүй байгааг илэрхийлдэг болно. ХӨГЗ.1д. Үлгэр зохиол, дуу аялгууны дүрийн онцлогийг илэрхийлж тоглоно	<ul style="list-style-type: none"> <li>- Төрөл бүрийн сэтгэл хөдлөл мэдрэх үлгэр, зохиолтой танилцаж тухайн дүр ямар үед таатай эсвэл таагүй мэдрэмж төрүүлсэн тухай ярилцах</li> <li>- Үлгэр зохиол, хүүхэлдэйн жүжгийг үзээд, утга санаа дүрийн онцлогийг ярилцах</li> </ul>	Чимээ

12 дугаар сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Олон төрлийн цаас	Тойргийн цаг	Олон төрлийн цаасыг (цэвэрхэн, бичигтэй, сонин, картон) бэлтгэж, ярилцана. Цаасыг дахин ашиглах тухай зөвлөгөө өгнө.	Төрөл бүрийн цаас (сонин, картон, бичигтэй/гүй цаас).	Цэвэрхэн цаасаар юу хийж болох вэ?; Нэг талдаа бичигтэй цаасыг дахин ашиглаж болох уу?.	Бүтээлчээр сэтгэх: Асуудалд шийдэл хайх, өөр хувилбар дэвшүүлэх	Цаасыг дахин ашиглах тухай санаа хэлдэг.
Зургийн дагуу ярилцъя	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	“Бяцхан цаасны түүх” зохиолыг танилцуулна. Зохиолын үйл явдлын зургуудыг дарааллаар байрлуулж, 5 багт хуваагдан зураг тус бүрээр тайлбарлан ярина.	Зохиолын үйл явдлын зургууд.	Цаас юуг хүсдэг байсан бэ? Цаас өөр дээрээ зураг зуруулахад ямар байсан бэ?	Суралцахуйд суралцах: Хамтын үйл ажиллагаанд нөхөрсгөөр оролцох Шүүн тунгаах: Үйл явдлын дарааллыг тогтоох	Зохиолын үйл явдлыг тайлбарлан ярьдаг Үйл явдалтай зургийг дарааллын дагуу байрлуулдаг.
Хогоо түүгээрэй	Хөгжөөн баясах цаг	Ангид санаатайгаар тараасан хог хаягдлыг (цаас, ундааны сав) түүлгэх, ижил төрлийн хогийг тус тусын уутанд ангилж ялгах.	Янз бүрийн цаас, ундааны сав зэрэг дахин боловсруулах боломжтой хог хаягдал, уут.	Багш хүүхдүүдийн санаачилга, идэвхтэй оролцоог ажиглана.	Хамтран ажиллах: Хамтдаа цэвэрлэх Нийгэм, сэтгэл хөдлөл: Үүрэг, хариуцлага хүлээж оролцох	Хог хаягдлыг ангилан ялгаж хаяхыг оролддог.
Цаас бүрийн онцлогийг ярилцъя	Тойргийн цаг	Төрөл бүрийн цаасыг тэмтэрч, нимгэн, зузаан, хатуу, зөөлөн зэрэг шинж чанарын талаар ярилцаж, ус шингээх чадварын талаар таамаглал дэвшүүлнэ.	Төрөл бүрийн цааснууд.	Ямар цаас усыг хамгийн хурдан шингээх вэ?; Яагаад энэ цаас илүү ус шингээнэ гэж бодож байна вэ?	Бүтээлчээр сэтгэх: Таамаглал дэвшүүлэх Шүүн тунгаах: Мэдрэхүйгээр юмсын шинж чанарыг ялгаж хэлэх	Юмсын 2-3 шинжийг ялгаж тайлбарладаг Шинж чанар илэрхийлсэн үг хэрэглэдэг.
Туршилт хийцгээе	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Төрөл бүрийн цаасыг усанд дүрэх туршилт хийж, аль нь хурдан шингээж байгааг ажиглан, хүснэгтэд тэмдэглэнэ.	Төрөл бүрийн цааснууд, ус, сав.	Ямар цаас илүү ус шингээж байна вэ?; Яагаад ингэж бодож байна вэ?.	Бүтээлчээр сэтгэх: Туршиж үзэх, үр дүнг тэмдэглэх Шүүн тунгаах: Үр дүнг харьцуулж дүгнэж хэлэх	Туршилтын үр дүнг ажиглаж өөрийн үгээр тайлбарладаг эсэх Хүснэгтэд тэмдэглэдэг.
Анхаар эхлэ	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Дохионы дагуу (урагш, хойш, баруун, зүүн) чиглэл, хурдаа өөрчлөн алхах, гүйх. Хөгжилтэй	Алчуур (Хөгжилтэй алчуур).	Хөдөлгөөнт тоглоом	Суралцахуйд суралцах: Давтан хийж, тууштай байдлыг урамшуулах	Чиглэл хурдыг өөрчилж чаддаг; Хоёр хөл дээр 8-10 зураас давж үсэрдэг.

		алчуур: Алчууртай цогц дасгал.				
Цаас хаанаас үүссэн бэ?	Тойргийн цаг	Цаасыг хэрхэн хийдэг тухай бичлэг үзүүлж (Модны үртэс, үйлдвэр) ярилцана.	Бичлэг.	Цаасыг юугаар хийдэг гэж боддог вэ?; Цаасаар бид юу хийдэг вэ?.	Харилцах: Асуултад тохирсон хариулт өгөх Суралцахуйд суралцах: Бусдын зөвлөгөөг хүлээн авч дагах	Юмсын шинж чанарыг тайлбарлахдаа үгээ оновчтой хэрэглэдэг.
Шинэ цаас бүтээх туршилт	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хуучин цаасыг дэвтээж, хутгаж, шахаж, хатаах замаар дахин цаас хийх туршилт хийнэ.	Хаягдал цаас, хувин, ус, хутгуур, шүүлтүүр.	Хуучин цаас яагаад задарч байгааг юу гэж бодож байна вэ?; Хатах үед яах бол?.	Бүтээлчээр сэтгэх: Байгальд ээлтэй бүтээлч санаа гарган туршиж үзэх, оролцох	Цаасны шинж чанарыг ялгаж тайлбарладаг.
Цаасаар юу хийж болох вэ?	Төвийн үйл ажиллагаа	Төрөл бүрийн цаасыг ашиглан хүүхдүүд өөрийн хүссэн зүйлээ бүтээнэ. Багш нугалах, хайчлах, наах аргыг зааж өгнө. Бүтээлээ тайлбарлана.	Төрөл бүрийн цаас, хайч, цавуу, скоч.	Энэ цаасаар юу хийж болох вэ?; Цаасыг яаж ашиглаж байсан бэ?.	Бүтээлчээр сэтгэх: Бүтээлч санаа гарган бүтээлээ бие даан бүтээх. Харилцах: Хийсэн бүтээлээ тайлбарлах	Цаас ашиглан эд зүйлс бүтээх оролдлого хийдэг.
Таагаарай	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Алчуураар бүтээсэн түмпэн доторх зүйлсийг тэмтэрч, таалгана. Юмсын шинж чанарыг (хатуу, зөөлөн, барзгар, гөлгөр) тодорхойлно.	Ариун цэврийн цаас, зоос, модон тоглоом, алчуур.	Чамд ямар зүйл мэдрэгдсэн бэ?; Хатуу байна уу? зөөлөн байна уу? Барзгар байна уу? гөлгөр байна уу?.	Шүүн тунгаах: Юмсын шинж чанарыг мэдэрч ялгах	Шинж чанар илэрхийлсэн үгийг хэрэглэдэг.
Цаасны туршилт	Төвийн үйл ажиллагаа	1. Цаасны шингээх чадварыг ус ашиглан туршина. 2. Цаасны бат бөх чанарыг зоос нэмж тавих туршилт хийнэ. Үр дүнг хүснэгтэд тэмдэглэнэ.	Ариун цэврийн цаас, ус, дусаагуур, зоос.	Хэдэн зоос тавихад цаас цоорсон бэ?; Ариун цэврийн цаас нь амархан цоорч байна уу?.	Шүүн тунгаах: Туршилтын үр дүнг дүгнэн хэлэх Суралцахуйд суралцах: Тууштай байх	Туршилтад оролцож үр дүнг тайлбарладаг. 1-10 хүртэл оноож тоолдог.
Чимээгээр таая	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд нүдээ анин, цаастай холбоотой дуу чимээг (хуудас эргүүлэх, цаас үрэх) сонсож таана.	Өсгөгч/дуу тоглуулагч.	Чи ямар дуу сонссон бэ?	Шүүн тунгаах: Сонссон зүйлээ тайлбарлах	Чимээ сонсоод юу сонсогдож байгааг тайлбарладаг.
Бяцхан цаасны сэтгэл хөдлөл	Хөгжөөн баясах цаг	“Бяцхан цаасны түүх” зохиолд тулгуурлан, бяцхан цаасны сэтгэл	Зурагт үзүүлэн	Бяцхан цаасыг хогийн саванд хаяхад түүний сэтгэл	Бүтээлчээр сэтгэх Биеийн хэлэмжээр илэрхийлэх	Сэтгэл хөдлөлөө нэрлэж хэлдэг.

		хөдлөлийг (баяртай, гунигтай) нүүрний хувирлаар илэрхийлэн тоглоно.		хөдлөл ямар байсан бэ?; Шинэхэн амны цаас болоход түүний сэтгэл хөдлөл ямар байсан бэ?.		Дүрийн онцлогийг нүүрний хувирлаар илэрхийлдэг.
--	--	---	--	---	--	---

Албан хэрэгцээнд

## ЮУ БОЛСНЫГ ТАЙЛБАРЛААРАЙ

**Шинэ үг:** Хаягдал, хог ангилах

**Үйл ажиллагаа 1.** Олон төрлийн цаас (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Цэвэрхэн бичиггүй цаас, нэг талдаа бичиг, зурагтай цаас, хоёр талдаа бичиг, зурагтай цаас, сонин, картон цаас

**Аргачлал:** Олон төрлийн цаасыг бэлтгэж асууж ярилцана.

**Багшийн чиглүүлэх асуултууд:**

- Энд ямар цааснууд байна вэ?
- Цэвэрхэн цаасаар юу хийж болох вэ?
- Нэг талдаа бичиг, зурагтай цаасыг дахин ашиглаж болох уу?
- Хоёр талдаа бичиг, зурагтай цаасыг яаж дахин ашиглах вэ?
- Сонингийн цаасаар юу хийж болох вэ?
- Цаасыг яаж дахин хэрэглэх вэ?

Цааснуудыг дахин ашиглах тухай хэлсэн хүүхдүүдийн санааг нэгтгэн цаасыг дахин ашиглаж болдог тухай мөн ариг гамтай хэрэглэх тухай зөвлөгөө өгнө.

**Үйл ажиллагаа 2.** Зургийн дагуу ярилцъя (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** “Бяцхан цаасны түүх” зохиолын үйл явдлын зураг

**Аргачлал:** Багш зохиолыг хүүхдүүдэд уншиж танилцуулна. Дараа нь самбарт зохиолын үйл явдлын зургийг үзүүлэн хүүхдүүдийн тусламжтай дарааллаар нь байрлуулж ярилцана.

Багш хүүхдүүдийг 5 багт болгож, үйл явдалтай 5 зургийг нэг нэгээр нь өгч тодорхойлон яриулна.

- Нэгдүгээр багт /Цав цагаахан, шив шинэхэн бяцхан цаас хүүхэд бүрд хэрэгтэй зургийн цаас байлаа. Тэр өдөр бүр өөр дээрээ будгаар будуулж, чимэглүүлэхийг хүсэн хүлээдэг байв./ Бяцхан цаас зураг зуруулахыг хүсдэг байсан
- Хоёрдугаар багт /Нэгэн өдөр түүний хүлээснээр олон янзын цэцэгс зуруулж, улаан, хөх, шар өнгийн будгаар будуулж, хананд өлгөгдөн аз жаргалтай цаас болж гэнэ/ Нэгэн өдөр цаасан дээр улаан, хөх, шар өнгөтэй цэцэг зурж хананд өлгөхөд их баярлаж гэнэ.
- Гуравдугаар багт /Хананд өлгөөтэй түүнийг буулгаж гэнэ. Олон хоног хайрцагт хадгалж байгаад хогийн саванд хаяжээ./ Хананд өлгөөтэй байсан цаасыг буулгаж хогийн саванд хаяхад гуниглаж гэнэ.
- Дөрөвдүгээр багт /Дараа нь түүнийг бусад хаягдал цааснуудын хамт дахин боловсруулах үйлдвэрт аваачив./ Цаас дахин боловсруулах үйлдвэрт ирээд гайхаж гэнэ.
- Тавдугаар багт /Үйлдвэрийн олон дамжлагаар дамжин явсаар хамгийн сүүлд амны цаас болгон хувиргаж гэнэ. Дахин шинээр мэндэлсэн цаас маань маш ихээр баяртай байлаа./ Бяцхан цаасыг амны цаас болгон хувиргахад маш их баярлаж гэнэ.

*“Бяцхан цаасны түүх” зохиомжит өгүүллэгийг уншиж өгнө.*

*Цав цагаахан, шив шинэхэн бяцхан цаас хүүхэд бүрд хэрэгтэй зургийн цаас байлаа. Тэр өдөр бүр өөр дээрээ будгаар будуулж, чимэглүүлэхийг хүсэн хүлээдэг байв. Нэгэн өдөр түүний хүлээснээр олон янзын цэцэгс зуруулж, улаан, хөх, шар өнгийн будгаар будуулж, хананд өлгөгдөн аз жаргалтай цаас болж гэнэ. Хүн бүр бяцхан цаас дээр зурсан зургийг сонирхон байнга хардаг байжээ. Гэвч энэ үйл явдал удаан үргэлжилсэнгүй. Хананд өлгөөтэй түүнийг буулгаж гэнэ. Олон хоног хайрцагт хадгалж байгаад хогийн саванд хаяжээ. Дараа нь түүнийг бусад хаягдал цааснуудын хамт дахин боловсруулах үйлдвэрт аваачив. Үйлдвэрийн олон дамжлагаар дамжин явсаар хамгийн сүүлд амны цаас болгон хувиргаж гэнэ. Дахин шинээр мэндэлсэн цаас маань маш ихээр баяртай байлаа.*

**Үйл ажиллагаа 3.** Хогоо түүгээрэй (Хөгжөөн баясах цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Янз бүрийн цаас, ундааны сав зэрэг дахин боловсруулах боломжтой хог хаягдал, уут

**Аргачлал:** Хүүхдүүдийг бүлгийн хүлээн авах өрөөнд оруулсны дараа ангийн орчинд янз бүрийн цаас, ундааны сав зэрэг дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг санаатайгаар тараасан байна. Хүүхдүүд ангид орж ирэх үед тэд газраар хаясан хогийг татаж авах үйл хөдлөлийг ажиглаж, өөрийн санаачилгаар хогийг түүж байна уу?, эсвэл багшийн сануулгын дараа үйлдэл хийж байна уу? гэдгийг тэмдэглэнэ. Дараа нь бүх хогийг хамтдаа цэвэрлэх ба ижил төрлийн хогийг тус тусын уутанд ангилж ялгуулна. Хог хаягдлыг ангилж ялгаж хаядаг тухай нэмэлт тайлбар өгнө.

## ЦААС УС ШИНГЭЭДЭГ ҮҮ?

**Шинэ үг:** Хатуу, зөөлөн

**Үйл ажиллагаа 1.** Цаас бүрийн онцлогийг ярилцъя (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Ариун цэврийн цаас, амны цаас, бичгийн цаас, сонингийн цаас, картон цааснууд

**Аргачлал:** Хүүхдүүд төрөл бүрийн цаасыг цуглуулж, гараараа тэмтэрч мэдэрнэ. Тэд цаасны нимгэн, зузаан, хатуу, зөөлөн зэрэг шинж чанарын талаар ярилцана.

Цааснуудыг ажигласны дараа асуултын дагуу ярилцлага өрнүүлж, хүүхдүүдээс өөрийн таамаглалыг дэвшүүлэхийг уриална.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Ямар цаас усыг хамгийн хурдан шингээх вэ?
- Чи яагаад энэ цаас илүү ус шингээнэ гэж бодож байна вэ?
- Ямар цаас усыг шингээж чадахгүй гэж бодож байна вэ?

Дараа нь хатуу, зөөлөн, нимгэн зузаан зэрэг шинжээр нь цаасыг харьцуулж ялгах ба аль нь усыг илүү хурдан шингээдэг талаар таамаг дэвшүүлж ярилцана.

**Үйл ажиллагаа 2.** Туршилт хийцгээе (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Ариун цэврийн цаас, амны цаас, бичгийн цаас, сонингийн цаас, картон цааснууд, ус, сав, тэмдэглэгээ хийх цаас

**Аргачлал:** Саванд ус хийж, төрөл бүрийн цаасыг (ариун цэврийн цаас, амны цаас, бичгийн цаас, сонин, картон цаас гэх мэт) усанд дүрнэ.

Хүүхдүүдтэй хамт аль цаас усыг хамгийн сайн шингээж байгааг ажиглаж, ялгааг ярилцана. Туршилтын явцад хүүхэд бүр өөрийн таамаглалыг хэлж, ажиглалтаа тэмдэглэнэ. Ямар цаас илүү ус шингээж байна вэ?, Яагаад ингэж бодож байна вэ? гэх мэт асуулт дэвшүүлж, харьцуулалт хийнэ.

Эцэст нь ажиглалтаа нэгтгэн, аль төрлийн цаас хамгийн сайн ус шингээдэг болохыг хүснэгтэд дүгнэж тэмдэглэнэ.

Цаасны төрөл	Ус ихээр шингэдэг (улаан)	Ус багаар шингэдэг (ногоон)
Ариун цэврийн цаас		
Амны цаас		
Картон цаас	.... гэх мэт	

## АНХААР ЭХЭЛ

**Шинэ үг:** Дохио, эргэх, хөрвөөх

**Үйл ажиллагаа 1.** Сэргэлэн хүүхдүүд (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Аргачлал:** Хүүхдүүд талбайн голд зогсоно. Багш дараах дохионуудыг өгч тайлбарлана.

- Гараараа баруун/зүүн тийш заахад хүүхдүүд баруун/зүүн тал руу алхана.
- Гараа дээш өргөхөд талбайн голд өлмий дээрээ алхаж цуглана.
- Гараа дээш өргөн сарвууны үеэр эргүүлэхэд тойргоор гүйнэ.
- Багш доошоо суухад хүүхдүүд газар сууна гэх мэт

Хүүхдүүд багшийн дохиог анхааралтай харж үйлдлийг гүйцэтгэж тоглоно.

**Үйл ажиллагаа 2.** Зүг зүг үсэрье. (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Аргачлал:** Хүүхдүүд гар гараасаа хөтлөлцөн тойргоор зогсоно. Багш “Урагшаа”, “Арагшаа” дохиогоор бүгдээрээ зэрэг үсэрнэ. Мөн баруун, зүүн гэсэн дохиог биелүүлэн үсэрнэ. Хүүхэд бүрийг үсрэлт хийж дуусахыг хүлээж дараагийн дохиог өгнө. Аажмаар хөгжмийн хурдан удаан хэмнэлтэй аянд хөдөлгөөнийг хийлгэж анхаарал төвлөрөлтийг шалгаж тоглоно.

**Үйл ажиллагаа 3.** Хөгжилтэй алчуур (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Жижиг алчуур

**Аргачлал:** Хүүхдүүд 4 эгнээгээр, шатарчилсан байрлалд завилж сууна. Хүүхэд бүр гартаа жижиг алчуур барина. Хөгжмийн хэмнэлийн дагуу алчууртай цогц дасгал гүйцэтгэнэ. Хүүхдүүд багшийг даган дуурайж хийнэ. Багш хөдөлгөөнийг ашиглан хөгжмийн аянд тохируулан зохиомжилно. /цахим холбоос 1./

**Үйл ажиллагаа 4.** Амралт (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Аргачлал:** Хөгжмийн ая эхлэхэд хүүхдүүд урагш мөлхөнө. Багш мөлхөлт гүйцэтгэж байх үед: “Доошоо харж хэвтээрэй”, “Тавтай нойрсоорой”, “Хажуу тийшээ харж эргээрэй”, “Сэрээд суниагаарай” гэх зэрэг дохиог өгөхөд дагаж биелүүлнэ. Хөгжим дуугарахад хүүхдүүд дахин мөлхөөд үргэлжлүүлэн давтаж тоглоно.

**12 дугаар сарын II долоо хоног**

### ЦААСНЫ ХЭРЭГЛЭЭ

**Шинэ үгс:** Модны үртэс, үйлдвэр

**Үйл ажиллагаа 1.** Цаас хаанаас үүссэн бэ? (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Бичлэг

**Аргачлал:** Цаасыг хэрхэн хийдэг тухай бичлэг үзүүлж ярилцана./цахим холбоос 2./

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Цаасыг юугаар хийдэг гэж боддог вэ?
- Цаасаар бид юу хийдэг вэ?

**Үйл ажиллагаа 2.** Шинэ цаас бүтээх туршилт (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Төрөл бүрийн цаас /сонин, картон, ариун цэврийн цаас, хаягдал цаас/, хувин, ус, хутгуур, шүүлтүүр

**Аргачлал:** Хүүхдүүд хуучин цаасыг жижиглэж савандаа хийж, ус нэмнэ. Багштай хамт цаасыг дэвтээж хутгана. Шүүлтүүр дээр нухсан цаасаа шахаад, нимгэн тараан тавьж хатаана.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Хуучин цаас задарч байгааг юу гэж бодож байна вэ?
- Цаасан дээр ус нэмэхэд юу өөрчлөгдсөн бэ?
- Хатах үед яах бол?

Маргааш өглөөний тойргийн цагаар хатсан цаасыг дахин ашиглаж болох эсэхийг ярилцана.

**Үйл ажиллагаа 3.** Цаасаар юу хийж болох вэ? (Төвийн үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Төрөл бүрийн цаас, хайч, цавуу, скоч, туузан наалт

**Аргачлал:** Цаасаар бид юу хийдэг вэ? гэсэн асуултын дагуу чиглүүлэг өгч ярилцана.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Энэ цаасаар юу хийж болох вэ?
- Цаасыг яаж ашиглаж байсан бэ?

Хүүхдүүд цаасаар өөрийн хүссэн зүйлээ бүтээнэ. Шинээр бүтээсэн цаасаа ашиглаж болно. Багш хүүхдийн хийх гэж буй зүйлийг чиглүүлж, нугалах, хайчлах, наах аргыг зааж өгнө. Хийж дууссаны дараа хүүхдүүд цаасаар хийсэн бүтээлээ тайлбарлаж танилцуулна.

## АРИУН ЦЭВРИЙН ЦААСАА ГАМНАЯ

**Шинэ үгс:** Таславч, барзгар

**Үйл ажиллагаа 1.** Таагаарай (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Ариун цэврийн цаас, түмпэн, зоос, модон тоглоом, алчуур

**Аргачлал:** Дөрвөн өөр түмпэнд ариун цэврийн цаас, хөвөн, зоос, модон тоглоомыг хийж алчуураар бүтээнэ. Дуу гаргах эсвэл тэмтрүүлэх зэргээр юу болохыг хүүхдээр таалгана. Хүүхэд сонссон болон тэмтэрсэн зүйлийн шинж чанарыг асуултын дагуу тодорхойлно.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Юу дуугарсан бэ?
- Чамд ямар зүйл мэдрэгдсэн бэ?
- Хатуу байна уу? зөөлөн байна уу?
- Барзгар байна уу? гөлгөр байна уу?
- Хүнд байна уу? хөнгөн байна уу? Таасан зүйлийн шинж чанарыг тайлбарлан ярина.

Цаасыг юугаар хийдэг тухай судалж ирэх даалгавар өгөх ба дараагийн өдрийн тойргийн цагаар цаас хэрхэн бүтсэн тухай ярилцлага хийнэ.

**Үйл ажиллагаа 2.** Цаасны туршилт (Төвийн үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Олон төрлийн ариун цэврийн цаас, ус, хоолны жижиг халбага, түмпэн, дусаагуур, аяга, зоос

**Аргачлал:** Баг - 1 Ариун цэврийн цаасны шингээх чадварыг туршигдаа түмпэнд хоолны жижиг халбагаар 3 удаа ус хийнэ. Тухайн усыг шингэхэд нэг нэг таслагчаар цаасыг таслан авч усан дээр ариун цэврийн цаасаа тавина. Хэдэн таславч цаас хэрэглэснийг хүснэгтэд тэмдэглэнэ.

Ариун цэврийн цаасыг жорлон руу хийвэл бохирын хоолой бөглөрөх аюултай байдаг тул уусдаг цаас хэрэглэхийг зөвлөнө. Хэрвээ ариун цэврийн цаас усанд задарч уусахгүй байвал хогийн сав руу хийж хэвшихийг сануулна.

Баг - 2 Ариун цэврийн цаасны бат бөх чанарыг туршиж үзье. Аяганд ус хийх ба ариун цэврийн цаасыг аяганы амсарт нь тогтооно. Тогтоосон ариун цэврийн цаас дээрээ дусаагуураар 5 удаа ус дусаана. Дараа нь зоосыг нэг нэгээр нь нэмж тавина. Цаас зоосыг даах хүртэл нэмж тавина. Урагдсан тохиолдолд туршилтыг дуусгана.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Ариун цэврийн цаас нь амархан цоорч байна уу?
- Цоорохгүй байна уу? Ажиглаарай.
- Хэдэн зоос тавихад цаас цоорсон бэ?

Нийт тавьсан зоосны тоог хүснэгтэд бичнэ.

### ЧИМЭЭ

**Шинэ үг:** Биеийн мэдрэмж

**Үйл ажиллагаа 1.** Чимээгээр таая (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Өсгөгч эсвэл дуу тоглуулагч (компьютер, гар утас, таблет)

**Аргачлал:** Хүүхдүүд “Сонсоорой” гэхэд анхаарлаа төвлөрүүлээд эргэн тойронд сонсогдож байгаа дуу чимээг тааж нэрлэнэ. Багш өгөгдсөн холбоос руу орж цаастай холбоотой дуу чимээнээс хүүхдүүдэд сонгож сонсгоно. Жишээ нь: хуудас эргүүлж буй чимээ, цаас сэгсрэх чимээ, цаас урах чимээ, цаас үрэх чимээ гэх мэт. /цахим холбоос 3./

**Үйл ажиллагаа 2.** Сонсоод дагаад хийгээрэй (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Эд зүйлс

**Аргачлал:** Багш эхлээд ангийн нэг хүүхдийг сонгон 2 үйлдэлт заавар өгнө. Дараа нь хүүхэд бүрд өөр өөр заавар өгч хийлгэнэ. Хүүхдүүд багшийн хэлсэн зааврыг биелүүлнэ. Үйл ажиллагааны төгсгөлд бид дуу чимээг чихээрээ сонсож биелүүлдэг гэдгийг тайлбарлана.

/алгаа зөөлөн ташаарай, алгаа хүчтэй ташаарай, ширээн дээр зөөлөн товшоорой, ширээн дээр хүчтэй товшоорой, цаасыг сэгсрээрэй гэх мэт/

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Сул дуу чимээг сонсоод, чамд ямар мэдрэмж төрж байна вэ?
- Чанга дуу чимээг сонсоод, чамд ямар мэдрэмж төрж байна вэ? гэсэн асуултын дагуу ярилцана.

**Үйл ажиллагаа 3.** Бяцхан цаасны сэтгэл хөдлөл (Хөгжөөн баясах цаг)

**Аргачлал:** “Бяцхан цаасны түүх” зохиомжит өгүүллэгийг сэргээн сануулж ярилцана. Багш хүүхдүүдтэй хамтран дараах тоглоом тоглоно. Бүх хүүхэд хоёр гарын алгыг дэлгэн нүүрний өмнө барьсан байна. Багш “-Бяцхан цаас дээр хүүхэд зураг зурахад түүний сэтгэл хөдлөл ямар байсан бол нүүрний хувирлаар илэрхийлээрэй” гэж хэлнэ. Хүүхдүүд зохиолын дүр болох бяцхан цаасны сэтгэл хөдлөлийг мэдэрч нүүрний хувирлаар илэрхийлж үзүүлэхдээ хоёр гарыг дэлгэн царайг бусдад харуулна. Энэ мэтчилэн тоглоомыг үргэлжлүүлэн тоглоно.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Бяцхан цаасыг зураг зуран хананд өлгөхөд түүний сэтгэл хөдлөл ямар байсан бэ?
- Бяцхан цаас дээрх зургийг хүүхдүүд сонирхон харахад түүний сэтгэл хөдлөл ямар байсан бэ?
- Бяцхан цаасыг хананаас буулгаж хогийн саванд хаяхад түүний сэтгэл хөдлөл ямар байсан бэ?
- Бяцхан цаас шинэхэн амны цаас болоход түүний сэтгэл хөдлөл ямар байсан бэ?

Өгүүллэгийн үйл явдлыг дэлгэрүүлэн үргэлжлүүлэн зохиож ярилцана.

**Сонсьё, дэмжье/ Туслалцаа:**

- Хүүхэд туршилт хийж байх үед бичлэг хийгээд баримтжуулах боломжтой бөгөөд үүний дараа QR код үүсгэн хувийн хавтаст хадгалаарай.
- Сонсгол, хараа, хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд ажиглах, сонсох, барьж тэмтрэх, хөдөлгөөнөөр илэрхийлэх зэрэг үйл ажиллагаанд өөрийн санаачилгаар оролцохыг дэмжиж, тэдний идэвхтэй оролцоог хангаарай.

**Эцэг эхтэйгээ хамтаръя.**

- Гарын хөдөлгөөнийг сайжруулах тоглоомын санааг эцэг эх, асран хамгаалагчтайгаа хамтран тоглож ирэх даалгавар болгон өгөх ба хүүхдүүддээ найзууддаа ирж тоглуулахыг санал болгоорой.
- Ойр зуурын юмс үзэгдлийн шинж чанарыг таньж мэдэх сонирхлыг өдөөж туршилт хийх боломжоор хангаж хамтдаа туршилт хийж шинж чанарыг таниулаарай.
- хатуу зөөлөн, барзгар гөлгөр гэх мэт шинж чанар илэрхийлсэн үгээр хүүхдийг ярихад нь дэмжлэг үзүүлээрэй.

Цахим холбоос:

1. <https://www.youtube.com/watch?v=f56PwbVQBqM&list=PL6tU7dpKrrtpLjOtc0-pGBNTDsimxMzg0&index=9>
2. <https://www.youtube.com/watch?v=s6KdIsNvPD8>
3. <https://pixabay.com/sound-effects/search/paper/>

**Багшийн эргэцүүлэмж**

<p><b>Эргэцүүлэл</b> /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ./</p> <p>Амжилттай хэрэгжүүлсэн: .....</p> <p>Сул хэрэгжүүлсэн:.....</p> <p>Цаашид сайжруулах:.....</p> <p>Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа: .....</p>
--

## ЗОРИГТОЙ ХҮҮХЭД

### Хүүхдийн эзэмших чадамж:

**Нийгэм сэтгэл хөдлөл:** Зохиолд тулгуурлан хүүхэд сэтгэл хөдлөлөө нэрлэж, тайвшрах аргыг сурах, мөн өдөр тутмын үйл ажиллагаанд тодорхой үүрэг, хариуцлага хүлээж идэвхтэй оролцдог болно.

**Харилцах:** Хүүхэд харилцан яриа, дүрд тоглох зэрэгт өөрийн санаачилгаар идэвхтэй оролцож, санаа бодлоо илэрхийлэх, номын зургийг тайлбарлан ярих, мөн дууны үгийг тод хэлж, ая хэмнэлийн дагуу бусадтай хамт дуулах зэрэг чадварыг эзэмшинэ.

**Шүүн тунгаах:** Зохиолын үйл явдлыг таамаглаж, харьцуулан дүгнэх, толинд харж өөрийгөө ажиглах, мэдрэмжээ илэрхийлэх чадварыг хөгжүүлнэ.

### Аюулгүй байдлын зөвлөмж:

Хүүхдэд аюулгүй, тохиромжтой орчныг бүрдүүлж, сургалтын хэрэгслийг багшийн хяналт дор зөв, зохистой ашиглуулах нь чухал. Багш хүүхдийн анхаарал, хөдөлгөөнийг байнга ажиглан, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авч, асуулт асууж, үйл ажиллагааг зөв удирдан чиглүүлнэ. Мөн хүүхдэд аюулгүй байдал болон дүрэм журмыг ойлгуулж, бие даан суралцах орчныг дэмжинэ.

### Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

#### Тойргийн цаг:

- "Ганааг зуръя" үйл ажиллагааны хүрээнд Ганаагийн айсан, баярласан, гайхсан үеийн нүүрний хувирал, биеийн хэлэмжийг зурагт үзүүлэн эсвэл номоос жишээлэн тайлбарлаж, хүүхдүүд өөрийн мэдрэмжээ үгээр болон дүрслэлээр илэрхийлэх чадварыг төлөвшүүлэхэд анхаараарай.
- Өглөө, өдөр, орой, шөнө гэсэн хоногийн хэсгүүдийн ялгааг зурагт үзүүлэн ашиглан ойлгуулах ба энэ үед эргэн тойронд юу өөрчлөгддөг талаарх хүүхдийн төсөөллийг дэмжээрэй.
- Толинд өөрийгөө ажиглаж, нүүр, үс, нүд, ам зэрэг биеийнхээ хэсгүүдийг зааж нэрлэх чадварыг дэмжиж ажиллаарай.

#### Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:

- "Мангас Оди" зохиолыг нүүрний хувирал, дуу хоолойн өнгө, дохио зангаа, хөдөлгөөнөөр баяжуулан жүжиглэж танилцуулах нь хүүхдийн анхаарал төвлөрөл болон шинэ үг, аялгуу суралцах чадварыг нэмэгдүүлнэ. Хэрэв айдастай бол тайвшруулах, айдсаа давж дуулахад нь туслаарай.
- Ганаа хүүгийн дүрийг зуруулахдаа усан будаг, бийр ашиглах, хурууны өндөг, бийрээр зурааслах, цэглэх аргаар чимэглүүлэх болон баримлын шавраар Оди нохойны их бие, толгой, чих, хөл зэрэг гурав ба түүнээс дээш хэсгийг цувих, бөөрөнхийлөх, хавтгайлах аргаар урлуулах аргачлалыг тодорхой тайлбарлаарай.
- Хүүхдэд хоногийн аль нэг үеийг (өглөө, орой гэх мэт) сонгон зурж, тухайн үед мэдэрсэн сэтгэл хөдлөлөө зураасаар илэрхийлэн, бүтээлээ тайлбарлах боломжийг олгоорой.

#### Төвийн үйл ажиллагаа:

- Баримлын шавар болон усан будгийг хольж шинэ өнгө гарган авах туршилтад хүүхдүүдийг идэвхтэй оролцуулж, хольж болох, болохгүй өнгөний талаар ярилцаарай. Хүүхдүүдээр шинээр үүсгэсэн өнгөтэй төстэй өнгөтэй тоглоомыг ангиас олж тоглоход чиглүүлснээр тэдний харьцуулан дүгнэх чадварыг хөгжинө.
- Ширээ, тоглоомын булангаа цэвэрлэх, тоглоомоо хураах зэрэг өдөр тутмын үйл ажиллагаанд анги хамт олноороо идэвхтэй, бие биеэ дэмжин оролцох дадлыг төлөвшүүлэх
- Хүүхдэд сэтгэл хөдлөл, биеийн хэлэмжийг ажиглан дүрслэх, өнгө хольж туршиж шинэ өнгө бүтээх чадвар олгоход чиглүүлнэ. Мөн ажиглах, төсөөлөх, бүтээлч сэтгэлгээ болон гарын хөдөлгөөний чадварыг хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

### Зугаалга:

- Зугаалгын үеэр цаг агаарын байдлыг (нар, цас, салхи гэх мэт) ажиглуулж, тухайн цаг агаарт тохирох хувцсыг сонгох, эсвэл хийх үйл ажиллагааг (жишээ нь, бороо орвол юу өмсөх, яагаад) тайлбарлах чадварыг дэмжээрэй.

### Хөгжөөн баясах цаг:

- Амьтдын дуу чимээг сонсож, ямар амьтан дуугарч байгааг таалгах, хөдөлгөөнөөр илэрхийлэхэд дэмжлэг үзүүлээрэй.
- "Миний сэтгэлийн хөдөлгөөн" үйл ажиллагаагаар хүүхдүүдээс "Өнөөдөр чиний хувьд ямар өдөр байна вэ?" гэж асууж, сэтгэл хөдлөлөө (инээмсэглэсэн, уурласан, гунигтай) стикерээр илэрхийлүүлж, тайлбарлахад нь чиглүүлнэ.

### Боломжууд:

Мангас Оди” зохиолд хүүхэд айх хэсэг гардаг тул багш “энэ бол зүгээр л зохиол, үнэхээр мангас биш” гэдгийг давтан хэлж, тайвшруулна. Хүүхэд айсан шинжтэй байвал тайвшралын буланд суулгаж, өөр зүйлд сатаарах, сэтгэл хөдлөлөө зургаар илэрхийлэх, эсвэл гүнзгий амьсгал авах зэргээр тайвшруулах аргыг зааж сургаарай.

### Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
ХЯЗ.2а. Харилцан ярианд өөрийн санаачилгаар оролцож санал бодлоо илэрхийлнэ. НСХЗ.1а. Сэтгэл хөдлөлөө таатай, таагүй байгааг илэрхийлдэг болно.	- Сонссон үлгэр, өгүүллэгийг өөрийн үгээр эргүүлэн ярьж, асуудлыг хэрхэн шийдсэн тухай өөрийн дүгнэлт, харьцуулалтыг хэлэх. - Төрөл бүрийн сэтгэл хөдлөл мэдэрэх үлгэр, зохиолтой танилцаж тухайн дүр ямар үед таатай эсвэл таагүй мэдрэмж төрүүлсэн тухай ярилцах.	Мангас Оди
ХӨГЗ.1б. Богино үгтэй дууг аянд тохируулж бусадтай хамт дуулна. ХЯЗ.3а. Номын зургаас үйл явдлыг ойлгож ярина.	- Бусдын дуулахыг анхааралтай сонсож хөгжмийн хамсраатай хамтран дуулах. - Амьтад, байгаль, үлгэрийн сэдэвт сонирхол татахуйц агуулгатай номын зураг үйл явдлыг ойлгож ярих	Миний гөлөг
ЗУЗ.2а. Өөрийн бодол төсөөллөөр зохиомжлон зурна. НСХЗ.3в. Үйл ажиллагаанд тодорхой үүрэг хүлээж оролцдог болно.	- Зурах сэдвийн хүрээнд ажиглаж, ярилцах - Ширээ, тоглоомын булангаа цэвэрлэх, тоглоомоо хураах зэрэг үйл ажиллагаанд анги хамт олноороо идэвхтэй, бие биеэ дэмжин оролцох	Ганааг зуръя
МАТЗ.2б. Өдөр тутмын хийдэг үйлийг дараалуулна. НСХЗ.1а. Сэтгэл хөдлөлөө таатай, таагүй байгааг илэрхийлдэг болно. ЗУЗ.2а. Өөрийн бодол төсөөллөөр зохиомжлон зурна.	- Өөрийн хийдэг үйлийг (сэрэх, шүдээ угаах, хувцас өмсөх, өглөөний цай уух, гутлаа өмсөх, цэцэрлэгтээ явах зэрэг үйлийг харуулсан зургийг өгч зөв дарааллаар байрлуулж ярих - Баяртай, ууртай, уйтгартай, гомдсон зэрэг сэтгэл хөдлөлийг нэрлэх, ялгааг тайлбарлах - Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн ялгааг зургаар илэрхийлэх	Хоногийн хэсгүүд ба миний сэтгэл хөдлөл
БНОЗ.1г. Цаг агаарын байдлыг зураг, тэмдэг ашиглан илэрхийлж, тохирох хувцас болон хийх үйл ажиллагааг сонгож тайлбарлана. ХЯЗ.2а. Харилцан ярианд өөрийн санаачилгаар оролцож санал бодлоо илэрхийлнэ.	- Жилийн дөрвөн улирлын цаг агаарын онцлог, хүмүүсийн хувцаслалт, амьтан ургамлын өөрчлөлтийг танин мэдэх, - Төрөл бүрийн сэдэв, үйл явдлын тухай харилцан ярьж тайлбарлах	Тольдоорой

<p>БНОЗ.1в. Мэдрэхүйн тусламжтайгаар юмсын шинж чанарыг ялгаж харьцуулна. ЗУЗ.3а. Баримлын шавар, элс, гурилан зуурмагаар гурав ба түүнээс дээш хэсгээс бүтсэн зүйлийг барьж бүтээнэ.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Юмсын шинж чанарыг мэдрэхүйгээрээ (амтлах, үнэрлэх, барих, харах, хүрэлцэх) мэдрэн ялгах</li> <li>- Баримлын багаж хэрэгслээ бие дааж сонгох</li> </ul>	<p>Одиг баримлаар урлая</p>
---	--	-----------------------------

Албан хэрэгцээнд

**1 дүгээр сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл**

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Зохиолтой танилцъя	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүдийг тойрог болгон суулгаж, “Бөмбөг дамжуулъя” тоглоом тоглоно. Багш зохиолыг нүүрний хувирал, дуу хоолой, хөдөлгөөнөөр баяжуулан жүжиглэн ярьж өгнө. Шинэ үг: дамжуулах, таатай, таагүй.	“Мангас Оди” зохиол, бөмбөг.	Ангид юу юу байна вэ? нэрлээрэй	Харилцах: Санаачилгаар оролцох	Санаачилгаар оролцож санал бодлоо илэрхийлдэг.
Асуултад хариулъя	Тойргийн цаг	Тоглоомын талбайд зохиолын үйл явдлыг хамтдаа ярилцана. Багш хүүхдийг сонгон бөмбөгийг шидээд асуулт асууна.	“Мангас Оди” зохиол	Ганаа юунаас айж байгаа бол?, Том цагаан нүдтэй зүйл юу байсан бэ?, Чи харанхуйгаас айдаг уу?, Хэрвээ чи байсан бол яах байсан бэ?, Ганаагийн сэтгэл хөдлөлийг үзүүлээрэй.	Нийгэм, сэтгэл хөдлөл: Айсан үед тайвшрах, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх	Сэтгэл хөдлөлөө таатай, таагүй байгааг хэлдэг.
Ямар амьтан дуугарсан бэ?	Тойргийн цаг	Амьтдын дуу чимээг (нохой, гөлөг, муур гэх мэт) ээлжлэн сонсоно. Хүүхдүүд амьтны дуу авиаг дуурайн дуугарна.	Амьтдын зурагт үзүүлэн, хөгжим.	Ямар амьтан дуугарсан бэ?, гөлөг яаж дуугардаг вэ?	Шүүн тунгаах: Дуу авиаг ялгах Харилцах: Дуурайн дуугарах	Амьтдын дуу чимээг сонсоод ялгаж нэрлэдэг
“Миний гөлөг” дуу сурцгаая	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Дууг сонсоно. Дууны утгаар ярилцана. Үг, аялгууны хүндрэлтэй хэсгийг давтан хэлүүлж, зурагт үзүүлэн дээр тайлбарлан цээжлүүлнэ. Шинэ үг: тохируулах.	Хөгжим, дууны бичлэг, дууны үгтэй зурагт үзүүлэн.	Дууны утга санааг тодруулах ярилцлага	Шүүн тунгаах: Дууны өнгө ялгаж тохируулан дуулах	Дууны үгийг тод хэлж, ая хэмнэлийн дагуу дуулдаг.
Том нохой, жижиг гөлөг	Хөгжөөн баясах цаг	Нохой, гөлөгний дууг сонсож өнгөөр ялгана (бүдүүн/нарийн). Хөдөлгөөнөөр илэрхийлнэ (нохой: хүчтэй алхах, гөлөг: үсрэх).	Хөгжим, нохой болон гөлөгний дуу хоолой.	Ижил үү, өөр үү сонсогдож байна уу?.	Шүүн тунгаах: Дууны өнгө ялгах Нийгэм, сэтгэл хөдлөл: Хөдөлгөөнөөр сэтгэл хөдлөлөө илэрхийлэх үйлийг дэмжинэ.	Нохой, гөлөгний дууг сонсоод ялгадаг Амьтныг дуурайж хөдөлдөг.

Сэтгэл хөдлөлийг дүрсэлцгээе	Тойргийн цаг	Багш "Ганаа айсан/баярласан үедээ ямар царайтай байсан бол?" гэж асууж ярилцана. Хүүхдүүд Ганаагийн биеийн хэлэмж, нүүрний хувирал зэргийг хэрхэн зурахаа ярилцаж, мэдрэмжээ тайлбарлана.	Олон төрлийн ном.	Ганаа айсан үедээ ямар царайтай байсан бол?; Баярласан, гайхсан үедээ яаж харагдсан бэ?.	Нийгэм, сэтгэл хөдлөл: Сэтгэл хөдлөлөө тайлбарлах Харилцах: Санаа бодлоо хуваалцах	Сэтгэл хөдлөлөө нэрлэж хэлдэг
Ганаа хүүг зурцгаая	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд Ганаа хүүгийн дүрийг усан будаг, бийр ашиглан зурж, зурааслах, цэглэх аргаар чимэглэнэ. Будаг хатсаны дараа хатуу цаасан дээр нааж хүрээний дагуу хайчилна.	Усан будаг, бийр, зургийн дэвтэр, хайч, амны цаас, хатуу цаас	(Хэрхэн дүрслэх, чимэглэх тухай чиглүүлэг)	Нийгэм, сэтгэл хөдлөл: Өөрийн бодол төсөөллөөр зохиомжлон зурах	Хүн, амьтны дүр, эд юмсын хэлбэрийг зөв илэрхийлдэг
Хоногийн хэсгийн талаар ярилцъя	Тойргийн цаг	Багш "өглөө, өдөр, орой, шөнө"-ийн зурагт үзүүлэнг харуулж, тухайн хэсгүүдэд юу болж байгааг ярилцана.Шинэ үг: Өглөө, өдөр, орой, шөнө.	Хоногийн хэсгийг харуулсан зурагт үзүүлэн	Өглөө хүмүүс юу хийдэг вэ?, Ганаа, Оди хоёр юу хийсэн бэ?, Орой, шөнө болохоор юу өөрчлөгддөг вэ?	Шүүн тунгаах: Цаг хугацааны ялгааг төсөөлөх	Өглөө, өдөр, орой, шөнийг ялгаж хэлдэг
Миний өдөр	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд хоногийн аль нэг үеийг сонгон зурж, тухайн үедээ мэдрэсэн сэтгэл хөдлөлөө зураасаар илэрхийлнэ. Бүтээлээ танилцуулна.	Зураг зурах цаас, өнгийн харандаа	Би өглөө цэцэрлэгтээ ирэхдээ баяртай байсан гэх мэтээр бүтээлээ танилцуулах		Өдөр тутмын хийдэг үйлийг дараалуулдаг.
Миний сэтгэлийн хөдөлгөөн	Хөгжөөн баясах цаг	Хүүхдүүд тухайн өдөр ямар сэтгэл хөдлөлтэй байгаагаа ярьж, сэтгэл хөдлөлийн стикерээс сонгож наана.	Хоногийн хэсгийг харуулсан зурагт үзүүлэн, сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлсэн зураг	Өнөөдөр чиний хувьд ямар өдөр байна вэ?, Өчигдөр ямар өдөр байсан бэ?.	Нийгэм, сэтгэл хөдлөл: Сэтгэл хөдлөлөө зураасаар илэрхийлэх Харилцах: Бүтээлээ тайлбарлах	Сэтгэл хөдлөлөө нэрлэж хэлдэг.
Өөрийгөө толинд харцгаая	Тойргийн цаг	Хүүхэд дунд хэмжээтэй толь ашиглан өөрийгөө харна. Биеийнхээ хэсгүүдийг зааж нэрлэнэ. Шинэ үг: Бохирдох.	Дунд хэмжээтэй толь.	Биеийнхээ аль хэсгийг харж чадаж байна вэ?, Би толинд нүүрээ харж байна гэх мэт.	Шүүн тунгаах: Өөрийгөө ажиглах	Юмсыг сайтар ажиглаж нэрлэдэг эсэх
Том, жижиг толь	Төвийн үйл ажиллагаа	Хүүхдүүд багт хуваагдан том, жижиг толь ашиглан ялгааг ажиглана. Толинд харсан биеийнхээ хэсгийг зурж, таалгана.	Жижиг, том хэмжээтэй 2 төрлийн толь, биеийн хэсгийг	Бүх биеэ харж чадаж байна уу?; Аль толинд өөрийн хувцасласан байдлаа	Шүүн тунгаах: Ажиглалт, харьцуулалт хийх	Орчны бодит юмсын 2-3 шинжийг ялгаж тайлбарладаг.

			харуулсан зурагт үзүүлэн, өнгийн харандаа.	бүрэн харах боломжтой вэ?		
Ганаа хүүгээ хувцаслая	Хөгжөөн баясах цаг	“Ганаа хүү” дүртэй зурагт цаг агаарт тохирох хувцсыг сонгон нааж/байрлуулна. Сонголтын шалтгааныг ярилцана.	Төрөл бүрийн хувцасны тараах материал, эрэгтэй хүүхдийн зурагт үзүүлэн.	Гадаа цаг агаар ямар байна вэ?; Яагаад энэ хувцсыг сонгосон бэ?	Шүүн тунгаах: Цаг агаарын байдлыг ажиглаж хэлэх Харилцах: Сонголтоо тайлбарлах	Цаг агаарт тохирох хувцас сонгож тайлбарладаг.
Өнгө хольж туршъя	Төвийн үйл ажиллагаа	Баримлын шавар, усан будгийг хольж шинэ өнгө гарган туршина. Хольж болох, болохгүй талаар ярилцана. Шинэ үг: Лав шавар, нийлэг шавар.	Баримлын шавар, засуур мод, ус, усан будаг, бийр, нийлүүр.	Шинэ өнгө үүсгэсэн болов уу?	Шүүн тунгаах: Өнгөний шинж, өөрчлөлтийг ялгах	Өнгө хольж туршилтад оролцдог.
Оди нохойг урлая	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд Оди нохойг бүтээхэд тохирох өнгийг сонгоно. Шавраар их бие, толгой, хөл, сүүл зэргийг цувих, бөөрөнхийлөх, хавтгайлах аргаар бэлдэнэ. Бэлдсэн хэсгүүдийг шавах, наах аргаар холбоно.	Баримлын шавар, хулдаас.	(Хэрхэн хэсгүүдийг бүтээж холбох тухай чиглүүлэг)	Нийгэм, сэтгэл хөдлөл: Гарын хөдөлгөөний чадварт дэмжлэг үзүүлнэ.	Гурав ба түүнээс дээш хэсгээс бүтсэн зүйлийг барьж бүтээдэг
Бүтээлийн үзэсгэлэн	Тойргийн цаг	Хүүхдүүдийн бүтээлийг байрлуулж, "Миний Оди юу хийж байгаа вэ?" гэх мэтээр тайлбарлуулна.	Хүүхдүүдийн бүтээлүүд.	Миний Оди юу хийж байгаа вэ?, Ганаа, Оди хоёр юу тоглож байна вэ?.	Харилцах: Бүтээлээ тайлбарлан ярих	Бүтээлийн тухай дүрслэн ярьдаг.

## 1 дүгээр сарын I долоо хоног

### МАНГАС ОДИ

Шинэ үг: дамжуулах, таатай болон таагүй

Үйл ажиллагаа 1. Зохиолтой танилцъя (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: “Мангас Оди” зохиол, бөмбөг

Аргачлал: Хүүхдүүдийг тойрог болгон суулгаж, “Бөмбөг дамжуулъя” тоглоом тоглоно. Бөмбөг дамжуулахдаа ангид байгаа нэг эд зүйлийг нэрлэнэ. (жишээ нь: сандал, ширээ, харандаа). Бүх хүүхэд дор хаяж нэг удаа бөмбөг дамжуулсны дараа багш зохиолыг нүүрний хувирал, дуу хоолойн өнгө, дохио зангаа, биеийн хөдөлгөөнөөр баяжуулан жүжиглэн ярьж өгнө.

Үйл ажиллагаа 2. Асуултад хариулъя (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Зохиолын үйл явдлын зураг

Аргачлал: Хүүхдүүд тойрог болж зогсоно. Зохиолын үйл явдлыг хамтдаа ярилцана.

Багшийн чиглүүлэг асуулт:

- Ганаа юунаас айж байгаа бол?
- Том цагаан нүдтэй зүйл юу байсан бэ?
- Чи харанхуйгаас айдаг уу?
- Хэрвээ чи байсан бол яах байсан бэ?
- Ганаагийн сэтгэл хөдлөлийг илэрхийлээрэй.

Анхаарах зүйл: Хүүхдүүд айж, түгшсэн байдал ажиглагдвал “Энэ бол зохиолын үйл явдал тул хэт их айх хэрэггүй. Айсан зүйл юу болохыг дараагийн хэсэгт хамтдаа мэдэцгээе” гэж тайвшруулна. Хэрвээ танай ангид тайвшралын булан байдаг бол тэр хэсэгт очиж, сэтгэл хөдлөлөө арилгахад тэдэнд туслаарай.

### МИНИЙ ГӨЛӨГ

Шинэ үг: тохируулах

Үйл ажиллагаа 1. Ямар амьтан дуугарсан бэ? (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Амьтдын зурагт үзүүлэн, хөгжим

Аргачлал: Багш амьтдын дуу чимээг (нохой, гөлөг, муур, тахиа гэх мэт) ээлжлэн сонсоно. “Ямар амьтан дуугарсан бэ?”, “Гөлөг яаж дуугардаг вэ?” гэж асууж ярилцана. Хүүхдүүд “Гөлөг-хав, хав, хав” гэж дуугардаг бол муур яаж дуугарах вэ? Багш амьтны зурагт үзүүлэнг харуулан ярилцаад, дуурайн дуугарна.

Үйл ажиллагаа 2. “Миний гөлөг” дуу сурцгаая (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хөгжим, дууны бичлэг

Аргачлал: “Миний гөлөг” дууг бичлэгээр эсвэл багш дуулж сонсоно. Дууны утгаар ярилцана. Үгийн болон аялгууны хүндрэлтэй хэсгийг 2-3 удаа давтан хэлүүлж, дуулуулна. Дууны үгийг зурагт үзүүлэн дээр тайлбарлан давтан хэлүүлнэ. Дууны үгийг мөр мөрөөр цээжилж, хэсэг хэсгээр холбон дуулна.

Үйл ажиллагаа 3. Том нохой, жижиг гөлөг (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Хөгжим, нохой болон гөлөгний дуу хоолой

Аргачлал: Хүүхдүүд тойрог болон зогсоно. Багш нохой, гөлөгний дууг сонсож, “Ижил үү сонсогдож байна уу?, Өөр сонсогдож байна уу?” гэж асууж ярилцана. Дараа нь хүүхдүүд дууг өнгөөр ялгаж дуурайн дуугарна.

Том нохой - бүдүүн, доод өнгөөр “ХАВ ХАВ ХАВ”, Жижиг гөлөг - нарийн, дээд өнгөөр “хав хав хав” гэж дуугарах гэх мэт. Хөдөлгөөнөөр илэрхийлнэ. Том нохой - хүчтэй алхах, суниах, гөлөг - үсрэх, гүйх гэх мэт.

### ГАНААГ ЗУРЪЯ

Шинэ үг: төсөөлөл

Үйл ажиллагаа 1. Ганаагийн сэтгэл хөдлөлийг дүрсэлцгээе (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Олон төрлийн ном

Аргачлал: Багш “Ганаа айсан үедээ ямар царайтай байсан бол?”, “Баярласан, гайхсан үедээ яаж харагдсан бэ?” гэж асууж ярилцана. Хүүхдүүд Ганаагийн биеийн хэлэмж, нүүрний хувирал, орчныг хэрхэн зурахаа ярилцаж, өөрийн мэдрэмжээ бусдад тайлбарлана. Ямар нэгэн номыг сонгон гол дүрийг олж ярилцана.

**Үйл ажиллагаа 2.** Ганаа хүүг зурцгаая (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Усан будаг, бийр, зургийн дэвтэр, хайч, амны цаас

**Аргачлал:** Багш жишээ зураг ашиглан хүүхдийн биеийн хэлэмж, байрлал, сэтгэл хөдлөлийг хэрхэн дүрслэхийг тайлбарлана.

Хүүхдүүд Ганаа хүүгийн дүрийг өөрийн төсөөллөөр усан будаг, бийр ашиглан зурна. Зургаа хурууны өндөг, бийрээр зурааслах, цэглэх аргаар чимэглэнэ. Будаг хатсаны дараа зургийг хатуу цаасан дээр нааж хүрээний дагуу хайчилна. Бүтээлээ байрлуулж үзэсгэлэн гаргана.

## 1 дүгээр сарын II долоо хоног

### ХОНОГИЙН ХЭСГҮҮД БА МИНИЙ СЭТГЭЛ ХӨДЛӨЛ

**Шинэ үг:** Өглөө, өдөр, орой, шөнө

**Үйл ажиллагаа 1.** Хоногийн хэсгийн талаар ярилцъя (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Өглөө, өдөр, орой, шөнө гэсэн хоногийн хэсгийг харуулсан зурагт үзүүлэн

**Аргачлал:** Багш “өглөө, өдөр, орой, шөнө”-ийн зурагт үзүүлэн харуулна. Хүүхдүүдтэй хамт зураг дээр юу болж байгааг ярилцана.

- Өглөө хүмүүс юу хийдэг вэ?
- Өдөр юу хийдэг вэ? Ганаа, Оди хоёр юу хийсэн бэ?
- Орой, шөнө болохоор эргэн тойронд юу өөрчлөгддөг вэ? гэх мэт.

**Үйл ажиллагаа 2.** Миний өдөр (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Зураг зурах цаас, өнгийн харандаа

**Аргачлал:** Хүүхдэд зургийн цаас, өнгийн харандаа өгч, “Өглөө, өдөр, орой, шөнө”-ийн аль нэг үеийг сонгон зурж, тухайн үедээ мэдэрсэн сэтгэл хөдлөлөө зураасаар илэрхийлнэ.

Зураг зурж дуусаад бүтээлээ танилцуулна.

- Би өглөө цэцэрлэгтээ ирэхдээ баяртай байсан.
- Би орой гэртээ очоод аав, ээжтэйгээ байхад аз жаргалтай байсан гэх мэт.

**Үйл ажиллагаа 3.** Миний сэтгэлийн хөдөлгөөн (Хөгжөөн баясах цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Өглөө, өдөр, орой, шөнө гэсэн хоногийн хэсгийг харуулсан зурагт үзүүлэн, сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлсэн зураг

**Аргачлал:** “Өнөөдөр чиний хувьд ямар өдөр байна вэ?”, “Өчигдөр ямар өдөр байсан бэ?” гэж асууж ярилцана. Хүүхдүүд тухайн өдөр ямар сэтгэл хөдлөлтэй байгаагаа ярьж, сэтгэл хөдлөлийн стикер (инээмсэглэсэн, уурласан, гунигтай гэх мэт)-ээс сонгон нүүрний зурагт байрлуулна. Жишээ нь: “Өглөө би баяртай байсан, тиймээс инээж буй зургийг сонгож байна.”

### ТОЛЬДООРОЙ

**Шинэ үг:** Бохирдох

**Үйл ажиллагаа 1.** Өөрийгөө толинд харцгаая (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Дунд хэмжээтэй толь

**Аргачлал:** Хүүхэд дунд хэмжээтэй толь ашиглан өөрийгөө харна.

- “Биеийнхээ аль хэсгийг харж чадаж байна вэ?” гэж асууж ярилцана.
- Хүүхдүүд ээлжлэн толинд өөрийгөө харж нүүр, үс, нүд, ам зэргийг зааж нэрлэнэ. Жишээ нь: Би толинд нүүрээ харж байна, Би хацраа харж байна гэх мэт

**Үйл ажиллагаа 2.** Том, жижиг толь (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Жижиг, том хэмжээтэй 2 төрлийн толь, биеийн хэсгийг харуулсан зурагт үзүүлэн, өнгийн харандаа,

**Аргачлал:** Хүүхдүүд багт хуваагдан дараах үйл ажиллагааг гүйцэтгэнэ. 1-р багийн хүүхдүүд том хэмжээтэй толинд биеийнхээ бүх хэсгийг харна. “Чи толинд юу харж байна вэ?”, “Бүх биеэ харж чадаж байна уу?” гэх мэт асуултаар ярилцана.

2-р багийн хүүхдүүд хоёр өөр хэмжээтэй толь (жижиг, том)-ийг ашиглан ялгааг ажиглаж зурагт үзүүлэн дээр тэмдэглэгээ хийнэ.

3-р багийн хүүхдүүд толинд харсан биеийнхээ хэсгийг зурж, бие биедээ таалгана. 4-р багийн хүүхдүүд ном дээрх зургаас биеийн хэсгүүдийг нэрлэж тоглоно.

Багууд төвүүд дээр ажиллаж дууссаны дараа дараах асуултын дагуу ярилцана.

- Аль толинд өөрийн хувцасласан байдлаа бүрэн харах боломжтой вэ?
- Хэрвээ товчоо буруу товчилсныг толинд харвал яах вэ? гэх мэт асуулт асууж ярилцана.

**Үйл ажиллагаа 3.** Ганаа хүүгээ хувцаслая (Хөгжөөн баясах цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Төрөл бүрийн хувцасны тараах материал, эрэгтэй хүүхдийн зурагт үзүүлэн

**Аргачлал:** Багш “Ганаа хүү” дүртэй зураг үзүүлж ярилцана.

**Багшийн чиглүүлэг асуулт:**

- Гадаа цаг агаар ямар байна вэ?
- Ганаа юу өмсөх хэрэгтэй вэ?

Хүүхдүүд цаг агаарын нөхцөл байдалд тохирох хувцсыг сонгон “Ганаа хүү”-д өмсгөнө. (нааж эсвэл байрлуулж болно).

Дараах асуултын дагуу ярилцана.

- Яагаад энэ хувцсыг сонгосон бэ?
- Хэрвээ бороо орвол ямар хувцас өмсөх вэ? гэх мэт.
- 

### **ОДИГ БАРИМЛААР УРЛАЯ**

**Шинэ үг:** Төрөл бүрийн баримлын шавар (лав шавар, нийлэг шавар)

**Үйл ажиллагаа 1.** Өнгө хольж туршъя (Төвийн үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Баримлын шавар, засуур мод, ус, усан будаг, бийр, нийлүүр

**Аргачлал:** 1-р багийн хүүхдүүд хольж болох, болохгүй өнгөний талаар ярилцана. Тухайн төвд байгаа тоглоом, хэрэглэгдэхүүн нэг бүрийн өнгөний талаар ярилцана. Тухайн өнгийг үүсгэхэд шинэ өнгө үүсгэсэн болов уу? Юу гэж бодож байна вэ? Ярилцана.

2-р багийн хүүхдүүд баримлын шаврыг хольж шинэ өнгө гарган туршина. 3-р багийн хүүхдүүд усан будгийг ашиглан 2 төрлийн өнгийг нийлүүлж шинэ өнгө үүсгэнэ. 4-р багийн хүүхдүүд 2 ба 3 дугаар багийн хүүхдүүдийн үүсгэсэн өнгөтэй төстэй өнгөтэй тоглоомыг олж тоглоно. Хэрвээ байхгүй бол ойролцоо өнгөтэй тоглоомыг сонгоно.

**Үйл ажиллагаа 2.** Оди нохойг урлая (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Баримлын шавар, хулдаас

**Аргачлал:** Хүүхэд Оди нохойг бүтээхэд тохирох өнгийг сонгоно. Шавраар нохойны их бие, толгой, чих, нүд, хамар, хөл, сүүл зэргийг цувих, бөөрөнхийлөх, хавтгайлах аргаар бэлдэнэ. Бэлдсэн хэсгүүдийг шавах, наах аргаар холбож, Оди нохойны баримал бүтээнэ.

**Үйл ажиллагаа 3.** Бүтээлийн үзэсгэлэн (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Хүүхдүүдийн бүтээлүүд

**Аргачлал:** Хүүхдүүдийн бүтээлийг анги болон хүлээн авалтын өрөөнд байрлуулж ярилцана.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Миний Оди юу хийж байгаа вэ?
- Ганаа, Оди хоёр юу тоглож байна вэ?” гэх мэтээр өөрийн бүтээлээ тайлбарлан ярина.

**Сонсьё, дэмжье/ Туслалцаа:**

Ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийг дэмжихийн тулд багш аюулгүй, хүртээмжтэй, ойлгоход хялбар орчинг бүрдүүлж, хүүхдийн хувийн хэрэгцээ, сонирхол, суралцах арга барилд тохируулан үйл ажиллагаа зохион байгуулна. Үүнд аюулгүй хэрэгсэл болон дарааллыг харуулсан тоглоом, дүрс ашиглах, шинэ үгийг давтан бататгах, ойлголтыг

тогтмол хянах, бие даах боломж олгох, хамтран ажиллах орчныг бүрдүүлэх, мөн сэтгэл хөдлөлийг үгээр илэрхийлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг арга барилыг багтаана.

### Эцэг эхтэйгээ хамтаръя.

Эцэг эхчүүд хүүхдийн бие даах чадвар, сэтгэл хөдлөлийг дэмжиж, өдөр тутмын үйл явдлыг ярилцан, шинэ үгийг бататгаж, ойлголтыг нь бэхжүүлэх, амьтны орчин, цаг агаар, технологийн хэрэглээг хамтдаа ажиглаж, бүтээлч тоглолт, зураг, хөгжим зэрэг үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг дэмжинэ.

Цахим холбоос:

1. <https://youtu.be/-SCF8y5Od-o>

### Багшийн эргэцүүлэмж

<p><b>Эргэцүүлэл</b> /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ./</p> <p>Амжилттай хэрэгжүүлсэн: .....</p> <p>Сул хэрэгжүүлсэн:.....</p> <p>Цаашид сайжруулах:.....</p> <p>Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа: .....</p>
--

## СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - II САР

### ХАМТДАА ТОГЛОЁ

#### Хүүхдийн эзэмших чадамж

**Харилцах:** Хүүхэд харилцан ярианд өөрийн санаачилгаар идэвхтэй оролцож, санал бодлоо хуваалцах, мөн юмсын байршил, шинж чанараар нь харьцуулан дүрслэхдээ үгээ оновчтой сонгож хэрэглэх, түүнчлэн "учраас", "болохоор", "яагаад гэвэл" зэрэг холбох үгсийг ашиглан тайлбарлаж сурах чадваруудыг эзэмшинэ.

**Шүүн тунгаах:** Хүүхэд хөгжмийн аялгууг сонсоод харьцуулах, ялгах, тайлбарлах зэргээр зохиомжлон дүрслэх, мөн зураг зурах, урлах үйлийн явцад олж авсан туршлага, шинэ санаагаа эргэцүүлэн дүгнэж, өөрийн үзэл бодол, үйлдлээ тодорхойлж тайлбарлахад суралцахад чиглэгдэнэ.

**Үндэсний болон дэлхийн өв соёлоос суралцах, өвлөх:** Хүүхэд мэдээлэл цуглуулах, ярилцах замаар уламжлалт тоглоом, наадам, хувцас, идээ ундаа зэрэг үндэсний онцлог, өв соёлыг ялган таньж, анхны туршлага хуримтлуулна.

#### Аюулгүй байдлын зөвлөмж:

Зугаалга болон Хөгжөөн баясах цаг-ийн үеэрх хөдөлгөөнт тоглоомыг зай талбай сайтай, аюулгүй газар зохион байгуулах, хурдтай өнхөрч байгаа том бөмбөг эсвэл цагариг ашигладаг тоглоомын үед, хүүхдүүдийн хөдөлгөөн, чиглэлийг байнга хянаж, бултаж зугтах үйлдлийг зөвхөн багшийн удирдлага дор, тодорхой зааварчилгааны дагуу гүйцэтгүүлэх шаардлагатай. "Шагайгаар наадъя" үйл ажиллагааны үеэр хүүхдүүд жижиг хэрэглэгдэхүүн (шагай)-тэй ажиллах тул, тэдгээрийг аманд хийхгүй байх, мөн нясалж харвах үйлдлийг гүйцэтгэхдээ эргэн тойрны хүүхдийг онохоос сэргийлж, багшийн нарийн хяналт дор тоглуулах, "Дүрэм зохиож мөрдье" үйл ажиллагаанд төрөл бүрийн чихэр, печень, ундааны цаас ашиглах тул хүүхдүүдэд зөвхөн цаасыг ашиглах, бодит амттан, хүнсний бүтээгдэхүүнийг огт хэрэглэхгүй, амталж үзэхгүй байх талаар анхааруулга өгч, эрүүл ахуйн дэглэмийг мөрдөөрэй.

#### Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

*Өглөөний хүлээн авалт:*

- Хүүхдүүдийг өглөө ирэх үед нь сонирхлыг нь татахуйц хөгжилтэй, эерэг уур амьсгал бүрдүүлж хүлээн авалтыг зохион байгуулаарай. Жишээлбэл: хөгжилтэй ая эгшиглүүлэх, хүүхэд бүртэй өөр, өөр аргаар мэндчилэх (гараа цохих, тэврэх, инээмсэглэх, асуулт асуух), тухайн өдрийн сэдэвтэй холбоотой бяцхан тоглоом санал болгож болно.

**Тойргийн цаг:**

- Цагаан сарын баярын онцлогийг хүүхдүүдэд ойлгуулахын тулд тойргийн цагаар хамтдаа сууж, баярын утга учир, уламжлалт зан үйл, ёс дэгийн талаар ярилцана. Хүүхдүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд олон тоглоомыг сонирхолтой аргаар төлөвлөн хэрэгжүүлээрэй.

**Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:**

- Хүүхдүүдэд учир шалтгааныг тайлбарлахдаа "учраас", "болохоор", "яагаад гэвэл" зэрэг холбох үгсийг ашигладаг тухай тайлбарлаж өгөөрэй.
- Шагайн тоглоомыг тоглох дүрмийг сайтар танилцуулж тоглож суртал нь зааварчилгаа өгч хамт тоглоорой.
- Чихэрлэг бүтээгдэхүүн хэрэглэхтэй холбоотой дүрмийг хамтдаа зохиоход дэмжлэг үзүүлээрэй.

**Төвийн үйл ажиллагаа:**

- Суралцахуйн үр дүнг бүрэн хэрэгжүүлэх нэг боломж нь төвийн үйл ажиллагаа юм. Хүүхэд бүр өөрийн сонирхсон төв дээр тоглох явцад харилцааны чадвар, асуудал шийдвэрлэх чадвар, биеийн уян хатан байдал, бүтээлч сэтгэхүйн чадвар зэрэг олон чадамжийг эзэмшихэд нь дэмжлэг үзүүлээрэй.

**Зугаалга:**

- Цаг агаар тогтуун өдрүүдэд хүүхдүүдийг гадаа гаргахдаа тодорхой хугацааг тогтоон, хөдөлгөөнт тоглоом тоглуулж байгаарай. Энэ нь биеийн хөдөлгөөн, хамтын ажиллагаа, анхаарал төвлөрөлтийг хөгжүүлэхэд тустай бөгөөд хүүхдүүдэд эрч хүч, баяр баясгалан өгнө.

**Хөгжөөн баясах цаг:**

- Бүлгийн багш болон багшийн туслах хамтран жүжигчилсэн үзүүлбэр үзүүлж, хүүхдүүдэд харилцах, дүрд орж тоглох боломжийг олгоорой.

**Боломжууд:**

Цагаан сарын ёс заншлын тухай болон тустай, тусгүй үйлийн ялгаануудын талаар нарийвчилсан харьцуулсан асуултуудыг асууж, улмаар "учраас", "болохоор", "яагаад гэвэл" гэсэн үгсийг ашиглан өөрийн үзэл бодол, хэрэгцээгээ тайлбарлах боломж олгоорой. Цөөнх үндэсний хүүхдүүд тухайн бүлэгт суралцдаг бол тэдний уламжлалт хувцасны онцлог болон цагаан сарын баярын ёс заншлыг бусад хүүхдүүдэд сонирхолтойгоор танилцуулаарай. Мөн бусад үндэсний соёлыг тайлбарлаж өгөөрэй.

**Үйл ажиллагааны төлөвлөлт:**

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
ХЯЗ.2в. Юмсын шинж чанар, онцлог илэрхийлсэн үгийг яриандаа ашиглана. БНОЗ.2д. Гэр бүлийн орчинд уламжлалт баярыг хэрхэн тэмдэглэдэг талаар өөрийн үгээр тайлбарлаж, ардын тоглоом, наадгайгаар наадна.	<ul style="list-style-type: none"><li>- Асуултын дагуу эд зүйлсийн онцлог шинжийг ярихдаа тохирсон үг хэлэх</li><li>- Зан заншлын тухай ярилцах</li></ul>	Цагаан сар гэж ямар баяр юм бол?
МАТ3.1а. 10 хүртэлх тоог цээжээр тоолох, 5 хүртэлх тооны юмсыг оноож тоолох, өгсөн тооноос эхэлж 1-ээр нэмэгдүүлэн тоолж, тоог жишнэ. НСХ3.1б. Өөрийн дуртай дургүй, чадах чадахгүй зүйлсээ илэрхийлж, хэрэгцээгээ тайлбарладаг болно. ХЭМ3.1в. Гарын сарвуу, хөлийн тавхайн хэсгээр хийх хөдөлгөөнийг зэрэг болон ээлжлэн гүйцэтгэнэ.	<ul style="list-style-type: none"><li>- 5 хүртэлх юмсыг оноож тоолох</li><li>- Өөрийн дуртай, дургүй зүйлсээ ялгаж, "Яагаад?" гэсэн асуултад хариулах</li><li>- Гар, хөлийн нарийн үйлдэлт хөдөлгөөнүүдийг ойлгож гүйцэтгэх</li></ul>	Шагайгаар наадъя
ЗУЗ.2в. Бүтээлээ толбо, дардсаар чимэглэнэ. ХӨГ3.1г. Аялгууны өөрчлөлтийг мэдэрч хөдөлгөөнөөр илэрхийлдэг.	<ul style="list-style-type: none"><li>- Бүтээлээ толболох аргаар давтамж үүсгэн чимэглэх</li><li>- "Хөдөлгөөнөө тааруулъя" хөдөлгөөнт тоглоом тоглох</li></ul>	Дээл

<p>НСХЗ.2в. Зан үйлүүдийг яагаад тустай, тусгүй болохыг тайлбарладаг болно. ЗУЗ.2б. Өөрийн бүтээлдээ тохирох өнгийг сонгож будна. БНОЗ.2д. Гэр бүлийн орчинд уламжлалт баярыг хэрхэн тэмдэглэдэг талаар өөрийн үгээр тайлбарлаж, ардын тоглоом, наадгайгаар наадна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Ямар үг, үйлдэл тустай байдаг, ямар үг, үйлдэл тусгүй байдаг талаар ярилцах</li> <li>- Зураг, бүтээлээ өнгө ялган, зохиомжлон будах</li> <li>- Зан заншлын тухай ярилцах</li> </ul>	<p>Тусч үйлийн хуанли</p>
<p>ХЭМЗ.2в. Хоол, хүнсний бүтээгдэхүүнээс эрүүл мэндэд тустай хүнсийг ялгаж, хэрэглэнэ. ЗУЗ.2б. Өөрийн бүтээлдээ тохирох өнгийг сонгож будна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хооллох үеийн дүрмийг ярилцах</li> <li>- Зураг, бүтээлээ өнгө ялган, зохиомжлон будах</li> </ul>	<p>Дүрэм зохиож мөрдье</p>
<p>ХӨГЗ.1в. Жигд ба жигд бус хэмнэлийг ялгана. НСХЗ.3в. Үйл ажиллагаанд тодорхой үүрэг хүлээж оролцдог болно.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хэмнэлийн зураглалыг харж ойлгох</li> <li>- Өдрийн дэглэмийн аливаа үйл ажиллагааны үед эвтэй оролцох</li> </ul>	<p>Дөрвөн бэрх</p>
<p>ХЭМЗ.1н. Хурдтай өнхөрч байгаа том бөмбөг, цагаригаас бултаж зугтана. ХЯЗ.2а. Харилцан ярианд өөрийн санаачилгаар оролцож санал бодлоо илэрхийлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хурдтай өнхөрч байгаа том бөмбөг, цагаригаас бултаж, зугтах хөдөлгөөнийг давтах</li> <li>- Төрөл бүрийн сэдэв, үйл явдлын тухай харилцан ярьж тайлбарлах</li> </ul>	<p>Авхаалжтай хүүхэд</p>

## 2 дугаар сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Миний гэр бүлийн цагаан сар	Тойргийн цаг	Эцэг эхээс авсан цагаан сар тэмдэглэж буй гэр бүлийн зургийг үзүүлж, тухайн зургийн эзэн хүүхдээр тайлбарлуулна.	Цагаан сар тэмдэглэж буй гэр бүлийн зураг.	(Зураг бүрийг хараад) Энд танай гэр бүл ямар баяр тэмдэглэж байна вэ? Юу хийж байна вэ?	Харилцах: Эд зүйлсийн шинж чанарыг яриандаа ашиглах	Уламжлалт баярыг талаар мэддэг.
Зургийг хараад тайлбарлаарай	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	А.Найгалмаагийн “Цагаан сар” шүлгийг уншиж өгнө. Цагаан сарын золгох ёслолын зургийг сонгуулан, тухайн үйлдлийг тайлбарлуулна. Тайлахдаа “учраас”, “болохоор”, “яагаад гэвэл” гэсэн үгсийг ашиглахад дэмжинэ.	Шүлгийн үйл явдлыг харуулсан зурагт үзүүлэн, зурган карт.	Ахмад хүнтэй яагаад тохойг нь түшин золгодог вэ?; Дүү хүнтэй яагаад гараа дээгүүр нь тавьж золгодог вэ?.	Харилцах: Санаа бодлоо илэрхийлэх	Баяр ёслолын мэндчилгээгээр мэндчилдэг.
Аль зургийг сонгох вэ?	Номын цаг	Цагаан сарын баярын үйл явдал, онцлогийг харуулсан зурган картуудаас сонгож, тухайн зүйлийг юунд хэрэглэдэг, хэрэгтэй эсэхийг тайлбарлана.	Цагаан сарын баярын зурган карт.	Бид үүнийг юунд хэрэглэдэг вэ?; Яагаад гэвэл энэ нь бидэнд хэрэгтэй юу?.	Харилцах: Асуултын дагуу хариулж, тайлбарлах	Юмсын байршил, шинж чанараар нь харьцуулах, дүрслэхдээ үгээ оновчтой сонгож ярьдаг.
Шагайгаар Таагаарай	Тойргийн цаг	“Эрхийн чинээ биетэй, эрхэм дөрвөн нэртэй. Тэр юу вэ?” оньсого таалгана. Шагайны дөрвөн талыг (хонь, ямаа, морь, тэмээ) зааж танилцуулна.	Шагай, олбог.	(Оньсогын хариулт); Шагайны дөрвөн тал юу юу вэ?	Үндэсний болон дэлхийн өв соёлоос суралцах, өвлөх: Уламжлалт тоглоомыг таних	5 хүртэлх юмсыг оноож тоолдог.
Шагайгаар Хамтдаа тоглоё	Төвийн үйл ажиллагаа	Хүүхдүүд сонирхлоор багт хуваагдан: 1) Шагайгаар морь уралдуулах; 2) Дөрвөн шагайг орхиж буусныг нэрлэх; 3) Шагайг усанд хийж туршилт хийх (живэх/хөвөх); 4) 3 удаа шагай орхиж, буусан талыг тоолж, цифрээр тэмдэглэх.	Шагай, олбог, цаас, чулуу, мод, ус, тэмдэглэх хуудас.	(Туршилттай холбоотой: Шагай яагаад живж, мод яагаад хөвж байна вэ?).	Үндэсний болон дэлхийн өв соёлоос суралцах, өвлөх: Уламжлалт тоглоомыг тоглох	Шагайгаар морь уралдуулж, дөрвөн бэрх тоглоомыг тоглодог.

Эрхий мэргэн	Хөгжөөн баясах цаг	Хүүхдүүд “няслах” үйлээр шагайг харваж тоглоно. Оносон шагайн тоог өөрөө тоолж, цаасан дээр цифрээр бичнэ.	Шагай (20 ширхэг), ширээ, харандаа, цаас.	Тоолж, тэмдэглэх	Шүүн тунгаах: Дүгнэлт хийх, тоолох	5 хүртэлх тооны юмсыг оноож тоолдог цифрийг тохируулдаг.
Дээл Ажиглаарай	Өглөөний хүлээн авалт	Дээл өмсөж ирсэн хүүхдүүдийн дээлийн өнгө, хээ, хэмжээ, урт богино болон дагалдах хувцсыг (малгай, гутал) хамтдаа ажиглаж ярилцана.	Дээл, малгай, монгол гутал (бодит үзүүлэн).	Чиний дээл ямар өнгөтэй вэ?; Дээлэн дээр чинь ямар дүрстэй хээ байна вэ?, Хээ нь ямар дүрстэй төстэй байна вэ? Хээ олон дахин давтагдсан байна уу? Дээл чинь урт уу, богино уу?	Харилцах: Асуултын дагуу хариулж, тайлбарлах	Асуултыг ойлгож хариулдаг.
Дээлийн зургийг чимэглэе	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Дээлийн зураг бүхий тараах материалыг усан будаг, туузан цаас зэрэг хэрэглэгдэхүүнээр өөрийн хүссэнээр чимэглэнэ. Хээний давтамж, дүрс, өнгөний зохицлыг ажиглана.	Дээлийн зурагтай тараах материал, будаг, бийр, цавуу, өнгийн цаас, эсгий бал.	Чимэглэлийн давтамж, өнгөний сонголт	Шүүн тунгаах: Зохиомжлон дүрслэх, шинэ санаагаа эргэцүүлэх	Бүтээлээ толбо, дардсаар чимэглэдэг. Зургийн дүр, эд юмсын онцлог нийцүүлэн тохирох өнгийг сонгож буддаг.
Бүжиглэцгээе	Хөгжөөн баясах цаг	Буриад, халх, казах ардын хувцастай хүмүүсийн бүжгийн бичлэгийг үзүүлнэ. Хүүхдүүд хөгжмийн хэмнэлд тохируулан хөдөлгөөн, бүжгийн хэв маягийг дуурайн гүйцэтгэнэ.	Хөгжим, дэлгэц, бичлэг.	Хэмнэлд тохируулан хөдлөх).	Шүүн тунгаах Аялгууны өөрчлөлтийг мэдэрч хөдөлгөөн хийхэд чиглүүлнэ.	Аялгууны өөрчлөлтийг мэдэрч хөдөлгөөнөөр илэрхийлдэг
Мэндчилгээ	Өглөөний хүлээн авалт	7 хоногийн өдрүүдэд өөр, өөр байдлаар мэндчилэхийг харуулсан хуанлийг ашиглан, өглөө бүр хэрхэн мэндчилэхийг чиглүүлнэ.	7 хоногийн өдрүүдэд мэндчилэхийг харуулсан хуанли.	Өнөөдөр ямар өдөр вэ?, Бид хэрхэн мэндчилэх вэ?.	Харилцах: Бусадтай мэндчилгээний үгээр мэндлэх	Өөрийн санаачилгаар мэндэлдэг.
Хуанли бүтээцгээе	Төвийн үйл ажиллагаа	Багууд "Цагаан сарын үеэр аав, ээждээ ямар ажилд туслах" тухай ярилцана. Багууд: 1) Туслах ажлыг зургаар илэрхийлэх (хуанли дээр); 2) Тустай, тусгүй	Хүснэгт бүхий цаас, эсгий бал, зурагт үзүүлэн, бичлэг.	Энэ их олон ажлыг хийхэд бид аав, ээждээ хэрхэн тусалж болох вэ?.	Харилцах: Тайлбарлах, санаа бодлоо хуваалцах	Зан үйлүүдийг яагаад тустай, тусгүй болохыг тайлбарладаг. Ярилцлагад идэвхтэй

		үйлийг ялгаж тайлбарлах (видео үзэх, жишээ хэлэх).				оролцож, санал бодлоо илэрхийлдэг.
Аль нь зөв бэ?	Хөгжөөн баясах цаг	Багш нар буруу/зөв зан үйлийг (золгох, мэндлэх) жүжиглэн үзүүлнэ. Хүүхдүүд тухайн үйлдэл зөв эсвэл буруу болохыг хэлж, яагаад зөв/бурууг тайлбарлана.	Багшийн жүжиглэсэн үзүүлбэр	Энэ үйлдэл зөв үү? Буруу юу? Яагаад зөв/буруу вэ?.	Үндэсний болон дэлхийн өв соёлоос суралцах, өвлөх: Ёс заншлыг таньж дагах	Баяр ёслолын мэндчилгээгээр мэндчилдэг. Хүний дүрд орж жүжиглэдэг.
Таамаглаарай	Тойргийн цаг	Чихэр, печень, ундаа зэрэг амттаны цаасыг ширээн дээр тарааж, хүүхдүүд таамаглал дэвшүүлэн, амт/төрлийг нь ярилцана.	Амттаны төрөл бүрийн цаас.	Энэ юуны цаас вэ?; Хэрвээ идэж байгаагүй бол ямар амттай гэж бодож байна вэ?.	Шүүн тунгаах: Таамаглалаа тайлбарлах	Юмсыг ажиглаж таамаглал дэвшүүлдэг.
Дүрэмтэй бугуйвч	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд бугуйвчаа чимэглэнэ. Чихэрлэг бүтээгдэхүүн хэрэглэх дүрмийг харуулсан зурагт үзүүлэнг нааж, тухайн зурагт тохирсон өөрийн дүрмийг зохионо.	Бугуйвч хийх тараах материал, дүрэм харуулсан зураг.	Энэ зургаар ямар дүрэм зохиож болох вэ? (Жишээ нь: Зайрмагийг хааяа идэж байгаарай).	Шүүн тунгаах: Дүрэм зохиож, хэрэгцээгээ тайлбарлах	Хооллох үеийн дүрмийг мэдэж, дүрэм зөрчилгүй хооллож чаддаг. Өөрт нь ямар хэрэгцээ үүссэн, явал дээр вэ гэдгийг тайлбарлан ярьдаг.
Дуугаа дуулъя / Алгаа ташаарай	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Дууны хэмнэлийг мэдэрч хамтран дуулна. Шагайг орхиж, буусан талын хэмнэлд тохируулан алгаа таших үйлдлийг гүйцэтгэнэ.	Хөгжим, шагай.	Хэмнэл ба хөдөлгөөний зохицол	Шүүн тунгаах: Хэмнэлийн өөрчлөлтийг мэдрэх	Хэмнэлийн өөрчлөлтийг мэдэрч хөгжмийн энгийн зэмсгээр тоглодог.
Бултаарай / Бүү оногд / Зугт	Зугаалга	Багш том цагаригийг уяагаар чирж нааш, цааш хөдөлгөхөд хүүхдүүд цагаригт хүрэхгүйгээр бултан зугтаж тоглоно.	40–50 см диаметртэй том цагариг, 2м уяа.	Хөдөлгөөний хурд, чиглэлийг таамаглах	Харилцах Найзуудтайгаа хамтран тоглох	Хурдтай бөмбөг, хөдөлгөөнт зүйлийн чиглэл, хурдыг таамагладаг, тэдгээрээс бултаж чаддаг.

## 2 дугаар сарын I долоо хоног

### ЦАГААН САР ГЭЖ ЯМАР БАЯР ЮМ БОЛ?

**Шинэ үг:** Золгох, нас чацуу

**Үйл ажиллагаа 1.** Миний гэр бүлийн цагаан сар (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Цагаан сар тэмдэглэж буй гэр бүлийн зураг, дэлгэц

**Аргачлал:** Багш эцэг эх, асран хамгаалагчаас файлаар авч бэлтгэсэн цагаан сар тэмдэглэж буй гэр бүлийн зургийг хүүхдүүдэд үзүүлнэ. Зураг бүрийг дэлгэц дээр томоор харуулж, тухайн зургийн эзэн хүүхэд өөрийн зураг дээр тайлбарлана.

**Үйл ажиллагаа 2.** Зургийг хараад тайлбарлаарай. (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Шүлгийн үйл явдлыг харуулсан зурагт үзүүлэн, зурган карт

**Аргачлал:** Багш хүүхдүүдэд А.Найгалмаагийн “Цагаан сар” шүлгийг уншиж өгнө. Унших явцад цагаан сарын баяраар хийдэг үйл ажиллагааны зургийг самбарт байрлуулж наана. Хүүхдүүд зурагт үзүүлсэн зургаас нэгийг сонгон, тухайн үйлдлийг тайлбарлана.

**Жишээлбэл:** Ахмад хүнтэй золгохдоо хоёр гараараа тохойг нь түшин “Та амархан сайн байна уу?” гэж хэлж, хоёр хацраа үнсүүлнэ. Нас чацуу хоёр хүн гар гарын бугуйгаар зөрүүлэн золгож байна гэх мэт.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Ахмад хүнтэй яагаад тохойг нь түшин золгодог вэ? (Өөрөөс минь ахмад хүн учраас гараа доогуур тавьж хүндэлж байгаа юм.)
- Дүү хүнтэй яагаад гараа дээгүүр нь тавьж золгож байна вэ? (Би өөрөө дүүгээсээ ах/эгч болохоор гараа дээгүүр нь тавьж золгодог гэдгийг тайлбарлана.)

Хүүхдүүд тайлбарлахдаа “учраас”, “болохоор”, “яагаад гэвэл” зэрэг холбох үгсийг ашиглан өгүүлбэрээр илэрхийлэхэд багш дэмжлэг үзүүлнэ.

**Үйл ажиллагаа 3.** Аль зургийг сонгох вэ? (Номын цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Цагаан сарын баярын үйл явдал, онцлогийг харуулсан зурган карт

**Аргачлал:** Багш ширээн дээр зурган картуудыг байрлуулж, хүүхэд бүр нэг зургийг сонгоно. Хүүхэд сонгосон зургаа ажиглан, ямар зураг болохыг тайлбарлана.

**Багшийн чиглүүлэх асуултууд:**

- Бид үүнийг юунд хэрэглэдэг вэ? Энэ зүйл бидэнд хэрэгтэй юу?

Хүүхдүүдийг дараах байдлаар ярьж сурахад багш дэмжлэг үзүүлнэ. Жишээ нь: “Аяганд хоол, цайгаа хийдэг. Аягандаа би хоолоо хийдэг учраас хэрэгтэй.”, “Яагаад гэвэл аягандаа хоол, цай хийх ёстой болохоор хэрэгтэй” гэх мэтээр холбох үгс ашиглан хариулахад дэмжлэг үзүүлнэ.

### ШАГАЙГААР НААДЪЯ

**Шинэ үг:** Таах, таалгах

**Үйл ажиллагаа 1.** Таагаарай (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Шагай, олбог

**Аргачлал:** Багш хүүхдүүдийг олбог дээр тойруулан суулгаж, таван хошуу малын зургийг үзүүлэн нэрлүүлнэ. Дараа нь дараах оньсогыг хэлж, таалгана.

“Эрхийн чинээ биетэй, эрхэм дөрвөн нэртэй. Тэр юу вэ?” (хариулт: шагай)

Оньсого таасны дараа хүүхэд бүрд нэг шагай өгч ажиглуулна. Багш шагайны дөрвөн талыг зааж, нэрлэж танилцуулна. (хонь, ямаа, морь, тэмээ)

**Үйл ажиллагаа 2.** Хамтдаа тоглоё (Төвийн үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Шагай, олбог, цаас, чулуу, мод, харандаа, тэмдэглэх хуудас

**Аргачлал:** Багш хүүхдүүдийг сонирхлын дагуу багуудад хуваана.

- 1-р баг: Шагайгаар морь уралдуулж тоглоно.
- 2-р баг: Хүүхдүүд тойрог болж суугаад 4 ширхэг шагайг орхиж, ямар ямар тал буусныг нэрлэж тоглоно.
- 3-р баг: Шагай, цаас, чулуу, мод зэрэг зүйлсийг устай саванд хийж, ямар зүйл живж, ямар нь хөвж байгааг ажиглан энгийн туршилт хийнэ.
- 4-р баг: Хүүхдүүд сагснаас 5 ширхэг шагай авч 1 удаа орхино. Тус бүрд нь хэдэн хонь, ямаа, тэмээ, морь буусныг тоолж, тохирох зургийн доор (+) тэмдэг тавина. 2 удаа орхиж

дууссаны дараа хамгийн доод талын хүснэгтэд нийт буусан шагайн тоог цифрээр бичиж эсвэл тооны цифрийг нааж тэмдэглэнэ.

**Үйл ажиллагаа 3.** Эрхий мэргэн (Чигүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** ширээ, шагай, харандаа, цаас

**Аргачлал:** Хүүхдүүдийг хоёр баг болгон хуваана.

- 1-р ширээн дээр: 20 ширхэг шагайг 30 см зайтайгаар эгнүүлэн байрлуулна.
- 2-р ширээн дээр: 10 ширхэг шагайг 10–15 см зайтайгаар эгнүүлэн тавина.

Нэг хүүхэд 10 удаа шагайгаа нясалж харвана. Харваж оносон шагайн тоог өөрөө тоолж, үр дүнд тохирсон цифрийг авч багшид өгнө. Дараа нь хоёр баг ширээгээ солин ээлжлэн тоглоно.

## ДЭЭЛ

**Шинэ үг:** уламжлалт хувцас, чимэглэх

**Үйл ажиллагаа 1.** Ажиглаарай (Өглөөний хүлээн авалт)

**Хэрэглэгдэхүүн:** Дээл

**Аргачлал:** Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдээ өглөө цэцэрлэгт дээлтэй ирүүлэхийг урьдчилан сануулна. Өглөөний хүлээн авалтын үеэр дээл өмсөж ирсэн хүүхэд бүрийн дээлийг хамтдаа ажиглан ярилцана.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Чиний дээл ямар өнгөтэй вэ?
- Дээлэн дээр чинь ямар нэгэн хээ байна уу? Хээний хэмжээ нь том уу, жижиг үү?
- Хээ нь ямар дүрстэй төстэй байна вэ? Хээ олон дахин давтагдсан байна уу?
- Дээл чинь урт уу, богино уу?

Мөн хүүхдүүд дээл өмсөхдөө малгай өмссөн эсэх, монгол гутал өмссөн эсэхийг ажиглаж, түүний онцлогийг ярилцана.

**Үйл ажиллагаа 2.** Дээлийн зургийг чимэглэе (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Дээлийн зурагтай тараах материал, усан будаг эсвэл гуаш, амны цаас, ус, бийр, эсгий бал, өнгийн цаас, цавуу

**Аргачлал:** Хүүхэд бүрд өөр, өөр дээлийн зураг бүхий тараах материал өгнө. Хүүхдүүд дээлийн зургийг өөрийн хүссэн өнгө, хэрэглэгдэхүүнээр чимэглэнэ. Жишээлбэл:

- Өнгийн туузан цаасыг жижиглэн дагнаас үүсгэх;
- Дугуй, дөрвөлжин, гурвалжин гэх мэт дүрсийг зохион бүтээж, давтамжтайгаар наах;
- Гуашаар дүрс, хээ зурах байдлаар бүтээлээ чимэглэж болно.

Багш хүүхдийн бүтээлч санааг дэмжиж, өнгөний зохицол, хээний давталт, дүрсний байрлалыг ажиглан ярилцана.

**Үйл ажиллагаа 3.** Бүжиглэцгээе (Хөгжөөн баясах цаг)

**Хэрэглэгдэхүүн:** дууны ая, хөгжим, дэлгэц

**Аргачлал:** Багш хүүхдүүдэд буриад, халх, казах ардын хувцастай хүмүүсийн бүжгийн бичлэгийг дэлгэцээр үзүүлнэ. Хүүхдүүд бичлэгийг үзэх явцдаа хөдөлгөөн, бүжгийн хэв маягийг ажиглаж, дараа нь хөгжмийн хэмнэлд тохируулан дагаж хөдөлнө. Хөдөлгөөнийг дуурайн хийхэд хүндрэлтэй байгаа хүүхдэд багш зааж чиглүүлэх, хамт хөдөлж дэмжлэг үзүүлнэ.

## 2 дугаар сарын II долоо хоног

### ТУСЧ ҮЙЛИЙН ХУАНЛИ

**Шинэ үг:** Бусдад тустай үйл, бусдад тусгүй үйл

**Үйл ажиллагаа 1.** Мэндчилгээ (Өглөөний хүлээн авалт)

**Хэрэглэгдэхүүн:** 7 хоногийн өдрүүдэд өөр, өөр байдлаар мэндчилэхийг харуулсан том хэмжээтэй хуанли

**Аргачлал:** 7 хоногийн өдрүүдэд хэрхэн мэндчилэхийг харуулсан хуанлийг ангийн үүдэнд байрлуулна. Өглөө хүүхдийг цэцэрлэгт ирэх үед багш тухайн өдөр нь долоо хоногийн хэд дэх өдөр болохыг асууж, “Өнөөдөр ямар өдөр вэ? Бид хэрхэн мэндчилэх вэ?” гэсэн асуултаар чиглүүлнэ. Хүүхэд тухайн өдрийн мэндчилгээг хэлсний дараа хамтдаа мэндчилж, ангидаа урин оруулна.

**Үйл ажиллагаа 2.** Хуанли бүтээцгээе (Төвийн үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Хүснэгт бүхий цаас, эсгий бал, сэдэвт тоглоомын хэрэглэгдэхүүн, олон төрлийн хэвлэмэл хуанли, зурагт үзүүлэн бичлэг, дэлгэц

**Аргачлал:** Хүүхдүүдийг 4–5 гишүүнтэй жижиг багаар хуваана. Багш “Цагаан сарын үеэр олон ажил хийдэг. Энэ их олон ажлыг хийхэд бид аав, ээждээ хэрхэн тусалж болох вэ?” гэсэн асуултаар үйл ажиллагаанд хүүхдүүдийг чиглүүлнэ.

**Багуудын үйл ажиллагаа:**

- 1-р баг: Хүснэгтэн хуанли дээр аав, ээждээ ямар ажилд туслахыг зургаар илэрхийлнэ.
- 2-р баг: “Цагаан сар” сэдэвт тоглоомоор тоглоно.
- 3-р баг: Хэвлэсэн хуанлийг хамтдаа ажиглаж, ямар хэсгүүдээс бүтсэн талаар багштай ярилцана.
- 4-р баг: Зурагт үзүүлэнг харж, тустай болон тусгүй үйлийг ялгаж тайлбарлана. Өөрийн туршлагаас жишээ хэлнэ.
- 5-р баг: Дэлгэцээр тустай болон тусгүй үйлийг харуулсан богино бичлэг үзээд, үзсэн зүйлээ ярилцана.

**Үйл ажиллагаа 3.** Аль нь зөв бэ? (Хөгжөөн баясах цаг)

**Аргачлал:** Багш, багшийн туслах хамтран цагаан сарын баяраар хийх болон болохгүй зан үйлүүдийг жүжиглэн үзүүлнэ. Жишээ нь: ахмад настай хүний гар дээр дүү хүн гараа тавин золгож буй байдал, цагаан сарын баяраар уулзахдаа золгохгүй байгаа үйлдэл гэх мэт. Хүүхдүүд багш нарын жүжигчилсэн тоглолтыг ажиглаж, тухайн үйлдэл зөв эсвэл буруу болохыг хэлнэ. Дараа нь “Яагаад зөв/буруу вэ?” гэдгийг тайлбарлана. Дараа нь хүүхдүүд өөрсдөө ахмад болон дүү хүний дүрд тоглон биечлэн хэрхэн мэндчилэхийг жүжиглэн харуулна.

### ДҮРЭМ ЗОХИОЖ МӨРДЬЕ

**Шинэ үг:** Бугуйвч

**Үйл ажиллагаа 1.** Таамаглаарай (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Төрөл бүрийн чихэр, печень, ундаа, үрэл зэрэг амттаны цаас хүүхдийн тоогоор

**Аргачлал:** Төрөл бүрийн чихэр, печень, ундаа, үрэл зэрэг амттаны цаасыг ширээний дээр тараан тавина. Хүүхдүүд өөрийн сонирхлоороо аль нэг цаасыг сонгон авна. Багш дараах асуултыг хүүхэд бүрд чиглүүлэн асууж, таамаглал дэвшүүлэн чиглүүлнэ.

- Энэ юуны цаас вэ?
- Чи ийм цаастай амттан идэж байсан уу?
- Ямар амттай байсан бэ?

**Үйл ажиллагаа 2.** Дүрэмтэй бугуйвч (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** бугуйвч хийх тараах материал, чихэр болон чихэрлэг бүтээгдэхүүн хэрэглэх дүрмийг харуулсан тараах материал

**Аргачлал:** Багш хүүхдийн тоогоор бугуйнд зүүх цаасыг хэвлэн бэлтгэнэ. Хүүхдүүд бугуйвчаа төрөл бүрийн зураасны загвараас сонгон зурж, чимэглэнэ.

Бугуйвч хийх цаасны голд чихэр болон чихэрлэг бүтээгдэхүүн хэрэглэх дүрмийг харуулсан тараах материалыг авч наана. Тараах материал дээрх зургийг ажиглан, түүнд тохирсон дүрэм зохионо. Жишээ нь: “Зайрмагийг идэж болохгүй.”, “Зайрмагийг хааяа идэж байгаарай.” гэх мэт. Хүүхдүүд дүрэм зохиоход багш чиглүүлж, дэмжлэг үзүүлнэ.

### ДӨРВӨН БЭРХ

**Шинэ үг:** дөрвөн бэрх, тойг

**Үйл ажиллагаа 1.** Дуугаа дуулъя (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Хөгжим, дууны ая, дэлгэц

**Аргачлал:** Багш Б.Дашгомбын үг, Г.Жанцансамбуугийн ая “Дөрвөн бэрх” дууг хүүхдүүдэд сонсгоно. Хүүхдүүд дууны мөр бүрийг нэг нэгээр давтан хэлж, мөр бүрийн утгыг тайлбарлана. Эхний бадгийг хүүхдүүдэд давтан хэлүүлсний дараа, дууны аялгуу, хэмнэлд

тохируулан дуулж сурахад багш дэмжлэг үзүүлнэ. Хүүхдүүд “тойг” гэсэн үгтэй мөр дээр дууны хэмнэлд тохируулан алгаа ташна.

## **Үйл ажиллагаа 2.** Алгаа ташаарай (Хөгжөөн баясах цаг)

**Хэрэглэгдэхүүн:** шагай, олбог

**Аргачлал:** Багш дөрвөн амьтны нэрийг хэлж, тухайн амьтны нэртэй холбогдсон тоогоор алгаа ташихыг хэлнэ. Морь → 1 удаа алгаа ташна. Тэмээ → 2 удаа алгаа ташна. Хонь → 1 удаа алгаа ташна. Ямаа → 2 удаа алгаа ташна.

Хоёр хүүхдэд тус бүр 4 ширхэг шагай өгч, шагайг ээлжлэн хаяж тоглоно. Хүүхдүүд ямар амьтан буусныг ажиглаж, тохирсон хэмнэлээр алгаа ташна.

Алдсан хүүхэд сүүлд очиж зогсох бөгөөд тоглоомыг үргэлжлүүлэн, хамгийн удаан үлдсэн хүүхдийг ялагч болгон тодруулна.

## **БУЛТААРАЙ**

**Шинэ үг:** бултах, зугтах

### **Үйл ажиллагаа 1.** Яаж бултах вэ? (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** 40-50 см диаметртэй цагариг 1 ширхэг, ундааны саванд уяа уях, 15-20 см-н диаметртэй бөмбөг 2 ширхэг

**Аргачлал:** Багш хүүхдүүдийг тойруулан зогсоож, “бултах” болон “зугтах” үйлдлийн ялгааг тайлбарлан, хэрэглэл ашиглан биечлэн үзүүлнэ. Ундааны саванд уяаг бэхэлж, хөдөлгөөнд оруулна. Хүүхдүүд оногдохгүйгээр бултах, зугтах үйлдлийг хийж тоглоомын аргаар гүйцэтгэнэ.

### **Үйл ажиллагаа 2.** Бүү оногд (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Компьютер, ая, чанга яригч, 40-60 см-н диаметртэй том бөмбөг,

**Аргачлал:** Тоглоомын талбайн нэг захаас нөгөө зах руу 50–60 см диаметртэй бөмбөгийг өнхрүүлнэ. Хүүхдүүд бөмбөгөнд оногдохгүйгээр гүйлтээр нөгөө талд гарах ёстой.

Багш бөмбөгийг эхэндээ удаанаар, дараа нь хурдан өнхрүүлж тоглоомын хэмнэлийг өөрчилнө. Бөмбөгөнд оногдсон хүүхдүүд түр хасагдаж, дараагийн удаад дахин оролцоно.

Хүүхдүүд анхаарлаа төвлөрүүлж, бөмбөгний хурд, чиглэлийг ажиглан найзуудтайгаа хамтран тоглоно.

### **Үйл ажиллагаа 3.** Зугт (Зугаалга)

**Хэрэглэгдэхүүн:** Компьютер, ая, чанга яригч, 40-50 см-н диаметртэй том бөмбөг, цагариг

**Аргачлал:** Тоглоомын талбайд хүүхдүүд том тойрог болж зогсоно. Багш тойргийн голд 40–50 см-ийн диаметртэй цагаригт ойролцоогоор 2 метр урт уяа уяж бэлтгэнэ.

Тоглоом эхлэх дохио өгөхөд багш цагаригийг уяанаас нь чирч нааш, цааш нь хөдөлгөж явна. Хүүхдүүд цагаригт хүрэхгүйгээр бултаж, зугтаж тоглоно. Цагаригт хүрсэн хүүхэд тоглоомоос хасагдана.

### **Сонсьё, дэмжье/ Туслалцаа:**

- Тоглолт, үзүүлбэрийн үеэр хүүхдүүд ямар сэтгэл хөдлөл, үйлдэл харуулж байгааг тэмдэглэн авч явцын үнэлгээгээ баяжуулаарай.

### **Эцэг эхтэйгээ хамтаръя.**

- Уламжлалт баяр ёслолын талаар танилцуулахдаа эцэг эх, асран хамгаалагчийн оролцоог идэвхтэй авч, хамтран ажиллах нь үр дүнтэй байдаг. Жишээ нь: Эцэг эх, асран хамгаалагчийг урьж оролцуулах, морин хуур тоглодог эцэг эх байвал хүүхдүүдэд тоглож үзүүлэх, үндэсний бүжиг бүжиглэдэг эцэг эхийг урьж, хүүхдүүдэд үзүүлэн хамт бүжиглүүлэх гэх мэт.

### **Багшийн эргэцүүлэмж**

**Эргэцүүлэл** /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ./

Амжилттай хэрэгжүүлсэн: .....

Сул хэрэгжүүлсэн:.....

Цаашид сайжруулах:.....

Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа: .....

## УХААЛАГ ХҮҮХЭД

### Хүүхэд эзэмших чадамж

**Суралцахууд суралцах:** Хүүхэд зүй тогтлыг ажиглан үргэлжлүүлэх, дарааллыг даган биелүүлэх, хөдөлгөөн болон дуу хөгжмийн өөрчлөлтөд мэдрэмжтэй хандаж зохицуулах, үйлүүдийг давтан хийх, гадаад орчныг ажиглан мэдээлэл цуглуулах замаар суралцахуйн идэвхтэй байдал, арга барилд суралцах чадамжид хувь нэмэр оруулна.

**Шүүн тунгаах:** Хүүхэд хөдөлгөөн болон тоглоомын явцад өөрийн биеийн хөдөлгөөнийг мэдэрч, орчны аюулгүй байдлыг ажиглан, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй зан үйл, орчны хүчин зүйлийг ялган таньж, тухайн нөхцөлд тохирсон шийдвэр гаргаж сурна.

**Бүтээлчээр сэтгэх:** Хүүхэд өөрийн амьдарч буй орчин тойрноо ажиглаж, асуулт асууж, эрэл хайгуул хийж, шинэ санаа гарган, бүтээлчээр туршиж үзэхдээ мэдлэг эзэмшинэ.

### Аюулгүй байдлын зөвлөмж:

Гадагш гарахаасаа өмнө “Гудамжинд аюулгүй байх дүрэм”-ийг давтан сануулна. Цэцэрлэгийн ойролцоох аюулгүй гудамж, тоглоомын талбайг урьдчилан сонгож, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс хол байлгахаас гадна таних тэмдэгтэй хантааз, малгай, тэмдэг хэрэглэж хүүхдийг багшид танигдахуйц болгоно. Дахин ашиглах зүйлсийг (савангийн сав, тетрапак, хайрцаг гэх мэт) урьдчилан угааж, хатаасан байхад анхаарна. Гудамжны загвар бүтээхдээ хүүхдийн насанд тохирсон, хурц ирмэггүй, хорт бодисгүй материалуудыг бэлтгэнэ. Хүүхдийн тооноос хамаарч бөмбөгийн тоог тохируулах, нэгэн зэрэг олон хүүхэд шидэхгүй байхад анхаарч, хөнгөн, зөөлөн бөмбөг ашиглаж сургалтыг зохион байгуулна.

### Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

#### Тойргийн цаг:

- Багш хүүхдүүдийн анхаарлыг зурагт байгаа үйл явдлын утга, сайн ба буруу үйлдлийг ялгахад чиглүүлж, эерэг зан үйлд уриалан оролцуулаарай.
- Дүрс, өнгөний дарааллыг ажиглуулах замаар хүүхдүүдийн анхаарал, юмсыг ажиглах, зүй тогтол ойлгох чадварыг сайжруулж, алдааг зөвөөр засахад дэмжлэг үзүүлнэ
- Аюулгүй байдлын талаар итгэлтэйгээр ярилцаж, “Боль” гэж хэлж чаддаг байх дадлыг төлөвшүүлэхэд анхаарч ажиллаарай.

#### Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:

- Хүүхдийн оролцоог дэмжиж, хогийг ангилах утгыг ойлгуулахын зэрэгцээ орчны бохирдлоос сэргийлэх дадлыг төлөвшүүлнэ.
- Анхаарлаа төвлөрүүлж, зүй тогтлыг ажиглаж үргэлжлүүлэх чадварыг хөгжүүлэхийн тулд зааврыг тодорхой, дараалалтай өгч, туслалцаа шаардсан хүүхдэд ганцаарчлан дэмжлэг үзүүлж ажиллана.
- Танихгүй хүнээс өөрийгөө хамгаалах тухай зөвлөгөө өгч дэмжлэг үзүүлнэ.

#### Төвийн үйл ажиллагаа:

- Багш хүүхдүүдийг багаар хамтран ажиллахад нь дэмжиж, даалгаврын зорилгыг ойлгуулах, хичээлийн хэрэгслийг зөв сонгон ашиглах, бүтээлээ дэлгэрэнгүй тайлбарлахад дэмжлэг үзүүлж, амжилтыг идэвхжүүлэн урамшуулаарай.

#### Зугаалга:

- Зугаалгын үеэр хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангаж, орчныг урьдчилан бэлтгэх, зугаалгын үед багшийн чиглүүлэгийг сонсох, анхааралтай ажиглах, харьцуулах, нэрлэх зэргээр үйлийг дэмжсэн чиглүүлэх асуултаар идэвхжүүлэн оролцоог хангаж ажиллаарай.

#### Хөгжөөн баясах цаг:

- Хүүхдүүдийн сонгосон дүрд нь нийцүүлэн оролцоог нь дэмжиж, харилцаа, хамтын ажиллагааг өдөөх асуултаар чиглүүлж, дүрийн тоглоомыг сонирхолтой, үргэлжлэх байдлаар удирдан чиглүүлнэ.

### Боломжууд:

Хүүхдийн хариуг буруу гэж шууд засахгүй, харин “Чи яагаад ингэж бодсон бэ?” гэж асууж ойлголтыг тодруулна. Ичсэн хүүхдэд урам өгч, “Чи ингэж хэлж чадсан нь маш

зоригтой байлаа” гэх мэтээр итгэлийг дэмжинэ. Зураг, хөдөлгөөн, хялбар жишээг ашиглан анхаарлыг дахин төвлөрүүлнэ. Буруу хийсэн хүүхдийг зэмлэхийн оронд хамт ажиглаж, “Одоо энэ хогийг хаана хийх вэ?” гэж асуун өөрөөр нь зөв хариуг олуулна. Дасгалыг алхам алхмаар зааж, сайн ойлгоогүй хүүхдэд ганцаарчлан тусална. Танихгүй хүний тоглоом тоглосны дараа заавал тайвшруулах яриа өрнүүлж, “Бид сая дүрд орж жүжиглэн юм, чи маш сайн ойлгосон шүү” гэж айдсыг намдаана. Багаар ажиллах дүрмийг сануулж, “Бид хамтдаа шийдэл олно” гэж хэлж, эв найрамдлыг дэмжинэ. Хэрэглэгдэхүүн хүрэлцэхгүй бол хуваах, ээлжээр хэрэглэх жишээг үзүүлнэ. Зааварчилгааны үед ажиллах дарааллыг самбар дээр эсвэл зурагт тэмдэглэгээ хэлбэрээр харуулж сануулна. Тоглоомын явцад дүрмийг хөнгөнөөр сануулж, дүрд орсон хүүхдийг урамшуулан чиглүүлнэ.

### Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
<p>БНО3.2г. Орчны эд зүйлсийг зориулалтын дагуу ашиглаж, ус хэмнэх, хог хаягдал ялгаж хаях үйлийг бие даан хийнэ.</p> <p>ЗУ3.3в. Тоглоом болон байгалийн материал, дахин ашиглах материалаас сонгож хүрээлэн буй орчноо бүтээнэ.</p> <p>НСХ3.3а. Өөрийнх нь үйлдэл бусдад хэрхэн нөлөөлдгийг ойлгож тайлбарладаг болно.</p> <p>ХЯ3.2г. Үгийг оновчтой сонгож, дэлгэрэнгүй өгүүлбэрээр ярина.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хог ангилан хаях дасгалыг бусдад хамт хийх</li> <li>- Хамтын бүтээл урлах (төсөлт ажил - хот айл)</li> <li>- Хамтын бүтээл хийхдээ хүлээцтэй байх, хамтарч ажиллах, бусдад туслах</li> <li>- Өдөр тутмын хүүхдүүдийн ашигладаг эд зүйл хэрхэн бүтдэг тухай товч видео үзэж ярилцах</li> <li>- Зурсан зураг, хийсэн бүтээл, оролцсон үйл ажиллагааны тухай дэлгэрүүлж ярих, ярилцлагад өөрийн санааг дэлгэрэнгүй өгүүлбэрээр илэрхийлэх</li> </ul>	Миний цэвэрхэн гудамж
<p>МАТ3.3в. Чиглэл байршлын дагуу үйлдэл хийнэ. (өмнө, хойно, дээшээ, доошоо)</p> <p>ХЭМ3.1к. Өргөсөн гараас дээш 10-15 см өндөр зүйлд үсэрч хүрнэ.</p> <p>ХЭМ3.1м. Бөмбөгийг дээш шидээд газарт ойлгон барьж авна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Чиглэлийн дагуу үйлдэл (том бөмбөгийг дээшээ өргөөрэй, доошоо буулгаарай гэж хэлээд чиглэлийг өөрчилж тоглох гэх мэт) хийх</li> <li>- Өргөсөн гараас дээш 10-15 см өндөр зүйлд үсэрч хүрэх</li> <li>- Бөмбөгийг дээш шидээд газарт ойлгож барьж авах хөдөлгөөнийг зааврын дагуу бие даан гүйцэтгэх</li> </ul>	Чиглэлээ ойлгоё
<p>ХЭМ3.2д. Өөрийн болон бусдын биеийн хүрч болохгүй хэсгийг ялгаж, шаардлагатай үед “Үгүй” гэж хэлж өөрийгөө хамгаална.</p> <p>ХЯ3.2а. Харилцан ярианд өөрийн санаачилгаар оролцож санал бодлоо илэрхийлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Өөрийгөө аюулаас хамгаалах аргыг мэдэж, бусдыг өөрийн нууц хэсэгт хүргэхгүй байх, өөрөө бусдын нууц хэсэгт хүрэхгүй байх сургах тоглоом тоглох</li> <li>- “Боль” гэж чанга дуугаар хэлэх, зугтах, итгэлтэй хүмүүст хандах, танихгүй хүний өгсөн зүйлсийг авахгүй байх тоглоом тоглох</li> <li>- Төрөл бүрийн сэдэв, үйл явдлын тухай харилцан ярьж тайлбарлах</li> </ul>	Өөрийгөө хамгаалаарай
<p>МАТ3.1б. Дараалан байрлуулсан тоглоом, дүрсүүдийн зүй тогтлыг ажиглаж үргэлжлүүлнэ.</p> <p>ХЯ3.3в. Энгийн зураасыг дагуулж зурна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Зүй тогтлыг үргэлжлүүлж (өнгө хэлбэр бүхий дүрсний картыг ажиглаад улаан дугуй, шар гурвалжин, хөх дөрвөлжин, улаан дугуй гээд гүйцээх, улаан дугуй, эхний хүүхэд үсрэх, дараагийн хүүхэд алга таших, 3 дахь хүүхэд үсэрч хөдөлгөөнийг давтах гэх мэт) тоглох</li> <li>- Шулуун, тахир, долгион зураасыг мөрөөр нь даган зурж, сонирхсон амьтан, эд зүйлстэй холбох зэрэг дасгал хийх</li> </ul>	Дараалал

<p>ХӨГЗ.1в. Дуу, аялгууны хэмнэлийг ялгаж, дагаж тоглоно.</p> <p>ХӨГЗ.1г. Аялгууны өөрчлөлтийг мэдэрч хөдөлгөөнөөр илэрхийлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хоёр ба гурван хувьт хэмнэлтэй аялгууг сонсож, хэмнэлийг дагаж алга таших, биеийн цохилтоор тоглох</li> <li>- “Хөдөлгөөнөө тааруулъя” хөдөлгөөнт тоглоом тоглох. Жишээ нь: Аялгууны өөрчлөлтөд тохируулан (чанга аялгуунд далайцтай хөдлөх, намуун аялгуунд өлмий дээр алхах, хурдан аялгуунд гүйх, удаан аялгуунд удаан алхах гэх мэт) хөдөлгөөнөө зохицуулах</li> </ul>	<p>Дагаад хийгээрэй</p>
--	--	-------------------------

Албан хэрэгцээнд

### 3 дугаар сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Гудамжинд юу болдог вэ?	Тойргийн цаг	Гудамжны үйл явдал, хүмүүсийн хийж буй үйлдэл (хог түүх, тоглох, машин явах)-ийн тухай зурагт үзүүлэн дээр ярилцана. Сайн ба буруу үйлийн талаар тайлбар өгнө.	Зурагт үзүүлэн.	Гудамжинд ямар хүмүүс байна вэ? Тэд юу хийж байна вэ?; Хэрвээ гудамжинд хогоо хаявал яах вэ?.	Шүүн тунгаах: Үйл явдлын утга, шалтгаан үр дагаврыг ялгах, “сайн үйл”-ийн талаар ойлгох	Өөрийн бодол санаагаа 3–4 үгтэй дэлгэрэнгүй өгүүлбэрээр илэрхийлж ярьдаг.
Гудамжаа судалъя	Зугаалга	Цэцэрлэгийн ойролцоох гудамжинд байх зүйлсийг (байшин, дэлгүүр, замын тэмдэг, хогийн сав) ажиглаж, зургийг нь дарж баримтжуулна.	Малгай, зургийн аппарат.	Гудамжинд юу, юу байсныг нэрлэж ярилцана.	Суралцахуйд суралцах: Орчноо анхааралтай ажиглах, харьцуулах	Гудамжинд байрлах зүйлсийг ажиглаж байршлыг хэлдэг.
Хамтдаа гудамжаа бүтээцгээе	Төвийн үйл ажиллагаа	Багаараа дахин ашиглах материал болон тоглоомыг ашиглан бичил гудамж (хот айл) бүтээж, зохиомжлон тоглоно.	Дахин ашиглах материал	Бүтээлээ дэлгэрэнгүй өгүүлбэрээр тайлбарлаж ярих.	Бүтээлчээр сэтгэх: Байгалийн материал, дахин ашиглах материалаар хүрээлэн буй орчноо зохион бүтээх	Тоглоом, байгалийн материал болон дахин ашиглах материалаар хүрээлэн буй орчноо зохион бүтээдэг. Өөрийнх нь үйлдэл бусад хүмүүст хэрхэн нөлөөлдгийг тайлбарладаг.
Бидний гудамжинд тавтай морил	Хөгжөөн баясах цаг	Ангийг бичил гудамж болгон тохижуулж, хүүхдүүд цэвэрлэгч, жолооч, явган зорчигч зэрэг дүрд орж, дүрүүдийн харилцан хамаарлыг ойлгоно.	Ангийн тоглоом, эд зүйлс	Харилцаа, хамтын ажиллагааг өдөөх асуултаар чиглүүлэх	Шүүн тунгаах: Асуудалд бусдын байр сууринаас хандах	Ярилцлага, туршилт, дүрд тоглох зэрэгт идэвхтэй оролцож, санаа бодлоо хуваалцдаг.
Хогоо ангилцгаая	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд гэрээс авчирсан хаягдлыг (сав, уут) 4 өнгийн уутанд (хар, цэнхэр, ногоон, улаан) зааврын дагуу ангилж хийх. Хогийг дахин боловсруулдаг тухай мэдээлэл өгнө.	4 өнгийн хогийн уут (хар, улаан, цэнхэр, ногоон), хог хаягдал.	Энэ хогийг ямар өнгийн уутанд хаях вэ?	Шүүн тунгаах: Хог хаягдал ялгаж хаях үйлийг бие даан хийх	Хог хаягдлыг ангилан ялгадаг.

Чиглэлээр хөдөлцгөөе	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Бөмбөгийг урд, хойно, дээр, доор, хажууд гэсэн байрлалд байрлуулж, чиглэл байршлыг ойлгоно. (Чиглэлийн дагуу үйлдэл хийнэ).	Бөмбөг.	Бөмбөгийг өөрийнхөө урд/хойно/дээр/доор хажууд байрлуулна уу..	Шүүн тунгаах: Зааврыг тодорхой, дараалалтайгаар дагах	Тоглоом, юмсын өмнө хойно, дээшээ, доошоо хөдөлгөж чиглэл байршлыг хэлдэг.
Өндөрт хүрцгээе	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Өргөсөн гараас дээш 10–15 см өндөр зүйлд үсэрч хүрэхийг тэмүүлэх. Хөлөө түлхэж, гараа савж, үсрэх оролдлого хийх.	Дээш өлгөсөн зүйлс.	<i>Хөлийн түлхэлт, гарын савалт.</i>	Шүүн тунгаах: Хөдөлгөөнөө мэдэрч, бие даан гүйцэтгэх	Бөмбөгийг бие бие рүүгээ газарт ойлгож дамжуулдаг. (1–1.5м зайд)
Чи авах уу?	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Танихгүй хүнээс санал болгосон зүйлийг авахгүй байх тухай ойлголттой болгоно.	(Танихгүй хүний дүр, зураг).	Танихгүй хүнээс чихэр/тоглоом авах уу?.	Шүүн тунгаах: Аюулаас хамгаалах аргыг мэдэх, "Боль" гэж хэлэх дадалтай болох	Танихгүй хүнээс юм авахгүй, дагаж явахгүй байхыг мэддэг.
Хүрч болохгүй хэсэг	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Өөрийн болон бусдын биеийн хүрч болохгүй хэсгийг ялгах. Аюулаас хамгаалах аргыг мэдэх, "Үгүй" гэж хэлж сурах.	(Дүрийн тоглолт).	Хэн нэгэн чамд таалагдахгүйгээр хүрвэл яах вэ? Энэ үед "Боль!" гэж чанга хэлэх ёстой юу?.	Шүүн тунгаах Аюулгүй байдлын талаар итгэлтэйгээр ярилцах	Бусдын биеийн хүрч болох болохгүй хэсгийг ялгадаг.
Дүрсний галт тэрэг	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Өнгө, хэлбэр бүхий дүрсний зүй тогтлыг ажиглаж үргэлжлүүлэх. (Жишээ: улаан дугуй, шар гурвалжин, хөх дөрвөлжин, улаан дугуй гэх мэт).	Өнгийн дүрсний карт, блок.	Энэ дараалал юугаар үргэлжлэх вэ?.	Шүүн тунгаах: Өөрийгөө хамгаалах, шаардлагатай үед "Үгүй" гэж хэлэх ёстойг ойлгох	Бусдын биеийн хүрч болох болохгүй хэсгийг ялгадаг.
Зураасан замаар аялъя	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Шулуун, тахир, долгион зураасыг мөрөөр нь даган зурж, сонирхсон амьтан, эд зүйлстэй холбоно.	Тасархай зураасан зам, харандаа.	<i>Зураасыг хэрхэн зөв холбох.</i>	Бүтээлчээр сэтгэх: Дүрс, өнгөний дарааллыг ажиглах, зүй тогтол ойлгох	Өнгө, хэлбэр, хэмжээгээр зүй тогтлыг үргэлжлүүлдэг.
Аялгуугаар хөдөлөе	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хөгжмийн аялгууны хурдан, удаан хэмнэлд тохируулан хөдөлгөөнөө удирдах. Хэмнэлд тааруулж алга таших, биеийн цохилтоор тоглох.	Хөгжим, аялгуу.	Аялгуу хурдан уу, удаан уу? Хурдан аялгуунд хэрхэн хөдлөх вэ?.	Шүүн тунгаах: Аялгууны өөрчлөлтийг мэдэрч, хөдөлгөөнөө илэрхийлэх	Аялгуу, хэмнэлийн өөрчлөлтийг мэдэрч хөдөлгөөнөө илэрхийлдэг. Хэмнэлийн өөрчлөлтийг дагаж энгийн хөгжмийн зэмсгээр тоглодог.

Хэмнэлээр хөдөлбө	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Цахим холбоос дээрх бичлэгийг үзээд хамтдаа хөдөлгөөнийг дагаж хийнэ.	Бичлэг	(Багш хөдөлгөөнийг хамтдаа дагаж хийнэ)	Шүүн тунгаах: Хэмнэлд тохируулан хөдөлгөөнөө удирдах	Бичлэгийг дагаж хөдөлгөөн хийдэг.
Аялгуунд тохируулъя	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Улаан, шар, цэнхэр өнгө бүрд тохируулан хөдөлгөөнөө өөрчлөхөд суралцана. (өнгөөр хөдөлгөөнөө удирдах).	Өнгөний тэмдэглэгээ.	<i>Өнгө солигдоход хөдөлгөөнөө хэрхэн өөрчлөх.</i>	Шүүн тунгаах: Хөгжмийн өөрчлөлтийг мэдэрч, тохирсон шийдвэр гаргах	Аялгуу, хэмнэлийн өөрчлөлтийг мэдэрч хөдөлгөөнөөр илэрхийлдэг.

Албан хэрэгцээ

### 3 дугаар сарын I долоо хоног

#### МИНИЙ ЦЭВЭРХЭН ГУДАМЖ

**Шинэ үг:** Гудамж, хороолол

**Үйл ажиллагаа 1.** Гудамжинд юу болдог вэ? (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Зурагт үзүүлэн

**Аргачлал:** Миний гудамж сэдэвт зурагт ном эсвэл зурагт үзүүлэн дээр ярилцлага хийнэ. Хүүхдүүд зургийг ажиглаад юу болж байгаа талаар ярилцана.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Гудамжинд ямар хүмүүс бана вэ?
- Тэд юу хийж байна вэ?
- Хэн гудамжаа цэвэрлэж байна вэ?
- Хэрвээ гудамжинд хогоо хаявал яах вэ?

Хүүхдүүд зурагт дүрслэгдсэн үйл явдлыг ойлгож ярина. (жишээ нь: хүүхдүүд тоглож байна, хэн нэгэн хогоо түүж байна вэ?, машин явж байна).

Багш хүмүүсийн хөдөлмөрийн үр дагаврын тухай хэлэлцэж, “сайн үйл”, “зөв үйл”-ийн талаар тайлбар өгнө.

**Үйл ажиллагаа 2.** Гудамжаа судалъя (Зугаалга)

**Хэрэглэгдэхүүн:** Малгай, зургийн аппарат

**Аргачлал:** Хүүхдүүд багштай хамт цэцэрлэгийн ойролцоох гудамжинд байх зүйлсийг судлахаар гарна. Багш гарахдаа хүүхэд бүрд дараах зүйлсийг сайн ажиглах чиглүүлэг өгнө. /байшин, барилга, дэлгүүр, засмал зам, замын тэмдэг, хогийн сав, автобусны буудал гэх мэт/

Зугаалгын үед ажигласан зүйлийнхээ тухай нэрлэж ярилцах ба багш зургийг дарж баримтжуулна. Ангидаа орж ирээд авсан зургуудаа зурагтад харуулна. Цэцэрлэгийн ойролцоо байрлах гудамжинд юу, юу байсныг хамтдаа нэрлэж ярилцана.

**Үйл ажиллагаа 3.** Хамтдаа гудамжаа бүтээцгээе (Төвийн үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Зузаан цаас, өнгийн цаас, цаасан хайрцаг, баримлын шавар, тарган цавуу, картон цаас, чимэглэл

**Аргачлал:** Багш хүүхдүүдийг 5-6 хүнтэй 1 баг болгож хуваана. Баг бүрд зугаалгын үед ажигласан зүйлүүдээ хийх даалгавар өгнө. Бэлтгэж тавьсан хэрэглэгдэхүүнээс сонгож юу хийхээ төлөвлөнө. Хүүхдүүд багаараа хамтран гудамжны загварыг бүтээнэ. Багш баг бүрд жижиг сэдвийг оноож өгч болно. /жишээ: засмал замын хэсэг, дэлгүүр, цэцэрлэг гэх мэт/. Баг бүр өөрийн “Миний гудамж” бүтээлээ танилцуулна. Хүүхдүүдийг дэлгэрэнгүй өгүүлбэрээр тайлбарлаж байгаа эсэхэд хяналт тавьж чиглүүлнэ.

**Үйл ажиллагаа 4.** Бидний гудамжинд тавтай морил (Хөгжөөн баясах цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Ангийн тоглоом, эд зүйлс

**Аргачлал:** Ангийг бичил гудамж болгон тохижуулна. Зам, гудамжны гэрэл, сандал, дэлгүүр, автобус, машин гэх мэт байж болно. Хүүхдүүд өөрийн саналаараа дүр авна /цэвэрлэгч, замын цагдаа, жолооч, худалдагч, явган зорчигч, автобусаар үйлчлүүлж байгаа хүмүүс гэх мэт/. Бүх хүүхдүүд өөрийн авсан дүрдээ орж тоглоно. Багш тоглоомын явцад дүрүүдэд чиглүүлэг өгч тоглоомыг удаан сонирхолтойгоор зохион байгуулж тоглоно. Дүрд орж тоглосон бүх хүмүүсийн үйлдэл хоорондоо хамааралтай болохыг нэмэлт тайлбар өгч ойлгуулна.

**Үйл ажиллагаа 5.** Хогоо ангилцгаая (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Хэрэглэсэн зүйлийн уут, сав, хогийн уут, зурагт үзүүлэн

**Аргачлал:** Багш дараагийн өдөр хүүхэд бүрийг гэртэй хэрэглээд дууссан зүйлийнхээ сав, хайрцаг, уут зэргийг авчрах даалгавар өгсөн байна.

Маргааш нь хүүхдүүд гэрээс авчирсан зүйлүүдээ урт зассан ширээн дээр байрлуулна. Хог хаягдал яагаад үүсч бий болдог тухай, хогийг дахин боловсруулан ашиглаж болдог тухай заавар өгнө. Хар, цэнхэр, ногоон өнгийн гялгар уутыг гаргаж ирээд багш тайлбар өгнө. /хар-хоолны хаягдал, цэнхэр- цаас, ногоон – ундааны лааз, шил гэх мэт/ Хүүхдүүдэд гэрээсээ авч ирсэн хог хаягдлыг 3 өнгийн уутанд ялгаж хийх даалгавар өгнө. Хүүхдүүд хогоо зааврын дагуу ангилж ялгана. Багш ялгасан хог хаягдлаас дахин боловсруулж шинэ бүтээгдэхүүн хийдэг тухай мэдээлэл өгнө.

Хувилбар – 1: Танхимын бус сургалтаар дахин боловсруулах үйлдвэрүүд рүү аялалд гарч болно.

## ЧИГЛЭЛЭЭ ОЙЛГОЁ

**Шинэ үг:** Чиглэл

**Үйл ажиллагаа 1.** Чиглэлээр хөдөлцгөөе (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Бөмбөг

**Аргачлал:** Багш заавар өгнө. “Бөмбөгөө өмнө байрлуул!”, “Бөмбөгөө хойно тавь!”, “Бөмбөгөө дээш өргө!”, “Доош тавь!”, “Бөмбөгөө бариад урагшаа алхаараа!”, “Бөмбөгөө бариад буцаад байр луугаа гүйгээрэй!” гэх мэт. Хүүхдүүд зааврын дагуу үйлдэл гүйцэтгэж тоглоно.

**Үйл ажиллагаа 2.** Өндөрт хүрцгээе (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Саваа мод, өнгийн тууз, агаарын бөмбөлөг

**Аргачлал:** Багш хананд эсвэл модонд өнгийн тууз, бөмбөлгийг хүүхдийн гараас 10–15 см өндөрт тогтооно. “Хэн хамгийн өндөрт үсэрч хүрэх вэ?” гэсэн чиглүүлэг өгч тоглоно. Хүүхэд тус бүр 2–3 удаа оролдоно. Үсрэх үед гар, хөлийн хөдөлгөөнийг зөв зааж чиглүүлэг өгнө. Өндөрт үсэрч хүрсэн хүүхдийг урамшуулна.

**Үйл ажиллагаа 3.** Бөмбөг барьцгаая (Зугаалга)

**Хэрэглэгдэхүүн:** Бөмбөг

**Аргачлал:** Багш бөмбөгийг дээш шидээд газар ойлгож барихыг үзүүлнэ. Хүүхдүүд туршина. Бөмбөгийг гараараа зөөлөн дээш шидээд газар буутал нь хүлээгээд газарт ойгоод буцаад ирэхэд нь барьж авна. Амжилттай хийсэн хүүхдүүдийг урамшуулна. Дараа нь “Бөмбөгний аялал” тоглоом тоглоно. “Бөмбөг дээшээ явлаа!”, “Доошоо буулаа!”, “Одоо барь!” гэх мэт заавар өгч тоглоомыг бүх хүүхэд хамтдаа тоглоно.

## 3 дугаар сарын II долоо хоног

### ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛААРЙ

**Шинэ үг:** Танихгүй

**Үйл ажиллагаа 1.** Чи авах уу? (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Баг, хар өнгийн хувцас, амны хаалт, нүдний шил, даавуун уут, амттан, гар утас

**Аргачлал:** Багш дүрд орох хүнээ сонгож “Танихгүй хүн”-ийг бүтээнэ. Ангид танихгүй хүн орж ирээд хүүхдүүдтэй ярилцана. “- Хүүхдүүдээ миний уутанд зөндөө амттан байгаа авах уу?”, “Миний гар утсан дээр гоё тоглоомууд байгаа хэн надтай хамт явж тоглох вэ?” гэх мэтээр хүүхдүүдийг уруу татсан үйлдэл үзүүлнэ. Уруу татагдсан хүүхдийг өргөөд ангиас гараад гүйнэ. Энэ үед багш танихгүй хүнд итгэж болохгүй, хамт дагаж явахгүй байх дүрмийг танилцуулна. Танихгүй хүн дахин орж ирээд уруу татаж авч явах гэнэ. Энэ үед хүүхдүүд үйлдлийг ойлгосон эсэхийг багш хянана. Танихгүй хүнээс эд зүй, амттан авч болохгүйг сануулж аргадах ба нэмэлт тайлбар өгнө.

**Үйл ажиллагаа 2.** Хүрч болохгүй хэсэг (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Зурагт үзүүлэн

**Аргачлал:** Биед хүрч болох, хүрч болохгүй хэсгийг зурагт үзүүлэн дээр зааж ярилцана. Дараах тохиолдолд “БОЛЬ” гэсэн үгийг хэрэглэж, аюулаас зайлсхийх талаар тайлбарлана.

- Хэн нэгэн чиний биеийн хүрч болохгүй хэсэгт хүрэх
- Чиний өмнө хэн нэгэн найзын чинь биеийн хүрч болохгүй хэсэгт хүрэх
- Зөвшөөрөлгүйгээр чиний хувцсыг тайлах, зураг авах, бичлэг хийх
- Хэн нэгний хувцасгүй зураг, видеог чамд үзүүлэх үед чангаар хэлэх ёстойг тайлбарлана.

“Би хэлнэ” дууг дагаж дуулж хөдөлгөөнийг хийнэ./цахим холбоос 1./

**Үйл ажиллагаа 3.** Сэтгэлгээний газрын зураг (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Тараах материал

**Аргачлал:** “Сэтгэлгээний газрын зураг” ашиглан биеийн хүрч болох, хүрч болохгүй хэсгийг ангилна. Биеийн хэсгүүдийг харуулсан тараах материал байна. Тэдгээр тараах материалыг 2 хэсэгт ангилна. Жишээ нь: Гарт хүрч болно, харин уруулд зөвшөөрөлгүй хүрч болохгүй гэх мэт. Чи бол өөрийн биеийн эзэн тул гэр бүлийн гишүүдээс бусад гадна сайн танил хүн /хамаатан садан, аав ээж ах, эгч, эмээ өвөөгийн найзууд/, танихгүй хүн чиний биед хүрэх эрхгүй гэдгийг тайлбарлана.

### ДАРААЛАЛ

**Шинэ үг:** Зүй тогтол

**Үйл ажиллагаа 1.** Өнгийг гүйцээе (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Төрөл бүрийн дүрс

**Аргачлал:** Өнгө өнгийн дүрсүүдийг дараалуулан байрлуулж хүүхдүүдээр ажиглуулна. Хүүхдүүд өнгийн дүрсүүдийг дарааллаар нь нэрлэнэ. Дарааллын төгсгөлд ямар дүрс байгааг үргэлжлүүлэн байрлуулж тоглоно.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Энд ямар өнгийн дүрс байна вэ? нэг нэгээр нь нэрлээрэй.
- Дараа нь ямар өнгөтэй, ямар дүрс байх вэ?
- Өнгийн дүрсүүдийг ажиглаад гүйцээгээрэй.

**Үйл ажиллагаа 2:** Зураасан замаар аялъя (Төвийн үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Тараах материал, балын харандаа

**Аргачлал:** Хүүхдүүдэд тараах материал дээрх дасгал ажлыг тайлбарлаж өгнө. Зүй тогтлыг ажиглаад эхний зургаас дараагийн зураг руу холбохдоо тасархай зураасыг дагуулан гүйцээж зурна. Том, жижиг, том ..... ямар амьтан руу холбож зураасыг үргэлжлүүлэх хэрэгтэйг багш тайлбарлана. Хүүхэд бүртэй ганцаарчлан ажиллах ба зүй тогтлыг өөрчлөн хийлгэнэ. Хийж дууссаны дараа өөрийн холбосон “Зураасан замын аялал”-ыг тайлбарлана.

**Үйл ажиллагаа 3.** Дүрсний галт тэрэг (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Том дүрснүүд, тараах материал, өрж байгуулах тоглоомууд

**Аргачлал:** Хүүхдүүд 3 баг болж саналаараа хуваагдана.

1-р баг – Газарт байрлуулсан том өнгийн дүрснүүдээс сонгож авахдаа багшийн хэлсэн зүй тогтлын дарааллыг анхаарч дүрсний гал тэргийг бүтээнэ. Хүүхэд “- Багшийн 1:1 гэсэн дараалалтай байхаар галт тэрэг бүтээгээрэй” багшийн зааварт тохирч дарааллыг бүтээнэ.

2-р баг – Урлалын төвөөс өнгийн харандаа, тосон харандаа, эсгий бал зэргийн аль нэгээс сонгож тараах материал дээр ажиллана. Галт тэрэгний чиргүүлийг багшийн хэлсэн зүй тогтлын дагуу будаж үргэлжлүүлнэ.

3-р баг – Тоглоомын төвөөс өнгийн блокуудыг сонгож авна. Хүүхдүүд багшийн өгсөн зааврын дагуу өнгийн блокуудыг зүй тогтлын дагуу байрлуулж тоглоно.

Бүх багууд даалгавраа гүйцээж дуусаад хийсэн ажлаа тайлбарлана.

## ДАГААД ХИЙГЭЭРЭЙ

**Шинэ үг:** Хэмнэл

**Үйл ажиллагаа 1.** Аялгуугаар хөдөлбө (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Хөгжим, ая, бөмбөр, шигшүүр

**Аргачлал:** Багш хөгжим сонсож ярилцана. Хүүхдүүд хөгжмийн аяыг сонсоод хөдөлгөөнөөр илэрхийлнэ (удаан бол алхах, хурдан бол гүйх гэх мэт)

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Энэ хөгжим хурдан сонсогдож байна уу, удаан сонсогдож байна уу?
- Ямар хөдөлгөөн хийхэд тохирох вэ?
- Ямар аялгуу хамгийн хөгжилтэй байсан бэ?
- Хөгжим хурдан болохоор яаж хөдөлж байсан бэ?

Багш бөмбөр эсвэл шигшүүр ашиглан өөр хэмнэлүүд тоглоно. Хүүхдүүд хэмнэлийг алхаа, үсрэлт, алга ташилтаар дагана. Дараа нь хүүхдүүд ээлжлэн багшийн оронд тоглож, найзууддаа хэмнэлийг таалгаж тоглуулна.

**Үйл ажиллагаа 2:** Хэмнэлээр хөдөлбө (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Бичлэг

**Аргачлал:** Бичлэгийг үзээд хамтдаа хөдөлгөөнийг дагаж хийнэ. /цахим холбоос 2./

**Үйл ажиллагаа 3.** Аялгуунд тохируулъя (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Өнгийн тууз (улаан, шар, цэнхэр гэх мэт), хөгжмийн гурван өөр аялгуу

**Аргачлал:** Улаан тууз өргөхөд хурдан аялгуу явах ба үсрэх, шар тууз өргөхөд зөөлөн аялгуу буюу гараа даллах, удаан алхах, цэнхэр тууз өргөхөд нам аялгуу буюу доош суух, найгах хөдөлгөөн хийнэ. Хөгжим солигдоход хүүхдүүд өөр өнгийн тууз барьж хөдөлгөөнөө өөрчилж тоглоно. Багш хөдөлгөөнийг ялгахгүй байгаа хүүхдэд дэмжлэг үзүүлнэ.

**Сонсьё, дэмжье/ Туслалцаа:**

- Ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд (хэл ярианы хоцрогдол, анхаарал төвлөрөл сул, хөгжлийн бэрхшээлтэй гэх мэт) ухаалаг төхөөрөмжийг таних, хэрэглээг ялгах, үйлдлийн дараалал ойлгоход нь дарааллыг харуулсан тоглоом, зураг болон дохио хослуулах, хэт их ачаалал өгөхгүй байх зэрэг дэмжлэг үзүүлнэ.
- Тоо, хэмжээ, дүрс, биет, байршил зэрэг ойлголтыг тоглоом, мэдрэхүй, хөдөлгөөнтэй хослуулан аажим, сонирхолтой байдлаар, үйлдлийг давтан хийх, бодитоор харьцуулах, үргэлж урам өгч, ахиц гарвал магтах зэргээр суралцахад дэмжлэг үзүүлнэ.
- Дуу авиа, хөдөлгөөн хослуулсан хэрэглэгдэхүүн, зураг, өнгө, дүрслэлээр дэмжсэн карт, аюулгүй материалаар хийгдсэн хэрэглэгдэхүүн зэргийг ашиглан дэмжлэг үзүүлнэ.

**Эцэг эхтэйгээ хамтаръя.**

- Хүүхдийнхээ сонирхол, суралцах арга барил, амьдралын хэв маягт гарч буй өөрчлөлтийг ажиглаж багштай мэдээллээ солилцоорой.
- Хүүхэдтэйгээ музей, номын сан, амьтны хүрээлэн, цэцэрлэгт хүрээлэн зэрэг бодит орчинд хамтдаа аялж нийгмийн орчныг танилцуулж, тухайн нөхцөлд өөрийгөө авч явахад нь сургаарай.
- Тоглоомоор давтамж үүсгэж өрөх, зүй тогтлын талаарх ойлголт мэдээлэл өгөөрэй.

Цахим холбоос:

1. <https://www.youtube.com/shorts/-RNJPpqjLCU>
2. <https://www.youtube.com/watch?v=kTWaOJWS99M>

**Багшийн эргэцүүлэмж**

**Эргэцүүлэл** /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ./  
Амжилттай хэрэгжүүлсэн: .....  
Сул хэрэгжүүлсэн:.....  
Цаашид сайжруулах:.....  
Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа: .....

## СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ – IV САР

### СОНИРХОЛТОЙ ЗАГВАР

#### **Хүүхдэд эзэмшүүлэх чадамж:**

**Бүтээлчээр сэтгэх:** Хүүхэд ажигласан, туршсан зүйлсээ харьцуулж, аль арга нь илүү зохимжтой вэ гэдгийг тунгаан, өөрийн бүтээлийг зохиох зэргээр бүтээлч байдалд суралцана.

**Харилцах:** Хүүхэд улирал байгаль, цаг агаарын үзэгдлийг ажиглах явцдаа асуулт асуух, ажиглах, ойлголтоо бататгах, санаагаа тайлбарлах замаар өөрийн мэдрэмж, санал бодлоо үг болон үйлдлээр илэрхийлж харилцаанд суралцана.

**Суралцахуйд суралцах:** Хүүхэд хүрээлэн буй орчныг таньж ялгах, байгаль, цаг агаарын үзэгдлийг ажиглах, холбоо хамаарлыг ойлгох, асуудлыг тодруулж, эрэл хайгуул хийх, туршиж үзэх мэдлэгээ өрөө бүтээх зэргээр бие даан суралцана.

#### **Аюулгүй байдлын зөвлөмж:**

Цахим үзүүлэн ашиглахдаа цахилгааны аюулгүй байдлыг шалгах, утастай төхөөрөмжийг хүүхдээс хол байрлуулах, туршилт, үрсэлгээ хийх үед ус, хөрс, үр зэргийг урьдчилан бэлтгэх, хүүхдэд зориулсан жижиг хүрз, хуванцар сав ашиглах, багаж хэрэгслийг хэрэглэсний дараа цэвэрлэж, аюулгүй байрлуулах, зугаалгаар явахын өмнө аялалд явахад тохиромжтой гутал, хувцастай эсэхийг шалгах, зугаалгын үед халтиргаа, гулгаатай газар, усны ойролцоо насанд хүрэгчдийн хяналттай явахыг зөвлөх зэргээр аюулгүй байдлыг хангаж ажиллана.

#### **Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:**

##### *Тойргийн цаг:*

- Тойргийн цагаар ярилцлага хийхдээ тодорхой зорилготой, хүүхдийн амьдралтай холбоотой зүйлсийн тухай ярилцах, харьцуулсан асуултаар өмнөх мэдлэгийг сэргээн сануулах, эргэцүүлэх боломж олгох, ярианы дарааллыг удирдахдаа “- Чи эхлээд ярь, дараагийн хүүхэд санаагаа нэмээрэй” гэх мэтээр хамтын яриаг дэмжин чиглүүлнэ. Багаар хэлэлцэх үед “сонсох, хүлээх” зэргээр удирдаарай.

##### *Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:*

- Үйл ажиллагааны өмнө зорилгыг тайлбарлах, зааврыг алхам алхмаар өгөх, бие даан туршиж үзэх, мэдлэг олж авах боломж олгоно
- Хүүхдийн асуултад хариулах, туршилт, бүтээл хийсний дараа үр дүнгээ хамтдаа дүгнэж, “Юу өөрчлөгдсөн бэ?”, “Яагаад ийм болсон гэж бодож байна?” гэх мэт бодох асуулт тавьж чиглүүлнэ.
- Бусад хүүхдүүдтэй хамтран тоглох, ярилцах, даалгавар биелүүлэхдээ хүлээцтэй хандаж эелдэг, найрсаг харилцахад чиглүүлээрэй.

##### *Төвийн үйл ажиллагаа:*

- Тухайн төвийг сонгоход нь чиглүүлэг өгч, хэрэглэгдэхүүнээ сонгож өгсөн зааврыг биелүүлэхэд нь дэмжих, бүтээлийнхээ санааг өөрөө олж чөлөөтэй сэтгэх боломж олгох, бие биеийнхээ бүтээлээр бахархах тухай ойлгуулах, үйл ажиллагааны дараа хийсэн, бүтээсэн зүйлээ ярилцах цаг заавал гаргаарай.

##### *Зугаалга:*

- Зугаалгын өмнө аюулгүй байдлын дүрмийг хэлэлцэх, зугаалгаар явахдаа хувцсаа тохируулж өмсөх, дүрмийг баримтлан явах, ажиглаж баримтжуулах зүйлээ сонгож зураг авах, байгальд хог тарихгүй модны мөчрийг хугалахгүй гэмтээхгүй байх, сонирхсон зүйлээ асууж тодруулах, зугаалгын дараа ажигласан зүйлээ зурагтай холбон бүтэн өгүүлбэрээр ярихад нь дэмжин туслаарай.
- Үрсэлгээ хийхэд хүүхдийг бие даан оролцуулах, ургамлын ургалтыг ажиглах, тэмдэглэхэд чиглүүлээрэй.

##### *Өөртөө үйлчлэх хөдөлмөр:*

- Зугаалгаар явахдаа хувцсаа өөрөө бие даан өмсөх, улирлын онцлог, цаг агаарын өөрчлөлтэй уялдуулан хувцсаа тохируулан өмсдөг тухай заавар өгнө.

**Хөгжөөн баясах цаг:**

- Хөгжим, хөдөлгөөн хоёр уялаатайг ойлгуулах, хүүхэд тэнцвэрээ хадгалахгүй унасан эсвэл алдаа гаргасан бол “- Чи дараагийн удаа сайн хийж чадна гэх мэт” урамшуулах байдлаар дэмжих, дууны үг, аялгуунд тохируулж хөгжимт хөдөлгөөн хийхийг ойлгуулж, бие даан хийж сурахад чиглүүлнэ.

**Боломжууд:**

Үүлний хэлбэрийг төсөөлж дүрслэх шинэ санаа хэлэх, гадаа цаг агаар өөрчлөгдөх (салхи гарах, үүл хөвөх, бороо дусах) бодит ажиглалт хийх, “Үүл хөдөлж байна уу? хаашаа явж байна?” гэх мэтээр сонирхлыг өдөөх асуулт асуух, хүүхэд өмнөх аяллын түүхээ хуваалцах үед анхааралтай сонсож сэдвээс хазайхгүй байхад анхаарах, тарьсан үрслэгээний ургалтыг ажиглах үед “-Минийх хурдан ургасан, найзынх ургаагүй” гэх мэтээр харьцуулж болох тул яагаад ялгаатай байгааг ярилцаж шалтгааныг тодруулж туршилт хийж болно.

**Үйл ажиллагааны төлөвлөлт:**

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
БНО3.1г. Цаг агаарын байдлыг зураг, тэмдэг ашиглан илэрхийлж, тохирсон хувцас болон хийх үйл ажиллагаагаа сонгож тайлбарлана. ЗУ3.2а. Өөрийн бодол төсөөллөөр зохиомжлон зурна.	<ul style="list-style-type: none"> <li>- Өдөр тутмын цаг агаарыг ажиглах, цаг агаарын тухай зурган карт, самбар дээр тэмдэглэгээ хийх (цэлмэг, бороотой, цастай, салхитай, нартай гэх мэт)</li> <li>- Зурах сэдвийн хүрээнд ажиглаж ярилцах</li> </ul>	Үүлсийн гайхамшиг
ХЯ3.2в. Юмсын шинж чанар, онцлог илэрхийлсэн үгийг яриандаа ашиглана. МАТ3.1б. Дараалан байрлуулсан тоглоом, дүрсүүдийн зүй тогтлыг ажиглаж үргэлжлүүлнэ.	<ul style="list-style-type: none"> <li>- Өдөр тутмын үйл ажиллагааны явцад янз бүрийн эд зүйлийг тэмтрэх, барих, амтлах, ажиглах зэргээр юмсын шинж чанарыг тодорхойлсон үгсийг хэрэглэх, давтан хэлж тогтоох, ялгаж нэрлэх шинж чанараар нь харьцуулан ярьж тоглох туршилтын явцаа тайлбарлан хэлэх зэрэг үйлд оролцох</li> <li>- Зүй тогтлыг үргэлжлүүлж тоглох</li> </ul>	Хаврын улирал ирлээ.
ХЭМ3.1а. Гарын сарвуу, хөлийн тавхайн хэсгээр хийх хөдөлгөөнийг зэрэг болон ээлжлэн гүйцэтгэнэ. НСХ3.3в. Үйл ажиллагаанд тодорхой үүрэг хүлээж оролцдог болно. ХӨГ3.1г. Аялгууны өөрчлөлтийг мэдэрч хөдөлгөөнөөр илэрхийлнэ.	<ul style="list-style-type: none"> <li>- Гарын сарвууг атгаж тэнийлгэх, чангалж суллах дасгал хийх, бөмбөг, зөөлөн тоглоом ашиглан базах, савлах зэрэг хөдөлгөөнийг ойлгож гүйцэтгэх</li> <li>- Өдрийн дэглэмийн үйл ажиллагааны үед “бид чадна, хамтдаа хийцгээе гэх мэт бие биеэ дэмжсэн уриа үгийг багаараа зохиож хэлэн эвтэй оролцох</li> <li>- Аялгууны өөрчлөлтөд тохируулан хөдөлгөөнөө зохицуулах</li> </ul>	Хаврын салхиар наацагсаа
БНО3.1г. Цаг агаарын байдлыг зураг, тэмдэг ашиглан илэрхийлж, тохирсон хувцас болон хийх үйл ажиллагаагаа сонгож тайлбарлана. ХЯ3.2г. Үгийг оновчтой сонгож, дэлгэрэнгүй өгүүлбэрээр ярина. ЗУ3.3в. Бүтээлээ толбо, дардсаар чимэглэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>- Жилийн дөрвөн улирлын цаг агаарын онцлог, хүмүүсийн хувцаслалт, амьтан ургамлын өөрчлөлтийг танин мэдэх</li> <li>- Зурсан зураг, хийсэн бүтээл, оролцсон үйл ажиллагааны тухай дэлгэрүүлж ярих</li> <li>- Бүтээлээ цэг, зураас, дүрсээр хүрээлж чимэглэх</li> </ul>	Хаврын аялал

<p>БНОЗ.16. Тасалгааны ургамлын гол хэсгүүд (үндэс, иш, навч, цэцэг)-ийг нэрлэж, арчлах, ургуулах үйлд оролцоно.</p> <p>ХЯЗ.2д. Үйл явдлын эхлэл, өрнөл, төгсгөлийг дарааллын дагуу ярина.</p> <p>ЗУЗ.3б. Нугалах, эвхэх, хайчлах аргаар хавтгай болон биет наамлын бүтээл урлана.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Туршлагын талбай, байгалийн буланд мод, ургамал тарих, цэцэг шилжүүлэн суулгах, үрслүүлэх, арчлах, ургуулах үйлд оролцох, тэмдэглэл хөтлөх</li> <li>- Үйл явдлын дарааллыг үзүүлсэн цуврал зураг, үзүүлэн, зурагт карт зэргийг зөв дараалалд оруулж хэсэг хэсгээр болон нийтээр нь тайлбарлан ярих, өөрөө бяцхан ном бүтээж дарааллын дагуу ярих</li> <li>- Дүрсээр зохиомжлон наах</li> </ul>	<p>Үрсэлгээ хийж сурцгаая</p>
<p>ХӨГЗ.1в. Дуу, аялгууны хэмнэлийг ялгаж, дагаж тоглоно.</p> <p>ХӨГЗ.1г. Аялгууны өөрчлөлтийг мэдэрч хөдөлгөөнөөр илэрхийлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Зураглалын дагуу хөгжмийн энгийн зэмсгээр, нийтээр хамтарч тоглох</li> <li>- Хүн амьтныг илэрхийлсэн хөгжимт хөдөлгөөнийг зохиомжлон хийх, тайлбарлах</li> </ul>	<p>Би цэцэг боллоо</p>

#### 4 дүгээр сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Цаг агаарын мэдээний бяцхан хөтлөгч	Тойргийн цаг	Хүүхдүүд өдөр бүрийн цаг агаарын өөрчлөлтийг ажиглан харьцуулж, өнөөдөр, өчигдөр, өөр өдрийн цаг агаарыг нэрлэнэ.	Цаг агаарын хуанли	Өнөөдөр гадаа ямар байна вэ?, Өчигдөр гадаа ямар байсан бэ?, Өнөөдрөөс өөр байна уу?"	Харилцах: Санаагаа үгээр илэрхийлэх Суралцахуйд суралцах: Ажиглалт хийх	Ажигласан цаг агаарын байдлыг зураг, тэмдэг ашиглаж тэмдэглэл хийдэг.
Үүлний илбэ	Зугаалга	Хүүхдүүд үүлсийг ажиглан ижил, ялгаатай хэлбэрийг таньж, үүлний өнгө, дүрсийг тайлбарлан уран сэтгэмжээр илэрхийлнэ. Хоёр, хоёроор нь баг болгож, зураг дээрх үүлстэй адилхан үүл олох даалгавар өгнө.	Зурган карт (голдоо дөрвөлжин нүхтэй, эргэн тойрон үүлний зурагтай).	Та нар өмнө нь үүл ажиглаж байсан уу?; Ямар үүлс харагдаж байна вэ?; Үүлний хэлбэр, өнгө, ялгааг тайлбарлана уу?.	Харилцах: Харьцуулан тайлбарлах Суралцахуйд суралцах: Холбоо хамаарлыг ойлгох	Юмсын байрлал, шинж чанараар нь харьцуулахдаа үгээ оновчтой зөв сонгож ярьдаг.
Бидний үүлэн урлан	Төвийн үйл ажиллагаа	Ажигласан үүлнийхээ дүр төрхийг бүтээлчээр илэрхийлж, хөвөнгөөр наан дүрслэх. Хүүхэд өөрийн бүтээлийн санааг чөлөөтэй олно.	Хөвөн, цавуу, зурах хэрэгслүүд	Чиний үүл ямар хэлбэртэй байна вэ?, Юутай адилхан харагдаж байна вэ?"	Бүтээлчээр сэтгэх: Уран сэтгэмжээр илэрхийлэх, өөрийн бүтээлийг зохиох	Хүн, амьтны дүр, эд юмсын хэлбэрийг зөв илэрхийлдэг.
Үүлсийн ид шид туршилт	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Үүл хэрхэн үүсдэг тухай туршилтыг ажиглан, усны халуун, хүйтний ялгаанаас үүл үүсэх явцыг ойлгоход чиглүүлнэ.	Ус, сав, будагч бодис	Ямар өөрчлөлт гарч байна вэ? Яагаад ийм болсон гэж бодож байна вэ?.	Суралцахуйд суралцах: Туршиж үзэх, мэдлэгээ өөрөө бүтээх Бүтээлчээр сэтгэх: Харьцуулж тунгаан бодох	Хүртэж мэдэрсэн зүйлээ дүрслэхдээ үгээ оновчтой зөв сонгож ярьдаг.
Хаврын тэнгэр ямар байна вэ?	Тойргийн цаг	Хаврын тэнгэрийн өөрчлөлтийг (нарлаг, үүлтэй, бороотой, салхитай) зурагт үзүүлэн ашиглан ажиглаж, тохирох үгээр илэрхийлэх.	Зурагт үзүүлэн.	Өнөөдөр тэнгэр ямар байна вэ? (Цэлмэг, бүрхэг); "Дулаахан", "сэрүүхэн", "зөөлөн", "цэлмэг" гэх үгсийн аль нь чиний зурагт тохирох вэ?.	Харилцах: Бүтэн өгүүлбэрээр харилцан ярилцах	Юмсын байрлал, шинж чанараар нь харьцуулахдаа үгээ оновчтой зөв сонгож ярьдаг.

Хаврын зан аашийг өнгөөр илэрхийлье	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хаврын байгаль, цаг агаарын онцлогийг өнгө, дүрслэлээр илэрхийлж, өөрийн сэтгэгдэл, мэдрэмжийг зургаар илэрхийлнэ.	Зурах/будгах хэрэгслүүд	Хаврын улиралд ямар мэдрэмж төрж байна вэ?, Хаврын ямар өдрийг хамгийн ихээр хүсдэг вэ? Яагаад?, Чиний зурсан байгаль ямар байна вэ?	Бүтээлчээр сэтгэх: Сэтгэгдлээ дүрслэн зурах Харилцах: Бүтээлээ тайлбарлах, санал бодлоо илэрхийлэх	Хүн, амьтны дүр, эд юмсын хэлбэрийг зөв илэрхийлэн зурдаг.
Хаврын өнгө	Төвийн үйл ажиллагаа	1-р баг: Завсрын өнгө (цайвар ногоон, ягаан гэх мэт) үүсгэх туршилт хийж, хэрхэн үүсэж буйг судална. 2-р баг: Хавар сэдэвт хамтын бүтээл хийж, дүрсэлнэ. Багууд туршилт болон бүтээлээ тайлбарлаж танилцуулна.	Бичлэг, гуаш, бийр, өнгийн цаас, балын харандаа, хайч, цавуу.	Хаврын улиралд ямар өнгөнүүд их ажиглагдсан бэ?; Хаврын улирлын өнгийг аж үүсгэх вэ?.	Бүтээлчээр сэтгэх: Завсрын өнгө үүсгэх, хамтын бүтээл хийх Суралцахуйд суралцах: Туршилт хийх, мэдээлэл олж авах	Өнгө үүсгэх туршилт хийдэг. Хамтын бүтээл хийхэд оролцдог.
Хаврын салхи	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Салхины чиглэлд тохируулан урагш, ухарч, хажуу тийш алхах, нэг хөлөө өргөн үсрэх гэх мэт янз бүрийн хөдөлгөөнийг дуурайж хийнэ.	Малгай.	Салхи урдаас үлээвэл яаж алхах вэ?; Салхи хүчтэй үлээвэл хэрхэн биеэ хөдөлгөөнгүй барих вэ?.	Суралцахуйд суралцах: Ажиглалтад тулгуурлан хөдөлгөөнөө зохицуулах	Гарын сарвуу, хөлийн тавхайн хэсгээр хийх хөдөлгөөнийг зэрэг болон ээлжлэн гүйцэтгэдэг.
Хаврын салхинд найгахгүй шүү	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Салхины хөдөлгөөнийг биеэрээ илэрхийлж, тэнцвэрээ хадгалах.	Хөдөлгөөнт тоглоом	Салхи хүчтэй болох үед чи яаж биеэ барьж, тэнцвэрээ хадгалах вэ?.	Суралцахуйд суралцах: Хөдөлгөөнөө бие даан удирдах	Тэнцвэрээ хадгалан зогсдог.
Аяллаа төлөвлөө	Тойргийн цаг	Хаврын улирлын байгаль, цаг агаар, ургамал, амьтанд гарах өөрчлөлтийг ажиглахаар зугаалгаар гарах тухай танилцуулж, хэн ямар зүйлийг ажиглахыг ангилна. Зургийг нь авч ирэх даалгавар өгнө.	Цаг агаарын зураг, амьтадын зураг, ургамлын зураг, самбар, маркер.	Хаврын улиралд ямар өөрчлөлт ажиглагддаг вэ?, Хэн юу ажиглах вэ? Сонгоорой"	Харилцах: Хамтын яриаг дэмжих, сонсох Суралцахуйд суралцах: Эрэл хайгуул хийх	Өдөр тутмын тоглоом үйл ажиллагаанд тодорхой үүрэг, хариуцлага хүлээж оролцдог.
Зугаатай аялал	Зугаалга	Хүүхдүүд өөрийн сонгосон зүйлээ ажиглаж, багшаас тодруулах асуулт асууна. Багш зураг авах үед	Зургийн аппарат	Гадаа цаг агаар ямар байна вэ? Тэнгэрийн байдлыг ажиглаарай; Газарт өвс, ургамал ургасан	Харилцах: Сонирхсон зүйлээ асууж тодруулах, дэлгэрэнгүй мэдээлэл авах	Харилцан ярианы явцад харилцагчаасаа дэлгэрэнгүй мэдээлэл авч,

		аппаратыг хөдөлгөөнгүй барих зааварчилгаа өгнө.		байна уу? Ямар шувуу дуугарч байна вэ?.		сонирхсон зүйлээ тодруулдаг. Олон нийтийн газар баримтлах дүрмийг биелүүлдэг.
Бидний аяллын ном	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүдийн дарсан зургийг хэвлэж, АЗ хэмжээтэй том ном бүтээх. Зургуудыг цаг агаар, амьтан, ургамал гэсэн хэсгүүдэд ангилж наан, чимэглэнэ. Номоо хамтдаа үзэж ярилцана.	Хэвлэсэн зураг, том ном (АЗ цаас), цавуу, эсгий бал, наадаг стикер.	Бид юу юуг ажигласан бэ?; Номоос хамгийн их таалагдаж байгаа хэсэг аль байсан бэ?.	Бүтээлчээр сэтгэх: Ном бүтээх, чимэглэх, бүтээлийн санаагаа өөрөө олох Харилцах: Зургийг тайлбарлан ярих, дэлгэрэнгүй өгүүлбэрээр ярих	Бүтээлээ толбо, дардсаар чимэглэдэг. Сонирхсон номоо сонгон үзэж, номын зургийг тайлбарлан ярьдаг.
Ургамал хэрхэн ургадаг вэ?	Тойргийн цаг	Ургамал ургаж буй бичлэг үзүүлж ярилцана.	Бичлэг (цахим холбоос 5).	Шар буурцгийг тарихад юу юу хэрэгтэй болсон бэ?; Хэдэн хоногийн дараа үр соёолсон бэ?; Шар буурцаг ургахад юу нөлөөлсөн бэ?.	Суралцахуйд суралцах: Мэдлэгээ өөрөө бүтээх, туршиж үзэх	Харилцан ярианы явцад харилцагчаасаа дэлгэрэнгүй мэдээлэл авч, сонирхсон зүйлээ тодруулдаг.
Үрсэлгээ хийе	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Шар буурцгийн үрсэлгээг зааврын дагуу хийж, арчилж ургуулахад дэмжинэ.	Үр, хөрс, сав	Үрсэлгээ хийхдээ эхлээд юу бэлтгэсэн бэ?, Ямар дарааллаар үрээ суулгасан бэ?	Суралцахуйд суралцах: Зааврыг алхам алхмаар дагах, дарааллыг ойлгох Харилцах: Дарааллыг тайлбарлах	Ургамлыг арчлах, ургуулах үйлд оролцдог.
Ургалтын тэмдэглэцгээе	Төвийн үйл ажиллагаа	Үрслэгээний өсөлтийг тэмдэглэх зүйлийг өөрийн гараар хийх, тарьсан шар буурцаг өдөр өдрөөр хэрхэн өсөж байгааг ажиглах, тэмдэглэнэ. Ургамлыг хайрлах, арчилгаанд сургана.	Тэмдэглэл хөтлөх хэрэгслүүд	Чиний тарьсан үр өнөөдөр хэдэн см өндөр болсон байна вэ?, 7 хоногийн дараа хэдэн см өндөр болсон байна вэ?	Суралцахуйд суралцах: Тэмдэглэл хөтлөх Бүтээлчээр сэтгэх: Хэмжигч хийх	Нугалах, хайчлах аргаар бие даан бүтээл хийдэг. Ургамлын өндрийг хэмждэг.
Бяцхан цэцэг	Хөгжөөн баясах цаг	"Бяцхан цэцэг" дууны үг аянд тохируулан хөгжимт хөдөлгөөн хийж сургана.	Хөгжим/дууны ая.	(Багш үйлдлийг хамтдаа давтахыг чиглүүлнэ)	Суралцахуйд суралцах: Даган дуурайх, бие даан хийж сурах	Аялгуу, хэмнэлийн өөрчлөлтийг мэдэрч

						хөдөлгөөнөөр илэрхийлдэг.
Зураглалаар тоглоё	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	"Бяцхан цэцэг" дууны хэмнэлийн зураглалыг дагаж хөгжмийн энгийн зэмсгээр хамтдаа тоглоход дэмжлэг үзүүлнэ.	Хэмнэлийн зураглал, хөгжмийн энгийн зэмсэг.	(Хөгжмийн зэмсгийг сонгуулж, хэмнэлийн зураглалыг дагаж тоглох аргачлалыг заах)	Суралцахууд суралцах: Хэмнэлийг дагах, бие даан суралцах	Дуу, аялгууны хэмнэлийг ялгаж, дагаж тоглодог.

Албан хэрэгцээнд

#### 4 дүгээр сарын I долоо хоног:

##### ЦАГ АГААР ӨӨРЧЛӨГДДӨГ ҮҮ?

**Шинэ үг:** Цаг агаарын байдал

**Үйл ажиллагаа 1.** Цаг агаарын мэдээний бяцхан хөтлөгч (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Цахим үзүүлэн /цахим холбоос 1./, цаг агаарын мэдээний хүрээ

**Аргачлал:** Тухайн өдрийн цаг агаарын талаар ярилцана.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Өнөөдөр гадаа ямар байна вэ?
- Өчигдөр гадаа ямар байсан бэ?
- Өнөөдрөөс өөр байна уу?

Хүүхдүүд цаг агаарын мэдээний хүрээний ард орж өнөөдрийн цаг агаарыг танилцуулж тоглоно. /өнөөдөр гадаа нартай дулаахан өдөр байна гэх мэт/

**Үйл ажиллагаа 2.** Үүлний илбэ (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Зурган карт (голдоо дөрвөлжин нүхтэй эргэн тойрон үүлний зурагтай)

**Аргачлал:** Хүүхдүүдийг хоёр, хоёроор нь баг болгож зураг дээрх үүлстэй адилхан, ижил төрлийн үүл олох даалгавар өгч дараах асуултын дагуу ярилцана.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Цонхоор харцгаая. Та нар өмнө нь үүл ажиглаж байсан уу?
- Тэнгэрийг хараарай, ямар үүлс харагдаж байна вэ?
- Бүх үүлс адилхан харагдаж байна уу?
- Ижил үүл олж чадсан уу?
- Үүлний хэлбэр, өнгө, ялгааг тайлбарлана уу?
- Ажигласан үүлс ямар нэгэн зүйлтэй адилхан харагдаж байна уу?

**Үйл ажиллагаа 3.** Бидний үүлэн урлан (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Цэнхэр өнгийн цаас, хөвөн, цавуу

**Аргачлал:** Цэнхэр өнгийн цаас тарааж, тэнгэрт гарсан үүлний хэлбэрийг бодож, хөвөнгөөр наах даалгавар өгнө. Үүлийг янз бүрийн хэлбэртэй нааж болохыг сануулна. Хүүхдүүд өөрсдийн наасан үүлээ нэрлэж, юутай адил төстэй байгааг тайлбарлана.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Чиний үүл ямар хэлбэртэй байна вэ?
- Юутай адилхан харагдаж байна вэ?

**Үйл ажиллагаа 4.** Үүлсийн ид шид туршилт (Төвийн үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Үүл үүсгэх туршилтын бичлэг, халуун бүлээн ус, мөс, мөсний хавчаар, шилэн аяга, хөвөн, цавуу, нэг удаагийн аяга, гялгар слайд, скоч, гар чийдэн эсвэл гар утасны гэрэл

**Аргачлал:** Хүүхдүүдийг хоёр, хоёроор нь баг болгож үүл үүсгэх туршилтыг дараах бичлэгийн дагуу хийнэ. /цахим холбоос 3, 4/

1. Шилэн аяганд халуун бүлээн ус хийнэ. (өөрчлөлтийг ярилцана)
2. Шилэн аяганд угаалгын шингэн хийнэ. (өөрчлөлтийг ярилцана)
3. Шилэн аяганд мөс хийнэ. (өөрчлөлтийг ярилцана)
4. Үүссэн хөөс, уурыг гараараа барьж мэдэрнэ. (өөрчлөлтийг ярилцана)

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Ямар өөрчлөлт гарч байна вэ?
- Юу өөрчлөгдсөн бэ?

##### ХАВРЫН УЛИРАЛ ИРЛЭЭ

**Шинэ үг:** Завсрын өнгө, байгалийн шинж

**Үйл ажиллагаа 1.** Хаврын тэнгэр ямар байна вэ? (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Зурагт үзүүлэн

**Аргачлал:** Хүүхдэд 4 төрлийн зураг үзүүлж бүтэн өгүүлбэрээр харилцан ярилцана. (нарлаг өдөр, үүлтэй өдөр, бороотой өдөр, салхитай өдөр)

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Өнөөдөр тэнгэр ямар байна вэ?(Өнөөдөр тэнгэр цэлмэг, бүрхэг байна.)
- Нар гарсан үед ямар байдаг вэ?(Салхи тогтуун, дулаан болсон байна.)
- Салхи үлээвэл ямар мэдрэмж төрдөг вэ?"(Салхи үлээхэд сэрүүхэн болдог.)

**Үйл ажиллагаа 2.** Хаврын зан аашийг өнгөөр илэрхийлье (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Өнгийн харандаа, балын харандаа, гуаш, бийр, эсгий бал, өнгийн цаас, хайч, цавуу

**Аргачлал:** Хүүхэд өөрт хамгийн их таалагдсан хаврын байгалийг дүрсэлнэ. Хийсэн бүтээлээ асуултын дагуу тайлбарлана.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Хаврын ямар өдрийг хамгийн ихээр хүсдэг вэ? Яагаад?
- Хаврын байгальд юу хамгийн сайхан санагддаг вэ?
- Хаврын салхи чамд ямар мэдрэмж төрүүлдэг вэ?
- Чиний зурсан байгаль ямар байна вэ?
- “Дулаахан”, “сэрүүхэн”, “зөөлөн”, “цэлмэг” гэх үгсийн аль нь чиний зурагт тохирох вэ?
- Хэрвээ чи хаврын тухай дуу зохиовол ямар үгс орно гэж бодож байна вэ?

**Үйл ажиллагаа 3.** Хаврын өнгө (Төвийн үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Бичлэг, гуаш, бийр, өнгийн цаас, балын харандаа, эсгий бал, хайч, цавуу

**Аргачлал:** Бичлэг үзээд асуултын дагуу ярилцана. /цахим холбоос 4./

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Хаврын улиралд ямар өнгөнүүд их ажиглагдсан бэ? Нэрлээрэй
- Хаврын улирлын өнгийг аж үүсгэх вэ?

Багш хүүхдүүдийг сонирхлынх нь дагуу 2 багт хуваана.

1-р баг Завсрын өнгө үүсгэх туршилт хийнэ. Багш хүүхдүүдийн нэрлэсэн завсрын өнгөнүүд хэрхэн үүсдэг тухай мэдээлэл өгнө./цайвар ногоон, ягаан, бүдэг цэнхэр гэх мэт/

2-р баг Хавар сэдэвт хамтын бүтээл хийнэ. Хүүхдүүд бичлэгээс өөрт таалагдсан зүйлсийг сонгож хамтдаа хаврын байгалийг зурж, наах, будах гэх мэтээр дүрсэлнэ.

Багууд даалгавраа гүйцэтгэж дууссаны дараа туршилт болон бүтээлээ тайлбарлаж танилцуулна.

## ХАВРЫН САЛХИАР НААДАЦГААЯ

**Шинэ үг:** Улирал

**Үйл ажиллагаа 1.** Хаврын салхи (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Малгай

**Аргачлал:** Салхины чиглэлд тохируулан урагш алхах, ухарч алхах, хажуу тийш алхах, хагас суулттай алхах, хоёр хөл дээр арагш, нэг хөл дээр урагш үсрэх гэх мэт янз бүрийн хөдөлгөөнийг дуурайн хийнэ.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Салхи урдаас үлээвэл яаж алхах вэ?
- Салхи араас үлээвэл яаж алхах?
- Салхи хүчтэй үлээвэл хэрхэн биеэ хөдөлгөөнгүй барих вэ?
- Салхи намуун болбол яаж алхах вэ? хөдөлгөөнийг дүрслэн үзүүлж тоглоно.

**Үйл ажиллагаа 2.** Хаврын улирал ирлээ (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Таглаатай усны сав

**Аргачлал:** Хүүхдүүд хоёр багт хуваагдан, нэг шугамд өөд өөдөөсөө харж зогсоно. Багш хүүхдүүдэд “-Хаврын улирал ирж байна. Бид байгальд шинэ амьдрал авчирдаг борооны дуслууд болох гэж байна” гэж хэлнэ. Эхний хүүхдэд “борооны дусал” буюу таглаатай усны савыг өгнө. Эхний хүүхэд савны тагийг нээж буцаж таглаад, дараагийн хүүхдэд болгоомжтой дамжуулна. Ингэж бүх хүүхдэд дамжуулан хурдан, алдаагүй гүйцэтгэсэн баг шалгарна.

**Багшийн чиглүүлэх яриа:**

- Борооны дусал хаашаа урсаж байна вэ? Борооны дусал газар хүрэхэд юу болдог вэ?
- Хэрвээ чи борооны дусал байсан бол хаашаа очихыг хүсэх байсан бэ?

- Хамгийн анхны бороо орсны дараа байгаль яаж өөрчлөгддөг вэ?

**Үйл ажиллагаа 3.** Хаврын салхинд найгахгүй шүү (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Зурагт картууд (хүн нэг хөл дээр зогсож байгаа, гараа тэнийлгэсэн, суулт хийсэн, өвдгөөрөө нугарсан байрлал гэх мэт), хөгжмийн аялгуу (зөөлөн хаврын салхи, шувуудын жиргээ гэх мэт дуу авиа)

**Аргачлал:** Хүүхдүүд талбайд хоорондоо зайтай зогсоно. Хүүхдэд нэг нэгээр нь зурагт карт харуулж зурагтай адил зогсох даалгавар өгнө. Хүүхдүүд тухайн байрлалаар зогсож, тэнцвэрээ хадгална. Багш “Хаврын салхи үлээлээ...” гэж хэлэхэд, зөөлөн хөгжим тавин, хүүхдүүд салхинд ганхаж байгаа мэт бага зэрэг хөдөлнө. Найгаж хөдлөхдөө тэнцвэрээ хадгална. Хэрэв хүүхэд унавал хасагдана. Дараа дахин тоглохдоо тэнцвэр хадгалж яадна гэж урамшуулна. Хамгийн удаан, хөдөлгөөнгүй тэнцвэрээ хадгалсан хүүхдүүдийг хөгжилтэй нэр өгч урамшуулна.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Салхи үлээхэд мод, навч, шувууд яаж хөдөлдөг вэ?
- Салхи хүчтэй болох үед чи яаж биеэ барьж, тэнцвэрээ хадгалах вэ?
- Тэнцвэрээ хадгалахад биедээ яаж анхаарал тавих вэ?

#### 4 дүгээр сарын II долоо хоног

### ХАВРЫН АЯЛАЛ

**Шинэ үг:** Нахиа,

**Үйл ажиллагаа 1.** Аяллаа төлөвлөө (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Цаг агаарын зураг, амьтадын зураг, ургамлын зураг, самбар, маркер

**Аргачлал:** Хаврын улирлын байгаль, цаг агаар, Ургамал, амьтдад гарах өөрчлөлтийг ажиглахаар зугаалгаар гарах тухай хүүхдүүдэд танилцуулна. Аяллын үеэр ажигласан зүйлийнхээ зургийг авч ирэх даалгавар өгнө. Самбарт аяллын зураглал гаргана. Хэн ямар зүйлийг ажиглах тухай нэрсийг тэмдэглэж хүүхдүүдийг ангилна.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Хаврын улиралд цаг, агаар, амьтан, ургамалд ямар өөрчлөлт ажиглагддаг вэ?
- Хэн юу ажиглах вэ? Сонгоорой
- Аялалд гарахдаа ямар хувцас өмсөх вэ?

**Үйл ажиллагаа 2.** Зугаатай аялал (Зугаалга)

**Хэрэглэгдэхүүн:** Аялалд гарахад тохиромжтой хувцас, зургийн аппарат, гар утас

**Аргачлал:** Багш хүүхдүүдийг аяллын төлөвлөөг сануулж хэн ямар зүйлийг ажиглаж зураг авах тухай тайлбар өгнө. Хүүхдүүд өөрсдийн сонгосон зүйлийг ажиглаж зургаар баримтжуулна. Багшаас асуух асуулт байвал асууж тодруулна. /яагаад зарим газар өвс ургаагүй байна вэ?, үүл яагаад бүрхэг болсон бэ? гэх мэт/ Багш хүүхдүүдийн асуусан асуултад хариулт өгч мэдлэгийг бататгана. Зураг авахад хүндрэл үүссэн хүүхдэд багш тусална.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Гадаа цаг агаар ямар байна вэ? Тэнгэрийн байдлыг ажиглаарай.
- Газарт өвс, ургамал ургасан байна уу?
- Ямар шувуу дуугарч байна вэ?
- Шавжууд гарсан байна уу? ажиглаарай

**Үйл ажиллагаа 2.** Бидний аяллын ном (Төвийн үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Хэвлэсэн зураг, том ном, цавуу, эсгий бал, тодруулагч, наадаг стикер

**Аргачлал:** Багш хүүхдүүдийн дарсан зургийг хэвлэж бэлтгээд ширээн дээр байрлуулна. Багш самбарт АЗ хэмжээтэй цаасаар ном бэлтгэж байрлуулна. Номын нүүрний хэсэгт “Бидний аяллын ном” гэсэн сэдвийг наана. Хоосон хуудсыг зургаар дүүргэж аяллын ном бүтээх тухай танилцуулна. Хүүхдүүд өөрийн дарсан зургуудаа авч цаг агаар, амьтан, ургамал, аяллын үеэр бид гэсэн хэсгүүдтэй хуудаст ангилж нааж өнгө өнгөөр хүрээлж номын хуудсаа хамтдаа чимэглэнэ. Том номоо хийж дууссаны дараа хамтдаа номоо үзэж ярилцана.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Бид ямар газар луу аялаар явсан бэ?
- Бид юу юуг ажигласан бэ?
- Номоос хамгийн их таалагдаж байгаа хэсэг аль байсан бэ?

Албан хэрэгцээнд

## ҮРСЭЛГЭЭ ХИЙЖ СУРЦГААЯ

**Шинэ үг:** Үрсэлгээ, соёолох, нахиалах

**Үйл ажиллагаа 1.** Ургамал хэрхэн ургадаг вэ? (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Бичлэг

**Аргачлал:** Ургамал ургаж буй бичлэг үзүүлж ярилцана. /цахим холоос 5./

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Шар буурцгийг тарихад юу юу хэрэгтэй болсон бэ?
- Хэдэн хоногийн дараа үр соёолсон бэ?
- Шар буурцаг ургахад юу нөлөөлсөн бэ?

**Үйл ажиллагаа 2.** Үрсэлгээ хийе (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Шар буурцгийн үр, хөрс, үрслэгээний сав, цэцэг улагч, хонуулж тоссон ус, жижиг хүрз, хөрс сийрүүлэгч, цэцгийн сав

**Аргачлал:** Багш үрслэгээний савыг хүүхэд бүрд хүрэлцээтэй байдлаар бэлтгэж таних тэмдэгжүүлсэн байна. Хүүхдүүд саванд хөрсөө хийнэ. Усалж чийгшүүлнэ. Хөрсөнд шар буурцгийн үрээ хурууны нэгдүгээр үений хэмжээтэй гүнд хийж хөрсөөр булна. Цэцэг улагчаар усална. Багш хүүхэд нэг бүрийг үрсэлгээ хийхэд оролцуулна. Дараа нь хийсэн зүйлийн тухай ярилцана.

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Үрсэлгээ хийхдээ эхлээд юу бэлтгэсэн бэ?
- Ямар дарааллаар үрээ суулгасан бэ?

**Үйл ажиллагаа 3.** Ургалтыг тэмдэглэцгээе (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Цаас, шугам, эсгий бал, хайч, цавуу, скоч

**Аргачлал:** Өөрийн тарьсан шар буурцгийн ургалтыг тэмдэглэх өндрийг хэмжигчийг хийнэ. Ямар ч загвараар хийж болох ба шугам дээрх см -ийг заавал зурж хийнэ. Өөрийн хийсэн өндөр хэмжигч дээр таних тэмдгээ нааж үрслэгээнийхээ хажууд байрлуулна. Шар буурцгийн үр соёолж эхэлсэн өдрөөс эхлэн ургалтыг тэмдэглэх ажлыг хөрсөнд шилжүүлэн суулгах хүртэл хийлгэж болно. /цахим холбоос 6. санаа авч болно./

**Багшийн чиглүүлэх асуулт:**

- Чиний тарьсан үр өнөөдөр хэдэн см өндөр болсон байна вэ? Харандаагаар тэмдэглэж будаарай
- 7 хоногийн дараа хэдэн см өндөр болсон байна вэ? тэмдэглээрэй

## БИ ЦЭЦЭГ БОЛЛОО

**Шинэ үг:**

**Үйл ажиллагаа 1.** Бяцхан цэцэг (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Бичлэг

**Аргачлал:** Багш “Бяцхан цэцэг” дууны хөдөлгөөнийг хүүхдүүдэд зааж өгнө./цахим холбоос 7./ Багш үйлдлийг 2-3 удаа давтаж хийлгэнэ.

**Үйл ажиллагаа 2.** Зураглалаар тоглоё (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Хэмнэлийн зураглалын үзүүлэн, хос дуут мод, бөмбөр, бариултай хонх, шигшрэг, туузан дээр бэхэлсэн хонх

**Аргачлал:** Багш “Бяцхан цэцэг” дууны хэмнэлийн зураглалыг томоор хэвлэн гаргаж хүүхдүүдэд хэрхэн тоглох аргачлалыг зааж үзүүлнэ. /цахим холбоос 8./

Хүүхдүүдээр энгийн хөгжмийн зэмсгийг сонгуулж хэмнэлийн зураглалыг дагаж тоглуулна.

**Сонсьё, дэмжье/ Туслалцаа:**

- Хүүхэд бүрт үйл ажиллагааг ойлгоход нь зориулсан тодорхой, энгийн заавар, дэмжлэг үзүүлэх (зураг, дүрс, жишээ, гар дохио гэх мэт).
- Бүх хүүхдэд оролцох боломж, ээлжийг жигд олгох, багийн тоглоом, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.
- Хэрэгцээтэй хүүхдэд шаардлагатай үед зааварчилгаа, нэмэлт туслалцаа, энгийн үйлдлээр оролцох боломж олгох, гэхдээ бусад хүүхдийн оролцоог хязгаарлахгүй байх.

**Эцэг эхтэйгээ хамтаръя.**

Эцэг эхэд үйл ажиллагааны зорилго, агуулгыг танилцуулж, гэртээ хүүхэдтэйгээ ажиглах, ярилцах, бүтээлч дасгал хийх боломжийг зааж өгөх.

- Хүүхдийн оролцоо, бүтээл, мэдлэгийг дэмжихийн тулд эцэг эхэд төлөвлөсөн дасгал, тоглоом, ажиглалтын арга болон хэрэглэх материалын жагсаалтыг өгч, хүүхэдтэйгээ хамт хийж туршихыг урамшуулах.
- Эцэг эхийг хүүхдийн амжилт, оролцоог үнэлж, эерэгээр урамшуулах талаар зөвлөнө.

#### Цахим холбоос:

1. <https://www.youtube.com/watch?v=sn6GLgaTY0M>
2. <https://www.pinterest.com/pin/68743120034/>
3. <https://www.pinterest.com/pin/68740754788/>
4. <https://www.youtube.com/watch?v=5H8wmJBIsPY>
5. <https://www.youtube.com/watch?v=Nkj2EWvPZO5>
6. <https://www.pinterest.com/pin/14566398793586941/>
7. [https://www.youtube.com/watch?v=mqfPEjDLt-U&list=RDmqfPEjDLt-U&start\\_radio=1](https://www.youtube.com/watch?v=mqfPEjDLt-U&list=RDmqfPEjDLt-U&start_radio=1)
8. <https://www.youtube.com/watch?v=MFQ8nswmntg>

#### Багшийн эргэцүүлэмж

<p><b>Эргэцүүлэл</b> /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ./</p> <p>Амжилттай хэрэгжүүлсэн: .....</p> <p>Сул хэрэгжүүлсэн:.....</p> <p>Цаашид сайжруулах:.....</p> <p>Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа: .....</p>
--

### СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - V САР

#### БИД ЧАДНА

##### Хүүхдэд эзэмшүүлэх чадамж

**Бүтээлчээр сэтгэх:** Хүүхэд тоглох, сонирхох, турших явцад асуудлыг өөрийнхөөрөө бодож шийдвэрлэх, гар чийдэн ашиглан нуугдсан зургийг илрүүлэх, баримлын шавар, элс, гурилан зуурмагаар хүн, амьтан, эд юмсыг зохиомжлон барих зэргээр бодит зүйлс болон төсөөллөөрөө илэрхийлэх, шинэ санааг өөрөө олж, идэвхтэй оролцох чадварыг эзэмшинэ.

**Хамтран ажиллах:** Хүүхэд бусдын санаа бодлыг хүндэтгэн сонсож, харилцан ойлголцож санал солилцох, багийн орчинд идэвхтэй оролцогч, хамтрагч байх нийгмийн харилцааны чадварт суралцахын зэрэгцээ хамтын шийдвэр гаргах, мөлхөх болон буухиа тоглоомын үед багаа дэмжих, мөн ангийнхаа бусад хүүхэдтэй сэтгэл хөдлөл, сонирхлоороо ижил төстэйгөө мэдэн хуваалцах чадварыг хөгжүүлнэ.

**Суралцахуйд суралцах:** Хүүхэд зурган зааварчилгааг ажиглан дарааллын дагуу үйлдэл хийн гүйцэтгэх, ухаалаг төхөөрөмж ашиглахын өмнө болон дараа нүдний дасгал хийж хэвших, мөн дүрс болон биетийн ялгааг туршилт хийж ажиглах, урт-богино авиа орсон үгийг сонсоод ялгах зэргээр дүрэм, зааврыг дагах чадварыг эзэмшинэ

##### Аюулгүй байдлын зөвлөмж:

Ухаалаг төхөөрөмжийг зохистой хэрэглэх дүрмийг мөрдөж, зөв зохистой хэрэглэхэд онцгой анхаарах, мөн хөдөлгөөнт тоглоом болон бусад үйл ажиллагааны үед хүүхдүүдийг дүрэм, зааврыг дагаж сурахад чиглүүлэн, тэдний нас, биеийн онцлогт тохирсон хэрэглэгдэхүүнийг бэлтгэж, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй орчныг бүрдүүлэх нь чухал юм.

##### Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

###### Өглөөний хүлээн авалт:

- Хамгийн түрүүнд ирсэн хүүхдүүдэд тоглоом тоглуулахдаа, дараа нь ирэх хүүхдүүдэд тухайн тоглоомыг хэрхэн тоглохыг зааж, удирдан чиглүүлэх боломж олгоорой.

###### Өглөөний дасгалын цаг

- Нүдний дасгалыг хийлгэхдээ дэлгэц эсвэл зурагт үзүүлэн ашиглан хөдөлгөөнийг үзүүлж, хүүхдүүдтэй хамтран хийж, тэдний анхаарлыг төвлөрүүлж чиглүүлээрэй.

###### Тойргийн цаг:

- Урт богино эгшигтэй зургийг зэрэгцүүлэн барьж, нэрлүүлж давтаж хэлүүлэн, зургийг эргүүлсний дараа "Адилхан сонсогдож байна уу?", "Яагаад өөр гэж бодож байна вэ?" гэсэн асуултуудыг тавьж, хүүхдүүдийн сонсож ялгах чадварыг дэмжээрэй.

- Ярилцлага хийхийн өмнө хүүхдүүдийн анхаарлыг төвлөрүүлэх болон бодол санаагаа чөлөөтэй илэрхийлэх боломжийг олгоно.

**Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:**

- Үйл ажиллагаа эхлэхээс өмнө гар чийдэн болон зураг нуугдсан тараах материалыг урьдчилан бэлтгэж, хүүхдүүдэд шилэн савнаас сонголт хийх боломж олгохоос гадна туршилтын үед нуугдсан дүрсийг асуулт асуух замаар хүүхдүүдээр өөрсдөөр нь ажиглуулж, тодорхойлуулна.
- Хөдөлгөөнт тоглоомын үеэр хүүхдүүд дүрэм, зааврыг дагуу ээлжлэн тоглох дамжуулж, багаа дэмжиж тоглоход чиглүүлнэ.
- Баримлаар бүтээсэн дүрснүүдээс сонгон амьтан эсвэл хүний дүрс бүтээж, биеийн хэсгүүдийг гүйцээн барьж, бүтээлээ харьцуулан ярилцахад чиглүүлнэ.
- Дууны үгийг зөв, тод хэлж дуулахад нь дэмжлэг үзүүлж, давтан хэлүүлээрэй.

**Төвийн үйл ажиллагаа:**

- Бүлгийн хүүхэд бүр өөр, өөр үйл ажиллагаанд оролцож байсан ч бүгдийг нэгэн нэгдсэн ойлголтод хүргэхүйц тоглоом, үйл ажиллагааг олон хувилбараар төлөвлөн хэрэгжүүлээрэй.

**Хөгжөөн баясах цаг:**

- Хүүхэд бүрд хөгжих, баясах боломжийг бүрдүүлж, сэтгэл ханамжтай оролцох орчинг бий болгоорой.

**Оройн таралт:**

- Ангид үлдсэн хүүхэд бүрд өөр, өөр зурагт үзүүлэн өгч будуулах ба дэмжлэг шаардлагатай хүүхэдтэй ганцаарчилсан байдлаар ажиллан, түүний чадварыг хөгжүүлэхэд анхаараарай.

**Боломжууд:**

Ухаалаг төхөөрөмжийн зохистой хэрэглээг мөрдөх дүрмийг зааж баримтлахад нь чиглүүлэг өгнө.

Ухаалаг төхөөрөмжийг хэрэглээ нь эрүүл мэндэд сөрөг нөлөөтэйг тайлбарлаж, зохистой хэрэглээг мөрдөх нь өөрийгөө хамгаалан энгийн үйлдэл гэдгийг ойлгуулах, дүрмийг зааж чиглүүлэг өгч дэмжин туслаарай.

**Үйл ажиллагааны төлөвлөлт:**

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
ХЭМЗ.2з. Ухаалаг төхөөрөмжийн хэрэглээний эерэг, сөрөг нөлөөг мэдэж, өөрийгөө хамгаалах үйлдэл хийнэ. ХЯЗ.3в. Энгийн зураасыг дуурайж бичнэ. МАТЗ.4а. Ухаалаг төхөөрөмжийг таньж, хэрэглээ зориулалтаар нь ялгаж нэрлэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>- Ухаалаг төхөөрөмжийг удаан хугацаагаар үзэх нь эрүүл мэндэд сөрөг нөлөөтэйг тайлбарлах</li> <li>- Амьтан, эд зүйлсийн зургийг гүйцээн зурах</li> <li>- Ухаалаг төхөөрөмжийг ажиглан нэрлэх</li> </ul>	Нуугдсан зургийг олоорой
ХЭМЗ.1е. Мөлхөлтийн төрлүүдийг (бөгсөөрөө гулсах, өвдөг тохойны тусламжтай мөлхөх) хэрэглэл ашиглан гүйцэтгэнэ. МАТЗ.3в. Чиглэл, байршлын дагуу үйлдэл хийнэ. (өмнө, хойно, дээшээ, доошоо)	<ul style="list-style-type: none"> <li>- Өвдөг, тохойны тусламжтай нуман доогуур мөлхөх</li> <li>- Чиглэлийн дагуу үйлдэл хийх</li> </ul>	Хэн сайн мөлхөх вэ?
МАТЗ.3б. Дугуй, гурвалжин, дөрвөлжин дүрсүүдийг нэрлэж, дүрс, биетийг ялгана. ХЯЗ.2г. Үгийг оновчтой сонгож, дэлгэрэнгүй өгүүлбэрээр ярина.	<ul style="list-style-type: none"> <li>- Дүрс болон биетийг харьцуулж тоглох</li> <li>- Бодит үйл явдлыг бүтэн өгүүлбэрээр хүүрнэн ярих</li> </ul>	Дүрс бүр ялгаатай

<p>ЗУЗ.3а. Баримлын шавар, элс, гурилан зуурмагаар хүн, амьтан, эд юмсыг зохиомжлон барина.</p> <p>МАТ3.3б. Дугуй, гурвалжин, дөрвөлжин дүрсүүдийг нэрлэж, дүрс, биетийг ялгана.</p> <p>НСХ3.3б. Бусадтай сэтгэл хөдлөл, сонирхлоороо ижил төстэйгөө мэддэг болно.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Баримлын шавраар эд юмс зохиомжлон барих</li> <li>- Дүрс болон биетийг харьцуулж тоглох</li> <li>- Бие биеэсээ асуулт асууж, өөрсдийн тухай мэдээллээ хуваалцах, хэн хэнтэй ижил төстэй байгаа талаар ярилцах</li> </ul>	<p>Чиний дуртай дүрс аль нь вэ?</p>
<p>ХЯЗ.1б. Урт, богино авиа орсон үгийг сонсоод ялгаж хэлнэ.</p> <p>ЗУЗ.2а. Өөрийн бодол төсөөллөөр зохиомжлон зурна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Урт, богино авиагаар эхэлсэн, төгссөн үгийг сонсоод ялгаж хэлж, хоёр авианы ялгааг тоо болон зураас, дүрс, үйлдлээр илэрхийлсэн тоглоомыг ойлгож тоглох</li> <li>- Зураас (шулуун, муруй, тахир, долгион), дүрсээр зохиомжлон гэр, байшин, гудамж, хүрээлэн буй орчноо өөрийн төсөөллөөр дүрслэн зурах</li> </ul>	<p>Сонсоод ялгаарай</p>
<p>БНОЗ.2г. Орчны эд зүйлсийг зориулалтын дагуу ашиглаж, ус хэмнэх, хог хаягдал ялгаж хаях үйлийг бие даан хийнэ.</p> <p>МАТ3.4б. Зурган зааварчилгааг ажиглан, дарааллын дагуу дуурайж хийнэ.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Ангид мөрдөх тэмдэг, тэмдэглэгээний утгыг ярилцах</li> <li>- Зурган зааварчилгааг ажиглаж, үйлдлийг даган хийх</li> </ul>	<p>Олоорой</p>

## 5 дугаар сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Нүдний дасгал	Өглөөний дасгалын цаг	Ухаалаг төхөөрөмж үзэхийн өмнө болон дараа нүдний дасгал хийнэ.	Дэлгэц, зурагт үзүүлэн	Нүдээ аних үед ямар санагдсан бэ?", "Нүдээ нээхэд ямар мэдрэмж төрж байна вэ?	Суралцахууд суралцах: Анхаарлаа төвлөрүүлэх, дадал хэвшилд сурах	Ухаалаг төхөөрөмжийг тохирсон зайнаас үздэг. Нүдний дасгал хийдэг.
Юу байна вэ?	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Шилэн саванд нуугдсан зурагтай цаасыг гар чийдэн тусгаж, нуугдсан зургийг илрүүлж тодорхойлно.	Шилэн сав, зураг нуугдсан тараах материал, гар чийдэн	Энэ цаасны хаа нэгтээ ямар нэг зураг нуугдсан байх боломжтой юу?, Хэрвээ нуугдсан байгаа бол яаж харж болох вэ?	Бүтээлчээр сэтгэх: Асуудлыг өөрийнхөөрөө бодож шийдвэрлэх	Өөрийн бодол санаагаа 3–4 үгтэй дэлгэрэнгүй өгүүлбэрээр илэрхийлж ярьдаг.
Цэгүүдийг холбоорой	Оройн таралт	Тасархай зураасаар дүрсэлсэн зургийг гүйцээн зурж, өөрийн төсөөллөөр чимэглэнэ.	Эсгий бал, тасархай зураасаар дүрсэлсэн зурагтай тараах материал	Ямар зүйл дутагдаж байна вэ?, Хэрвээ энэ зургийг гүйцээвэл юу болох бол?	Бүтээлчээр сэтгэх: Төсөөллөө илэрхийлэх	Энгийн дүрс, зураас дуурайж зурж бичдэг.
Саадыг сүлжээрэй	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	2 багт хуваагдан, саадын дээгүүр 4 хөллөж мөлхөх, буцахдаа саадыг сүлжиж мөлхөнө.	5 ширхэг саад	Хүүхдүүдийг багт хувааж, мөлхөлтийн хоёр төрлийг ялган гүйцэтгэхэд чиглүүлэх. Дүрэм, зааврыг дагахад анхаарах	Хамтран ажиллах: Багийн орчинд хамтран оролцох Суралцахууд суралцах: Дүрэм, зааврыг дагах	Хэрэглэл, мөлхөлтийн төрлүүдийг тохируулж мөлхдөг.
Нуман доогуур мөлхөөрэй	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Нуман доогуур өвдөг тохойгоор мөлхөн гарч, бөмбөгийг скочинд тогтоох буухиа тоглоом	Өргөн скоч, 5-10 см бөмбөгнүүд, нум.	(Багийн хүүхдийн гарыг цохиж ээлжийг дамжуулж багаа дэмжиж тоглоход чиглүүлэг)	Хамтран ажиллах: Багаа дэмжих, ээлж солилцох	Хэрэглэл, мөлхөлтийн төрлүүдийг тохируулж мөлхдөг.
Цагаригийг зөөгөөрэй	Оройн таралт	Цагариг дотор өвдгөөрөө сууж, нэг гараараа жижиг цагаригийг конусууд руу ээлжлэн хийнэ.	Цагариг, бай болох зүйл, конус, жижиг хэмжээтэй конус.	(Цагариг дотор өвдгөөрөө сууж, нэг гараараа зөөх үйлийг хийх)	Суралцахууд суралцах: Зааврыг дагах	Тоглоом, юмсын өмнө хойно, дээшээ, доошоо хөдөлгөж чиглэл байршлыг хэлдэг.

Ялгааг олъё	Төвийн үйл ажиллагаа	Хавтгай дүрс (2D) болон биет дүрс (3D)-ийн ялгааг (өнхрүүлэх, шидэх, давхарлах) туршилт, бичлэг ашиглан 4 багт хуваагдан судална.	Дугуй, дөрвөлжин дүрс, бөмбөг, хайрцаг, дэлгэц, бичлэг, ундааны бөглөө.	Дүрс болон биетийг өнхрүүлж, шидэж, давхарлаж туршилт хийх.	Хамтран ажиллах: Багийн шийдвэр гаргах Суралцахууд суралцах: Туршилт хийх, ялгааг ажиглах	Дүрс, биетийг ялгаж нэрлэдэг.
Давхарлан зурья	Төвийн үйл ажиллагаа	Төрөл бүрийн хэмжээтэй дүрсийн ирмэгээр өнгийн харандаагаар хүрээлэн, жигд хэмнэлээр давхарлан зурна.	Тараах материал, өнгийн харандаа.	Дүрсийн ирмэгийн гадна талаар хүрээлэн, жигд хэмнэлээр зурахыг чиглүүлэх.	Бүтээлчээр сэтгэх: Зохиомжлон зурах	Энгийн дүрс, зураас дуурайж зурж бичдэг.
Дүрсийг бүтээе	Өглөөний хүлээн авалт	Блок тоглоомоор 2D, 3D дүрс бүтээх, хэдэн блок орсныг тоолох, найзуудынхаа бүтээлтэй харьцуулан ярилцана.	Блок тоглоом.	"Дөрвөлжин дүрсэнд хэдэн блок орсон бэ?", "Юугаараа ижил, юугаараа өөр байгааг харьцуулан ярилцана".	Бүтээлчээр сэтгэх: Зохиомжлон барих Харилцах: Ижил төстэй байдлаа хуваалцах	Ангийнхаа бусад хүүхэдтэй ижил төстэй сэтгэл хөдлөлөө хуваалцдаг.
Дүрсийг хувиргая	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Баримлын шавраар 2D дүрс бүтээж, налуу зам дээр өнхрүүлэн турших. Туршилтын үр дүнг хэлэлцээд, дүрсээ хүн, амьтан болгон хувирган барина.	Баримлын шавар, суурь, налуу зам.	"Яагаад зарим дүрс хурдан өнхөрсөн, зарим нь өнхрөөгүй талаар өөрсдийн бодлоо хуваалцана".	Бүтээлчээр сэтгэх: Шавраар зохиомжлон барих, хувиргах	Хүн амьтан, эд юмсыг баримлын шавар, элс, гурилан зуурмагаар зохиомжлон барьдаг.
Урт, богино үгс	Тойргийн цаг	Урт, богино эгшиг орсон үгс (Цас-цаас, хол-хоол)-ийг зурагт картаар нэрлүүлж, ялгааг нь хэлэлцэнэ.	Зурагт карт.	Адилхан сонсогдож байна уу?, Яагаад өөр гэж бодож байна вэ?, Энэ юуны зураг вэ?	Суралцахууд суралцах: Сонсож ялгах чадвар, анхаарлаа төвлөрүүлэх	Урт, богино авиа орсон үгийг сонсоод ялгаж хэлдэг.
Тоолоод үсэрье	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Үг доторх эгшгийн тоог хуруугаараа илэрхийлэх. Урт/богино эгшигтэй үгэнд тохируулан тохирох тал руу үсрэх буухиа тоглоом.	Зурагт карт, тууз.	Үгийг анхааралтай сонсоод, урт бол урт эгшигтэй тал руу, богино бол богино эгшигтэй тал руу үсрэх.	Суралцахууд суралцах: Дүрмийг дагаж биелүүлэх	Урт, богино авиа орсон үгийг сонсоод ялгадаг.

Сонсоод зураарай	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Багшийн хэлсэн үгийг сонсоод, урт авиатай бол урт зураас, богино авиатай бол богино зураасыг цаасан дээр зурна.	Цаас, харандаа.	Ямар зураас зурснаа найз болон багшдаа үзүүлж тайлбарлана.	Бүтээлчээр сэтгэх: Авиаг дүрсээр илэрхийлэх	Энгийн дүрс, зураас дуурайж зурж бичдэг.
Ажиглаад гүйцэтгээрэй	Тойргийн цаг	4-5 үйлдлийн дарааллыг харуулсан зурган зааварчилгааг ажиглаад, бие даан гүйцэтгэнэ.	Зурган зааварчилгаа харуулсан зурагт карт.	"Сандлыг аваад ширээний дэргэд байрлуулаад сууна уу" гэх мэт үйлдэл.	Суралцахуйд суралцах: Зурган зааварчилгааг дарааллын дагуу хийх	4-5 үйлдэлтэй зурган зааварчилгааг дарааллын дагуу хийж гүйцэтгэдэг.
Юу нуугдсан байна бэ?	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Баг болж элсэнд нуусан ангийн эд зүйлсийн зургийг олох, ангиас бодит зүйлийг нь зааж олох, дараа нь блок тухайн зүйлийг бүтээн эвлүүлнэ.	Зурагт үзүүлэн, хайрцагтай элс, блок тоглоом.	Багууд бүгдээрээ зураг олсон эсэхийг ажиглаж, хамтын оролцоог дэмжих.	Хамтран ажиллах: Багийн оролцоо, хамтын шийдвэр гаргах	Бүтээлээ бусдад тайлбарладаг.

## 5 дугаар сарын I долоо хоног

### НУУГДСАН ЗУРГИЙГ ОЛООРОЙ

**Шинэ үг:** Эерэг, сөрөг

**Үйл ажиллагаа 1.** Нүдний дасгал (Өглөөний дасгалын цаг)

**Хэрэглэгдэхүүн:** дэлгэц, зурагт үзүүлэн

**Аргачлал:** Багш хүүхдүүдийг нүдээ анихыг хүсээд “Нүдээ нээ гэж хэлэх хүртэл битгий нээгээрэй” гэж чиглүүлнэ. “Нүдээ нээгээрэй” гэж хэлсний дараа дараах асуултуудыг тавина.

- Одоо юу харагдаж байна вэ? Нүдээ аних үед ямар санагдсан бэ?
- Нүдээ нээхэд ямар мэдрэмж төрж байна вэ?

Багш нүдний дасгалын зурагт үзүүлэн болон дэлгэц ашиглан хөдөлгөөнийг үзүүлж, хамтран хийж үзүүлнэ. Хүүхдүүд багшийн зааврын дагуу анхаарлаа төвлөрүүлж нүдний дасгалыг хийж гүйцэтгэнэ.

**Үйл ажиллагаа 2.** Юу байна вэ? (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Шилэн сав, холбоос дээрх аргаар бэлтгэсэн тараах материал (зураг нуугдсан цаас), гар чийдэн

**Аргачлал:** Багш үйл ажиллагаа эхлэхээс өмнө хэрэглэгдэх зүйлсийг урьдчилан бэлтгэнэ. Тараах материалыг шилэн саванд хийж, хүүхдүүдэд сонгох боломжтой болгоно. Хэрэглэгдэхүүн бэлтгэх зааврыг доорх холбоосоор хараарай. /цахим холбоос 1./

Хүүхдүүд шилэн савнаас өөрийн сонирхсон тараах материалыг сонгож авна. Сонгосон материал дээр юу харагдаж байгааг ярилцана. Багш дараах чиглүүлэх асуултуудыг тавина.

- Энэ цаасны хаа нэгтээ ямар нэг зураг нуугдсан байх боломжтой юу?
- Хэрвээ нуугдсан байгаа бол яаж харж болох вэ?

Багш гар чийдэнгийн гэрлийг цагаан цаасан дээр тусгаж үзүүлнэ. Хүүхэд бүр өөрийн сонгосон зураг руу гэрэл тусгаж, нуугдсан дүрсийг ажиглана. Илэрсэн дүрсийг хамтдаа ярилцаж тодорхойлно.

**Үйл ажиллагаа 3.** Цэгүүдийг холбоорой (Оройн таралт)

**Хэрэглэгдэхүүн:** Эсгий бал, тасархай зураасаар дүрсэлсэн зурагтай тараах материал

**Аргачлал:** Багш хүүхдүүдэд тараах материалыг өгч, зураг дээр юу дүрслэгдсэнийг хамтдаа ажиглана. Багш “Энд ямар зүйл дутагдаж байна вэ?”, “Хэрвээ энэ зургийг гүйцээвэл юу болох бол?” гэх мэт чиглүүлэх асуулт тавина. Хүүхдүүд зургийн тасархай хэсгийг гүйцээн зурахдаа өөрийн төсөөллөөр чимэглэж болно. Гүйцээж зурсан зургийг харилцан ярилцаж, бүтээлээ харьцуулан ярилцана.

### ХЭН САЙН МӨЛХӨХ ВЭ?

**Үйл ажиллагаа 1.** Саадыг сүлжээрэй (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэгсэл:** 5 ширхэг саад

**Аргачлал:** Ангийн нэг захаас нөгөө зах хүртэл 5 ширхэг жижиг хэмжээтэй саадыг ижил хэмжээтэй зайд байрлуулсан байна. Хүүхдүүдийг 2 багт хуваан мөлхөлтийн төрлийг гүйцэтгүүлнэ. Эхлээд нэг захаас нөгөө зах руу саадын дээгүүр 4 хөллөж мөлхөнө. Буцахдаа саадыг сүлжиж мөлхөнө.

**Үйл ажиллагаа 2.** Нуман доогуур мөлхөөрэй (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэгсэл:** Өргөн скоч, 5-10 см диаметртэй бөмбөгнүүд, нум

**Аргачлал:** Бүлгийн өрөөний нэг захад скочийг хүүхдийн гар хүрэх өндөрт уртаар эгнүүлэн байрлуулна. Хүүхдүүдийг 2 багт хувааж, ээлжээр тоглоно. Багийн хүүхэд нуман доогуур өвдөг, тохойгоороо мөлхөн гараад 5–10 см диаметртэй бөмбөгийг авч, скочинд тогтооно. Дараа нь буцаж очоод дараагийн хүүхдийн гарыг цохиж ээлжийг дамжуулж багаа дэмжиж тоглоно.

**Үйл ажиллагаа 3.** Цагаригийг зөөгөөрэй (Оройн таралт)

**Хэрэгсэл:** Цагариг, бай болох зүйл, конус, жижиг хэмжээтэй конус

**Аргачлал:** Хүүхэд цагариг дотор өвдгөөрөө сууж, нэг гараараа урд байрлах бай дээр гараа тавина. Нөгөө гараараа цагаригийн урд талд байгаа нэг конусаас нөгөө талд байрлах конус руу жижиг цагаригийг ээлжлэн хийнэ.

### **ДҮРС БҮР ЯЛГААТАЙ**

**Шинэ үг:** Биет дүрс

**Үйл ажиллагаа 1.** Ялгааг олъё (Төвийн үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Дугуй, дөрвөлжин дүрс, бөмбөг, хайрцаг, өнгийн харандаа, дэлгэц, бичлэг, ундааны бөглөө

**Аргачлал:** Дугуй дүрс болон бөмбөг, дөрвөлжин дүрс болон хайрцгийг зэрэгцүүлэн байрлуулна. Хүүхдүүдийг дөрвөн багт хувааж, дараах чиглүүлгийг өгнө.

- 1-р баг: Дүрс болон биетийг өнхрүүлж, шидэж туршилт хийж үзнэ.
- 2-р баг: Дугуй, дөрвөлжин дүрсийн ирмэг дээр давхарлаж байрлуулж, дүрсийн гадна талаас ундааны бөглөө зэрэгцүүлэн тавьж тоглоно.
- 3-р баг: Өгөгдсөн хавтгай дүрсийн тасархай зураасыг холбон зурж, будаж гүйцээнэ. Дараа нь бөмбөг болон хайрцгийг будаж үзээд ялгааг тодорхойлно.
- 4-р баг: Дүрс болон биетийн ялгааг харуулсан бичлэг үзэж, олон дүрсээс өнцөггүй дүрсийг олж, өнцөгтэй дүрсийг нэрлэнэ.

**Үйл ажиллагаа 2.** Давхарлан зуръя (Төвийн үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Тараах материал, өнгийн харандаа

**Аргачлал:** Дугуй, дөрвөлжин, гурвалжин дүрсийн талыг том жижиг, урт богино гэх мэт өөр өөр хэлбэрээр хэвлэн бэлтгэсэн байна. Хүүхдүүд тухайн дүрсийн ирмэгийн гадна талаар өнгийн харандаагаар хүрээлэн жигд хэмнэлээр давхарлан зурна.

**5 дугаар сарын II долоо хоног**

### **ЧИНИЙ ДУРТАЙ ДҮРС АЛЬ НЬ ВЭ?**

**Шинэ үг:** Өнхрөх

**Үйл ажиллагаа 1.** Дүрсийг бүтээе (Өглөөний хүлээн авалт)

**Хэрэглэгдэхүүн:** Блок тоглоом

**Аргачлал:** Хүүхдүүд хавтгай болон биет дугуй, дөрвөлжин, гурвалжин дүрсийг блок тоглоомоор бүтээнэ. Эвлүүлсний дараа тухайн дүрсийг бүтээхэд хэдэн ширхэг блок тоглоом хэрэглэсэн болохыг тоолж тэмдэглэнэ. Жишээ нь: “Дөрвөлжин дүрсэнд хэдэн блок орсон бэ?” гэх мэтээр ярилцана.

Дараа нь хүүхдүүд өөрсдийн эвлүүлсэн дүрстэй адил дүрс бүтээсэн найзуудаа олж, хамтдаа юугаараа ижил, юугаараа өөр байгааг харьцуулан ярилцана.

**Үйл ажиллагаа 2.** Дүрсийг хувиргая (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Баримлын шавар, суурь, налуу зам

**Аргачлал:** Хүүхэд бүр баримлын шавар ашиглан дугуй, гурвалжин, дөрвөлжин дүрс бүтээнэ. Бүтээсэн дүрсээ ажиглаж, хоорондын ялгааг ярилцана. Дараа нь өөрсдийн бүтээсэн дүрсийг налуу зам дээр өнхрүүлж, аль дүрс хамгийн хурдан өнхөрсөн, аль нь өнхрөөгүйг ажиглана. Яагаад зарим дүрс хурдан өнхөрсөн, зарим нь өнхрөөгүй талаар өөрсдийн бодлоо бусадтай хуваалцана. Эцэст нь бүтээсэн дүрснүүдээс сонгон амьтан эсвэл хүний дүрс бүтээж, түүний биеийн хэсгүүдийг гүйцээн барина. Бусад хүүхдийн бүтээлтэй өөрийн бүтээлийг харьцуулан ярилцана.

### **СОНСООД ЯЛГААРАЙ**

**Шинэ үгс:** Урт, богино авиа

**Үйл ажиллагаа 1.** Урт, богино үгс (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Зурагт карт

**Аргачлал:** Урт, богино үг орсон зурган картын дагуу ярилцана. Цас-цаас, хол-хоол, ул-уул г.м үгтэй зурган картууд байна. Багш хүүхдүүдээс асуулт асууж ярилцана.

- Энэ юуны зураг вэ? нэрлээрэй.
- Багш урт богино эгшиг орсон 2 зургийг зэрэгцүүлэн бариад нэрлүүлж давтаж хэлүүлнэ.
- Дараа нь зургийг эргүүлж үгийг дахин давтаж хэлүүлээд асууна.
- Адилхан сонсогдож байна уу?, Өөр сонсогдож байна уу?
- Яагаад адилхан бэ? яагаад өөр гэж бодож байна вэ?
- Өнөөдөр бүгдээрээ эдгээр үгийг ашиглан тоглоё.

**Үйл ажиллагаа 2.** Тоолоод үсэрье (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Зурагт карт, урт, богино эгшигтэй зурагт карт, тууз

**Аргачлал:** Зурагт картуудыг доош харуулж тавина. Хүүхдүүд ээлжлэн картаас сонголт хийж тухайн үгнүүдийг үсгэн тэмдэгтүүдийг ажиглаж тайлбарлана. Цас гэхэд голд байгаа “а” авиа хэд байгааг тоолно. Цаас гэхэд хэдэн ширхэг “а” авиа болсныг тоолж ялгана. Тоглох явцдаа хуруугаараа тоог илэрхийлнэ. Дараа нь ангийн голд туузыг уртаар нь байрлуулж хүүхдүүдийг дээр нь зогсооно. Мөн хоёр талд нь урт богино эгшигтэй зурагт картуудыг томоор гаргаж байрлуулна. Хүүхдүүдийг үгээ анхааралтай сонсоод урт бол аа, богино бол а богино эгшигтэй тал руу үсрэх даалгавар өгнө. Алдсан хүүхдүүд тоглоомоос хасагдана. /ул- уул, хол-хоол гэсэн үгээр тоглож болно/

**Үйл ажиллагаа 3.** Сонсоод зураарай (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Цаас, харандаа

**Аргачлал:** Багш хүүхэд бүрд балын харандаа, цаас өгнө. Багшийн хэлсэн үгийг анхааралтай сонсоод урт авиа орсон үг хэлбэл урт зураас, богино авиатай орсон үг хэлсэн үед богино зураасыг зохиож зурах даалгавар өгнө. Жишээ нь: Цас гэхэд \_\_ зураас, цаас гэж хэлэхэд \_\_\_\_\_ гэж урт зураас зурах гэх мэт.

Ямар зураас зурснаа найз болон багшдаа үзүүлж тайлбарлана.

## ОЛООРОЙ

**Шинэ үг:** зурган дараалал

**Үйл ажиллагаа 1.** Ажиглаад гүйцэтгээрэй (Тойргийн цаг)

**Хэрэглэгдэхүүн:** Зурган зааварчилгаа харуулсан зурагт карт

**Аргачлал:** Багш хүүхдүүдэд үйлдэл хийх дарааллыг харуулсан зурагт картыг бэлтгэнэ. Жишээ нь: “Сандлыг аваад ширээний дэргэд байрлуулаад сууна уу” гэх мэт. Хүүхдүүд зурган зааварчилгааг хараад тухайн үйлдлийг гүйцэтгэнэ. Хэрвээ зурган зааврыг ойлгож гүйцэтгэж чадахгүй хүүхэд байвал багш тайлбарлаж, дэмжлэг үзүүлнэ.

**Үйл ажиллагаа 2.** Юу нуугдсан байна бэ? (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

**Хэрэглэгдэхүүн:** Зурагт үзүүлэн, сандал

**Аргачлал:** Хүүхдүүдийг баг болгон хуваарилан суулгана. Ширээ бүрд ангид байгаа зүйлсийн зургийг харуулсан зурагт картыг хайрцагтай элсэнд нууж өгнө. Хүүхдүүд элсэнд нуусан зургийг олоод ангийн хаана байгааг олж заана, эсвэл хэлнэ. Олсон зургийн бодит хэрэглэгдэхүүнийг блок тоглоом ашиглан бүтээнэ. Зургийг элсэнд буцаан нуух ба багууд хайрцгаа солилцож үргэлжлүүлэн тоглоно.

Цахим холбоос:

1. <https://www.pinterest.com/pin/5699937023415027/>

**Сонсьё, дэмжье/ Туслалцаа:**

- Хөдөлгөөнт тоглоом тоглуулахдаа дэмжлэг шаардлагатай хүүхдэд тохирсон хэрэглэгдэхүүн бэлтгэх нь үр дүнтэй байдаг. Тиймээс хүүхэд бүрийн онцлогийг харгалзан уян хатан төлөвлөж, хэрэгжүүлээрэй.

**Эцэг эхтэйгээ хамтаръя.**

- Гэр болон цэцэрлэгийн орчноос дугуй, дөрвөлжин, гурвалжин дүрстэй төстэй эд зүйлсийг олж нэрлээд, хэлбэр дүрсийг хэлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Гэр бүлээрээ хөдөлгөөнт тоглоомыг тоглохыг санал болгоорой.

**Багшийн эргэцүүлэмж**

<p><b>Эргэцүүлэл</b> /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ./</p> <p>Амжилттай хэрэгжүүлсэн: .....</p> <p>Сул хэрэгжүүлсэн:.....</p> <p>Цаашид сайжруулах:.....</p> <p>Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа: .....</p>
--

Албан хэрэгцээнд

